LINGO LAB

Mongolian Language

for Intermediate Students

Bayarmaa Khalzaa

Халзаагийн Баярмаа

Монгол хэл

(Дунд шатны оюутнуудад зориулав)

Улаанбаатар хот

2011 он

© Халзаагийн Баярмаа 2011
© Энэхүү номыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.

Хянасан: Х. Олонбаяр
Naomi Joy McKenzie
Steve Griffin

Эхийг хэвлэлтэд бэлдсэн: Ewen Kitto
Х. Баярмаа

Хавтасны зургийг: Ewen Kitto

ISBN 978-99962-0-483-8

DDC 494.238'077
Б - 384

Proofreading: Olonbayar Khalzaa
Naomi Joy McKenzie
Steve Griffin

Typesetting: Ewen Kitto
Bayarmaa Khalzaa

Cover photo: Ewen Kitto

© Bayarmaa Khalzaa 2011
© This book may not be copied or reproduced without the permission of the copyright owner.

Оршил

Энэхүү ном нь монгол хэл сурч байгаа дунд шатны оюутнуудад зориулагдсан бөгөөд хэлзүйн мэдлэгээ ярианда дадал чадвар болгоход нь оюутнуудад туслах зорилготой юм.

- Уг ном нь тавин хичээлтэй бөгөөд таван хичээл тутамд давтлага хичээл болон тесттэй.
- Өдөр тутмын ярианд өргөн хэрэглэгддэг хэлзүйн дүрмүүдийг сонгон оруулсан ба хэлзүйн тайлбар болон зөв бичих дүрмийг англи хэл дээр бичиж, жишээг монгол, англи хэл дээр харьцуулан үзүүлэв.
- Оюутнуудад өдөр тутам тохиолдож болох нөхцөл байдлуудыг дасгалуудад тусгалаа.
- Монгол хүмүүсийн нэр нь үгсийн сангийн үгсээс ихэвчлэн бүрддэг учраас зарим тохиолдолд оюутнуудыг эргэлзэхэд хүргэдгийг харгалзан үзэж эмэгтэй хүний нэрийн ард "маа," эрэгтэй хүний нэрийн ард "хүү"-г тус тус залгаж хэрэглэв. Жишээ нь: Гэрэлмаа, Ганхүү

Энэхүү номыг хийхэд үнэтэй санал зөвлөгөө өгч тусалсан Ewen Kitto, Naomi Joy McKenzie, Steve and Lisa Griffin, Х. Олонбаяр, И. Лхагвацэцэг болон бусад оюутан, найз нөхдөдөө гүн талархлаа илэрхийлье.

Халзаагийн Баярмаа

Э-шуудангийн хаяг: mongolianed@yahoo.com

Introduction

This book is for intermediate students of the Mongolian language. The goal of this book is to help students have ability to use their grammar knowledge in speaking.

- This book has fifty lessons. After every five lessons, there is a review lesson and a test.
- Grammar that is used in everyday speech is chosen in this book. Explanations and spelling rules are in English. Examples have English translations.
- Exercises reflect the type of situations students may face in everyday life.
- Mongolian names often consist of real words, which makes it difficult for students to know if a word is a name or just a word. In order for students to recognize names easily, "маа" is added to women's names and "хүү" to men's names in this book. For example: Гэрэлмаа, Ганхүү.

I'm very thankful to Ewen Kitto, Naomi Joy McKenzie, Steve and Lisa Griffin, Kh. Olonbayar, I. Lhagvatsetseg, other students and friends for giving worthwhile advice and help.

Bayarmaa Khalzaa

E-mail address: mongolianed@yahoo.com

Гарчиг Contents

Нэгдүгээр хичээл **8**
Нийлмэл өгүүлбэр — Complex Sentence—When — 8
Хоёрдугаар хичээл **11**
Болзох төлөв — Conditional — 11
Холбох үг (... яагаад ... юм бэ гэвэл ...) — Conjunction (The reason why ... is because ...) — 14
Гуравдугаар хичээл **15**
Захируулан холбох үг (-ийн[2] оронд) — Subordinating Conjunction (instead of, in place of) — 15
Дөрөвдүгээр хичээл **17**
Захируулан холбох үг (-хаас(аа)[4] өмнө) — Subordinating Conjunction (Before) — 17
Захируулан холбох үг (-ийн[2] өмнөөс) — Subordinating Conjunction (for) — 19
Захируулан холбох үг (-ийн[2] төлөө) — Subordinating Conjunction (for (sake of)) — 20
Тавдугаар хичээл **21**
Захируулан холбох үг (-сан[4]ы[2] дараа) — Subordinating Conjunction (After) — 21
Захируулан холбох үг (-аас[4] хойш) — Subordinating Conjunction (Since) — 23

Давтлага хичээл (1-5) **24**
Тест **26**

Зургадугаар хичээл **27**
"нь" нөхцөлийн хэрэглээ — Usages of the Suffix "нь" — 27
Долдугаар хичээл **32**
Санаа бодлоо хэрхэн илэрхийлэх нь — How to Express One's Opinion — 32
Наймдугаар хичээл **34**
Тэмдэг нэрийн бууруулах зэрэг — Modification of Adjectives (Diminutive) — 34
Тэмдэг нэрийн эрчимжүүлэх зэрэг — Modification of Adjectives (Intensifying) — 34
Тэмдэг нэрийн давуу зэрэг (хамгийн) — Superlative Form (-est, most) — 35
Захируулан холбох үг (-ийг[2]/-г бодвол) — Subordinating Conjunction (If compared ... to ...) — 36
Есдүгээр хичээл **37**
Захируулан холбох үг (-х гэж/-хаар[4]) — Subordinating Conjunction (to, in order to) — 37
Аравдугаар хичээл **40**
Тодотгон холбох нөхцөл — Adjective Clause — 40

Давтлага хичээл (6-10) **46**
Тест **48**

Арван нэгдүгээр хичээл **49**
"-х" дагавар — Suffix "-х" — 49
Арван хоёрдугаар хичээл **51**
Давхар тийн ялгал — Double Cases — 51
Арван гуравдугаар хичээл **53**
Үйл үгийн холбох нөхцөл (-тал[4], -т(а)лаа[4]) — Verb Determining Suffix (Until) — 53
Арван дөрөвдүгээр хичээл **56**
Үйл үгийн холбох нөхцөл (-вч) — Verb Determining Suffix (Even though, although) — 56
Арван тавдугаар хичээл **59**
Бүрмөсөн үйлдэх байдал (-чих) — Completed Action — 59

Давтлага хичээл (11-15) **62**
Тест **64**

Арван зургадугаар хичээл **65**
Тодорхойгүй төлөөний үг (хэн ч ...-гүй, г.м.) Indefinite Prowords (no one, etc.,) 65
Арван долдугаар хичээл **68**
Тодорхойгүй төлөөний үг (хэн нэгэн хүн, г.м.) Indefinite Prowords (someone, etc.,) 68
Арван наймдугаар хичээл **70**
Захируулан холбох үг (-аас[4] гадна) Subordinating Conjunction (as well as, besides) 70
Захируулан холбох үг (-аас[4] бусад) Subordinating Conjunction (except for) 71
Арван есдүгээр хичээл **72**
2-р биеэр төгсгөх нөхцөл (-аар[4]ай[3], -аач[4], г.м.) Second Person-bound Terminating Suffixes 72
2-р биеэр төгсгөх нөхцөл (-уузай[2]/-в (аа)[4]) Be careful. Don't ..., Make sure don't ... 74
Хорьдугаар хичээл **76**
3-р биеэр төгсгөх нөхцөл (-г, -тугай[2]) Third Person-bound Terminating Suffixes 76
Бүрмөсөн үйлдэх байдал (-аадах[4]) Completed Action 79

Давтлага хичээл (16-20) **80**
Тест **82**

Хорин нэгдүгээр хичээл **83**
3-р биеэр төгсгөх нөхцөл (-аа[4]сай[3]) Third Person-bound Terminating Suffix 83
Чимэх үг (-х юмсан) Modal Construction 84
Хорин хоёрдугаар хичээл **85**
Орон цагийн нэр Postpositions 85
Хорин гуравдугаар хичээл **88**
Үйл үг (-хаа[4] болих) Verb (to stop ...-ing) 88
Хорин дөрөвдүгээр хичээл **90**
Үйл үгийн холбох нөхцөл (-лгүй) Verb Determining Suffix (without) 90
Хорин тавдугаар хичээл **92**
Тусагдахуун гишүүн өгүүлбэр Objective Clause 92

Давтлага хичээл (21-25) **97**
Тест **99**

Хорин зургадугаар хичээл **100**
Тусагдахуун гишүүн өгүүлбэр Objective Clause 100
Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр Subjective Clause 101
Хорин долдугаар хичээл **102**
Нийлмэл өгүүлбэр Combined Sentences (When) 102
Үйл үгийн холбох нөхцөл (-(а[4])х(л)аар[4]) Verb Determining Suffix (when (whenever)) 103
Хорин наймдугаар хичээл **108**
Хүрэх гэдэг үйл үгийн утгууд Meanings of Verb "хүрэх" 108
Хорин есдүгээр хичээл **110**
Төлөөний үг (яах) Proword (to do what) 110
Гучдугаар хичээл **112**
Үйлдүүлэх хэв Causative Voice 112
Нийлмэл хэв Double Causative Voice 116

Давтлага хичээл (26-30) **117**
Тест **119**

Гучин нэгдүгээр хичээл **120**
Үйлдэгдэх хэв Passive Voice 120
Гучин хоёрдугаар хичээл **123**
Хамтран үйлдэлцэх хэв (-лц) Communal Voice 123
Харилцан үйлдэлдэх хэв (-лд) Reciprocal Voice 124
Гучин гуравдугаар хичээл **125**

Үйл үгийн холбох нөхцөл (-саар[4])	Verb Determining Suffix (keep ...-ing)	125
Гучин дөрөвдүгээр хичээл		**127**
Үйл үгийн холбох нөхцөл (-нгуут[2]/-магц[4])	Verb Determining Suffix (As soon as)	127
Гучин тавдугаар хичээл		**130**
Үйл үгийн холбох нөхцөл (-нгаа[4])	Verb Determining Suffix (While)	130
Давтлага хичээл (31-35)		**132**
Тест		**134**
Гучин зургадугаар хичээл		**135**
"Гэ" язгууртай үйл үг	The Verb "гэ"	135
Гучин долдугаар хичээл		**140**
"Болох" гэдэг үйл үгийн утгууд	Meanings of the Verb "болох"	140
Гучин наймдугаар хичээл		**146**
Төлөөний үг (тэгэх)	Proword (to do so)	146
Гучин есдүгээр хичээл		**150**
Төлөөний үг (ингэх)	Proword (to do this way)	150
Төлөөний үгс (ингэж/тэгж)	Prowords (like this/that)	152
Төлөөний үгс (ийм/тийм)	Prowords (like this/that)	152
Дөчдүгээр хичээл		**153**
Цагтай холбоотой үгс	Words that are related to time	153
Давтлага хичээл (36-40)		**156**
Тест		**158**
Дөчин нэгдүгээр хичээл		**159**
Өөрийн төлөөний үг (өөрөө)	Reflexive Proword (myself/herself, etc.,)	159
Ялгах төлөөний үг (бие бие...)	Demonstrative Proword (each other)	161
Дөчин хоёрдугаар хичээл		**163**
Ялгах төлөөний үгс (зарим, бүгд)	Demonstrative Prowords (some, all)	163
Ялгах төлөөний үгс (бусад, цагаан нь)	Demonstrative Prowords (others/the others, the white one)	166
Дөчин гуравдугаар хичээл		**168**
Нийлмэл үгс (гадаа гэртгүй, г.м.)	Compound Words (every where, etc.,)	168
Нийлмэл үгс (байсан байгаагүй, г.м.)	Compound Words (either ... or not, etc.,)	169
Дөчин дөрөвдүгээр хичээл		**170**
Чимэх үг (... юм бол?/... юм бол уу?)	Modal Construction (I wonder ...?/I wonder if ...?)	170
Чимэх үг (... бол?/... бол уу?)	Modal Construction (Do you think ...?)	171
Дөчин тавдугаар хичээл		**172**
Чимэх үг (... гэж?/... гэж үү?)	Modal Construction (Do you mean ...?)	172
Чимэх үг (... гэлээ?/... гэлүү?)	Modal Construction (Did you say ...?)	173
Давтлага хичээл (41-45)		**174**
Тест		**176**
Дөчин зургадугаар хичээл		**177**
Захируулан холбох үг (-х замд(аа))	Subordinating Conjunction (On the way to)	177
Захируулан холбох үг (-х болгонд(оо))	Subordinating Conjunction (Every time ...)	178
Дөчин долдугаар хичээл		**179**
Чимэх үг (-даг[4] байж)	Modal Construction (Should have ... -ed)	179
Чимэх үг (-хаас[4] (даа[4]))	Modal Construction (I don't want to, but I have to ...)	180
Дөчин наймдугаар хичээл		**181**
Захируулан холбох үг (-хаар[4] барахгүй)	Subordinating Conjunction (Not only ..., ...)	181
Захируулан холбох үг (-х нь байтугай)	Subordinating Conjunction (Don't ... not even ...)	181
Дөчин есдүгээр хичээл		**182**
Захируулан холбох үгс	Subordinating Conjunctions	

Хэдий чинээ ... төдий чинээ ...	How much ... that much ...	182
Захируулан холбох үг (-х тусам(аа))	Subordinating Conjunction (More ... more ...)	183
Тавьдугаар хичээл		**184**
Холбох үг (юм чинь)	Conjunction (Because)	184
Холбох үг (чинь)	Conjunction (When)	185
Давтлага хичээл (46-50)		**186**
Тест		**188**
Дасгалуудын хариу	**Key to Exercises**	**189**
Хавсралт	**Appendix**	**212**
Үгүйсгэх болон хориглон чимэх үгс	Negative particles	212
Онцлон чимэх үг (л)	Particle (л)	213
Онцлон чимэх үг (ч)	Particle (ч)	214
Батлан чимэх үг (даа[4])	Particle (даа[4])	215
Өгүүлбэрийн зэрэгцүүлэн холбох үгс	Sentence Coordinating Conjunctions	216
Өгүүлбэрийн захируулан холбох үгс	Sentence Subordinating Conjunctions	217
Үг бүтээх дагаврууд	Word Forming Suffixes	218
Үг нийлэх аргаар нэр үг бүтэх	Word—Building by Word Combinations	219
Ном зүй	**Bibliography**	**220**

Нэгдүгээр хичээл

Нийлмэл өгүүлбэр (Complex Sentence — When)

Sentences with same subject:

Subject ..... verb stem + (а[4])хдаа[4] ..... verb
Subordinate clause Main clause

Тэр манайд **ирэхдээ** жимс авчирсан. **When** he **came** to my house, he brought fruit.
Тэр манайд ирэхдээ жимс авчирна. When he comes to my house, he will bring fruit.
Тэр манайд ирэхдээ жимс авчирдаг. When he comes to my house, he brings fruit.

Sentences with different subjects:

Subject 2 + ийг[2], г ..... verb stem + (а[4])хад[4] **subject 1** ..... verb
Subordinate clause Main clause

Намайг ирэхэд **багш** ангид байсан. When **I** came, **the teacher** was in the classroom.
Намайг ирэхэд багш ангид байна. When I come, the teacher will be in the classroom.
Намайг ирэхэд багш ангид байдаг. When I come, the teacher is in the classroom.

Spelling rules:
Verb stems with а, у and я + (а)хдаа/-(а)хад → уухдаа/уухад, явахдаа/явахад
Verb stems with э, ү and и +(э)хдээ/-(э)хэд → үзэхдээ/үзэхэд, хийхдээ/хийхэд
Verb stems with о + (о)хдоо/-(о)ход → боохдоо/бооход, орохдоо/ороход
Verb stems with ө + (ө)хдөө/-(ө)хөд → хөөхдөө/хөөхөд, өгөхдөө/өгөхөд

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (-аа[4]).

Ахыгаа дуулахад тэд чимээгүй байсан. **When their brother sang**, they were quiet.
Ээжийгээ ажилдаа явахад охин уйлдаг. The girl cries when her mother leaves for her work.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Цас ороход хүүхдүүд их баярладаг. When it snows, children are so happy.
Онгоц хөөрөхөд би харж байсан. I was watching when the airplane took off.

Тэр онгоц**ыг** хөөрөхөд би харж байсан. I was watching when that airplane took off

Negative: After negative verbs, the verb **байх** is used.

Чамайг энд байхгүй **байхад** найз чинь ирсэн. When you were not here, your friend came.
Том хүмүүс энийг хийж чадахгүй **байхад** хүүхдүүд яаж чадах юм бэ? When adults can't do this, how children can do it?

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг уншаад орчуул. (Read the sentences and translate them.)

1. Би хөдөө явахдаа дулаан хувцас авч явсан.
2. Намайг хичээлдээ явахад хүүхдүүд тоглож байсан.
3. Гэрэлмаа хоол хийхдээ цэцэгтэй хормогчоо зүүдэг.
4. Гэрэлмааг хоол хийхэд хүүхдүүд нь тусалдаг.
5. Бид энд ирэхдээ монгол хэл мэддэггүй байсан.
6. Биднийг анхны удаа Монголд ирэхэд их хүйтэн байсан.
7. Тэд Монголд байхдаа олон сайхан юм үзсэн.
8. Тэднийг Монголд байхад тэнгэр өдөр бүр цэлмэг, нартай байсан.
9. Хүмүүс хоол идэж байхдаа хоорондоо ярих дуртай.
10. Хүмүүсийг хоол идэж байхад хөгжимчид хөгжим тоглож байсан.
11. Хүрэлхүү хичээлээ хийж байхдаа намуухан хөгжим сонсох дуртай.
12. Хүрэлхүүг хичээлээ хийж байхад дүү нь түүнд саад болдоггүй.
13. Намайг ирэхэд эхнэр маань хувцас хунар угаах гэж байсан.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Би Америкт байхдаа ...
2. Намайг Америкт байхад ...
3. Би 20 настай байхдаа ...
4. Намайг 20 настай байхад ...
5. Би дунд сургуульд байхдаа ...
6. Намайг дунд сургуульд байхад ...
7. Би сургуулиа төгсөхдөө ...
8. Намайг сургуулиа төгсөхөд ...
9. Би анх Монголд ирэхдээ ...
10. Намайг анх Монголд ирэхэд ...
11. Би гэрээ цэвэрлэхдээ ...
12. Намайг гэрээ цэвэрлэхэд ...
13. Бороо ороход ...
14. Хичээлийн шинэ жил эхлэхэд ...
15. Утас дуугарахад ...
16. Автобус зогсоход ...

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. When I was home, I did house work.
2. When I go home, I will take a taxi.
3. When Ganhuu was in school, he learned English.
4. When the teacher entered the calssroom, the students were sitting at their tables.
5. When I was eighteen, I graduated from my school.
6. When I was thirty, I got married.
7. When you are eating, don't talk too much.
8. When she was reading a book, she was eating an apple.

9. When I came home, my mom was making tea.
10. When the teacher left, her students gave her flowers.
11. When it started raining yesterday, I was at the store.
12. When Bathuu sang, we were surprised.
13. When you were writing an email, I was listening to music.
14. When it was raining, we were playing outside.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүүхдүүд цэцэг түүхдээ ...
2. Хүүхдүүд цэцэг түүж байхдаа ...
3. Хүүхдүүд цэцэг түүх гэж байхдаа ...
4. Хүүхдүүдийг цэцэг түүхэд ...
5. Хүүхдүүдийг цэцэг түүж байхад ...
6. Хүүхдүүдийг цэцэг түүх гэж байхад ...

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

-даг[4] байсан (used to)

Би хүүхэд байхдаа гадаа их тоглодог байсан. (When I was a child, I used to play outside a lot.)

1. Би хүүхэд байхдаа ...
2. Би дунд сургуульд байхдаа ...
3. Би гэртээ байхдаа ...
4. Би цахилгаан шатаар явахдаа ...
5. Аав ажлаасаа гэртээ ирэхдээ ...
6. Найз маань надтай утсаар ярихдаа ...
7. Манай хүү унтаж байхдаа ...
8. Би усанд сэлэхдээ ...
9. Багш хичээл заахдаа ...
10. Би тоглоом тоглохдоо ...

Дасгал 6

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Хоёрдугаар хичээл

Болзох төлөв (Conditional)

Conditional sentence with same subject:

(Хэрэв) **subject** ..... verb stem + вал[4]	..... verb
Subordinate clause	Main clause

Би ядарвал амарна.	**If I'm tired**, I will rest.
Тэд энд байвал их юм сурна.	If they stay here, they will learn many things.
Чи энэ ажлыг хийвэл амжилтанд хүрнэ.	If you do this work, you will gain success.

Conditional sentence with different subjects:

(Хэрэв) **subject 2** + ийг[2], г ..... verb stem + вал[4]	**subject 1** .....verb
Subordinate clause	Main clause

Таныг ядарвал **би** (танд) тусална.	If **you** are tired, **I** will help you.
Түүнийг өлсвөл хоол өгөөрэй.	If he is hungry, please give him food.
Тэднийг шантарвал зоригжуулаарай.	If they are discouraged, please encourage them.

Spelling rules:

Verb stems with а, у and я + вал →	уувал, харвал, яривал
Verb stems with э, ү and и + вэл →	үзвэл, хийвэл, нэрлэвэл
Verb stems with о + вол →	орвол, босвол
Verb stems with ө + вөл →	өгвөл, өргөвөл

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (-**аа**[4]).

Ээжийг**ээ** ирвэл хүүхдүүд баярлана.	If **their** mother comes, the children will be happy.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Утас дуугарвал аваарай.	If the phone rings, please answer it.
Машин эвдэрвэл зас.	If the car is broken, fix it.
Энэ машин**ыг** эвдэрвэл зас.	If this car is broken, fix it.

After verb stems that end with letter **в, л** and **м**, бал[4] is used.

Та хөдөө **явбал** энэ майхныг авч яваарай.	If you go to the countryside, please take this tent.
Таныг **хэлбэл** тэр таны үгэнд орно.	If you tell him, he will obey you.
Давс **нэмбэл** хоол шорвог болно.	If you add salt, the food will be too salty.

After sentences that end with negative verbs, adjectives, nouns, хэрэгтэй, дуртай and all tenses except for future (after verb stem), **бол** is used separately from the words.

Та **амарсан бол** ядрахгүй байсан.	If you rested, you would not have been tired.
Та **амрахгүй бол** ядарна.	If you don't rest, you will be tired.
Тэр сайн **ном бол** аваарай.	If that is a good book, please buy it.
Та жимс идэх **дуртай бол** энийг идээрэй.	If you like to eat fruit, please eat this.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Тэд энд амьдарвал ...
2. Тэднийг энд амьдарвал ...
3. Та явах хэрэгтэй бол ...
4. Таныг явах хэрэгтэй бол ...
5. Та эмчид үзүүлбэл ...
6. Таныг эмчид үзүүлбэл ...
7. Би ажилдаа ирэхгүй бол ...
8. Намайг ажилдаа ирэхгүй бол ...
9. Манай хүүхэд өлсвөл ...
10. Манай хүүхдийг өлсвөл ...
11. Чи хичээлээ сайн хийвэл ...
12. Чамайг хичээлээ сайн хийвэл ...
13. Цас орвол ...
14. Утас дуугарвал ...
15. Тог тасарвал ...
16. Гадаа салхитай байвал ...

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. If you work many hours, you will be tired.
2. If you work many hours, I will help you.
3. If you don't eat well, you will get sick.
4. If it's cold outside, wear your warm clothes.
5. If she doesn't come, I will go to her house.
6. If you can't come to my house, please call me.
7. If you meet him, tell him to come at five o'clock.
8. If they need to learn Mongolian, please teach them.
9. If he asks, his dad will help him.
10. If you hang your clothes outside, they will dry faster.
11. If you pay attention to your lesson, you will understand it well.
12. If it's windy, I won't play outside.
13. If he plays on our team, we will win.

Дасгал 3

Өгөгдсөн өгүүлбэрүүдээс загварын дагуу гинжин хэлхээ үүсгэн өгүүлбэр зохиогоод хамгийн эхний болон сүүлийн өгүүлбэрийг нийлүүлж нэг өгүүлбэр болго. (Make chain sentences as in the example out of following sentences and put the very first and last sentences together.)

Загвар: Гадаа дулаахан байвал ...
Гадаа дулаахан байвал бид нар хөдөө явна. → Бид нар хөдөө явбал олон сонирхолтой юм үзнэ. → Бид нар олон сонирхолтой юм үзвэл танд ярьж өгнө. → Танд ярьж өгвөл та баярлана. → Таныг баярлавал **бид баярлана.**

Гадаа дулаахан байвал бид баярлана.

1. Хүүхэд чихэр их идвэл ...
2. Та ажил хийвэл ...
3. Гадаа хүйтэн байвал ...
4. Та хоол идэхгүй бол ...

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээлбэл:
Та надтай явсан бол олон сонирхолтой юм үзэх байсан.
(If you went with me, you would have seen many interesting things.)

1. Та эм уусан бол ...
2. Таныг эм уусан бол ...
3. Гадаа халуун байсан бол ...
4. Би өвдсөн бол ...
5. Хүүхдүүд амарсан бол ...
6. Тэд мөнгөтэй байсан бол ...
7. Би хүүхэд байсан бол ...
8. Та нарыг хуралд ирсэн бол ...

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. If he graduated from his university, he would have had a good job.
2. If you broke that glass, you would have paid a lot of money.
3. If you came yesterday, you wouldn't have regretted it.
4. If she didn't go to the countryside, she wouldn't have been sick.
5. If his mother didn't leave, he wouldn't have cried.
6. If it didn't rain, I wouldn't have stayed home.
7. If my friend didn't help me, I wouldn't have been able to finish this.
8. If they had played football, they would have won.
9. If I were a doctor, I would have been able to explain this to you.
10. If you were a wrestler, you would have been a world champion.
11. If you were a billionaire, what would you have done?

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг уншаад загварын дагуу өөрчилж бич.
(Read the sentences and change them like the sentences in the example.)

-сан бол .....-х байсан	If did ..... would have .....-ed
-аагүй бол .....-хгүй (байх) байсан	If didn't ..... wouldn't have .....-ed

Би хөдөө яваагүй учраас (болохоор) сонирхолтой юм үзээгүй.
Та явсан бол сонирхолтой юм үзэх байсан.

Би хөдөө явсан учраас (болохоор) сонирхолтой юм үзсэн.
Та яваагүй бол сонирхолтой юм үзэхгүй байсан.

1. Бие нь өвдөөгүй учраас Болдхүү эм уугаагүй.
2. Бие нь өвдсөн учраас Болдхүү эм уусан.
3. Хүүхэд бүдэрч унаагүй болохоор уйлаагүй.
4. Хүүхэд бүдэрч унасан болохоор уйлсан.

5. Би өчигдөр театр луу яваагүй болохоор жүжиг үзэж чадаагүй.
6. Би өчигдөр театр луу явсан болохоор жүжиг үзэж чадсан.
7. Тэр миний хэлсэн өгүүлбэрийг ойлгоогүй болохоор инээгээгүй.
8. Тэр миний хэлсэн өгүүлбэрийг ойлгосон болохоор инээсэн.
9. Тэр, монгол хэл сайн сурсан учраас монгол хүмүүстэй ярьж чадсан.
10. Тэр, монгол хэл мэдэхгүй учраас монгол хүмүүстэй яриагүй.

Дасгал 7

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the following pictures.)



Холбох үг (Conjunction)

... яагаад ... юм бэ гэвэл ... (The reason why ... is because ...)

Би **яагаад** Ховд руу явах дуртай юм бэ **гэвэл** Ховд бол миний төрсөн нутаг. (The reason why I like to go to Hovd is because Hovd is my homeland.)

Дасгал 8

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Хүүхдүүдэд яагаад ээж аав хэрэгтэй юм бэ гэвэл тэдэнд ээж аавын хайр хэрэгтэй.
2. Би яагаад биеийн тамирын дасгал хийдэг юм бэ гэвэл дасгал хийх эрүүл мэндэд сайн.
3. Тэр яагаад онгоцоор явах дургүй юм бэ гэвэл тэр өндрөөс айдаг.
4. Би яагаад шинэ машин худалдаж авах гэж байгаа юм бэ гэвэл машин цаг их хэмнэдэг.

Дасгал 9

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Хүмүүс яагаад шашин шүтдэг юм бэ?
2. Хүмүүс яагаад биеийн тамирын дасгал хийдэг юм бэ?
3. Хүмүүс яагаад хотод амьдрах дуртай юм бэ?
4. Та яагаад өнөөдөр монгол хэл сурч байгаа юм бэ?

Гуравдугаар хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-ийн², -(н)ий², -н оронд (instead of, in ... place)

Би **таны оронд** ажиллана.	I will work **in your place**.
Та **энэ номын оронд** тэр номыг унш.	You read that book **instead of this book**.
Хоолонд **сонгинын оронд** сармис хий.	Put garlic in the food **instead of onion**.
Эм **уухын оронд** витамин уу.	Take vitamins **instead of taking** medicine.
Загнахын оронд хүүхэдтэйгээ ярь.	Talk with your child **instead of scolding**.
Чихэртэй ундаа **уухын оронд** ус уу.	Drink water **instead of drinking** sweet drinks.
Би **түүний оронд** байсан бол тамхи татахгүй байсан.	If I were **in his place**, I wouldn't have smoked.
Та **миний оронд** байсан бол яах байсан бэ?	What would you have done if you were **in my place**?
Тэр **таны оронд** байсан бол амжилт гаргахгүй байсан.	If he was **in your place**, he wouldn't have made success.

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, та, оронд байх; уурлах
Би таны оронд байсан бол уурлах байсан. (If I were in your place, I would have gotten angry.)

Би, та, оронд байх, уурлах(гүй)
Би таны оронд байсан бол уурлахгүй байсан. (If I were in your place, I wouldn't have gotten angry.)

1. Би, тэр, оронд байх; монгол хэл, сурах
2. Би, Ганхүү, оронд байх; энэ боломж, ашиглах
3. Би, тэр, хүүхэд, оронд байх; өөрөө, хоол хийх
4. Би, та, оронд байх; галт тэрэг, явах
5. Би, та, оронд байх; машин, өөр газар, тавих
6. Би, тэр, оронд байх; найз, тусламж гуйх
7. Би, та, оронд байх; найз, хангалттай, шатахуун, авах
8. Би, та, оронд байх; гэр, утастах
9. Би, та, оронд байх; найз, туслах
10. Би, тэр, оронд байх; тэр оньсого, тааж чадах
11. Би, тэр, оронд байх; болгоомжтой байх

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, тэр, оронд, хөдөө, явах
*Би **түүний оронд** хөдөө явна. (I will go to the countryside **instead of her**.)*

1. Та, би, оронд, унадаг дугуй, уралдах
2. Тэр, өнөөдөр, та, оронд, хүүхэд, хичээл заах
3. Энэ хүүхэд, тэр хүүхэд, оронд, энэ баг, хөл бөмбөг, тоглох
4. Ганхүү, Сүххүү, оронд, тийшээ, явах
5. Та, газтай ундаа, оронд, ус, уух
6. Чи, мотоцикл, оронд, машин, унах
7. Хүмүүс, мах, оронд, ногоо, идэх
8. Та, энэ, оронд, тэр, энд, тавих
9. Та, машин, оронд, онгоц, явах

Чи зүгээр **суухын оронд** хичээлээ хий. (Do your lesson **instead of** just **sitting**.)

1. Зүгээр ярих; хийх
2. Автобус, явах; троллейбус, явах
3. Шороон зам, явах; засмал зам, явах
4. Хурд нэмэх; хурд хасах
5. Явган явах; унаа, явах
6. Энэ, авах; тэр, авах
7. Нар, суух; сүүдэр, суух
8. Завь, явах; усан онгоц, явах
9. Өөх, идэх; ногоо, идэх
10. Уурлах; тайван байх

Дасгал 3

Зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the pictures.)

Дөрөвдүгээр хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-(а⁴)хаас(аа)⁴ өмнө (Before)

Sentences with same subject:

Subject ..... verb stem + (а⁴)хаасаа⁴өмнө	..... verb
Subordinate clause	Main clause

Би Монголд **ирэхээсээ өмнө** Монголын талаар их судалсан.	I learned much about Mongolia **before I came** to Mongolia.
Та нар хоол идэхээсээ өмнө гараа угаах хэрэгтэй.	You need to wash your hands before you eat food.

Sentences with different subjects:

Subject 2 + ийг², г ..... verb stem + (а⁴)хаас⁴ өмнө	**subject 1** ..... verb
Subordinate clause	Main clause

Намайг **ирэхээс өмнө** манай нөхөр хоёр удаа Монголд ирсэн.	My husband came to Mongolia two times **before I came**.
Хүүхдүүдийг унтахаас өмнө би үлгэр ярьж өгнө.	Before the children go to bed, I will tell a story to them.

Spelling rules:

Verb stems with а, у and я + (а)хаас(аа) →	уухаас(аа), харахаас(аа)
Verb stems with э, ү and и + (э)хээс(ээ) →	үзэхээс(ээ), хийхээс(ээ)
Verb stems with о + (о)хоос(оо) →	орохоос(оо), босохоос(оо)
Verb stems with ө + (ө)хөөс(өө) →	өгөхөөс(өө), өргөхөөс(өө)

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (**-аа⁴**).

Нөхрийг**өө** явахаас өмнө би хоол хийнэ.	I will cook before my husband leaves.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Харанхуй болохоос өмнө ажлаа дуусгаарай.	Please finish your work before it gets dark.

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та хоол идэхээсээ өмнө яадаг вэ?
2. Та гадаа гарахаасаа өмнө яадаг вэ?
3. Та хичээлээ хийхээсээ өмнө яадаг вэ?
4. Та хөдөө явахаасаа өмнө яадаг вэ?

5. Та орой унтахаасаа өмнө яадаг вэ?
6. Өвөл болохоос өмнө малчид яадаг вэ?

Дасгал 2

Тусдаа байгаа өгүүлбэрүүдийг нийлмэл өгүүлбэр болгон бич.
(Make complex sentences out of the separate sentences.)

Жишээ нь:
Би хоол идсэн. Тэрнээсээ өмнө зурагт үзсэн. → Би хоол идэхээсээ өмнө зурагт үзсэн.

1. Тэр хичээл хийнэ. Тэрнээсээ өмнө жаахан амарна.
2. Би ирэх долоо хоногт хөдөө явна. Тэрнээсээ өмнө би тантай уулзана.
3. Та манайд ирээрэй. Тэрнээсээ өмнө утастаарай.
4. Би мартна. Тэрнээсээ өмнө таны номыг өгнө.
5. Би хувцасны шүүгээгээ цэвэрлэнэ. Тэрнээсээ өмнө номын тавиураа янзална.
6. Чи шалаа угаах хэрэгтэй. Тэрнээсээ өмнө шалаа шүүрдэх хэрэгтэй.
7. Та ямар нэг юм хийх хэрэгтэй. Тэрнээсээ өмнө сайн бодох хэрэгтэй.
8. Та баярын ширээ засах хэрэгтэй. Тэрнээсээ өмнө бүтээлгийг нь солих хэрэгтэй.
9. Чи ногоогоо хэрчих хэрэгтэй. Тэрнээсээ өмнө ногоогоо сайн угаах хэрэгтэй.
10. Та шинэ бизнес эхэлж болно. Харин тэрнээсээ өмнө сайн төлөвлөх хэрэгтэй.
11. Тэр манай гэрт ирсэн. Тэрнээс өмнө би хичээлээ хийж байсан.
12. Хичээл өглөө 9 цагт эхэлдэг. Тэрнээс өмнө би сургууль дээрээ очих ёстой.
13. Багш хичээлээ 9 цагт эхэлдэг. Тэрнээс өмнө бүх оюутан ширээндээ суудаг.
14. Ээж удахгүй ирнэ. Тэрнээс өмнө би эвдэрхий сандлаа засна.
15. Удахгүй бороо орно. Тэрнээс өмнө чи гэр лүүгээ явах хэрэгтэй.
16. Цас орсон. Тэрнээс өмнө бид хотод очсон.
17. Нар мандсан. Тэрнээс өмнө би боссон.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. My brother came home before I came.
2. Talk to him about your plan before he leaves.
3. Look at the use by date, before you buy something.
4. She painted the wall before she painted the floor.
5. Measure the paper well before you cut it with scissors.
6. Herders prepare food for animals before winter comes.
7. We need to get there before it gets dark.
8. He had to fix his car before 10 o'clock.
9. Clean the wall before you paste up the wall paper.
10. You need to think before you say something.

11. You need to think before you do something.
12. You need to think before you get angry at someone.
13. You need to wash your hands before you eat.
14. Call me before you come.
15. Please close the windows before you leave.
16. She was learning Mongolian before she came to Mongolia.
17. What do you do before you eat?
18. What do people do before they move to new apartments?
19. What do you prepare before you go on a trip?

Дасгал 4

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох зөвлөгөөг өг. (Give appropriate advice for the given situations.)

Жишээ нь:
Би хөдөө явахдаа цаг агаарын мэдээ сонсдоггүй. → Хөдөө явахаасаа өмнө цаг агаарын мэдээ сонсох хэрэгтэй.

1. Би дэлгүүрээс хүнсний юм авах хэрэгтэй байна.
2. Би олон сар хөдөө ажиллах учраас манай гэр эзгүй байна.
3. Би хүмүүст дандаа юм амладаг.
4. Би өнөөдөр оройн хоолонд пицца хийнэ. Би өмнө нь пицца хийж байгаагүй.
5. Би хатуу үг хэлээд найзыгаа дандаа гомдоодог.
6. Би удахгүй ажилд орно.
7. Бие өвдвөл би эмчид үзүүлэлгүй өөрөө эмийн сангаас эм авч уудаг.
8. Би байр хөлсөлж амьдрах гэж байгаа.
9. Би жолооны үнэмлэх аваагүй байгаа. Харин машин баримаар байна.
10. Би энэ зун их сургуулиа төгсөх гэж байгаа.
11. Би энэ хавар ногоо тарих гэж байгаа.

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-ийн[2] (-(н)ий[2], -н) өмнөөс (for)

Би **багшийнхаа өмнөөс** маш их баярласан.	I was very happy **for my teacher**.
Миний өмнөөс түүнд баяр хүргээрэй.	Please congratulate him for me.
Та найзад маань миний өмнөөс энийг өгөөрэй.	Please give this to my friend for me.
Би чиний өмнөөс Галхүүтэй уулзана аа.	I will meet Galhuu for you.
Би түүний өмнөөс ичиж байна.	I'm embarrased for him.

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Please say hi to him for me.

2. Please ask him for forgiveness for me.
3. Please say thank you to him for me.
4. Please say nice words to my brother for me.
5. Please give this gift to my sister for me.
6. Please shake hands with him for me.
7. Please kiss my son for me.
8. Please give a hug to my friend for me.
9. Please encourage my friend for me.
10. Please give a speech at the meeting for me.
11. I was embarrassed for them.
12. He will worry for you.
13. He will meet with the director for me.
14. I'm giving those flowers to you for your students.
15. I used to do all the work for my brother because he was sick.

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-ийн² (-ний², -ий², -н) төлөө (for (sake of))

Тэд **хүүгийнхээ төлөө** бүхнийг хийдэг.	They do everything **for their son**.
Би найзынхаа төлөө л тийшээ явсан.	I went there only for my friend.
Эрүүл мэндийн төлөө!	For health! (When people cheer)
Ажлын амжилтын төлөө!	For success of the work! (When people cheer)

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Таны эрүүл мэндийн төлөө!
2. Миний төлөө хийсэн бүхэнд чинь баярлалаа, найз минь.
3. Тэр хүн мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй.
4. Хүмүүс эрх чөлөөнийхөө төлөө тэмцдэг.
5. Би энийг чиний ирээдүйн амьдралын төлөө хийж байна.

Дасгал 7

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ төлөө юу хийдэг вэ?
2. Хүмүүс эх орныхоо төлөө юу хийх ёстой вэ?
3. Хүмүүс эрүүл мэндийнхээ төлөө санаа тавьдаг уу?
4. Хүмүүс юу юуны төлөө тэмцдэг вэ?

Тавдугаар хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-сан[4]ы[2](хаа[4]) дараа (After)

Sentences with same subject:

Subject ..... verb stem + сан[4]ы[2](хаа[4]) дараа Subordinate clause	..... verb Main clause
Би хоол **идсэнийхээ дараа** хичээлээ хийсэн.	I did my lesson **after I ate** food.
Би их сургуулиа төгссөнийхөө дараа энэ компанид ажиллана.	I will work in this company after I graduate from my university.
Эхний ажлаа хийж дуусгасныхаа дараа дараагийнхаа ажлыг хийж эхэл.	Start doing your next work after you finish doing your first work.

Sentences with different subjects:

Subject 2 + ийг[2], г ..... verb stem + сан[4]ы[2] дараа Subordinate clause	**subject 1** ..... verb Main clause
Багшийг шинэ хичээл **заасны дараа** оюутнууд олон асуулт асуусан.	**After** the teacher **taught** the new lesson, the students asked many questions.
Чамайг хоолоо идэж дууссаны дараа би чамд зайрмаг өгнө өө.	I will give you an icecream after you finish eating your food.
Намайг "Эхэл" гэж хэлсний дараа та нар зурж эхлээрэй.	After I say "Start," (you all) please start drawing.

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (-**аа**[4]).

Дүүгээ үсээ засуулсны дараа би үсээ тайруулсан. I had my hair cut after my sister had her hair cut.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Бороо орсны дараа тэд гадаа алхах дуртай.	They like to walk outside after it rains.
Хичээл тарсны дараа бид гэр лүүгээ явсан.	We went to our house after the lesson was over.
Энэ киног дууссаны дараа бид гэр лүүгээ явна.	We will go to our house after this movie is over.

Spelling rules:
When -сан[4]ы[2] is used after verb stems that end with vowels or the consonants **м, г, л, в** or **р**, the vowel before **н** is dropped. For example: явсны, ирсний, хаасны

When -сан[4]ы[2] is used after verb stems that end with the consonants **ц, ж, з, с, д, т, ш, ч** or **х** (in цоожоо засаад тушаачих), the vowel before **н** is not dropped. For example: идсэний, түгжсэний, бодсоны, хатсаны, ачсаны

Дасгал 1

Тусдаа байгаа өгүүлбэрүүдийг нийлмэл өгүүлбэр болго.
(Make complex sentences out of the separate sentences.)

Жишээ нь:
Хүүхдүүд хоолоо идсэн. Дараа нь номоо уншсан.
Хүүхдүүд хоолоо идсэнийхээ дараа номоо уншсан.

Хүүхдүүд хоолоо идсэн. Дараа нь ээж аяга таваг угаасан.
Хүүхдүүдийг хоол идсэний дараа ээж аяга таваг угаасан.

1. Тэр сургуулиа төгссөн. Дараа нь ажил хийсэн.
2. Би баншаа жигнэнэ. Дараа нь бага зэрэг шарна.
3. Махаа чанаарай. Дараа нь утаарай.
4. Би заримдаа монголоор буруу ярьдаг. Дараа нь шууд мэддэг.
5. Хоолоо идээрэй. Дараа нь энэ эмийг уугаарай.
6. Хоолоо идээрэй. Дараа нь амттан идээрэй.
7. Кофегоо сайн хутга. Дараа нь уу.
8. Модоо сайн хэмжээрэй. Дараа нь хөрөөдөөрэй.
9. Өгүүлбэр бичээрэй. Дараа нь шалгаарай.
10. Би ярьсан. Дараа нь найз маань их баярласан.
11. Хүүхдүүд явсан. Дараа нь би тэднийг их үгүйлсэн.
12. Багш самбар дээр үг бичдэг. Дараа нь хүүхдүүд уншдаг.
13. Бороо ордог. Дараа нь шалбааг тогтдог.
14. Цас ордог. Дараа нь хүүхдүүд цасан дээр тоглодог.
15. Бороо зогссон. Дараа нь бид гадаа гарсан.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Please give me this book after you read it.
2. After you think well then you need to make a decision.
3. People sometimes regret what they say after they say it.
4. He didn't do any work after he graduated from his university.
5. He will understand about city life after he comes to the city.
6. He started learning Mongolian after he stayed in Mongolia for one year.
7. After you finish writing the text, please give it to the teacher.
8. Mongolians greet people after they go in a ger.
9. After translating your sentences, please check them.
10. He always smokes after he eats.
11. Use someone's thing after you ask.
12. Mongolians used to buy clothes for babies after they were born.

13. Close the door after all the people come into the hall.
14. Start your lesson after all students are ready.
15. After you cut the meat, cut the vegetables.
16. I will tell you an interesting thing after you eat your food.
17. Go out after it stops rainning.
18. Put your books on the shelf after you wipe the dust off it.
19. I will speak after she finishes speaking.

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-аас[4] хойш/-с(а)наас(аа)[4] хойш (Since)

Тэр **2002 оноос хойш** энд ажиллаж байгаа.	She has been working here **since 2002**.
Би 1991 оноос хойш найзтайгаа уулзаагүй.	I have not seen my friend since 1991.
Тэр их сургуулиа **төгссөнөөсөө хойш** энд ажиллаж байгаа.	He has been working here **since** he **graduated from** his university.
Найзыгаа гуйснаас хойш тэр дахиж тамхи татаагүй.	He has not smoked again since his friend asked him not to.
Бороо орсноос хойш ногоо их сайхан ургаж байна.	The vegetables have been growing very well since it rained.

Note: Spelling rules are the same as the "-с(а)ны" from the previous lesson.

Дасгал 3

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та Монголд хэдэн оноос хойш амьдарч байна (вэ)?
2. Та хэдэн оноос хойш одоогийн энэ ажлаа хийж байна (вэ)?
3. Та хэдэн оноос хойш монгол хэл сурч байна (вэ)?

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Намайг банкинд ажилд орсноос хойш ...
2. Би дунд сургуулиа төгссөнөөсөө хойш ...
3. Би монгол хэл сурч эхэлснээсээ хойш ...
4. Намайг гэртээ нохой тэжээж эхэлснээс хойш ...
5. Тэд машин худалдаж авснаасаа хойш ...
6. Би Монголд ирснээсээ хойш ...
7. Намайг Монголд ирснээс хойш ...
8. Тэр, аав ээжээсээ тусдаа амьдарч эхэлснээсээ хойш ...
9. Тэд гэрлэснээсээ хойш ...

Давтлага хичээл (1–5)

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Тэр, хүүхэд, байх; их өвдөх → Тэр хүүхэд байхдаа их өвддөг байсан.

1. Би, ирэх; ээж, бууз, жигнэх
2. Би, энд, ирэх; урт, үстэй, байх
3. Багш, анги, орох; тэр, мэндлэх
4. Тэр, хөдөө, байх; олон, зураг авах
5. Тэр, энд, амьдрах; тэмцээн, түрүүлэх
6. Би, гэр, байх; найз, утастах
7. Тэр, цонх арчих; болгоомжтой, байх
8. Хүүхэд, уйлах; ээж, санаа зовох

Дасгал 2

Өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given verbs.)

А. … -вал[4] ..... -на
Б. … -сан[4] бол .....-х байсан
В. … -аагүй[4] бол .....-хгүй байсан

If … do ..... will .....
If … did..... would have .....-ed
If … didn't ..... wouldn't have .....-ed

1. Сурах, ярих
2. Мэдэх, тоглох
3. Тоглох, хожих
4. Ядрах, амрах
5. Өлсөх, идэх
6. Зогсох, даарах
7. Даарах, өмсөх
8. Ярих, ойлгох
9. Ирэх, утастах
10. Эхлэх, дуусах
11. Асуух, хариулах
12. Эрэх, олох
13. Эвдрэх, засах
14. Хэлэх, хийх
15. Айх, уйлах

Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences that suit the given situations.)

Жишээ нь:
Би тамхи их татдаг. → Би чиний оронд байсан бол тамхи татахгүй байсан. Тамхи татахын оронд жимс ид.

1. Би дандаа шарсан, хуурсан хоол иддэг.
2. Би хичээлээсээ дандаа хоцордог.
3. Би гэртээ ер нь шалан дээрээ сууж хичээлээ хийдэг.
4. Би үргэлж гэртээ ганцаараа тоглодог. Хүүхдүүдтэй тоглох дургүй.
5. Манай ажлын газар манай гэрээс хол биш. Гэхдээ би дандаа машинаараа явдаг.
6. Би хүмүүстэй ярих дургүй.
7. Би үнэтэй юм худалдаж авах дуртай.
8. Би хичээл хийх их дургүй. Харин найзуудтайгаа тоглох их дуртай.
9. Би хөдөө явах дургүй. Хотод сайхан шүү дээ.

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Юм хийх → Чи юм хийхээсээ өмнө сайн бодох хэрэгтэй.
Чи юм хийснийхээ дараа сайн шалгах хэрэгтэй.

1. Сургуулиа төгсөх
2. Хоол идэх
3. Хүмүүстэй ярих
4. Нүүх
5. Хүүхэдтэй болох
6. Ажлаасаа гарах
7. Дэлгүүрээс юм авах
8. Усанд сэлэх
9. Хүмүүстэй хамтарч ажиллах
10. Хурим хийх

Дасгал 5

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences that suit the given situations.)

Жишээ нь:
Би тэмцээнд түрүүлсэн. → Би чиний өмнөөс маш их баярлаж байна.

1. Ажил олох их хэцүү байсан. Харин өчигдөр би ажилд орсон.
2. Өчигдөр (би) будаа агшаасан чинь түлэгдчихсэн.
3. Би хөршдөө талархлаа илэрхийлж амжаагүй л байна.
4. Найз маань намайг буруу ойлгоод надад гомдчихсон.
5. Миний олон мөрөөдлийн нэг нь биелсэн.
6. Би найзынхаа гэрт очих ёстой байснаа мартчихжээ.

Дасгал 6

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

1. Ажил олсноосоо хойш
2. Ажил олсноос хойш
3. Зээл авснаасаа хойш
4. Зээл авснаас хойш
5. Ан хийхээ больсноосоо хойш
6. Ан хийхээ больсноос хойш
7. Хэл сурснаасаа хойш
8. Хэл сурснаас хойш
9. Кинонд тоглосноосоо хойш
10. Кинонд тоглосноос хойш
11. Дасгал хийж эхэлснээсээ хойш
12. Дасгал хийж эхэлснээс хойш

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I worry about you and your family.
2. I will pray for your health and your work.
3. My parents do everything for me.
4. He needs to do more things for his children.
5. For your success!

Тест (1–5)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Намайг энд ирэхдээ их ядарсан.
Б. Би энд ирэхэд их ядарсан.
В. Би энд ирэхдээ их ядарсан.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Түүнийг явахад би бэлэг өгсөн.
Б. Тэр явахад би бэлэг өгсөн.
В. Түүнийг явахдаа би бэлэг өгсөн.

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Танд өлсвөл хоол хийж идээрэй.
Б. Таныг өлсвөл хоол хийж идээрэй.
В. Та өлсвөл хоол хийж идээрэй.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэд амардаггүй бол ядрах байсан.
Б. Тэд амраагүй бол ядрах байсан.
В. Тэд амрахгүй бол ядрах байсан.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чамайг энд байвал ээж баярлана.
Б. Чамайг энд байбол ээж баярлана.
В. Чамайг энд байсан бол ээж баярлана.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би чи оронд теннис тоглоё.
Б. Би чиний оронд теннис тоглоё.
В. Би чамд оронд теннис тоглоё.

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хоол идэхээсээ өмнө гараа угаа.
Б. Хоол идсэнийхээ өмнө гараа угаа.
В. Хоол идээсээ өмнө гараа угаа.

8. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чамайг дуулахаасаа өмнө би дуулсан.
Б. Чамайг дуулахаас өмнө би дуулсан.
В. Чи дуулахаас өмнө би дуулсан.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Миний өмнөөс түүнд баяр хүргээрэй.
Б. Би өмнөөс түүнд баяр хүргээрэй.
В. Намайг өмнөөс түүнд баяр хүргээрэй.

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би тэр өмнөөс баярласан.
Б. Би түүний өмнөөс баярласан.
В. Намайг түүний өмнөөс баярласан.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та нарт ажлын амжилтын төлөө!
Б. Та нар ажлын амжилтын төлөө!
В. Та нарын ажлын амжилтын төлөө!

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэд хүүгийнхээ төлөө их юм хийдэг.
Б. Тэд хүүдээ төлөө их юм хийдэг.
В. Тэд хүүгээ төлөө их юм хийдэг.

13. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Бид гүйснийхээ дараа хөлөө амраадаг.
Б. Бид гүйхээсээ дараа хөлөө амраадаг.
В. Бид гүйснээсээ дараа хөлөө амраадаг.

14. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүүг минь унтсаны дараа би унтдаг.
Б. Хүүгээ унтсаны дараа би унтдаг.
В. Миний хүүг унтсаны дараа би унтдаг.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Бороо орохоос хойш ногоо их ургалаа.
Б. Бороо орсноос хойш ногоо их ургалаа.
В. Бороо орохын хойш ногоо их ургалаа.

16. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хичээл эхэлснээс хойш битгий гар.
Б. Хичээлийг эхэлснээс хойш битгий гар.
В. Хичээлийн эхэлснээс хойш битгий гар.

Оноо (point): 16/ .....

Зургадугаар хичээл

"нь" нөхцөлийн хэрэглээ (Usages of the Suffix "нь")

нь = his/her/it's/their

Гэр нь хөдөө байдаг.	His/their house is in the countryside.
Би хүүд нь итгэж байна.	I trust his son.

нь = he/she/they

Гарахад нь цас орж байсан.	When he went out, it was snowing.
Ирэнгүүт нь энийг өгөөрэй.	As soon as she comes, please give this to her.

нь = something mentioned earlier

Би кино үзсэн. Дараа нь унтсан.	I watched the movie. After that, I went to bed.
Би кино үзсэн. Өмнө нь хоол идсэн.	I watched the movie. Before that, I ate food.

нь = of them (of a group)

Тэнд таван ном байгаа. Нэг нь минийх.	There are five books. One of them is mine.
Зарим нь ирээгүй.	Some of them didn't come.

verb + нь = verb+ing (Subjective clause)

Их сургуульд сурсан нь дээр.	Studying at university is better.
Уурласнаас инээсэн нь дээр.	It's better to laugh than to get angry.
Тэр энэ ажлыг хэзээ хийх нь надад хамаагүй.	I don't care when he will do this work.

Also it's used a lot in titles.

Улаанбаатарт ирсэн нь	Coming to Ulaanbaatar
Хүүхдүүд элсээр тоглож байгаа нь	The children are playing with sand

нь = your (It shows closeness.)

Найз нь сая ирлээ.	I (who am your friend) just came.
Ээж нь чамд бэлэг авсан.	I (who am your mom) bought you a gift.
Охин нь одоо очиж байна.	I (who am your daughter) am coming now.

Verb(гүй) + нь (ээ) = ((I found out that) ... will (not) ...)

Энэ ажил удахгүй дуусах нь ээ.	(I found out that) this work will finish soon.
Энэ ажил мөд дуусахгүй нь.	(I found out that) this work will not finish soon.
Би энийг хийж чадахгүй нь ээ.	(I found out that) I can't do this.

Note: нь ээ = юм байна

For future tense "нь ээ" is used, but "юм байна" is used for all tenses. For example:

Тэд энд ирэхгүй юм байна.	(I found out that) they will not come here.
Тэд энд ирэх юм байна.	(I found out that) they will come here.
Тэд энд ирсэн юм байна.	(I found out that) they came here.
Тэд энд ирдэг юм байна.	(I found out that) they come here.

Дасгал 1

Биеийн төлөөний үгсийг "нь" нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns with the suffix "нь.")

Жишээ нь:
Түүний гэр 3 дугаар хороололд байдаг. → Гэр нь 3 дугаар хороололд байдаг.
Түүнийг өлсөхөд түүний ээж хоол хийж өгдөг. → Өлсөхөд нь ээж нь хоол хийж өгдөг.

1. Түүний гар хар болчихжээ.
2. Би түүний нэрийг мартчихжээ.
3. Би түүний машинаар явсан.
4. Тэдний яриа сонирхолтой байдаг.
5. Удаан алхсан учраас түүний хөл өвдөж байлаа.
6. Тэдний хүүхдүүд их хүмүүжилтэй.
7. Би тэдний байранд нэг хэсэг амьдарсан.
8. Түүнийг ирэхэд би түүний гэр бүлийнхний талаар асуусан.
9. Тэднийг манайд байх үед би монгол хоолоор дайлсан.
10. Тэднийг явахад тэдний ээж дандаа "Болгоомжтой яваарай" гэж хэлдэг.
11. Түүнийг гэртээ байхад тог тасрав.
12. Түүнийг ажил дээрээ байхад түүний дарга дуудлаа.
13. Тэднийг өглөө босоход тэдний ээж цай чанаж байсан.
14. Түүнийг очиход түүний хичээл эхэлчихсэн байсан.

Дасгал 2

Дараах зургуудыг хараад хэн хэн юу хийж байгаа, тэрнээсээ өмнө юу хийсэн болон дараа нь юу хийхийг бич. (Write about what the people below are doing and what they did before or will do after.)

Жишээ нь:
Гэрэлмаа шоколад идэж байна. Дараа нь найзтайгаа уулзана. Өмнө нь хоол идсэн.



Дасгал 3

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

нэг нь	Нэг нь манай найз.	One of them is my friend.
нэгийг нь	Би нэгийг нь сайн танина.	I know one of them well.
хар нь	Хар нь их үнэтэй байна.	The black one is very expensive.
харыг нь	Би харыг нь авахгүй.	I won't buy the black one.
зарим нь	Зарим нь ирээгүй байна.	Some of them haven't come.
заримыг нь	Багш заримыг нь загнасан.	The teacher scolded some of them.
жижиг нь	Жижиг нь их хоол иддэг.	The small one eats a lot of food.
жижгийг нь	Би жижгийг нь харсан.	I saw the small one.
бусад нь	Бусад нь минийх.	The other ones are mine.
бусдыг нь	Чи бусдыг нь ав.	Take the other ones.
ихэнх нь	Ихэнх нь англи хэл мэднэ.	Most of them know English.
ихэнхийг нь	Би ихэнхийг нь идсэн.	I ate most of it.
бүгд(ээрээ)	Бүгд гадаа байсан.	All of them were outside.
бүгдийг нь	Та бүгдийг нь үзсэн үү?	Did you see all of it?
үлдсэн нь	Үлдсэн нь гадаа гараарай.	The rest, go outside.
үлдсэнийг нь	Би үлдсэнийг нь авч явна.	I will take the rest with me.
аль нь	Аль нь минийх юм бэ?	Which one is mine?
алийг нь	Би алийг нь авах юм бэ?	Which one should I take?

Дасгал 4

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд нөхөж бич. (Write the appropriate words from below in the spaces.)

нэг нь, нэгийг нь
зарим нь, заримыг нь
бүгдээрээ, бүгдийг нь
аль нь, алийг нь
цагаан нь, цагааныг нь
том нь, томыг нь

1. ..... хямд байна.
2. ..... багш.
3. Та ..... зассан уу?
4. Бид ..... олоогүй.
5. ..... гэрт байгаа.
6. Ээж ..... хүлээгээгүй.
7. ..... сонирхолтой байна.
8. ..... өнөөдөр манайд ирнэ.
9. Тэд ..... авахгүй гэж хэлсэн.
10. Тэр ..... идээгүй байна.
11. ..... хаана байна вэ?
12. ..... хэзээ хөдөө явах вэ?
13. Та ..... хийсэн бэ?
14. ..... сонирхолтой вэ?
15. ..... таных вэ?
16. ..... танай байр вэ?
17. Та ..... авмаар байна вэ?
18. Чи ..... авмаар байна уу?
19. Би ..... хараагүй.
20. ..... минийх.

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. There are many people outside of the school. Some of them are students, some of them are teachers. Some of them are sitting and some of them are standing. I know some of them. I saw some of them before.
2. There are books on the table. Three of them are blue and four of them are white. One of them is red. The biggest one (of them) is mine. The smallest one (of them) is my friend's. The red one (of them) is the Mongolian language book. I bought the red one from the store. You may read the blue one. I put the white one on the table.
3. There are four paper birds. I made one of them and she made three of them. Two of them are next to the box and the other two are on the box.
4. There were three apples on the plate. One of them was red and the others were green. I ate one of them and my sister ate two of them.
5. There are some shirts. I want to buy the yellow one because the yellow one is pretty. He wants to buy two of them. She wants to buy the big one. The big one is on the table.
6. The long one is mine. I bought the long one yesterday.
7. All of them look nice. I want to buy all of them.

Дасгал 6

Загварын дагуу асуулт, хариулт зохион багштайгаа ярилц.
(Make questions and answers like the example and talk to your teacher.)

Жишээ нь:
А: —Хотод амарсан нь дээр үү, хөдөө амарсан нь дээр үү?
Б: —Хотод амарснаас хөдөө амарсан нь дээр.
А: —Яагаад?
Б: —Яагаад гэвэл хөдөө агаар их сайхан байдаг.

1. Гэрт амьдрах, байранд амьдрах
2. Хөзөр тоглох, шатар тоглох
3. Онгоцоор явах, машинаар явах
4. Гэртээ хоол идэх, гуанзанд идэх
5. Уурлах, инээх
6. Загнах, гар хүрэх
7. Ярих, шийтгэх
8. Ярих, ярих(гүй)
9. Хаях, ашиглах
10. Доромжлох, ерөөх
11. Хүлээх, хүлээх(гүй)
12. Хувцас эвхэх, өлгөх
13. Жүжигчин болох, ажилчин болох
14. Асуулт асуух, дуугүй байх
15. Агаар хуурай байх, чийглэг байх
16. Өндөг чанах, өндөг шарах
17. Уучлал гуйх, дуугүй байх
18. Сонсох, ярих

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг уншаад ямар нөхцөл байдалд хэлж болохыг бич.
(Read the sentences and write in what situations they can be used.)

Жишээ нь:
Энэ хүн их сайхан зурдаг юм байна. (Тэр хүний зурсан зургийг үзээд сайхан зурдгийг нь мэдэж авсан.)

1. Энд их бороо орсон юм байна.
2. Би энэ, энийг идэж чадахгүй нь ээ.
3. Та нар авъяастай юм байна.
4. Тэр, онгоцны билет аваагүй юм байна.
5. Энэ чийдэн асахгүй нь ээ.
6. Энд хүн амьдардаггүй юм байна.
7. Та нар үнэнч юм байна.
8. Энэ байр их хүйтэн юм байна.
9. Энэ цамц их үнэтэй юм байна.
10. Нислэг хойшилсон юм байна.
11. Найз маань марк цуглуулдаг юм байна.
12. Би хичээлээ ойлгохгүй нь ээ.
13. Тэднийх нэг хүүхэдтэй юм байна.
14. Миний мөнгө хүрэхгүй нь ээ.
15. Тэр үнэнээ хэлэхгүй нь ээ.
16. Тэр захиаг минь авсан юм байна.

Дасгал 8

Сурсан нөхцөлөө ашиглан доорх нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич.
(Write appropriate sentences for the situations below using the suffix you have learned.)

1. Хүүхэд чинь өвдөөд та хичээлдээ очиж чадахгүй болжээ.
2. Та математикийн хичээлд сууж байна. Нэг тоог та бодож чадахгүй байна.
3. Та найзынхаа гэрт очих ёстой байсан боловч ажил гараад очиж чадахгүй болсон.
4. Таны бие өвдөөд найздаа тусалж чадахгүй болжээ.
5. Та нэг үгийг зөв хэлэх гэж их хичээсэн боловч хэлж чадахгүй байна.
6. Найз чинь танд өөрийнхөө чанасан цайг өгсөн боловч цай шорвог байсан болохоор та ууж чадахгүй байна.
7. Найз чинь бичиг баримт орчуулаад өгөөч гэж танаас гуйжээ. Харин та орчуулж чадахгүй байжээ.
8. Та явж байгаа машин дотор, цаасан дээр юм бичих гэж оролдсон боловч бичиж чадахгүй байна.
9. Найз чинь танд шинэ тоглоом зааж өгсөн боловч та тоглож чадахгүй байна.
10. Таны хөл өвдөж байсан боловч та багаа бодоод тэмцээнд орсон. Харин жаахан тоглоод хөл чинь улам их өвдөөд тоглоход хэцүү болжээ.
11. Эм уусан боловч таны шүдний өвчин намдахгүй байна.
12. Гадаа маш их чимээтэй байсан учраас та унтах гэж хичээсэн боловч чадахгүй байна.
13. Хаалганы цоож эвдэрсэн учраас та онгойлгох гэж хичнээн хичээгээд ч онгойлгож чадахгүй байна.
14. Яаралтай явах хэрэгтэй байсан боловч машин чинь асахгүй байна.
15. Бороотой, салхитай байсан учраас найзын чинь суух ёстой онгоц цагтаа хөөрч чадахгүй болжээ.

Долдугаар хичээл

Санаа бодлоо хэрхэн илэрхийлэх нь (How to Express One's Opinion)

... гэж би бодож байна.	**I think that ...**
Энэ ном сайн ном гэж би бодож байна.	I think this book is a good book.
Та юу гэж бодож байна (вэ)?	What do you think?
Би бас тэгж бодож байна.	I think so.
Би тэгж бодохгүй байна.	I don't think so.
... гэж би найдаж байна.	**I hope that ...**
Удахгүй дулаарна гэж би найдаж байна.	I hope it will get warm soon.
Би бас тэгж найдаж байна.	I hope so.
Би тэгж найдахгүй байна.	I don't hope so./I hope not.
... гэдэгт(ээ) би итгэж байна.	**I believe that ...**
Энийг хийж чадна гэдэгт тань би итгэж байна.	I believe that you can do this.
Би энийг хийж чадна гэдэгтээ итгэхгүй байна.	I don't believe that I can do this.
Миний бодлоор ...	**In my opinion, ...**
Миний бодлоор энэ тийм том асуудал биш.	In my opinion, this is not too big of an issue.
Миний бодлоор энийг ингэж хийвэл дээр.	In my opinion, it's better if (we) do this this way.
Миний хувьд ...	**For me, ...**
Миний хувьд аль нь ч зүгээр.	For me, either way is fine.
Миний хувьд энэ саналаас татгалзах зүйлгүй.	For me, I have no reason to refuse this suggestion.
... байх аа	**1. Probably 2. I think 3. Maybe**
Тэд энэ санааг дэмжих байх аа.	They will probably support this idea.
Тийм байх аа.	Probably yes./I think so.
Үгүй байх аа.	Probably not./I don't think so.
...-ж/-ч байж магадгүй	**Maybe ...**
Тэд намайг ойлгоогүй байж магадгүй.	Maybe they didn't understand me.
Тийм байж магадгүй.	Maybe so.
Үгүй байж магадгүй.	Maybe not.
... юм шиг байна.	**It seems/looks like/sounds like ...**
Бороо орохгүй юм шиг байна.	It looks like it will not rain.
Тийм юм шиг байна.	It seems so.
Үгүй юм шиг байна.	It seems not.
...-х санаатай	**... intend to ...**
Би энэ хавар ногоо тарих санаатай.	I intend to plant vegetables this spring.
Би ирэх жилээс хөдөө ажиллах санаатай.	I intend to work in the countryside from next year.

Дасгал 1

Хэллэгүүдийг ашиглан асуултуудад хариулж бич. (Answer the questions using the expressions.)

1. Хүмүүс яагаад хамт амьдардаг вэ?
2. Хүмүүс яагаад шашин шүтдэг вэ?
3. Хүмүүс яагаад сэтгэлээр их унадаг вэ?
4. Зарим хүн яагаад согтууруулах ундаа хэрэглэх дуртай байдаг вэ?
5. Хүмүүс яагаад бие биенийгээ шүүмжилдэг вэ?
6. Та аз жаргалтай гэр бүл гэж ямар гэр бүлийг хэлэх вэ?
7. Та ямар хүнийг сайн хүн гэж хэлэх вэ?

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

1. Миний жин их нэмэгдэж байгаа.
2. Манай хүүхэд хичээлээ хийх их дургүй.
3. Найз маань компьютер тоглоом тоглох их дуртай. Тэгээд хамт тоглоё гэж надаас гуйдаг. Би найзыгаа гомдоохгүйн тулд дандаа хамт тоглодог.
4. Би химийн хичээлд дургүй. Харин манай ээж аав намайг химич бол гэдэг.
5. Би нөхөр, охинтойгоо таван өрөө байранд амьдардаг. Заримдаа манай байр хэтэрхий том юм шиг санагддаг.
6. Миний зүрх дандаа өвддөг. Харин би ерөөсөө эмчид үзүүлдэггүй.
7. Манай хүүхэд дандаа асуулт асуудаг. Их ядаргаатай.

Дасгал 3

Зурган дээрх хүмүүсийн талаар багштайгаа ярилц. (Talk about the people in the pictures with your teacher.)



Наймдугаар хичээл

Тэмдэг нэрийн бууруулах, эрчимжүүлэх зэрэг (Modification of Adjectives (Diminutive and Intensifying))

	-дуу[2] **(-ish)**	**-втар**[4] **(-ish)**	**-в (very)**
хуучин (old)	хуучиндуу (oldish)	хуучивтар (oldish)	хув хуучин (very old)

Spelling rules:
1. After masculine words "**-дуу**," after feminine words "**-дүү**" are added directly. For example: хардуу, бордуу, уртдуу, хөхдүү, хүйтэндүү, хатуудуу

2. The suffixes **-втар** (after words with a and у), **-втэр** (after words with э, ү and и), **-втор** (after words with о) and **-втөр** (after words with ө) are used directly after words that end with vowels. For example: хатуу → хатуувтар, богино → богиновтор
When they are used after words that end with consonants except for **н**, a vowel is inserted. For example: бор → боровтор, урт → уртавтар
If the word ends with **н**, drop the **н** and add the suffixes. For example: халуун → халуувтар, зөөлөн → зөөлөвтөр, хүйтэн → хүйтэвтэр

3. The suffix **-в** is used after the first single vowel of words. For example: хатуу → хав хатуу, хүйтэн → хүв хүйтэн, эрүүл → эв эрүүл, хар → хав хар

Дасгал 1

Тэмдэг нэрэнд нөхцөлүүдийг залгаж бич. (Add the suffixes to the adjectives.)

Жишээ нь:

шинэ →	А. шинэдүү	Б. шинэвтэр	В. шив шинэ
нарийн →	А. нарийндуу	Б. нарийвтар	В. нав нарийн

1. халуун
2. хөгшин
3. шингэн
4. хүйтэн
5. хатуу
6. гашуун
7. зузаан
8. тарган
9. хурдан
10. зөөлөн
11. бүлээн
12. богино
13. туранхай
14. шар
15. улаан
16. хар
17. ногоон
18. бор

Дасгал 2

Сурсан нөхцөлүүдээ ашиглан асуултад хариулж бич.
(Answer the questions using the suffixes you have learned.)

1. Та хүйтэн өдөр ямар цай уух дуртай вэ?
2. Та халуун өдөр ямар ундаа уух дуртай вэ?

3. Жаахан хүүхдэд хир халуун цай өгвөл зүгээр вэ?
4. Хөргөгчинд ямар ус байж болох вэ?
5. Та өтгөн кофе уух дуртай юу?
6. Шинэ ааруул ямар байдаг вэ?
7. Та ямар талх идэх дуртай вэ?
8. Та ямар өнгөтэй хувцас өмсдөг вэ?
9. Залуу хүмүүс ямар өнгөтэй, ямар хувцас өмсдөг вэ?
10. Танай оронд ямар өнгөтэй машин байдаг (байдаггүй) вэ?
11. Та гэрийнхээ тавилга, ханын цаасыг дүрсэлж хэлнэ үү.
12. Таны цүнхэнд юу юу байна (вэ)?
13. Ямар өнгөтэй хувцсан дээр ямар өнгөтэй хувцас өмсвөл зохимжтой вэ?

Тэмдэг нэрийн давуу зэрэг (Superlative Form)

Хамгийн (-est, most)

Хамгийн том	biggest	Хамгийн ойрхон	nearest
Хамгийн жижиг	smallest	Хамгийн хэцүү	most difficult
Хамгийн сайн	best	Хамгийн дуртай	like the most
Хамгийн муу	worst	Хамгийн дургүй	like the least
Хамгийн өндөр	tallest	Хамгийн хэрэгтэй	need the most
Хамгийн үнэтэй	most expensive	Хамгийн хэрэггүй	need the least

Дасгал 3

Асуултад хариулж, багштайгаа ярилц. (Answer the questions and talk to your teacher.)

1. Танай оронд хамгийн өндөр байшин хэдэн давхар вэ?
2. Танай оронд хамгийн үнэтэй хоол ямар хоол байдаг вэ?
3. Танай орны хамгийн том нуур ямар нэртэй нуур байдаг вэ?
4. Танай оронд хамгийн өндөр настай хүн хэдэн настай вэ?
5. Таны хамгийн сайн найз хэн бэ?
6. Хамгийн муу хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?
7. Танд хамгийн чухал юм юу вэ?
8. Ямар хэл хамгийн хэцүү хэл гэж та боддог вэ?
9. Ямар хэл хамгийн амархан хэл гэж та боддог вэ?
10. Таны хамгийн дуртай спорт ямар спорт вэ?
11. Таны хамгийн дуртай хоол юу вэ?
12. Таны хамгийн дургүй хоол юу вэ?
13. Таны хамгийн дуртай жимс юу вэ?
14. Таны хамгийн дургүй юм юу вэ?
15. Хүмүүст хамгийн хэрэгтэй юм юу вэ?
16. Хүмүүст хамгийн хэрэггүй юм юу вэ?

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

... -ийг²,-г бодвол ... (If compared to ..., ...)

Гэрэлмаа **Батхүүг бодвол** өндөр. (**If compared to Bathuu**, Gerelmaa is taller.)
Намайг бодвол та илүү туршлагатай. (You are more experienced **if compared to me**.)
Өчигдрийг бодвол өнөөдөр дулаахан байна. (If compared to yesterday, today is warmer.)
Эрэгтэй хүмүүс эмэгтэй хүмүүсийг бодвол хүчтэй. (Men are stronger if compared to women.)

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Багшийн ажил, эмчийн ажил
2. Америк хүмүүс, монгол хүмүүс
3. Америк улс, Монгол улс
4. Баавгай, тэмээ
5. Шинэ ааруул, хуучин ааруул
6. Сумочид, бөхчүүд
7. Монгол хэл, англи хэл
8. Хотын хүн, хөдөөний хүн
9. Монгол хоол, солонгос хоол
10. Хүүхдүүд, том хүмүүс
11. Өнөөдөр, өчигдөр
12. Өнгөрсөн өвөл, энэ өвөл
13. Усан онгоц, завь
14. Онгоц, нисдэг тэрэг
15. Хонины мах, үхрийн мах
16. Байр, байшин

Дасгал 5

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Есдүгээр хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-х гэж/-хаар[4](to, in order to)

Би монгол хэл **сурахаар** энд **ирсэн**.
Тэд мах авахаар дэлгүүр лүү сая явчихлаа.
Би тантай нэг чухал юмны талаар ярихаар ирлээ.
Би найзтайгаа уулзахаар гэрт нь очно.
Би монгол хэл **сурах гэж** энд ирсэн.
Тэд модон онгоц хийж сурах гэж их цаг зарцуулсан.
Хүүхдүүд эрдэм ном сурах гэж сургуульд явдаг.

I **came** here **to learn** Mongolian.
They just went to the store to buy meat.
I came to talk with you about one important thing.
I will visit my friend's house to meet her.
I came here **in order to learn** Mongolian.
They spent a lot of time in order to learn how to make a wooden airplane.
Children go to school in order to get an education.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Би и-мэйлээ шалгахаар ...
2. Би дүүдээ номыг нь өгөхөөр ...
3. Тэд хөгжим сонсохоор ...
4. Бид байр түрээслэхээр ...
5. Би угаасан юмаа индүүдэхээр ...
6. Ганхүү загас барихаар ...
7. Хүмүүс балет үзэхээр ...
8. Би ... банкинд очсон.
9. Тэд ... гадаа гарсан.
10. Сурагчид ... ангидаа орно.
11. Манай гэр бүлийнхэн ... хотод ирсэн.
12. Тэр ... хөдөө явдаг.
13. Охин ... гүйсэн.
14. Би ... найзтайгаа уулздаг.

Дасгал 2

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та яах гэж Монголд ирсэн бэ?
2. Та яах гэж монгол хэл сурч байгаа юм бэ?
3. Та яах гэж өдөр бүр дасгал хийдэг юм бэ?
4. Хүүхдүүд яах гэж сургуульд сурдаг вэ?
5. Хүмүүс яах гэж ном уншдаг вэ?
6. Хүмүүс яах гэж гандан руу явдаг вэ?
7. Хүмүүс яах гэж ажил хийдэг вэ?
8. Хүмүүс яах гэж гэрлэдэг вэ?
9. Хүмүүс яах гэж муу юм хийдэг вэ?
10. Хүмүүс яах гэж бие биентэйгээ маргалддаг вэ?

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I went to the store to buy meat.
2. They go at one o'clock to that fast food place to eat lunch.
3. I came here to teach English.
4. They came here to give an interview.
5. Children went out to play football.
6. Teachers and parents sat down in the room to talk.
7. He is sitting at the table to write a letter to his friend.
8. My father will go to the countryside with his friends to catch fish.
9. She took my pen to write her lesson.
10. The dog jumped to catch the stick.
11. Bolormaa got into the bus to go to her school.
12. She came to tell us it will rain tomorrow.
13. We are walking to show the new store to our friend.
14. Children like to go there to listen to nice songs.
15. I will go with my friend to see the museum.
16. He ran to his house to get his bag.
17. Students stood up to sing.
18. The girl got out of the car to pick flowers.
19. She went out to take a walk.
20. Children are laying down to sleep.
21. My friend called me to say he can't come tomorrow for his lesson.

Дасгал 4

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

авч явах	to take with (me, you ...)
авч очих	to take with (me, you ...)
авч ирэх (авчрах)	to bring
авахаар явах	to go to take/buy/get
авахаар очих	to get to somewhere to take/buy/get
авахаар ирэх	to come to take/buy/get

1. What will you take to the countryside with you?
2. What did he take with him to his school?
3. When you go out, you don't need to take lots of money with you.
4. She likes to take candy with her when she goes to the cinema.
5. If they don't take food with them, they will be hungry.
6. What will you take with you for the wedding?
7. I will take toys with me to my friend's house.
8. That woman took her child to the hospital and had the doctor check her.
9. They brought many things here from the countryside.
10. He went to take his book from the school.
11. We are going to go to the store to buy bread.
12. I will go to the school soon to get my younger brother.
13. They will come to take the results of their blood test.
14. She is going to get permission from the director.
15. Maybe she came to get her things.
16. I came to meet you.
17. The students went to ask their teacher about their exam.
18. I went to my friend's house to get my book.
19. He will go there to tell students that they have to come to the school tomorrow.

Аравдугаар хичээл

Тодотгон холбох нөхцөл (Adjective Clause)

Sentences with same subject:

Adjective clauses that emphasize subjects:

[Зургийн хичээл заадаг] багш ирж байна.	The teacher [who teaches the art lesson] is coming.
Зургийн хичээл заасан багш Америкаас ирсэн.	The teacher who taught the art lesson came from America.
Зургийн хичээл заах багш Америкаас ирсэн.	The teacher who will teach the art lesson came from America.
Зургийн хичээл зааж байгаа багш Америкаас ирсэн.	The teacher who is teaching the art lesson came from America.

Adjective clauses that emphasize objects:

Эмэгтэй [дөнгөж сая хийсэн] хоолоо идэж байна.	The woman is eating the food [she cooked just now].
Би өчигдөр зурсан зургаа багшид үзүүлсэн.	I showed my picture that I drew yesterday to the teacher.
Би зурсан зургандаа нэр өгмөөр байна.	I want to give a name to the picture I drew.

Sentences with different subjects:

Adjective clauses that emphasize subjects:

[Миний таньдаг] жолооч ирж байна.	The driver [that I know] is coming.
Миний хэрэглэдэг тооны машин ширээн дээр байна.	The calculator that I use is on the table.
Миний хэрэглэсэн тооны машин ширээн дээр байна.	The calculator that I used is on the table.
Таны уулзах хүн англи хэл мэднэ.	The person that you will meet knows English.

Adjective clauses that emphasize objects:

Жолооч [миний хийсэн] хоолыг идсэн.	The driver ate the food [I cooked].
Багш миний зурсан зургийг үзсэн.	The teacher looked at the picture I drew.
Хүүхдүүд таны зааж байгаа хичээлийг ойлгож байна.	The children understand the lesson you are teaching.
Би таны хийх гэж байгаа хоолыг хийж сурмаар байна.	I want to learn to cook the food you are going to cook.
Хүүхдүүд таны хийж байгаа хоолонд дуртай.	The children like the food you are cooking.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуулж Дасгал 2-оос орчуулгыг харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 2 and correct any mistakes.)

1. Сандал дээр сууж байгаа эрэгтэй хүн зохиолч.
2. Дуу дуулсан эрэгтэй хүн алдартай дуучин.
3. Надтай уулзсан хүүхдүүд миний сурагчид.
4. Энэ байранд амьдрах хүн дуурийн дуучин.
5. Таны хийх гэж байгаа ажил сонирхолтой байх аа.
6. Улаан цамцтай (цамц өмссөн) хүн хэн бэ?
7. Ширээн дээр байгаа аяга минийх.
8. Америкт амьдардаг миний найз зураг зурах их дуртай.
9. Гадаа тоглож байгаа хүүхдүүд баяр хөөртэй байна.
10. Англи хэл мэддэг хүн Монголд олон байдаг уу?
11. Гадаа зогсож байсан охин монгол хэл их сайн мэднэ.
12. Хоол идэж байгаа нохой дохио зангаа сайн ойлгодог.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуулж Дасгал 1-ээс орчуулгыг харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 1 and correct any mistakes.)

1. The man [who is sitting on the chair] is a writer.
2. The man who sang a song is a famous singer.
3. The children who met me are my students.
4. The person who will live in this apartment is an opera singer.
5. The work you are going to do is probably interesting.
6. Who is the person wearing a red shirt?
7. The cup that is on the table is mine.
8. My friend who lives in America likes very much to draw pictures.
9. The children who are playing outside are happy.
10. Are there many people in Mongolia who know English?
11. The girl who was standing outside knows Mongolian very well.
12. The dog that is eating food understands signs well.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Тогтмол алхдаг хүн ...
2. Их хоол иддэг хүн ...
3. Ажил хийх дургүй хүн ...
4. Мөнгөгүй хүн ...
5. Худал хэлдэг хүн ...
6. Үнэн хэлдэг хүн ...
7. Хоол хийж байгаа охин ...
8. Хичээл заах гэж байгаа багш ...

Дасгал 4

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Би ном уншиж байгаа хүүхдийн ээж.
2. Би ном уншиж байгаа хүүхдэд талархаж явдаг.
3. Би ном уншиж байгаа хүүхдээс энийг авсан.
4. Би ном уншиж байгаа хүүхдийг сайн танихгүй.
5. Би ном уншиж байгаа хүүхэдтэй чацуу.
6. Би ном уншиж байгаа хүүхэд рүү бөмбөг шидсэн.
7. Би ном уншиж байгаа хүүхдээр бахархаж байна.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүмүүс ... хүнд дургүй.
2. Хүмүүс ... хүнээс айдаг.
3. Би ... хүнтэй ярих дуртай.
4. Бид ... хүнийг мэднэ.
5. Хүмүүс ... хүн рүү хардаг.
6. ... цүнхэнд олон ном байна.
7. ... цүнхнээс ном аваарай.
8. Би ... цүнхийг авсан.
9. Би гимнастик хийж байгаа охины ...
10. Би гимнастик хийж байгаа охинд ...
11. Би гимнастик хийж байгаа охиныг ...
12. Би гимнастик хийж байгаа охиноос ...
13. Би гимнастик хийж байгаа охинтой ...
14. Би гимнастик хийж байгаа охин руу ...

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуулаад Дасгал 8-аас харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 8 and correct any mistakes.)

1. Энэ миний уншсан ном.
2. Энэ Одхүүгийн (надад) өгсөн тэмдэглэлийн дэвтэр.

3. Энэ тэдний амьдардаг байр.
4. Энэ миний оёсон ширээний бүтээлэг.
5. Энэ миний нэхсэн бээлий.
6. Миний очсон рестораны эзэн солонгос хүн байдаг.
7. Миний сууж ирсэн автобус их хүнтэй байсан.
8. Түүний төрсөн хот эндээс холгүй байдаг.
9. Таны харж байгаа зураг миний аавын зураг.
10. Түүний машинаа тавьдаг зогсоол манаачтай.
11. Таны хичээл зааж байгаа хүүхдүүд 10 настай.
12. Таны буусан зочид буудлын үйлчилгээ сайн.
13. Миний амьдардаг хороолол тохилог.
14. Түүний хийсэн дасгал зөв байсан.
15. Бидний үзсэн кино уйтгартай байсан.
16. Манай эгчийн хийсэн хоол шорвог байсан.
17. Тэдний амьдардаг байр тагтгүй.
18. Манай ээжийн очдог үсчний газар циркийн зүүн талд байдаг.

Дасгал 8

Өгүүлбэрүүдийг орчуулаад Дасгал 7-гоос харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 7 and correct any mistakes.)

1. This is the book that I read.
2. This is the notebook that Odhuu gave me.
3. That is the apartment that they live in.
4. This is the table cloth that I sewed.
5. These are the gloves that I knitted.
6. The owner of the restaurant that I went to is Korean.
7. There were many people on the bus that I rode here.
8. The city he was born in is not far from here.
9. The photo that you are looking at is my father's photo.
10. The parking lot that he puts his car in has a watchman.
11. The children that you are teaching are 10 years old.
12. The service of the hotel that you are in is good.
13. The district that I live in is comfortable.
14. The exercise that she did was correct.
15. The movie that we watched was boring.
16. The food that my sister cooked was too salty.
17. The apartment that they live in has no balcony.
18. The hairdresser that my mother goes to is on the left side of the circus.

Дасгал 9

Өгүүлбэрүүдийг орчуулаад Дасгал 10-аас харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 10 and correct any mistakes.)

Би [авсан] зургаа танд үзүүлмээр байна. (I want to show you the photo I took.)
Би [таны авсан] зургийг үзэж болох уу? (Can I see the photo you took?)

1. Би зурсан зургаа танд үзүүлнэ.
2. Би хийсэн тоглоомоо танд үзүүлсэн.
3. Би худалдаж авсан цүнхээ барьж байгаа.
4. Би сурсан үгээ мартчихжээ.
5. Би худалдаж авсан нарны шилээ дэлгүүрт мартчихжээ.
6. Та сурсан дуугаа дуулаарай.
7. Та хийсэн хоолоо авчраарай.
8. Та уншсан номоо надад өгөөрэй.
9. Та уншсан номоо тэмдэглээрэй.
10. Та асуусан асуултаа давтаж хэлээрэй.
11. Та сурсан хэлзүйгээ давтаарай.
12. Таны сурсан дууг би мэдэхгүй.
13. Таны зурсан зургийг би үзмээр байна.
14. Таны сурсан дууг би сонсмоор байна.
15. Таны худалдаж авсан цамцыг би үзэж болох уу?
16. Таны хэлсэн өгүүлбэрийг би ойлгосонгүй.
17. Таны асуусан асуултыг би ойлгосон.
18. Түүний заасан хичээлийг би ойлгосон.
19. Ээжийн (надад) өгсөн балыг би хаячихжээ.
20. Таны (надад) ярьж байсан рестораныг би олсон.
21. Таны явуулсан картыг би авсан.
22. Миний явуулсан мессэжийг чи авсан уу?

Дасгал 10

Өгүүлбэрүүдийг орчуулаад Дасгал 9-өөс харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the translations in Exercise 9 and correct any mistakes.)

1. I will show you the picture that I drew.
2. I showed you the toy that I made.
3. I have been carrying (using) the bag that I bought.
4. I forgot the words I learned.
5. I forgot the sunglasses that I bought, at the store.
6. Please sing the song you learned.
7. Please bring the food you cooked.

8. Please give me the book you read.
9. Please mark the books you read.
10. Please repeat the question you asked.
11. Please review the grammar you learned.
12. I don't know the song you learned.
13. I want to see the picture you drew.
14. I want to hear the song you learned.
15. Can I see the shirt you bought?
16. I didn't understand the sentence you said.
17. I understood the question you asked.
18. I understood the lesson he taught.
19. I lost the pen my mother gave to me.
20. I found the restaurant you were telling me about.
21. I received the card you sent me.
22. Did you receive the message I sent to you?

Дасгал 11

Өгүүлбэрүүдийг уншаад орчуул. (Read the sentences and translate them.)

1. Явсан нохой яс зуудаг.
2. Үнэнийг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй.
3. Илүүдсэн бүхэн хор болдог.
4. Юу ч асуудаггүй хүн юу ч сурдаггүй.
5. Инээсэн бүхэн нөхөр биш, уурласан бүхэн дайсан биш.
6. Дуудах нэрийг эцэг эх өгдөг, дуурсах нэрийг өөрөө олдог.
7. Өнгөрсөн цаг хугацаа эргэж олдохгүй.
8. Өөрийгөө хүндэлдэггүй хүн, өрөөлийг хүндэлдэггүй.
9. Ичсэн хүн хүн алдаг.

Давтлага хичээл (6–10)

Дасгал 1

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences that suit the given situations.)

Жишээ нь:
Сайн найзынхаа талаар бич. → Найзын маань нэрийг Гэрэлмаа гэдэг. Гэр нь 13-р хороололд байдаг. Аав ээж нь хүүхдийн эмч.

1. Очих дуртай рестораныхаа талаар бич.
2. Нэг хамаатныхаа талаар бич.
3. Очиж байсан нэг улсынхаа талаар бич.

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Улаан нь, улааныг нь
2. Зарим нь, заримыг нь
3. Нэг нь, нэгийг нь
4. Том нь, томыг нь
5. Бүгдээрээ, бүгдийг нь
6. Үлдсэн нь, үлдсэнийг нь
7. Энэ нь, энийг нь
8. Тэр нь, тэрийг нь

Дасгал 3

Нөхцөл байдал бүрт тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

Жишээ нь:
Би найзыгаа уучлахгүй. → Чи найзыгаа уучилсан нь дээр. Чи найзтайгаа яриад уучлалт гуйх хэрэгтэй гэж би бодож байна.

1. Манай хүүхэд их турж байгаа.
2. Надад мөнгө байвал би шууд юм авчихдаг. Тэгээд дараа нь мөнгөгүй болдог.
3. Би англи хэл сайн сурмаар байна. Би яаж гэдгээ мэдэхгүй байна.
4. Хүмүүст үгүй гэж хэлэх найзад маань хэцүү байдаг.

Дасгал 4

Асуултуудыг орчуулаад хариулт бич. (Translate the questions and answer them.)

1. What is the most important thing in life?
2. What is the worst thing in life?
3. What is your favorite thing?
4. When do you drink very hot tea?
5. When do you drink very cold water?

6. How hot (what temperature) food do you give to toddlers?
7. Do you think Mongolians and Americans are the same?
8. Do you think men and women think the same?
9. Do you think adults and children are very different?

Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь:
Хүмүүс яагаад дэлгүүр лүү явдаг вэ? → Хүмүүс юм авах гэж дэлгүүр лүү явдаг./Хүмүүс юм авахаар дэлгүүр лүү явдаг.

1. Хүмүүс яагаад сургуульд сурдаг вэ?
2. Хүмүүс яагаад хоол иддэг вэ?
3. Хүмүүс яагаад ажил хийдэг вэ?
4. Хүмүүс яагаад хулгай хийдэг вэ?
5. Хүмүүс яагаад нэг нэгнийдээ очдог вэ?
6. Хүмүүс яах гэж ширээнд суудаг вэ?

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. ..... эмэгтэй манай гэрт ирсэн.
2. ..... хүмүүс ажил хийх дургүй.
3. ..... хүн англи хэл сайн мэднэ.
4. ..... эрэгтэй хүн дандаа хүмүүст тусалдаг.
5. Би ..... номыг уншсан.
6. Төрхүү ..... хүүхдэд хичээл заадаг.
7. Жаргалмаа..... хүүхдээс асуулт асуумаар байна.
8. Би..... хүний нэрийг мэдэхгүй.
9. Хүүхдүүд ..... байранд амьдардаг.
10. Багш..... хоолыг хийсэн.

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I know the girl who is dancing.
2. The girl who is dancing knows English.
3. The food that is on the table is hot.
4. Who made the food that is on the table?
5. Give this to the teacher who taught the lesson.
6. I want to learn the song you learned.
7. Please teach me the song you have learned.
8. Put the dishes you have washed here.
9. May I see the boots you bought?

Тест (6–10)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. His brother is a doctor.
А. Ах нь эмч.
Б. Ах тань эмч.
В. Ах маань эмч.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Заримыг нь хямд байна.
Б. Зарим нь хямд байна.
В. Зарим хямд байна.

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би хоолоо бүгд нь идчихлээ.
Б. Би хоолоо бүгд идчихлээ.
В. Би хоолоо бүгдийг нь идчихлээ.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чи энийг өөрөө хийсэн нь дээр.
Б. Чи энийг өөрөө хийгээд нь дээр.
В. Чи энийг өөрөө хийдэг нь дээр.

5. I just found out that I can't eat it.
А. Би энийг идэж чадахгүй.
Б. Би энийг идэж чадахгүй нь ээ.
В. Би энийг идэж чадахгүй ээ.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр маргааш хичээлгүй магадгүй.
Б. Магадгүй тэр маргааш хичээлгүй.
В. Тэр маргааш хичээлгүй байж магадгүй.

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр чамд тусалж магадгүй.
Б. Магадгүй тэр чамд тусална.
В. Тэр чамд тусална магадгүй.

8. They are probably home now.
А. Тэд одоо гэртээ байж байх аа.
Б. Тэд одоо гэртээ байгаа байх аа.
В. Тэд одоо гэртээ байна байх аа.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүйтэвтэр
Б. Хүйтэнвтэр
В. Хүйтэнэвтэр

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хуучив хуучин
Б. Хуув хуучин
В. Хув хуучин

11. You are faster if compared to me.
А. Намайг бодвол чи хурдан юм аа.
Б. Чамайг бодвол би хурдан юм аа.
В. Би бодвол чи хурдан юм аа.

12. I came here to study Mongolian.
А. Би энд монгол хэл сурахад ирсэн.
Б. Би энд монгол хэл сурахаар ирсэн.
В. Би энд Монгол хэл сурах ирсэн.

13. Borhuu went out to buy bread.
А. Борхүү авах гэж талх гарсан.
Б. Борхүү гарах гэж талх авсан.
В. Борхүү талх авах гэж гарсан.

14. The child who is running is 13 years old.
А. Хүүхэд гүйж байгаа хүүхэд 13 настай.
Б. Гүйж байгаа хүүхэд 13 настай.
В. 13 настай хүүхэд гүйж байна.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Таны хийсэн хоол амттай байна.
Б. Таныг хийсэн хоол амттай байна.
В. Та хийсэн хоол амттай байна.

16. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чи сурсан дууг би сурмаар байна.
Б. Чиний сурсан дууг би сурмаар байна
В. Чиний сурсан дуу би сурмаар байна.

Оноо (point): 16/ .....

Арван нэгдүгээр хичээл

"-х" дагавар (Suffix "-х")

дээрх = дээр байгаа (байдаг)
Ширээн дээрх ном минийх. (The book on the table is mine.)
Дээрх өгүүлбэрийг орчуул. (Translate the sentence above.)

доорх = доор байгаа
Ширээн доорх хайрцгийг аваарай. (Please take the box under the table.)
Доорх асуултуудад хариул. (Answer the following questions.)

доторх = дотор байгаа
Хайрцган доторх юмнуудыг гаргаарай. (Please take out the things inside the box.)

Дараах = доор байгаа
Дараах өгүүлбэрүүдийг дэвтэртээ хуулж бич. (Copy the following sentences in your notebook.)

хажуудах = хажууд байгаа
Би гэрийнхээ хажуудах ресторанд хоол идсэн. (I ate food at the restaurant next to my house.)

өмнөх = өмнө байгаа/өмнө нь хийсэн
Бид байрныхаа өмнөх талбайг цэвэрлэнэ. (We will clean the square in front of our apartment.)
Бид өмнөх хичээл дээр дуу сурсан. (We learned a song in the previous lesson.)

хойдох = хойно байгаа
Замын хойдох үсчин ер нь их хүнтэй байдаг. (Usually there are many people at the hair dresser which is on the north side of the road.)

урдах = урд байгаа
Урдах замаа сайн хар. (Look closely at the road in front of you.)

гаднах = гадна байгаа
Манай байрны гаднах цэцгүүд гоё харагдаж байна. (The flowers outside of our apartment building look nice.)

наадах = наана байгаа/таны барьж байгаа, **цаадах** = цаана байгаа
Замын наадах дэлгүүрээс мах ав. (Buy meat from the store that is on this side of the road.)
Наадах чинь 10 000 төгрөг. (That (thing you are holding) is 10 000 togrog.)

Голын цаадах айлууд бие биендээ их тусалдаг. (The families on the other side of the river help each other a lot.)

Spelling rules: This suffix is added directly to words ending with vowels and the consonant **р**. For example: өмнө + х = өмнөх, дээр + х = дээрх
When it's added to words ending with the consonant **д**, a vowel is inserted. For example: наад + х = наадах, хажууд + х = хажуудах

Дасгал 1

"Байгаа" гэдэг үйл үгийн оронд "–х" дагаврыг бич. (Write the suffix "–х" in place of the verb "байгаа.")

Жишээ нь:
Хаалган дээр байгаа хаягийг авах хэрэггүй. → Хаалган дээрх хаягийг авах хэрэггүй.

1. Сургуулийн гадна байгаа шат эвдэрчихжээ.
2. Зочид буудлын урд байгаа сандал дээр хүмүүс сууж байна.
3. Манай гэрийн хойно байдаг уул их өндөр.
4. Барималчид замын наана байгаа хөшөөг зассан.
5. Замын цаана байгаа хашааг будах хэрэгтэй байна.
6. Байшин дотор байгаа тавилгуудыг битгий зөөгөөрэй.
7. Энэ саван дотор байгаа усыг аса.
8. Таны өмнө байгаа ширээн дээр олон дэвтэр байна.
9. Сандал доор байгаа цааснуудыг хаяж болохгүй шүү.
10. Цонхны тавцан дээр байгаа цэцгүүдийг услаарай.
11. Хөргөгчин дотор байгаа хоолыг халааж идээрэй.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
... модыг хүүхдүүд хугалчихлаа. → Сургуулийн гаднах модыг хүүхдүүд хугалчихлаа.

1. ... хувцсыг угаагаарай.
2. ... цайг би чанасан.
3. ... номтой адилхан ном ав.
4. ... хогийг хая.
5. ... цасыг цэвэрлэх хэрэгтэй.
6. ... тоглоомыг ах надад өгсөн.
7. ... усыг чи арчаагүй байна.
8. ... цэцгийг энд тавь.
9. ... ханыг цайвар ногооноор буд.
10. ... мөсийг хайлуул.
11. ... зураг их гоё байна.
12. ... мод сайхан ургаж байна.

Дасгал 3

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)




Арван хоёрдугаар хичээл

Давхар тийн ялгал (Double Cases)

Би найз**ын**хаа гэр**т** очсон.	=	Би найз**ынд**аа очсон.
Би найз**ын**хаа гэр **луу** явсан.	=	Би найз**ынх руу**гаа явсан.
Би найз**ын**хаа гэр**ээс** ирлээ.	=	Би найз**ынхаас**аа ирлээ.
Би найз**ын**хаа гэр**ээр** дайрсан.	=	Би найз**ынхаар**аа дайрсан.
Би найз**ын**хаа үзг**ийг** авсан.	=	Би найз**ынхыг**аа авсан.
Би малгай**тай** хүн**тэй** нь ярьсан.	=	Би малгай**тайтай** нь ярьсан.
Би зураг**тай** ном**ыг** нь уншсан.	=	Би зураг**тайг** нь уншсан.
Би зураггүй номыг нь уншсан.	=	Би зураггүйг нь уншсан.
Би шил**тэй** ундаан**аас** нь уусан.	=	Би шил**тэйгээс** нь уусан.
Би шил**тэй** ундаан**д** нь дуртай.	=	Би шил**тэйд** нь дуртай.
Шил**тэй** будг**аар** нь ханаа буд.	=	Шил**тэйгээр** нь ханаа буд.
Уут**тай** чихр**ээс** нь авъя.	=	Уут**тайгаас** нь авъя.
Та чихэргүй талхыг нь ид.	=	Та чихэргүйг нь ид.

Дасгал 1

Өгүүлбэрийн тусагдахуунуудыг давхар тийн ялгалтай болгон бич.
From the following sentences, write down the objects with double cases.)

1. Би эгчийнхээ гэрт хоносон.
2. Тэд хамаатныхаа гэрт баяр тэмдэглэсэн.
3. Хүүхдүүд эмээ өвөөгийнхөө гэрт очиж тоглох дуртай.
4. Хүүхдүүд эмээ өвөөгийнхөө гэрээс 5 цагт гарсан.
5. Сурагчид багшийнхаа гэрийг амархан олсон.
6. Долгормаа хүүгийнхээ гэрт амьдардаг.
7. Энэ шоколадтай зайрмагийг авъя.
8. Манай гэрт дахиад ирээрэй.
9. Би танай гэрт маргааш очиж чамтай тухтай ярина аа.
10. Би тэдний гэрт кино үзэж, шатар тоглоно.
11. Шоколадтай зайрмагаас хоёрыг авъя.
12. Чи махтай пиццаг нь идэж үзээрэй.
13. Чи махгүй пиццаг нь идэж үзээрэй.
14. Чи махтай пиццанаас нь жаахан идээд үз дээ.
15. Би хадмынхаа гэрээр ороод гарсан (дайрсан).

Дасгал 2

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та хэн хэнийд очдог вэ?
2. Хөдөөнөөс ирсэн оюутнууд хэнийдээ амьдардаг вэ?
3. Манай дэлгүүрт зурагтай, зураггүй олон цамц байгаа. Та ямраас нь авах вэ?
4. Манайд хээтэй, хээгүй олон янзын даавуу байгаа. Та ямрыг нь үзэх юм бэ?
5. Энд модон, төмөр, хуванцар гэртэй балнууд байна. Та ямраар нь бичиж үзэх вэ? Та ямрыг нь авах вэ?
6. Манай ресторанд халуун ногоотой, ногоогүй хоол байгаа. Та ямраас нь авах вэ?

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. багшийндаа
2. багшийнх руугаа
3. дүүгийндээ
4. найзынхаасаа
5. хүргэнийдээ
6. ахынхыгаа
7. чихэртэйгээс нь
8. чихэргүйгээс нь
9. бор өнгөтэйгөөр нь
10. нохойтойд нь
11. устай руу нь
12. урт үстэйтэй нь
13. цэцэгтэйг нь
14. цэцэггүйг нь
15. ногоон өнгөтэйд нь
16. хатуу хавтастайгаас нь

Дасгал 4

Доорх зургуудыг харж ярилц. (Look at the following pictures and discuss them.)



Арван гуравдугаар хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-тал[4], -т(а)лаа[4] (until)

Sentences with same subject:

Subject ..... verb stem + т(а)лаа[4] ..... verb
Subordinate clause Main clause

Хүүхдүүд хичээлээ **ойлготлоо** давтсан. The children reviewed their lessons **until** they **understood**.

Та нар ядартлаа ажиллах хэрэггүй. You shouldn't work until you get tired.
Тэр 20 нас хүртлээ аав ээжтэйгээ амьдарсан. He lived with his parents until he turned 20 years old.

Sentences with different subjects:

Subject 2+ийг[2], г ..... verb stem + тал[4] **subject 1** ..... verb
Subordinate clause Main clause

Хүүхдүүдийг **ойлготол** багш тайлбарласан. The teacher explained it **until** the children **understood.**
(Багш хүүхдүүдийг ойлготол тайлбарласан.)
Намайг ярьж дуустал анхааралтай сонс. Listen to me with attention until I finish talking.
Хүрэлхүүг машинаа засаж дуустал би түүнд тусалж, хамт байна. Until Hurelhuu finishes fixing his car, I will help him and stay with him.

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (**-аа**[4]).

Ээжийг**ээ** иртэл хүү унтаагүй. The boy didn't go to bed until his mother came.
Найзы**гаа** иртэл би хүлээнэ. I will wait until my friend comes.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Бороо зогстол бид дотор хүлээсэн. We waited inside until the rain stopped.
Харанхуй болтол тэд малаа хайсан. They looked for their animals until it got dark.
Тэр автобус**ыг** иртэл би буудал дээр байсан. I stayed at the bus stop until that bus came.

Spelling rules:
When –талаа[4] is used after verb stems that end with vowels or the consonants **м, г, л, в** or **р,** the vowel before **л** is dropped. For example: явтлаа, иртлээ, хаатлаа
When –талаа[4] is used after verb stems that end with the consonants **ц, ж, з, с, д, т, ш, ч** or **х** (in доожоо засаад тушаачих), the vowel before **л** is not dropped. For example: идтэлээ, түгжтэлээ, бодтолоо, ачталаа

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Зочдыг энд иртэл ...
2. Зочид энд иртлээ ...
3. Ńайзыгаа утсаар ярьтал ...
4. Манай найз утсаар ярьтлаа ...
5. Намайг унттал ...
6. Би унтталаа ...
7. Жуулчдыг ядартал ...
8. Жуулчид ядартлаа ...
9. Харанхуй болтол ...
10. Жүжиг эхэлтэл ...
11. Бороо зогстол ...
12. Ресторан хаатал ...
13. ... хүмүүс алга ташсан.
14. Жаргалмаа ... сурсан үгээ давтана.
15. Зорчигчид ... суудлаасаа боссонгүй.
16. ... үзэгчид хүлээсэн.
17. ... өвчтөний санаа зовдог.
18. ... хүмүүсийн санаа амардаггүй.

Жич:
Батхүү кино үзээд **үхтэлээ** инээсэн. (Bathuu wacthed the movie and he laughed **to death**.)
үхтэлээ инээх (уурлах, ядрах, айх, өлсөх, цангах, халууцах, даарах, ажиллах, алхах)

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Жүжигчид, ирэх; үзэгчид, хүлээх
2. Охин, унтах; би бүүвэйн дуу, дуулах
3. Би, ойлгох; багш, тайлбарлах
4. Орчуулагч, ядрах; ярих
5. Хоол, болох; хүүхдүүд, тоглох
6. Бороо, зогсох; бид, гэр, байх
7. Тэр, эдгэх; эм, уух
8. Та, найз, уулзах; и-мэйл, бичих
9. Тэр, тайвшрах; юм, угаах
10. Би, үг, цээжлэх; олон удаа, бичих
11. Хийл, тоглож сурах; олон удаа, давтах
12. Тэр, шалгалт, өгөх; сурах бичиг, унших

Дасгал 3

Сурсан нөхцөлөө ашиглан асуултад хариулж бич.
(Answer the questions using the suffix you have learned.)

Жишээ нь:
Та найзыгаа хүлээгээд ирэхгүй бол яадаг вэ? → Би найзыгаа иртэл хүлээдэг.

1. Идэх гэж байгаа шөлтэй хоол чинь халуун байвал та яадаг вэ?
2. Таныг бодоод өгүүлбэрээ хэлж байхад багш чинь тэвчээртэй хүлээдэг үү?
3. Та шинэ үгээ яаж цээжилдэг вэ?
4. Таныг шинэ хэлзүй ойлгохгүй бол багш чинь яадаг вэ?
5. Та кино үзвэл дандаа бүгдийг нь дуусгадаг уу?
6. Хүүхдүүд чинь танаас чихэр гуйгаад, (таныг) өгөхгүй бол яадаг вэ?
7. Хүүхдүүд нь хоолоо идэхгүй бол эцэг эхчүүд яадаг вэ?
8. Үзэгчид дуучдыг дахин дуулуулахыг хүсвэл яадаг вэ?
9. Хүмүүс инээдтэй юм сонсоод яадаг вэ?

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Let's play cards until the food is done.
2. Sit and wait here until the lesson is over.
3. Students have lessons until summer comes.
4. Please look for your pen until you find it.
5. They waited until I came.
6. They watched TV until they went to bed.
7. Don't go out until the rain stops.
8. If you work quickly, you can make ten chairs by (until) next Monday.
9. She lived with her parents until she got married.
10. He really likes to play tennis. He plays until he gets tired.
11. He makes something again and again until he is able to make it well.
12. The doctor said "Take this medicine until you become healthy."
13. Some children cry until they get what they want.
14. They work eight hours from 9:00 to 17:00.
15. It takes three hours from Ulaanbaatar to Darhan by car.
16. Please wait until the student finishes writing the text.
17. Kids, you can't sit on the chairs until their paint dries.
18. We played outside until we felt cold.

Дасгал 5

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Арван дөрөвдүгээр хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-вч (Even though, although)

Verb stem + вч (more in writing)
Verb in any tense + боловч (ч гэсэн, мөртлөө, хирнээ, хэдий ч)

Боловч, ч гэсэн, хэдий ч, -вч and **ч** are used for sentences with both one or two subjects.
Мөртлөө and **хирнээ** are used for sentences with only one subject.

Sentences with same subject:

Subject ..... verb боловч (мөртлөө, хирнээ, ч гэсэн ...)	..... verb
Subordinate clause	Main clause

Тэр туранхай **мөртлөө/хирнээ** их хүчтэй.	**Even though** he is thin, he is strong.
Энхмаа өвчтэй байсан **ч** тэмцээнд оролцсон.	Even though Enhmaa was sick, she participated in the competition.
Тэд олон цаг алхсан **ч гэсэн** ядарсангүй.	Even though they walked many hours, they were not tired.
Тэр ажлаа хурдан хийхийг хүсэ**вч** чадахгүй байна.	Even though he wants to do his work faster, he can't.

Sentences with different subjects:

Subject 2 +ийг[2], г ..... verb боловч (ч гэсэн, хэдий ч, ч)	**subject 1** ..... verb
Subordinate clause	Main clause

Түүнийг үнэнээ хэлэхийг хүсэхгүй байсан ч **ах нь** дахин дахин асуугаад байв.	Even though **he** didn't want to tell the truth, **his brother** kept asking again and again.
Гэрэлмааг хэрэггүй гэсэн ч гэсэн ээж нь түүнд шинэ гутал авч өгчээ.	Even though Gerelmaa said she doesn't have to buy new boots for her, her mother did.

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (**-аа**[4]).

Дэрээр байлдахаа боль гэж ахыг**аа** хэлсэн ч гэсэн хүүхдүүд больсонгүй.	Even though their brother told them to stop fighting with pillows, the children didn't stop.

When a complex sentence has different subjects and if the subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Цахилгаан тасарсан ч сурагчид лаа асааж, хичээлээ хийв.	Even though the electricity was gone, students lit candles and did their lesson.
Цаг агаар сайхан байсан боловч хүүхдүүд гадаа гарсангүй./Цаг агаар сайхан байсан ч гэсэн хүүхдүүд гадаа гарсангүй.	Even though it was nice outside, children didn't go out.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг уншаад орчуул. (Read the sentences and translate them.)

1. Тэр борооны цув өмссөн мөртлөө норчихжээ.
2. Жолооч нар замын хөдөлгөөний дүрмийг мэддэг ч гэсэн/мөртлөө дүрэм зөрчдөг.
3. Улаанбаатар хот том биш ч гэсэн олон сайхан барилгатай.
4. Найзыгаа уурласан ч гэсэн чи тайван байх хэрэгтэй.
5. Тэд нэг орцонд амьдардаг мөртлөө бие биентэйгээ мэндэлдэггүй.
6. Гадаа цас орж байгаа хэдий ч дулаахан байна.
7. Охин ээжийгээ санаж байгаа хирнээ уйлахгүй байна.
8. Энэ хот олон хүнтэй ч гэсэн их цэвэрхэн юм аа.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Кассчин хурдан бичсэн ...
2. Тэр хичээлээс хоцордог ...
3. Би найзыгаа ойлгосон ...
4. Үйлчлүүлэгчдийг уурласан ...
5. Гадаа их салхитай байсан ...
6. Хүүхдүүд хичээлээ давтсан ...
7. Хүмүүс дугаарлаж зогссон ...
8. Гадаа их хүйтэн байгаа ...
9. Тэр хүүхэд 5 настай ...
10. Тэр монгол хүн ...
11. Худалдагчийг хариулт мөнгө өгсөн ...
12. Хүүхэд их чихэр идэх дуртай ...
13. Тэр гутал их үнэтэй байсан ...
14. Тэр саяхан үсээ засуулсан ...
15. Мах түүхий байсан ...
16. Би юм идэх хэрэгтэй ...

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Тэр өвчтэй байх, ажлаа хийх
2. Зам халтиргаатай байх, бид алхах
3. Тэд нар зам сайн мэдэх, хөдөө явах, төөрөх
4. Тэр кино үзэх дургүй, найзтайгаа хамт үзэх
5. Би хоол идэх, дахиад найзтайгаа хамт идэх
6. Тэр намайг харах, хараагүй юм шиг өнгөрөх
7. Найз нь ирэх, тэр юу ч хэлэх(гүй)
8. Гадаа бүгчим байх, дотор сэрүүн байх
9. Хувцас нь томдох, тэр өмсөх
10. Хувцас нь багадах, тэр хадгалах
11. Тэр эмэгтэй 50 настай, 40 настай юм шиг харагдах
12. Жаргалмаа зөвлөгөө өгөх, хүүхдүүд нь зөвлөгөөг нь дагах(гүй)
13. Би зургаа муухай зурах, багш гоё байна гэж хэлэх

14. Бороо их орох, аялал сайхан байх
15. Тэр амлах, амласнаа биелүүлэх(гүй)
16. Юмны үнэ өсөх, ажилчдын цалин нэмэгдэх(гүй)
17. Хүүхэд унах, уйлах(гүй)

Дасгал 4

*Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (**Make sentences** using the following pictures.)*

Арван тавдугаар хичээл

Бүрмөсөн үйлдэх байдал (Completed Action)

Verb stem + чих = already/completely ...

For tenses:

Ганхүү хоол хий**чих**сэн.	[hiitseng]	Ganhuu **already** cooked.
Ганхүү хоол хийчихлээ.	[hiichlee]	Ganhuu just finished cooking.
Ганхүү хоол хийчихнэ.	[hiichin]	Ganhuu will finish cooking.
Ганхүү хоол хийчихсэн байна.	[hiitsembain]	Ganhuu has cooked./Bat will have cooked.
Ганхүү хоол хийчихжээ.	[hiichij]	Ganhuu has cooked.
Ганхүү хоол хийчихсэн байгаа.	[hiitsembaigaa]	Ganhuu has cooked.
Ганхүү хоол хийчихсэн байдаг.	[hiitsembaidag]	Ganhuu has always cooked.
Ганхүү хоол хийчихсэн байсан.	[hiitsembaisang]	Ganhuu had cooked.

For commands

Би хоол хийчихье.	[hiichii]	Let me cook.
Та хоол хийчих.	[hiichih]	You, cook.
Та хоол хийчхээрэй.	[hiicheerei]	You, cook please.
Та хоол хийчхээч.	[hiicheech]	You, cook. (You should cook.)

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

Батхүү ирсэн үү? (Did Bathuu come?)

1. Батхүү ирчихсэн. (Bathuu already came.)
2. Батхүү ирчихсэн байна. (Bathuu has come.)
3. Батхүү ирчихсэн байгаа. Тэр өрөөнд байгаа. (Bathuu has come. He is in that room.)
4. Батхүү өдийд ирчихсэн байдаг. (Bathuu has always come around this time.)
5. Намайг ирэхэд Батхүү ирчихсэн байсан. (When I came, Bathuu had come.)

Угаасан хувцас хатчихсан уу?

1. Угаасан хувцас хатчихсан.
2. Угаасан хувцас хатчихсан байна.
3. Орой угаасан хувцас өглөө гэхэд хатчихсан байдаг.
4. Намайг үзэхэд угаасан хувцас хатчихсан байсан.

Кино эхэлсэн үү?

1. Эхэлчихсэн.
2. Үзээд ирье. (Хэдэн минутын дараа)... Эхэлчихсэн байна.
3. Кино эхэлчихсэн байгаа. Би сая жаахан үзэж байгаад ирлээ.
4. Намайг зурагт асаахад эхэлчихсэн байсан.

Дасгал 2

Доорх гурван цагаас тохирохыг нь цэгийн оронд нөхөж бич.
(Write the correct tense from the following three tenses in the spaces.)

-чихсан байна, -чихсан байдаг, -чихсан байсан

1. —Батхүү! Надад талх аваад ир.
   —За, одоохон. Би аваад ирье. (Хэдэн минутын дараа) Өө, талх дуус...
2. —Захирал явсан уу?
   —Мэдэхгүй. Би үзээд ирье. (Хэдэн минутын дараа) Захирал яв...
3. Биднийг өчигдөр онгоцны буудал дээр очиход онгоц ир...
4. Намайг нэг цагийн дараа ангид ороход хичээл эхэл...
5. Намайг гэртээ ирэхэд ээж дандаа хоол хий...
6. Тэр гэрийн даалгавраа хийсэн үү?
   А. Намайг хэдэн минутын өмнө үзэхэд тэр гэрийн даалгавраа хий...
   Б. Намайг үзэхэд дандаа хий...
   В. Мэдэхгүй. Би үзээд ирье. (Хэдэн минутын дараа) Хий...
7. Би уржигдар ахынхаа гэрт очсон чинь ах маань хөдөө яв...
8. Өглөө намайг босоход эхнэр маань дандаа цай чана...
9. —Охин унтчихсан байна уу?
   —Тийм, унт...
10. Ус буцалсан юм бол уу? Би үзээд ирье. Буцал...
11. Яана аа, уучлаарай. Би таны номыг март...
    Өчигдөр бас таны номыг март.... Энд ирээд мэдсэн.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Wow, it has snowed. When I got up in the morning, it had snowed.
2. Children have come. When I came, children had come.
3. It has become dark. When I went out, it had become dark.
4. Your clothes have become dirty. When I met him, his clothes had become dirty.
5. The lesson has started. When I came, the lesson had started.
6. The students have paid their university fees. When I met the students, they had paid their fees.
7. The electricity has been off. When I left, the electricity had been off.
8. My son has slept. When I entered the room, my son had gone to sleep.
9. Tickets have been sold out. When we got there, tickets had been sold out

Дасгал 4

Өгүүлбэрийн үйл үгийг өнгөрсөн цагийн 3 хэлбэрээр хувиргаж, утгыг нь багштайгаа ярилц.
(Add three past tense suffixes to each verb of the sentences and discuss their meanings with your teacher.)

~ихсан[4] (general), -чихлаа[4] (resent), -чихжээ (not personally witnessed)
Манай найз ирчихсэн. (My friend came.)
Манай найз ирчихлээ. (My friend just came.)
Манай найз ирчихжээ. (I found out that my friend has come.)

1. Багш, явах
2. Засварчин, засах
3. Ус, буцлах
4. Хоол, болох
5. Ус, тасрах
6. Гол, хөлдөх
7. Мөс, хайлах
8. Хурал, дуусах
9. Хувцас, бохир, болох
10. Нүүр, хар, болох
11. Цаг, эвдрэх
12. Файл, устгах

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

-х байсан	would have ...-ed
~ихсан[4] байсан	had ...-ed
~ихсан[4] байх байсан	had been ...-ed

When he came, the meeting had started.
Түүнийг ирэхэд хурал эхэлчихсэн байсан.
If he came on time, the meeting would have started on time.
Түүнийг цагтаа ирсэн бол хурал цагтаа эхлэх байсан.
If he had come on time, the meeting would have started already and would have finished by 5 o'clock.
Түүнийг цагтаа ирсэн бол хурал аль хэдийн эхлээд 5 цаг гэхэд дуусчихсан байх байсан.

1. If he knew how bad cigarettes are for one's health, he would have stopped smoking.
   When he met me, maybe he had stopped smoking.
   If he had seperated from his bad friend when I told him, he would have already stopped smoking by now.
2. When I entered school, I had already learned to ride a horse.
   If I grew up in the countryside, I would have learned to ride a horse.
   If I grew up in the countryside, I would have already learned to ride a horse by now.
3. If he had more time, he would have finished that work.
   If his friend didn't help him, he couldn't have finished that work.
   When we came, he had finished that work.
4. If Bathuu didn't get mad, they would have already decided where to go for their holiday.
   They had already decided where to go for their holiday before Bathuu got mad.
   If Bathuu had not gotten mad, they would have decided quickly where to go.
5. If her alarm rang, she would have already been up when her mother came.
   If her alarm rang, she would have woken up.
   When her alarm rang, she had already woken up.

Давтлага хичээл (11–15)

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг уншаад орчуул. (Read the sentences and translate them.)

1. Ширээн дээрх номуудыг номын тавиур дээр тавь.
2. Доорх өгүүлбэрүүдийг унш.
3. Манай байрны хажуудах дэлгүүр хаалттай байна.
4. Сургуулийн өмнөх моднуудыг услаарай.
5. Торон доторх ногоонуудыг хөргөгчинд хий.
6. Дараах өгүүллэгийг уншаад утгыг нь ярилц.
7. Аяган доторх усыг асгачхаарай.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. She visited her brother's (house).
2. He came from his sister's (house).
3. I will go to my friend's (house).
4. They live in their grandparents' (house).
5. I want to buy from the one with chocolate.
6. Do you want to eat the one with raisins?
7. I like the one with nuts.
8. (Looking at different fabrics) You may make clothes out of the one with flowers.
9. Take the one with water in it.
10. Take the one that has no water in it.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. When I came, a dog had already eaten all the meat.
2. When the dog had eaten all the meat, I came.
3. When I came in the teachers' room, some teachers had already left.
4. When an airplane takes off, passengers have already sat in their seats and they have their seat belts on.
5. When students have cleaned their classroom, the teacher comes.
6. Before it became dark, they had put up their ger.
7. When I got to the cinema, the movie had already started.
8. When I looked at the contract, they had already signed their names.

9. When I go to forest at the end of July, strawberries have ripened.
10. When I come home, my mother will have cooked.
11. Before she came here, she had learned Mongolian.
12. Before you called me on the phone, I had already gotten up.
13. Before I told them, they had watered the plants.
14. Before I asked them, they had put the garbage away.
15. If he had done his homework, he would have gone with us.
16. If I had reminded him, he wouldn't have made that mistake.
17. If he hadn't finished his work, his friends would have helped him.
18. If he hadn't gone to the countryside, he would have watched this interesting concert with us.
19. If it had snowed much, we wouldn't have been able to get there.
20. Even though I had watched this movie, I watched it again with her.

Дасгал 4

Эгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Ганхүүг гэртээ ирэхэд ...
2. Ганхүү гэртээ ирэхдээ ...
3. Ганхүүг гэртээ ирвэл ...
4. Ганхүү гэртээ ирвэл ...
5. Ганхүүг гэртээ иртэл ...
6. Ганхүү гэртээ иртлээ ...
7. Ганхүүг гэртээ ирсэн ч гэсэн ...
8. Ганхүү гэртээ ирсэн ч гэсэн ...
9. Бороо зогсоход ...
10. Бороо зогстол ...
11. Өнөөдөр бороо зогсвол ...
12. Бороо зогссон ч гэсэн ...
13. Чамайг энийг хийж дуусахад ...
14. Чи энийг хийж дуусахдаа ...
15. Чамайг энийг хийж дуусвал ...
16. Чи энийг хийж дуусвал ...
17. Чамайг энийг хийж дуустал ...
18. Чи энийг хийж дуусталаа ...
19. Чамайг энийг хийж дууссан ч ...
20. Намайг голоос загас барихад ...
21. Би голоос загас барихдаа ...
22. Намайг голоос загас баривал ...
23. Би голоос загас баривал ...
24. Намайг голоос загас барьтал ...
25. Би голоос загас барьтлаа ...
26. Би голоос загас барьсан ч гэсэн ...
27. Намайг голоос загас барьсан ч ...
28. Эхнэрээ цай чанахад ...
29. Манай эхнэр, цай чанахдаа ...
30. Эхнэрээ цай чанавал ...
31. Эхнэр, цай чанасан мөртлөө ...
32. Эхнэрээ цай чанасан ч гэсэн ...
33. Эхнэрээ цай чанатал ...
34. Манай эхнэр, цай чанатлаа ...

Тест (11–15)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Торон доторх байгаа юмыг гарга.
Б. Торон доторх юмыг гарга.
В. Торон дотор юмыг гарга.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Гэрийн гаднах модыг усал.
Б. Гэрийн гадна байгаах модыг усал.
В. Гэрийн гадна модыг усал.

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Дэлгүүрийн урдах сандал гоё юм аа.
Б. Дэлгүүр урдах сандал гоё юм аа.
В. Дэлгүүрээс урдах сандал гоё юм аа.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би найзынхаа руу явсан.
Б. Би найзынх руугаа явсан.
В. Би найзын руугаа явсан.

5. I want to buy the one with fruit.
А. Жимстэйг нь авъя.
Б. Жимстэй нь авъя.
В. Жимстэйгээс нь авъя.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэд багшийнхдаа очих хэрэгтэй.
Б. Тэд багшийнаад очих хэрэгтэй.
В. Тэд багшийндаа очих хэрэгтэй.

7. I worked outside until it got dark.
А. Би харанхуй болтол гадаа ажилласан.
Б. Би харанхуй болоход гадаа ажилласан.
В. Би харанхуй болсон ч гадаа ажилласан.

8. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Энийг ойлготлоо унш.
Б. Энийг ойлготол унш.
В. Энийг ойлгож хүртэл унш.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Бид Дархантал мориор явна.
Б. Бид Дархан хүртэл мориор явна.
В. Бид хүртэл Дархан мориор явна.

10. Which one is right in meaning?
А. Тэр жижиг биетэй ч гэсэн их хүчтэй.
Б. Тэр том биетэй ч гэсэн их хүчтэй.
В. Тэр жижиг биш ч гэсэн их хүчтэй.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Мөртлөө энэ чанартай хямд байна.
Б. Энэ чанартай мөртлөө хямд байна.
В. Энэ мөртлөө чанартай хямд байна.

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та хичнээн гуйсан ч тэр туслахгүй.
Б. Таны хичнээн гуйсан ч тэр туслахгүй.
В. Таныг хичнээн гуйсан ч тэр туслахгүй.

13. She has cooked. (You can see the food.)
А. Тэр хоол хийчихсэн байгаа.
Б. Тэр хоол хийчихсэн байна.
В. Тэр хоол хийчихсэн байдаг.

14. I already ate food.
А. Би хоол идсэн.
Б. Би хоол идчихсэн.
В. Би хоол идчихлээ.

15. The lesson had started.
А. Хичээл эхэлчихжээ.
Б. Хичээл эхэлчихсэн байсан.
В. Хичээл эхэлчихсэн байгаа.

16. Oh, I forgot your book.
А. Өө, би чиний номыг мартчихсан.
Б. Өө, би чиний номыг мартчихлаа.
В. Өө, би чиний номыг мартчихжээ.

Оноо (point): 16/ .....

Арван зургадугаар хичээл

Тодорхойгүй төлөөний үг (Indefinite Prowords)

·эн ч (хэний ч, хэнд ч) ...-гүй	no one	ямар ч ...-гүй	none of any kind
·эзээ ч ...-гүй	never	хэдэн ч ...-гүй	no number of
·аана ч (хаашаа ч, хаанаас ч) ...-гүй	no where	аль ч ...-гүй	none
·оу ч (юугаар ч, юунаас ч ...) ...-гүй	nothing	яаж ч ...-гүй	no 'how' (Action was done , but speaker does not want to say how)

Хэн ч ирэх**гүй**.	**No one** will come.
Би **хэзээ ч** тамхи татах**гүй**.	I will **never** smoke.
Миний ном **хаана ч** байх**гүй** байна.	My book is **no where**.
Би дэлгүүрээс **юу ч** авааг**үй**.	I bought **nothing** from the store.
Би дэлгүүрээс ямар ч ном авааг**үй**.	I didn't buy any books from the store.
Би хэдэн ч ном уншаагүй.	I read no number of books.
Тэр хэнд ч итгэдэггүй.	He trusts no one.
Би хэнээс ч тэр тухай асуугаагүй.	I asked no one about that.
Тэр хэнтэй ч уулзмааргүй байна.	He wants to meet no one.
Би хэнийг ч гомдоомооргүй байсан.	I didn't want to offend anyone.
Чи ийм үзгийг хаанаас ч олохгүй.	You will not find this kind of pen from any where.
Би өчигдөр хаашаа ч яваагүй.	I went no where yesterday.
Би аль ч дэлгүүр луу яваагүй.	I didn't go to any store yesterday.

Хэн ч биш. (No one.)	Хаанаас ч биш. (From no where.)
Хэнд ч биш. (To no one.)	Хаана ч биш. (No where.)
Юу ч биш. (Nothing.)	Хэзээ ч биш. (Never.)

But in affirmative sentences with чадах, болох or хамаагүй:

·эн ч → anyone	хаана ч → anywhere	ямар ч → any kind
·эзээ ч → anytime	юу ч → anything	хэдэн ч → any number of

Хэн ч энийг хийж чадна.	**Anyone** can do this.
·эн ч энд ирж болно.	Anyone is allowed to come here.
Би танд **хэзээ ч** тусалж чадна.	I can help you **anytime**.
Та манайд хэзээ ч ирж болно.	You may come to my house anytime.
Тэд **хаана ч** үнэнийг хэлж чадна.	They can tell the truth **anywhere**.
Та хаана ч сууж болно.	You can sit anywhere.
Би юуг ч (хамаагүй) хийж чадна.	I can do anything.
Та найздаа юу ч өгч болно.	You may give anything to your friend.
Бид хэдэн ч өдөр ажиллаж чадна.	We can work any number of days.
Та хэдэн ч өдөр ажиллаж болно.	You may work any number of days.
Чи ямар ч ажлыг хийж чадна.	You can do any kind of work.
Та ямар ч ажил хийж болно.	You may do any kind of work.
Та хэзээ ч хамаагүй ирээрэй.	Please come anytime. (It doesn't matter when.)
Би хаана ч хамаагүй суудаг.	I sit anywhere.
Тэр нохой юу ч хамаагүй иддэг.	That dog eats anything.

Дасгал 1

Асуултуудад үгүйсгэх хариулт бич. (Write negative answers to the questions.)

1. Хэн өчигдөр ирсэн бэ?
2. Хэн энд хог тарьсан бэ?
3. Хэн танд туслах вэ?
4. Та хэнд энэ номыг өгөх вэ?
5. Та хэнд итгэдэг вэ?
6. Та хэнд хичээл зааж байгаа юм бэ?
7. Та хэнд энэ тухай хэлсэн бэ?
8. Та хэнээс айдаг вэ?
9. Та хэнд энийг авсан бэ?
10. Энэ хэний буруугаас болсон бэ?
11. Энэ хэний шугам бэ?
12. Чи хэн рүү цаас шидэв?
13. Багш хэн рүү харж байна вэ?
14. Та хэнтэй уулзав?
15. Та гудамжинд хэнтэй тааралдсан бэ?
16. Та энд хэнтэй амьдрах вэ?
17. Та хэнийг загнадаг вэ?
18. Та хэнийг дуурайдаг вэ?
19. Та дэлгүүрээс юу авсан бэ?
20. Та оройн хоолонд юу идсэн бэ?
21. Та юу уумаар байна вэ?
22. Та уржигдар өглөө юу хийсэн бэ?
23. Та юугаар гэр лүүгээ явах вэ?
24. Та юугаар бичих дуртай вэ?
25. Та энийг юугаар хийсэн юм бэ?
26. Та хаана суумаар байна вэ?
27. Танай гэр хаана байдаг вэ?
28. Та машинаа хаана тавьсан бэ?
29. Та маргааш хаашаа аялах вэ?
30. Та хаашаа онгоцоор нисэх вэ?
31. Та дахиад хэзээ энд ирэх вэ?
32. Та хэзээ мөрийтэй тоглохоо болих вэ?
33. Та хэзээ машин жолоодож сурах вэ?
34. Та хэзээ найзыгаа зодсон бэ?

Дасгал 2

Асуултыг орчуулж, хариул. (Translate the questions and answer them.)

1. What do you want to eat?
2. What do you like?
3. What do you like to do?
4. What can I eat there?
5. What can I buy from there?
6. What did you buy?
7. What can I put here?
8. What are you afraid of?
9. With what may I write my lesson?
10. With what may I eat my food?
11. Out of what can I make flowers?
12. How (by what) can I go there?
13. How did you come here?
14. When can I drive a car?
15. When can I go to a party?
16. When can I delete this file?
17. When will he come here?
18. When will you learn how to swim?
19. When will you help me?
20. When can I wear earrings?
21. Where can I buy a mobile phone?
22. When can I start working?
23. Where can I smoke?
24. Where can I play ?
25. Where did you go yesterday?
26. Where did you throw your garbage?

Дасгал 3

Асуултуудад үгүйсгэх болон батлах хариулт бич.
(Write negative and affirmative answers to the questions.)

Жишээ нь:
1. Хэн энэ ажлыг хийж чадах/болох вэ?
2. Хэн ч энэ ажлыг хийж чадахгүй/болохгүй.
3. Хэн ч энэ ажлыг хийж чадна/болно.

1. Хэн монгол хоол хийж чадах вэ?
2. Хэн цанаар гулгаж чадах вэ?
3. Хэн нисэж чадах вэ?
4. Хэн надад тусалж чадах вэ?
5. Би хэнтэй дээс тоглож болох вэ?
6. Би хэнд хөгжим тоглож өгч болох вэ?
7. Би хэнээс юм асууж болох вэ?
8. Та хэзээ манайд ирж чадах вэ?
9. Би хэзээ танайд очиж болох вэ?
10. Энэ саванд юу хийж болох вэ?
11. Та юу хийж чадах вэ?
12. Юугаар энэ толбыг арилгаж болох вэ?
13. Юугаар чимэглэл хийж болох вэ?
14. Мууранд ямар хоол өгч болох вэ?
15. Хүүхдэд ямар тоглоом өгч болох вэ?
16. Би хэдэн өгүүлбэр хэлж болох вэ?

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
I have never eaten this kind of food before. → Би өмнө нь ийм хоол (ерөөсөө) идэж байгаагүй.

1. I have never cooked this kind of food before.
2. She said she has never met this person before.
3. They have never gone to Darhan before.
4. I have never seen this big a horse before in my life.
5. I have never heard about this terrible criminal before.
6. They had never eaten pizza before I gave it to them.
7. She has never complained about her work before.
8. I have never thought about this before.
9. We have never gone there before.
10. I have never played this game before.
11. He has never studied at any school before.
12. They have never obeyed their parents, I heard.
13. Her heart has never had a problem before.
14. She was never happy like this before.
15. She was never angry like this before.
16. She was never disappointed like this before.
17. She was never tired like this before.
18. She was never sad like this before.

Арван долдугаар хичээл

Тодорхойгүй төлөөний үг (Indefinite Prowords)

хэн нэг(эн) хүн	someone	хаа нэг(эн) газар	somewhere
хэзээ нэгэн цагт	sometime	ямар нэг(эн) юм	something

Энд (**хэн нэгэн**) **хүн** байсан юм шиг байна.	It looks like **someone** was here.
Хэн нэг хүн түүнийг загнасан байх аа.	Probably someone scolded him.
Энэ тухай хэн нэгэн хүнд хэл.	Tell someone about this.
Чи тэр номын талаар хэн нэгэн хүнээс асуу.	You ask someone about that book.
Тийшээ хэн нэгэн хүнтэй хамт яваарай.	Please go there with someone.
Тэр **хэзээ нэгэн цагт** буруугаа ойлгоно..	He will realize his mistake **sometime**.
Та хэзээ нэгэн цагт найзтайгаа уулзана.	You will meet your friend sometime.
Хэзээ нэгэн цагт бүх юм тодорхой болно.	Everything will become clear sometime.
Чиний ном гэрт **хаа нэг газар** байгаа.	Your book is **somewhere** at home.
Найз чинь энэ дэлхийн хаа нэг газар байгаа.	You friend is somewhere in this world.
Энийг өрөөндөө хаа нэг газар тавь.	Put this somewhere in your room.
Тэр надаас **ямар нэг юм** нуугаад байна.	He is hiding **something** from me.
Тэр чамаас ямар нэгэн юм асуусан уу?	Did he ask you something?
Чи тэр дэлгүүрээс ямар нэгэн юм ав.	Buy something from that store.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. If someone knocks on the door late at night, don't open it.
2. I think someone was here, in my room.
3. Someone took my wallet.
4. If someone offends you, please tell me.
5. Your pen is somewhere in this room. Look for it again.
6. Hide this somewhere in this fence. I will find it.
7. I hope you will meet your friend sometime, somewhere.
8. He will understand his parents sometime.
9. She will come and ask you for forgiveness sometime.
10. I need to say something for my friend.
11. Did you find something from there?
12. Will you buy something for your friend?
13. I think he wants to say something to us.
14. It seems they are hiding something from us.
15. If something happens, call me.

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдлуудыг уншаад өөрийн бодлоо бич. (Read the given situations and write your opinions.)

Жишээ нь: Баярхүү цагдаагийн газар байна. → Тэр ямар нэгэн муу юм хийсэн байх.

1. Жаахан хүүхэд гадаа суугаад уйлж байна.
2. Ангид байгаа хүүхдийн нүүр их улайсан байна.
3. Сургуулийн жижүүр их ууртай байна.
4. Найз чинь онгоцны тасалбар худалдан авч байна.
5. Тэр хүү дандаа өөрөөсөө жаахан хүүхдүүдийг зоддог.
6. Найз маань ерөөсөө хичээлээ тасалдаггүй. Харин өнөөдөр хичээлдээ ирсэнгүй.
7. Ширээн дээр байсан миний цүнх алга болчихжээ.
8. Би сонгодог хөгжмийн концерт ерөөсөө үзээгүй.
9. Манай ээж аав надад дандаа юу хийх ёстойг минь заадаг.
10. Нэг байшингийн гадна талд бөөн хүн зогсож байна.
11. Маргааш манай найзын төрсөн өдөр. Би яах вэ?
12. Би нүдний шилээ хайгаад олохгүй байна.
13. Надад дотно найз байдаггүй учраас би их ганцаарддаг.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

1. Хэн нэгэн хүн
2. Хэн нэгэн хүнээс
3. Хэн нэгэн хүнд
4. Хэн нэгэн хүнтэй
5. Хэн нэгэн хүний
6. Хэн нэгэн хүнийг
7. Хэн нэгэн хүн рүү
8. Хаа нэгэн газар
9. Хаа нэгэн газраас
10. Хаа нэгэн газар луу
11. Хэзээ нэгэн цагт
12. Ямар нэгэн юм
13. Ямар нэгэн юманд
14. Ямар нэгэн юмнаас
15. Ямар нэгэн юмаар
16. Ямар нэгэн юмтай

Дасгал 4

Зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the pictures.)



Арван наймдугаар хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-аас[4] гадна (as well as, besides)

Тэр **англи, монгол хэлээс гадна** орос хэл мэднэ.
Манай ангид **надаас гадна** хоёр монгол оюутан байдаг.
Баярхүү сайн **дуулахаас гадна** сайн бүжиглэж чаддаг.
Гэрэлмаа мал **сааж сурахаас гадна** цагаан идээ хийж сурсан.

He knows Russian **as well as English and Mongolian**.
There are two Mongolian students in my class **besides me**.
Bayarhuu can dance well **besides singing** well.

Gerelmaa learned to make milk products **besides learning to milk** livestock.

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та монгол хэлээс гадна ямар ямар хэл мэдэх вэ?
2. Та Монгол улсаас гадна аль аль улсад амьдарч байсан бэ?
3. Та Монголд хэл сурахаас гадна өөр юу хийдэг вэ?
4. Бууз хийхэд мах, гурилаас гадна өөр юу юу хэрэгтэй вэ?
5. Зураг зурахад харандаа, цааснаас гадна өөр юу юу хэрэгтэй вэ?
6. Жин хасахыг хүсч байгаа хүмүүс хоолондоо анхаарахаас гадна өөр яах хэрэгтэй вэ?
7. Жолооч хүн замын хөдөлгөөний дүрмээс гадна юу мэдэх шаардлагатай вэ?
8. Жүжигчин хүн сайн жүжиглэхээс гадна юу юу хийж чаддаг байх хэрэгтэй вэ?
9. Эмэгтэй хүн хоол хийж сурахаас гадна өөр юу юу хийж сурах хэрэгтэй вэ?

Дасгал 2

Сурсан шинэ үгээ ашиглан өгүүлбэрүүдийг дэлгэрүүлж бич.
(Make the sentences longer using the new word you have learned.)

Жишээ нь:
Хүүхдүүд хичээлээ сайн хийх хэрэгтэй. → Хүүхдүүд хичээлээ сайн хийхээс гадна аав ээждээ туслах хэрэгтэй.

1. Хүмүүс түрийвчиндээ мөнгө хийдэг.
2. Хүмүүс савхаар хоол иддэг.
3. Даавуугаар хувцас хийдэг.
4. Хүмүүс ядрахгүйн тулд хоол сайн идэх хэрэгтэй.
5. Эрэгтэй хүмүүс бяртай байдаг.
6. Эмэгтэй хүмүүс урт үстэй байдаг.
7. Өвлийн хүйтэнд хүмүүс дулаан гутал, малгай, бээлий өмсөх хэрэгтэй.
8. Хүүхдэд аав ээж хэрэгтэй.

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-аас[4] бусад (except for)

Тэр дэлгүүр **бүтэн сайнаас бусад** бүх өдөр онгойдог.
Тэд **энэнээс бусад** бүх номыг уншсан.
Би **хараас бусад** бүх өнгөнд дуртай.
Чамаас бусад бүх хүн хуралд ирсэн.
Тэр юм **оёхоос бусад** бүх ажлыг хийж чадна.
Тэр **хоол хийхээс бусад** бүх гэрийн ажлыг хийх дургүй.

That store opens all days **except for Sunday**.

They read all books **except for this one**.
I like all colors **except for black**.
All people came to the meeting **except for you**.
She can do all work **except for sewing** things.
He doesn't like doing any house work **except for cooking**.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Буузнаас бусад монгол хоол → Би буузнаас бусад монгол хоолыг хийж чадахгүй.

1. Маргаашаас бусад өдөр
2. Надаас бусад бүх оюутан
3. Монголоос бусад улс
4. Найман сараас бусад бүх сар
5. Муурнаас бусад бүх амьтан
6. Нохойн махнаас бусад бүх мах
7. Алимнаас бусад бүх жимс
8. Мөнгөнөөс бусад бүх юм
9. Унаанаас бусад бүх юм
10. Антрактидаас бусад бүх тив
11. Манай орцноос бусад бүх орц
12. Энэ шүүгээнээс бусад бүх тавилга

Дасгал 4

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ нь:
Та ямар ямар монгол хөгжим тоглож чаддаг вэ? → Би морин хуураас бусад бүх монгол хөгжмийг тоглож чадна/чадахгүй.

1. Та хэддэх хэддэх өдөр хичээлтэй байдаг вэ?
2. Та ямар ямар хэл мэдэх вэ?
3. Та аль аль улсад очиж байсан бэ?
4. Та ямар ямар ажил хийж байсан бэ?
5. Нарантуул зах дээр юу юу байдаг вэ?
6. Та гэрийн ямар ямар ажлыг хийж чаддаг вэ?
7. Таны ширээн дээр юу юу байдаг вэ?
8. Та ямар ямар дуу сонсох дуртай вэ?
9. Та ямар ямар хоолыг идэж чадах вэ?

Арван есдүгээр хичээл

Хоёрдугаар биеэр төгсгөх нөхцөл

(Second Person-Bound Terminating Suffixes)

Verb stem	(Hard command)
Verb stem + **аарай**[4]	Please
Verb stem + **аач**[4]	1. should 2. I'm begging you to …
Verb stem + **хгүй юү**	Would you please … or why don't you …
Verb stem + **уузай**[2]	Make sure don't …; Be careful, don't …
Verb stem + **в (аа**[4]**)**	Make sure don't …; Be careful, don't …
Verb stem + **на**[4] **уу**[2]	Would you please (In formal speach or writing)
Verb stem + **гтун**[2]	Please (In formal speach or writing)

Чи гэрт ор.	You go in the house.
Гэрт ороорой.	Please go in the house.
Гэрт орооч.	You should (or I'm begging you to) go in the house.
Тэрийг аваад өгөөч.	Would you pass that for me.
Та гэрт орохгүй юү.	1. Would you please go in the house. 2. Why don't you go in the house.
Мориноос унуузай.	Be careful. Don't fall off the horse.
Мориноос унав аа.	Be careful. Don't fall off the horse.
Миний номыг мартуузай.	Make sure, don't forget my book.
Миний номыг мартав аа.	Make sure, don't forget my book.
Гутлаа арчина уу!	Please wipe off your shoes!
Энийг үргэлж санагтун.	Please remember this all the time.

Note: When verb stem is said twice, it expresses softer command.

Чи гэрт ор ор.	You go in the house.

Дасгал 1

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох өгүүлбэрүүдийг бич. (Write sentences that suit each situation.)

Жишээ нь:
Би өлсөж байна. → 1. Хоол ид. 2. Хоол идээрэй. 3. Хоол идээч. 4. Хоол идэхгүй юү.

1. Би даарч байна.
2. Миний цамц урагдчихлаа.
3. Миний дотор муухайрч байна.
4. Миний толгой эргэж байна.
5. Би энд байхаас айгаад байна.
6. Би сандраад байна.
7. Миний оймс цоорчихжээ.
8. Миний хөл өвдөж байна.
9. Миний цүнх алга болчихжээ.
10. Миний цамц урагдчихжээ.
11. Миний мөнгө дуусчихлаа.
12. Миний цаг зогсчихлоо.
13. Миний гутал норчихлоо.
14. Миний гар муухай болчихлоо.
15. Би хоолоо асгачихлаа.
16. Би найзыгаа гомдоочихсон.

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Энэ, засах, өгөх → (Та) энийг (надад) засаад өгөөч. (Would you fix this for me.)

1. Энэ, орчуулах, өгөх
2. Энэ, тайлбарлах, өгөх
3. Барааны саван, авах, өгөх
4. Давс, авах, өгөх
5. Халбага, авах, өгөх
6. Энэ, шалгах, өгөх
7. Энэ хивс, өргөх, өгөх
8. Энэ цаас, онгоц, хийх, өгөх
9. Тавиур дээр, ном, тавих, өгөх
10. Тавиур дээр, ном, авах, өгөх
11. Ээж ээ, ор, засах, өгөх
12. Ээж ээ, ор, хураах, өгөх
13. Энэ өгүүлбэр, засах, өгөх
14. Энэ нүүр гарын алчуур, солих, өгөх
15. Энэ эмийн заавар, унших, өгөх
16. Аав аа, үлгэр, ярих, өгөх
17. Аав аа, зураг, зурах, өгөх
18. Миний шүдний сойз, олох, өгөх
19. Шүүгээний шургуулга, хаах, өгөх
20. Лааз, онгойлгох, өгөх
21. Аяга, цай, хийх, өгөх
22. Энэ ус, арчих, өгөх
23. Энэ, монгол, бичих, өгөх
24. Энэ, цэвэрлэх, өгөх

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Would you fix this for me.
2. Would you correct that for me.
3. Would you close the car door for me.
4. Would you clean the floor for me.
5. Would you break this wood for me.
6. Would you be quite for me.
7. Would you write it down for me.
8. Would you pass salt for me.
9. Would you cut it for me.
10. Would you throw that ball to me.
11. Would you hold this for me.
12. Would you explain this for me.
13. Would you translate this for me.
14. Would you do this work for me.
15. Would you teach a song for me.
16. Would you draw flowers for me.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Миний эгч энэ цэцгийг надад хийж өгсөн. (My sister made this flower for me.)
Надад дуу зааж өгөөрэй. (Please teach a song for me.)
Би тэр дууны үгийг бичиж өгнө өө. (I will write down the words of that song.)

1. I can cook Mongolian food for them.
2. We taught many songs to children.
3. Please buy me a bottle of perfume for my birthday.
4. Please sing for me at the dinner.

5. I want to tell you a real story.
6. My grandmother used to prepare lunch for me when I went to school.
7. She bought a nice gift for her friend.
8. My father fixes my bicycle for me.
9. Please comb my hair tomorrow.
10. He played guitar for me.
11. I taught him the way to get to the park.
12. Please translate this instruction for me when you have time.
13. My grandmother used to read stories for me.
14. When we got married, my husband bought a nice necklace for me.
15. When you come to my house, I will teach you how to cook Italian food.
16. Our teacher explained many things to us.
17. She always buys expensive clothes for her daughter.
18. My brother built a nice house for us.
19. You need to do something good for your friend.
20. They like to make cards for their mother for the holidays.
21. I will wash your clothes for you.
22. I will bring other interesting books for you.

Хоёрдугаар биеэр төгсгөх нөхцөл

(Second Person-Bound Terminating Suffixes)

-уузай[2]/-в (аа)[4] (Be careful. Don't ..., Make sure don't ...)

Модноос унуузай/унав аа.	Be careful. Don't fall from the tree.
Их ажиллаад ядруузай/ядрав аа.	Make sure don't work a lot and be tired.
Хаалгаа түгжихээ мартуузай/мартав аа.	Make sure, don't forget to lock your door.

Spelling rules:
-уузай[2] (хар + уузай = харуузай, уна + уузай = унуузай, нээ + үүзэй = нээгүүзэй)
-в (аа) (хар + в = харав, уна + в = унав, хаа + в = хаав)

Дасгал 5

"-уузай[2]/-в аа[4]"нөхцөлүүдийг ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио.
(Make sentences out of the given words using the suffixes "-уузай[2]/-в аа[4]")

1. Мориноос унах
2. Хичээлээсээ хоцрох
3. Түлхүүрээ мартах
4. Нүдний шилээ хагалах
5. Үзгээ хугалах
6. Тоглоомоо эвдэх
7. Муухай үг хэлэх
8. Хуруугаа зүсэх
9. Гал гаргах
10. Найзыгаа цохих
11. Мөнгөө гээх
12. Хоолоо асгах
13. Хэлээ түлэх
14. Хувцсаа муухай болгох

Дасгал 6

Доорх нөхцөл байдлуудад тохирох өгүүлбэрүүдийг бич. (Write sentences that suit each situation.)

Жишээ нь:
Найз чинь цонх угааж байна. → Цонх хагалуузай.

1. Хүүхэд хашаан дээгүүр явж байна.
2. Хүүхэд нойтон шалан дээр гүйж байна.
3. Хүүхэд шүдэнз зурж байна.
4. Хүүхэд хутгаар тоглож байна.
5. Хүүхэд дэлгүүрээс юм авахаар явж байна.
6. Найз чинь машинаар хурдан давхидаг.
7. Найз чинь бодолгүй үг хэлдэг.
8. Найз чинь халуун хоол яаран идэж байна.
9. Найз чинь гар утсаа гаднах халаасандаа хийж байна.
10. Найз чинь нохойгоо салхинд гаргах ёстой.
11. Хүү чинь байрныхаа мөнгийг төлөх ёстой.

Дасгал 7

Зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the pictures.)



Дасгал 8

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Гэрэл, унтраах, мартах → Гэрлээ унтраахаа мартуузай/мартав аа. (Make sure don't forget to turn off the light.)

1. Дулаан хувцас, авч явах, мартах
2. Цонх, хаах, мартах
3. Түлхүүр, авах, мартах
4. Би, утастах, мартах
5. Эм, уух, мартах
6. Гар, угаах, мартах
7. Гэр, шүүрдэх, мартах
8. Хоолны сав, таглах, мартах
9. Сэрүүлэг, тавих, мартах
10. Гутал, арчих, мартах
11. Мөнгө, төлөх, мартах
12. Мах, хөлдөөгч, хийх, мартах

Хорьдугаар хичээл

Гуравдугаар биеэр төгсгөх нөхцөл (Third Person-Bound Terminating Suffixes)

Verb stem + **г**	Let (him/her/it) …
Verb stem + **тугай**[2]	May …
Verb stem + **аасай**[4]	I wish …

Тэр энд сууг.	Let him sit here.
Тэр дуртай хоолоо захиалаг.	Let her order the food she likes.
Энхмаа найзыгаа гаргаж өгөг.	Let Enhmaa send off her friend.
Монгол орон мандтугай.	May Mongolia rise.
Мөрөөдөл чинь биелэх болтугай.	May your dream come true.
Тэр зорилгодоо хүрэх болтугай.	May he achieve his goal.
Бороо ороосой.	I wish it would rain.
Ээж минь хурдан ирээсэй.	I wish my mother would come quickly.
Найз маань хурдан эдгээсэй.	I wish my friend would be healed quickly.

Spelling rules:

The suffix –**г** is used directly after verb stems that end with vowels and when it's used after verb stems that end with consonants, vowel is inserted. For example: хаа + г = хааг, сана + г = санаг, мэд + г = мэдэг, өг + г = өгөг, ол + г = олог, уз + г = узэг

The suffixes –**тугай** (for verb stems with а, о, у and я) and -**түгэй** (for verb stems with э, ө, ү and и) are used directly after all verb stems. For example: яв + тугай = явтугай, асуу + тугай = асуутугай, эхэл + түгэй = эхэлтүгэй, өг + түгэй = өгтүгэй, хий + түгэй = хийтүгэй

Дасгал 1

Цэгийн оронд "г" нөхцөлийг бичээд өгүүлбэрүүдийг орчуул.
(Add the suffix "г" in the spaces and translate the sentences.)

1. Хүү маань унт…
2. Тэр миний хэлснийг сайн бод…
3. Тэр миний цагийг зүү…
4. Гэрэлмаа тэр тухай мэд…
5. Тэр хүн асуулт асуу…
6. Тэр бодсон юмаа ярь…
7. Төрхүү тэр баримтат киног уз…
8. Энхмаа хичээл заа…
9. Тэр өөрөө сургуулиа сонго…
10. Тэр, ногооны талбайгаа цэвэрлэ…
11. Тэр энд үлд…
12. Долгормаа эмчид үзүүл…
13. Сүхээ өөрөө шийд …
14. Тэр, тэмцээнд оролц …

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох өгүүлбэрүүдийг бич. (Write sentences that suit each situation.)

Жишээ нь:
Хүүхдүүд амармаар байна гэнэ ээ. → Хүүхдүүд амраг.

1. Хүү чинь найзтайгаа кинонд явна гэнэ ээ.
2. Охин чинь угаалгын машинаар биш, гараараа юмаа угаана гэнэ ээ.
3. Гэрэлмаа өрөөг чинь янзална гэнэ ээ.
4. Хүү чинь бууз жигнэнэ гэнэ ээ.
5. Тэр, хүүхэлдэйн кино үзнэ гэнэ ээ.
6. Охин чинь машин барина гэнэ ээ.
7. Сандал дээр чинь тэр хүүхэд суумаар байна гэнэ.
8. Тэр таны хэрэгтэй цаасыг хаях гэж байна.
9. Найз чинь чиний гацуур модыг чимэглэнэ гэнэ.
10. Энхмаа ногоогоо биш, махаа эхлээд хуурна гэнэ.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Let the child eat food first.
2. She sings very well. Let her sing.
3. Let her clean her room herself.
4. Let him fix the chair which he broke.
5. Let him think about this.
6. Let it rain. I like rain.
7. You played many times. Let your friend play.
8. He worked too much. Let him rest.
9. Let him wait for his friend inside. It's cold outside.
10. She knows the road to Hovsgol lake very well. Let her drive.
11. Don't cut the flower that is on the table. Let it grow.
12. Don't kill that deer. Let it live.
13. Let her cry. Then she will be calm.
14. Let him talk. He talks about interesting things.
15. Let them walk. Walking is good for health.
16. Let them learn to cook by themselves.
17. Let them stay at my house for one week.
18. Let them go by airplane.
19. Let her sit by the fire.

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Хичээлдээ явах
Би хичээлдээ явъя. Let me go to my lesson.
Чи хичээлдээ яв. You go to your lesson.
Тэр хичээлдээ яваг. Let him go to his lesson.

1. Монгол дуу заах
2. Муур тэжээх
3. Ресторанд хоол идэх
4. Бялуу хийх
5. Машин жолоодох
6. Нууraас загас барих
7. Өөрийнхөө санааг илэрхийлэх
8. Тэр тухай бодож үзэх
9. Хувцсуудыг индүүдэх
10. Даргатай уулзах
11. Ширээн дээрх юмнуудаа янзлах
12. Халуун цай уух
13. Үдэшлэг зохион байгуулах
14. Хэлзүй тайлбарлах

Дасгал 5

Загварын дагуу өгүүлбэр зохиож бич. (Make sentences as in the example.)

Жишээ:

Чи ... Би ...	Чи сууж бай. Би цай аваад ирье.	You keep on sitting. Let me go and get some tea.
Тэр ... Чи ...	Тэр сууж байг. Чи цай аваад ир.	Let him keep on sitting. You go and get some tea.
Би ... Чи ...	Би сууж байя. Чи цай аваад ир.	Let me keep on sitting. You go and get some tea.
Би ... Тэр ...	Би сууж байя. Тэр цай аваад ирэг.	Let me keep on sitting. Let him go and get some tea.
Чи ... Тэр ...	Чи сууж бай. Тэр цай аваад ирэг.	You keep on sitting. Let him go and get some tea.

1. Та, наанаа суух; би, цай, авах, ирэх
2. Та, и-мэйл, бичих; би, хог, асгах, ирэх
3. Та, зурагт, үзэх; би, дэлгүүр, явах, ирэх
4. Та, сонин, унших; би, уух юм, авах, ирэх
5. Та, наанаа хүлээх; би, шат, авах, ирэх
6. Та, хоол, идэх; би, зайрмаг, авах, ирэх
7. Та, сандал дээр, суух; би, захирал, утсаар ярих, ирэх
8. Та, энд, зогсох; би, тэр, дэлгүүр, орох, ирэх
9. Та, энд, байх; би, тэр, нохой, хоол, өгөх, ирэх
10. Та, амрах; би, хүү, цэцэрлэг, авах, ирэх
11. Та, энд, хүлээх; би, түргэн тусламж, дуудах, ирэх
12. Та, энд, байх; би, үсчний газар, цагийн хуваарь, харах, ирэх
13. Та, энд, байх; би, лаа, авах, ирэх

Бүрмөсөн үйлдэх байдал (Completed Action)

-аадах[4]ъя[3]	Би хараадахъя.	Let me take a look real quick.
-аадах[4]	Та хараадах.	Take a look real quick
-аадхаг[4]	Тэр хараадхаг.	Let him take a look real quick.

Би цонх хаагаадахъя.	Let me close the window real quick.
Та цонх хаагаадах.	You close the window real quick.
Тэр цонх хаагаадхаг.	Let him close the window real quick.
Би энэ хогийг цэвэрлээдэхье.	Let me clean up this garbage real quick.
Чи энэ хогийг цэвэрлээдэх.	You clean up this garbage real quick.
Тэр энэ хогийг цэвэрлээдхэг.	Let him clean up this garbage real quick.
Би энэ мөнгийг тоолоодохъё.	Let me count this money real quick.
Чи энэ мөнгийг тоолоодох.	You count this money real quick.
Тэр энэ мөнгийг тоолоодхог.	Let him count this money real quick.
Би нохойд хоол өгөөдөхье.	Let me give food to the dog real quick.
Чи нохойд хоол өгөөдөх.	You give food to the dog real quick.
Тэр, нохойд хоол өгөөдхөг.	Let her give food to the dog real quick.

Дасгал 6

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох өгүүлбэрүүдийг бич. (Write sentences that suit each situation.)

Жишээ нь:
Хог шүүрдэх хэрэгтэй байна. → Би хог шүүрдээдэхье. (Чи хог шүүрдээдэх. Тэр хог шүүрдээдхэг.)

1. Хаалганы хонх дуугарч байна.
2. Өрөөнд их халуун, бүгчим байна.
3. Бүх аяга таваг бохир байна.
4. Ширээний бүтээлэг тос болчихсон байна.
5. Машин эвдрээд асахгүй байна.
6. Ширээ их тоостой байна.
7. Хүүхдийн жижиг бөмбөг орон доогуур орчихсон байна.
8. Том хайрцгийг гэрээс гаргах хэрэгтэй болсон.
9. Цэцэгнүүдийн шороо бүр хатчихсан байна.
10. Ангид байгаа номнуудыг тоолох хэрэгтэй байна.
11. Аавын чинь цамцны товч уначихсан байна.
12. Нэг хүний хаягийг цаасан дээр бичих хэрэгтэй байна.
13. Асгарсан усыг арчих хэрэгтэй байна.
14. Хогны сав дүүрчихсэн байна.
15. Хоол хөрчихсөн байна.
16. Тоос сорогчоор хивс цэвэрлэх хэрэгтэй байна.
17. Хоол аягалах/таваглах хэрэгтэй байна.

Давтлага хичээл (16–20)

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. хэн ч
2. хэнд ч
3. хэнийг ч
4. хэнээс ч
5. хэнээр ч
6. хэнтэй ч
7. хэн рүү ч
8. хэний ч
9. юу ч
10. юугаар ч
11. юунаас ч
12. юунд ч
13. юуг ч
14. хаанаас ч
15. хаана ч
16. хаашаа ч

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. You may come here anytime.
2. I can help you anytime.
3. You may ask me anything.
4. You may put anything here.
5. You may sit anywhere.
6. People may go anywhere.
7. Anyone can do this work.
8. You may play this game with anyone.
9. I can teach this song to anyone.
10. He can live anywhere.

Дасгал 3

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд нөхөж бич. (Write the appropriate words in the spaces.)

хэн нэгэн хүн
хэн нэгэн хүнээс
хэн нэгэн хүнийг
хэн нэгэн хүнтэй
хэн нэгэн хүн рүү
хэн нэгэн хүнд
ямар нэгэн юм
ямар нэгэн юмаар
ямар нэгэн юманд
ямар нэгэн юмнаас
хаа нэгэн газар
хэзээ нэгэн цагт

1. Чи энэ тухай ..... асуух хэрэгтэй.
2. Чи ..... чулуу шидсэн үү?
3. Тэр ..... санаа зовж байгаа байх.
4. Тэр ..... буруугаа ойлгоно.
5. Чи тэр тухай ..... хэлсэн үү?
6. Чи ..... гомдоосон уу?
7. Тэд ..... айсан юм шиг байна.
8. Энд .....байсан юм шиг байна.
9. Та энийг ..... зүсэх хэрэгтэй.
10. Та ..... ярих хэрэгтэй.
11. Та энэ дэлгүүрээс ..... аваарай.
12. Чиний ном ..... байгаа байх аа.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуулаад хариулж бич. (Translate the sentences and answer them.)

1. What can you make besides dumplings?
2. What language are you learning besides Mongolian?
3. Who all came yesterday besides you?
4. What things should girls learn besides cooking?

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Нарантуул зах хоёрдахь өдрөөс бусад өдөр ажилладаг.
2. Чамаас бусад бүх оюутан хичээлдээ ирсэн.
3. Би Ховд аймгаас бусад бүх аймагт очиж үзсэн.
4. Ах маань онгоцоос бусад бүх тээврийн хэрэгслийг жолоодож чадна.
5. Тэр, хонины махнаас бусад бүх махыг иддэг.
6. Надаас бусад бүх хүүхэд сайн дуулдаг байх аа.

Дасгал 6

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Энэ, засах, өгөх → Энийг засаад өгөөч.

1. Давс, авах, өгөх
2. Үлгэр, ярих, өгөх
3. Энэ, орчуулах, өгөх
4. Хаалга, онгойлгох, өгөх
5. Гөлөг, нүх, гаргах, өгөх
6. Энэ, тайлбарлах, өгөх
7. Энэ, норгох, өгөх
8. Энэ, үүргэвч, хийх, өгөх

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Be careful, don't fall off the horse.
2. Be careful, don't make mistakes.
3. Be careful, don't burn your fingers.
4. Be careful, don't cut your fingers.
5. Make sure, don't be tired.
6. Make sure, don't be late for your lesson.
7. Make sure, don't forget to bring your book.
8. Make sure, don't forget to turn off the light.
9. Make sure, don't forget to eat food.
10. Make sure, don't forget to call your friend.

Дасгал 8

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Тавиг
2. Хоног
3. Байг
4. Хараг
5. Хайг
6. Явуулаг
7. Болиг
8. Бодог
9. Шүүрдэг

Тест (16–20)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Өчигдөр хэн ч манайд ирсэн.
Б. Өчигдөр хэн ч манайд ирээгүй.
В. Өчигдөр хэн манайд ирээгүй.

2. Anyone can do this.
А. Хэн энийг хийж чадна.
Б. Хэн нэг хүн энийг хийж чадна.
В. Хэн ч энийг хийж чадна.

3. You may put this anywhere.
А. Энийг хаана тавьж болно.
Б. Энийг хаана ч тавьж болно.
В. Энийг хаа нэг газар тавьж болно.

4. I bought nothing.
А. Би юу ч худалдаж аваагүй.
Б. Би юм худалдаж аваагүй.
В. Би юм ч худалдаж аваагүй.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Түлхүүр чинь хаана нэг газар байгаа.
Б. Түлхүүр чинь хаашаа нэг газар байгаа.
В. Түлхүүр чинь хаа нэг газар байгаа.

6. You didn't forget anything, did you?
А. Чи ямар нэг юм мартаагүй биз?
Б. Чи юу ч мартаагүй биз?
В. Чи нэг юм мартаагүй биз?

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр хэзээ үнэнийг мэднэ.
Б. Тэр хэзээ нэгэн цагт үнэнийг мэднэ.
В. Тэр хэзээ нэгэн үнэнийг мэднэ.

8. Put spices in the food besides salt.
А. Хоолонд давснаас гадна амтлагч хий.
Б. Хоолонд амтлагчаас гадна давс хий.
В. Хоолонд амтлагч гадна давснаас хий.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чи бусад бүх сурагч ирчихсэн.
Б. Чамаас бусад бүх сурагч ирчихсэн.
В. Чиний бусад бүх сурагч ирчихсэн.

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Ээж ээ, надад ном уншаач.
Б. Ээж ээ, надад ном унш.
В. Ээж ээ, надад ном уншаад өгөөч.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би чамд гоё дуу зааж өгнө өө.
Б. Би чамд гоё дуу заах өгнө өө.
В. Би чамд гоё дуу заана өгнө өө.

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Миний хүү, гараа түлуузай.
Б. Миний хүү, гараа түлээзэй.
В. Миний хүү, гараа түлүүзэй.

13. Make sure, don't forget to lock your door.
А. Хаалгаа түгжихээ битгий март.
Б. Хаалгаа түгжихээ мартахгүй.
В. Хаалгаа түгжихээ мартав аа.

14. Let my son rest.
А. Хүү маань амраг.
Б. Хүү маань амар.
В. Хүү маань амраасай.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр цай аваад ир.
Б. Тэр цай аваад ирье.
В. Тэр цай аваад ирэг.

16. Let me take a look at this real quick.
А. Би энийг хараадахъя.
Б. Би энийг хурдан харъя.
В. Би энийг одоохон харъя.

Оноо (point): 16/ .....

Хорин нэгдүгээр хичээл

Гуравдугаар биеэр төгсгөх нөхцөл (Third Person-Bound Terminating Suffix)

Verb stem + **аа**[4]**сай**[3]	I wish it (he, she) …
Verb stem + **даг**[4] **ч** (байсан) **болоосой**	I wish it was possible for … to …
Аав ээж маань гэртээ хурдан ирээсэй.	I wish my parents would come home quickly.
Тэд гэртээ хурдан ирдэг ч (байсан) болоосой.	I wish it was possible for them to come home quickly.
Зун хурдан болоосой.	I wish summer comes quickly.
Зун хурдан болдог ч болоосой.	I wish it was possible for summer to come soon.

Spelling rule: The suffixes –аасай (for verb stems with **а**, **у** and **я**), –ээсэй (for verb stems with **э**, **ү** and **и**), –оосой (for verb stems with **о**), –өөсэй (for verb stems with **ө**) are used directly after verb stems that end with consonants and when they are used verb stems that end with long vowels, **–г** is inserted. But when they are used after verb stems that end with short vowels, the short vowels are dropped. For example: яв + аасай = яваасай, өг + өөсэй = өгөөсэй, бод + оосой = бодоосой, суу + аасай = суугаасай, хий + ээсэй = хийгээсэй, тогло + оосой = тоглоосой, сана + аасай = санаасай

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Шуурга, намдах
2. Бороо, битгий, орох
3. Цас, хайлах
4. Хүүхэд, хурдан, эдгэх
5. Тэд, уралдаан, түрүүлэх
6. Хурдан, дулаан, болох
7. Юмны үнэ, буух
8. Баг, хожих
9. Банкны хүү, өсөх
10. Машин, хурдан, явах
11. Хүүхдүүд, цагтаа ирэх
12. Хоол, хурдан, ирэх
13. Ус, хурдан, ургах
14. Муу юм, тэр, битгий, тохиолдох

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Найз, ирэх → Найз маань ирдэг ч болоосой.

1. Тэр, монгол хэл, сайн мэдэх
2. Тэд, ус, сэлэх, чадах
3. Галхүү, мужааны ажил, хийх, чадах
4. Тэр, уран зураг, зурах, чадах
5. Тэд, төгөлдөр хуур, тоглох, чадах
6. Тэр, юм нэхэх, чадах
7. Найз, хөдөө, амьдрах
8. Гэрэлмаа, хувцас, оёх
9. Тэр охин, сургууль, сурах
10. Хүү, худалдаа наймаа, хийх

Чимэх үг (Modal Construction)

-х юмсан (I wish I could ... (Because of some reason it's not possible now.))

Хурдан том болох юмсан.	I wish I could grow big quickly.
Найзтайгаа уулзах юмсан.	I wish I could meet my friend.
Нохойтой болох юмсан.	I wish I could have a dog.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Хөдөө, явах → Хөдөө явах юмсан. (I wish I could go to the countryside. (It's not possible right now.))

1. Байрандаа засвар хийх
2. Компани байгуулах
3. Хөдөө амьдрах
4. Далайн эрэг явах
5. Тэтгэлэг авах
6. Алдартай зураач болох
7. Ногоо тарих
8. Алтан медаль авах
9. Уралдаанд түрүүлэх
10. Өндөр болох
11. Банкинд хадгаламжтай болох
12. Их сургуульд орох
13. Онгоц жолоодож сурах
14. Монгол хэл хурдан сурах

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Бороо орох, гадаа бороонд алхах
Бороо ороосой. Гадаа бороонд алхах юмсан. (I wish it would rain. I wish I could walk in the rain.)

1. Цас орох, цасан хүн хийх
2. Дэлгүүрт олон хүн орж ирэх, олон юм зарах
3. Хотод олон цэцэрлэгт хүрээлэн барих, зугаалах
4. Тэр сургуулиа битгий хаях, түүнтэй ярьж ойлгуулах
5. Энэ хүүхэд хурдан эдгэх, аав ээжид нь сайхан мэдээ дуулгах
6. Хурдан дулаан болох, хөдөө явах
7. Манай хичээл хурдан эхлэх, шинэ юм сурах
8. Манай баг хожих, аварга болох авах
9. Машин хурдан явах, хичээлээсээ хоцрох(гүй)
10. Цахилгаан ирэх, утас цэнэглэх
11. Цахилгаанчин хурдан ирэх, хоол хийх
12. Аав надад шинэ машин авч өгөх, машинаар хурдан давхих
13. Пар хурдан ирэх, гэртээ тухтай байх

Хорин хоёрдугаар хичээл

Орон цагийн нэр (Postpositions)

Хаана? (where)		**Хаашаа**? (to/towards where)	**Хаагуур**? (by, by __ way)
дээр	(on)	дээшээ (up)	дээгүүр (over)
доор	(under)	доошоо (down)	доогуур (by under)
ард, хойно	(behind)	арагшаа, хойшоо	ардуур, хойгуур
урд, өмнө	(in front of)	урагшаа	урдуур, өмнүүр
хажууд	(next to)	хажуу тийшээ	хажуугаар
баруун тал(д)	(on the west side of)	баруун тийшээ	баруун талаар
зүүн тал(д)	(on the east side of)	зүүн тийшээ	зүүн талаар
наана	(on this side of)	нааша	наагуур
цаана	(on that side of)	цаашаа	цаагуур
гадаа/гадна	(outside)	гадагшаа	гадуур
дотор	(inside)	дотогшоо	дотуур
хооронд	(in between)		хоорондуур
дунд	(in the middle)		дундуур
энд	(here)	ийшээ	энүүгээр
тэнд	(there)	тийшээ	тэрүүгээр

Examples of the verbs that are used with words above:

байх	харах	явах
зогсох	явах	гүйх
суух	гүйх	алхах
хүлээх	алхах	өнгөрөх (to pass)
тавих	эргэх	гарах (to pass)

Note: The words that are in the first column express location of people or things (non moving). The words that are in the second column express people or things moving to/towards a direction and the words in the third column express people or things moving by something or someone.

Ганхүү **шатан дээр** сууж байна.	Ganhuu is sitting **on the ladder**.
Ганхүү **шатаар дээшээ** гарч байна.	Ganhuu is going **up the ladder.**
Ганхүү **шатан дээгүүр** харайж байна.	Ganhuu is jumping **over the ladder**.
Хүмүүс дэлгүүрийн урд байсан.	People were in front of the store.
Дэлгүүрийн урдуур хүмүүс өнгөрсөн.	People passed in front of the store.
Хүмүүс урагшаа явсан.	People went to the south.
Хүүхдүүд гадаа тоглож байна.	The children are playing outside.
Хүүхдүүд гадагшаа гарсан.	The children went out.
Хүүхдүүд гадаа гарсан.	The children went outside.
Хүүхдүүд гадуур их явсан.	The children went outside (or many places) a lot.
Таны хажууд байсан хүн хэн байсан бэ?	Who was the person who was next to you?
Таны хажуугаар өнгөрсөн хүн хэн бэ?	Who is the person who passed by you?
Тэр хажуу тийшээ харж байгаа хүн хэн бэ?	Who is the person who is looking side ways?

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Уулан дээр олон хүн байсан.
2. Хүүхдүүд сандал дээр сууж байна.
3. Дэлгүүрийн наана миний машин байсан.
4. Манай гэр тэр цагаан дэлгүүрийн цаана байдаг.
5. Дэлгүүрийн зүүн талд бид зогсож байсан.
6. Та нар дэлгүүрийн цаагуур яваарай.
7. Та дэлгүүрийн зүүн талаар, урагшаа яваарай.
8. Наашаа хараарай. Цаашаа битгий хараарай.
9. Баруун тийшээ биш, зүүн тийшээ эргэ.
10. Хүүхдүүд шатаар дээшээ, доошоо гүйх дуртай.
11. Багш юм бодоод урагшаа, хойшоо алхаж байна.
12. Уулан дээгүүр, үүлэн доогуур олон шувуу нисч байна.
13. Уулын наагуур морьтой хүн өнгөрч байна.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. When we were sitting outside, many birds flew over us.
2. If soldiers pass by officers, they salute them.
3. It's dangerous to pass over the old bridge.
4. Mongolian people don't pass under the clothes line.
5. If someone is sitting, we don't pass in front of that person.
6. Don't pass in front of the guests.
7. There is one nice picture in front of Sukhbaatar square. If you pass in front of Sukhbaatar square, look at that picture.
8. When I was walking outside, one car passed by me very close.
9. When we were playing football, the ball passed between me and Bathuu.
10. He threw a ball to me and a ball passed under my legs because I jumped.
11. The stone he threw to me passed over my head.
12. If we pass by the bank, tell me. I need to exchange some money.
13. The person who is walking in front of that store is my friend.
14. Don't run in front of or behind your parents.
15. Don't walk on the fence. It's dangerous.
16. We came here by the right side of the theater.
17. If you go by the left side of that building, it's close.
18. They couldn't hit the ball over the net.
19. She passed close by me, but she didn't recognize me.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Look up (down, to the left side, to the right side).
2. Go up (down) stairs.
3. Is it easier to go up stairs or down stairs?
4. Teachers walk back and forth when they are teaching lessons.
5. Should we go this way or that way?
6. Throw the ball this way (that way).
7. First take three steps to the left and then take three steps to the right.
8. Run forward. Don't look back.
9. Look forward and do your lesson.
10. We went inside and saw very nice things.
11. I like to see outside through the window.
12. Turn to the right hand side. Then turn to the left hand side. Then go straight ahead.
13. Look this way. Don't look side ways.
14. It's cold outside. Let's go inside.

Дасгал 4

Найздаа хаана хэрхэн хүрч болохыг хэлж өг. (Tell your friend how to get to some places.)

Жишээ нь:
Би чамд маш сайхан хоолтой нэг рестораныг зааж өгье. Та эндээс чигээрээ баруун тийшээ алхаад, Сүхбаатарын талбайн урдуур өнгөрөөд, хойшоо эргээрэй. Хойшоо чигээрээ алхаж байгаад нэг шар байшингийн хажуугаар өнгөрөөд, зүүн гар тийшээ эргээд банкны хойгуур чигээрээ алхаарай. Хориод метр яваад урд чинь бор өнгөтэй байшин тааралдана. Тэр байшин дотор байгаа.

Хорин гуравдугаар хичээл

Үйл үг (-хаа[4] болих) (to stop ...-ing)

Хоцрохоо (хоцордгоо) **боль**!	**Stop** being late.
Би ингэхээ (ингэдгээ) **болимоор байна**.	I **want to stop** doing this.
Би сагсан бөмбөг тоглохоо **болимооргүй байна**.	I **don't want to stop** playing basketball.
Чи оюутны байранд амьдрахаа **болих юм уу**?	**Will** you **stop** living in a dormitory?
Би нэг жилийн өмнө мах идэхээ больсон.	I stopped eating meat one year ago.

Note: The verb "байх" is also used in place of "болих."

Би тийшээ явахаа **байна**.	I **will stop** going there.
Тэд энд ирэхээ **байсан**.	They **stopped** coming here.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
... учраас чи тамхи татахаа боль. → Эрүүл мэндэд хортой учраас (учир) чи тамхи татахаа боль.

1. ... учраас би хүмүүст муухай үг хэлэхээ болино.
2. ... учраас тэр компьютер тоглоом тоглохоо больсон.
3. ... учраас хүүхэд тоглоомоо эвдэхээ больсон.
4. ... учраас чи гудамжны мод хугалахаа болих ёстой шүү.
5. ... учраас чи их инээхээ боль.
6. ... учраас чи дандаа такси барьдгаа боль.
7. ... учраас чи өдөржин шөнөжин ажиллахаа болих хэрэгтэй.
8. ... учраас би хурд хэтрүүлэхээ больсон.
9. ... учраас чи гарцгүй газраар зам гарахаа боль.

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

Жишээ нь:
Би гадаа наранд их тоглодог. Тэгээд миний арьс наранд их түлэгддэг. → Гадаа наранд тоглохоо боль.

1. Би ер нь эм их уудаг учраас миний ходоод их өвддөг.
2. Би хүүхдүүдийг их шоолдог учраас хүүхдүүд надтай тоглох дургүй.
3. Чихэр их иддэг учраас миний олон шүд цоорсон.
4. Би ногоон гэрэл асахыг хүлээлгүй улаан гэрлээр зам хөндлөн гардаг.
5. Манай хүү их сахилгагүй учраас би хүүгээ дандаа загнадаг.

6. Би нэг ажлыг удаан хийх дургүй учраас нэг ажилд ороод удалгүй тэр ажлаасаа гардаг.
7. Би дандаа хүүгийнхээ гэрийн даалгаврыг хийж өгдөг.
8. Би охиндоо дандаа шинэ загварын, үнэтэй хувцас авч өгдөг.
9. Би ер нь хичээлээсээ дандаа хоцордог.
10. Би гэртээ ганцаараа байх дуртай. Хүмүүсийн дунд байх дургүй.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан асуулт зохион, хариулж бич. (Make questions using the given words and answer them.)

Жишээ нь:

Та, тэр, ресторан, хоол идэх?

Та тэр ресторанд хоол идэж байгаа юу? (Have you been eating in that restaurant?)

А. Би тэр ресторанд хоол идэж **л** байгаа. (I have been **still** eating in that restaurant.)

Б. Би тэр ресторанд хоол идэхээ больсон. Яагаад гэвэл хоол нь муу.

Би тэр ресторанд хоол идэхээ болино. Яагаад гэвэл муу хоолтой.

1. Та, байр, хөлслөх?
2. Та, өглөө бүр, гадаа, гүйх?
3. Та, марк, цуглуулах?
4. Та, монгол хэл, сурах?
5. Та, гэрэл зураг, авах?
6. Та, газрын теннис, тоглох?
7. Та, цагаан хоол, идэх?
8. Та, ан хийх?
9. Та, хүүхдүүд, хэл, заах?
10. Та, нөгөө машин, барих?
11. Тэр, нөгөө байшин, амьдрах?
12. Чи, өвчин намдаах эм, уух?

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

... -х гэж байгаад болиод ... (... going to ..., but decided not to and ...)

Жишээ нь:

Тэр хичээлээ хийх гэж байгаад болиод зураг үзсэн. (He was going to do his lesson, but he decided not to and he watched TV.)

1. Бид хоол хийх, болих, ресторанд хоол идэх
2. Би байрны түрээсийн төлбөрөө урьдчилж төлөх, болих, сар сараар нь төлөх
3. Баярхүү найздаа тэмдэглэлийн дэвтэр бэлэглэх, болих, ном бэлэглэх
4. Ганхүү эмгэнэлт жүжигт тоглох , болих, инээдмийн жүжигт тоглох
5. Тэр, дуурь үзэх, болих, бүжгэн жүжиг (балет) үзэх
6. Тэр хуулийн чиглэлээр сурах, болих, эдийн засгийн чиглэлээр сурах
7. Тэр алхах, болих, таксигаар явах
8. Тэр найздаа үнэнийг хэлэх, болих, чимээгүй явах
9. Жаргалмаа найздаа и-мэйл бичих, болих, найз руугаа утсаар ярих
10. Тэд хувцсаа хуурай хими цэвэрлэгээний газар өгөх, болих, гэртээ угаах
11. Төмөрхүү шинэ машин авах, болих, хуучин машинаа засах
12. Хүүхдүүд ширээний теннис тоглох, болих, агаарын теннис тоглох

Хорин дөрөвдүгээр хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-лгүй (without)

Бид **төөрөлгүй** энд ирлээ.
Чи аав ээждээ **хэлэлгүй** ийш тийш явж болохгүй шүү.
Тэд **амралгүй** 5 километр гүйсэн.
Захиа **бичилгүй** удсанд уучлаарай.
Бодолгүй унших нь зажлалгүй залгихтай адил.

We came here **without getting lost**.
You may not go anywhere **without telling** your parents.
They ran 5 kilometers **without resting**.
Sorry for **not writing** a letter for a long time.
To read without thinking is like to swallow without chewing.

Spelling rule:
When "-лгүй" is added to verb stems that end with consonants, vowels are inserted before it and when it's added verb stems that end with vowels, it's added directly. For example: яв + лгүй = явалгүй (without going), унш + лгүй = уншилгүй (without reading), хаа + лгүй = хаалгүй (without closing), ав + лгүй = авалгүй (without buying/without taking)

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Хүн хоол идэлгүй хир удаан амьдарч чадах вэ?
2. Хүн ус уулгүй хир удаан амьдарч чадах вэ?
3. Хүн унталгүй хир удаан байж чадах вэ?
4. Та амьсгалалгүй хир удаан байж чадах вэ?
5. Та дэлгүүрээс хүнсний юм авахдаа хугацааг нь харалгүй авдаг уу?
6. Та дэлгүүрээс хувцас авахдаа өмсөж үзэлгүй авдаг уу?
7. Та дэлгүүрээс цахилгаан барааг шалгалгүй авдаг уу?
8. Та эзнээс нь асуулгүй хүний юмыг авч хэрэглэдэг үү?
9. Хүмүүс танайд урьдчилж хэлэлгүй ирдэг үү?

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, хоол, халаах, идэх
2. Чи, хоол, асгах, идэх
3. Чи, бусад хүний юм, хэлэх, авах, болох(гүй)
4. Чи, түүхий сүү, буцалгах, уух, болох(гүй)
5. Та нар, цонхны шил, хагалах, болгоомжтой зөөх
6. Би, залхуурах, хичээл, хийх хэрэгтэй

7. Би, банк, мөнгө, тоолох, авах
8. Чи, хурал дээр, инээх, ярих
9. Та, хүмүүс, уурлах, ярих
10. Чи, чимээ гаргах, энд суух

Дасгал 3

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
И-мэйл, бичих, удах, уучлах → И-мэйл бичилгүй удсанд уучлаарай.

1. Утастах, удах, уучлах
2. Таних, өнгөрөх, уучлах
3. Харах, өнгөрөх, уучлах
4. Хэлэх, хөдөө, явах, уучлах
5. Бодох, хатуу үг хэлэх, уучлах
6. Асуух, энэ ажил, хийх, уучлах
7. Тэр тухай, хэлэх, нуух, уучлах
8. Танай, хоол, идэх, чадах, явах, уучлах
9. Та, тухтай ярих, явах, уучлах
10. Хамт ажиллах, чадах, явах, уучлах
11. Хамт, анд явах, үлдэх, уучлах

Хорин тавдугаар хичээл

Тусагдахуун гишүүн өгүүлбэр (Objective Clause)

Sentences with same subjects: verbs with any tenses + аа, -ээ, -оо, -өө

Тэр **юу хийснээ** надад хэлээгүй.	He didn't tell me **what he did**.
Тэр **юу хийхээ** надад хэлээгүй.	He didn't tell me **what he will do.**
Тэр **юу хийдгээ** надад хэлээгүй.	He didn't tell me **what he does**.
Тэр **юу хийж байгаагаа** надад хэлсэн.	He told me **what he has been doing**.
Тэр юу хийх гэж байгаагаа надад хэлээгүй.	He didn't tell me **what he is going to do**.
Тэр **юу хийдэг байснаа** надад хэлсэн.	He told me **what he used to do**.

Sentences with different subjects: verbs with any tenses + ыг/-ийг/-г

Түүнийг (түүний) энд ирснийг би мэдээгүй.	I didn't know **that he came here**.
Түүнийг хэдэн цагт энд ирдгийг би мэднэ.	I know what time **he comes here**.
Түүнийг ийшээ ирж байгааг би мэдээгүй.	I didn't know that he is coming here.
Түүнийг энд ирэх гэж байгааг би мэдээгүй.	I didn't know that he is going to come here.
Түүнийг энд ирдэг байсныг би мэднэ.	I know that he used to come here.
Түүнийг маргааш гэртээ байх, үгүйг нь (байхгүйг нь) би мэдэхгүй байна.	I don't know if he will be at his home tomorrow or not.
Тэр маргааш гэртээ байх, үгүйгээ (байхгүйгээ) надад хэлээгүй.	He didn't tell me if he will be at his home tomorrow or not.

If sentences end with question particles, nouns or adjectives, гэдгийг or гэдгээ are used.

Түүнийг маргааш гэртээ байх уу, үгүй юү гэдгийг би мэдэхгүй байна.	I don't know **if he will be at his home tomorrow or not**.
Тэр маргааш гэртээ байх уу, үгүй юү гэдгээ надад хэлээгүй.	He didn't tell me **if he will be at his home tomorrow or not**.
Түүнийг багш гэдгийг би мэдээгүй.	I didn't know that he was a teacher.
Тэр багш гэдгээ надад хэлээгүй.	He didn't tell me that he was a teacher.
Энэ ажил хэцүү гэдгийг хэн ч надад хэлээгүй.	No one told me that this work is difficult.

хэн, юу, хэд, хэзээ, хаана, ямар, яагаад + гэдгийг/гэдгээ

Найз маань манайд ирнэ гэж хэлсэн. Харин **яг хэзээ гэдгээ** надад хэлээгүй.	My friend said that she would come to my house, but she didn't tell me **exactly when**.
Найз маань манайд ирнэ гэж хэлсэн. Харин яг **хэзээ гэдгийг** нь би мэдэхгүй байна.	My friend said that she would come to my house, but I don't know **exactly when**.
Их дэлгүүрийн ойролцоо нэг том номын дэлгүүр байдаг. Харин яг хаана гэдгийг нь би хэлж мэдэхгүй байна.	There is a big book shop nearby the State Department Store, but I can't tell exactly where it is.

Note: The verbs like мэдэх, мартах, хэлэх, асуух, санах, сурах, анзаарах, ухаарах, харах, заах use

nouns or verbs with accusative case.

Spelling rules:
v (vowel), **c** (consonant), **7** (м, н, г, л, б, в, р), **9** (ц, ж, з, с, д, т, ш, ч, х)

vcvc → хийсэн + ээ = хийснээ, гаргадаг + ийг = гаргадгийг
79vc → авсан + аа = авснаа, ирсэн + ийг = ирснийг
99vc → идсэн + ийг = идсэнийг, хасдаг + аа = хасдагаа
Verbs that end with **x** → явах + аа = явахаа, ирэх + ийг = ирэхийг

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Одмааг хэзээ ирэхийг би мэдэхгүй байна.
2. Дэлгүүр хэдэн цагт онгойдгийг би мартчихжээ.
3. Түүнийг хаанаас ирснийг чи санаж байна уу?
4. Танай хүүхдийг монгол хэл сурч байгааг найз чинь надад хэлсэн.
5. Таныг Хятад руу явах гэж байгааг би мартчихжээ.
6. Таныг ямар ажил хийдэг байсныг би санаж байна.
7. Тэр юу хийх ёстойгоо сайн мэдэхгүй байна.
8. Би номоо хаана тавьснаа санахгүй байна.
9. Тэр аль байранд амьдардгаа надад хэлсэн.
10. Чи хаана сууж байгаагаа битгий мартаарай.
11. Чи юу хийх гэж байгаагаа ээж аавдаа хэлдэг байсан уу?
12. Та дунд сургуульд ямар хувцас өмсдөг байснаа санаж байна уу?

Дасгал 2

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Их дэлгүүр хаана байдгийг та мэдэх үү?
2. Монгол хоол яаж хийдгийг та мэдэх үү?
3. Багшийгаа хаана төрснийг та мэдэх үү?
4. Солонгос хоол яаж хийдгийг та багшдаа зааж өгөх үү?
5. Солонгос хоол яаж хийдгийг та хэзээ сурсан бэ?
6. Хэдэн настайг нь та хүмүүсээс асуудаг уу?
7. Найзыгаа ямар хувцас өмссөнийг та ер нь анзаардаг уу?
8. Монголчуудыг шагайгаар яаж тоглож байгааг та харсан уу?
9. Та хаашаа явж байгаагаа аав ээждээ дандаа хэлдэг байсан уу?
10. Та хаана амьдардгаа монголоор хэлж чадах уу?
11. Та хүмүүст юу гэж хэлснээ дандаа санадаг уу?
12. Та номоо хаана тавьснаа дандаа санадаг уу?
13. Та өмсөж байгаа цамцаа хаанаас авснаа санаж байна уу?

Дасгал 3

Асуултуудыг орчуулаад хариулж бич. (Translate the sentences and answer them.)

1. Do you know how to cook Mongolian food?
2. Do you know how to learn languages fast?
3. Do you know how to get to the central post office?
4. When did you learn how to make a paper bird?
5. When did you learn how to make Mongolian food?
6. Do you see how Mongolia is developing?
7. Did you notice that Mongolians like to eat meat?
8. Do you notice that it's getting cold here?

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Please teach me how to make cake.
2. Please teach me how to play this game.
3. Ask her why she didn't come.
4. Ask her how she is learning Mongolian.
5. Guess who came here this morning.
6. Guess how many stones are in my hand.
7. Guess what I bought from the store.
8. Guess what happened there the day before yesterday.
9. Tell me how you did that.
10. Tell me what time you came.
11. Tell me why you didn't want to sit there.
12. Tell me how you came here.
13. Please write down what you said.
14. Please write down what you did.
15. Please write down what you learned.
16. He didn't remember what he did.
17. He didn't remember what he said.

Дасгал 5

Узсэн хэлзүйгээ ашиглан асуулт бүрт 5-аас доошгүй хариулт бич.
(Write at least five sentences for each question using the grammar you have learned.)

Жишээ нь:
Та орой унтахаасаа өмнө юу юуны талаар боддог вэ?
А. (Би) тэр өдөр юу юу хийснээ боддог.
Б. Дараагийн өдөр нь юу хийхээ боддог.
В. Дараагийн өдөр нь хаашаа явахаа боддог.

Б. Найзынхаа юу гэж хэлснийг боддог.
В. Хүмүүст юу гэж хэлснээ боддог.

1. Та орой унтахаасаа өмнө юу юуны талаар боддог вэ?
2. Та найзтайгаа юу юуны тухай ярьдаг вэ?
3. Та найздаа (аав ээждээ) юу юуны талаар и-мэйл бичдэг вэ?
4. Хүмүүс намтартаа юу юу бичдэг вэ?
5. Та юу юуг мартдаггүй вэ?

Дасгал 6

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ:
Та энэ байранд олон жил амьдрах уу?
А. Би энэ байранд олон жил амьдрах, үгүйгээ мэдэхгүй байна.
Б. Би энэ байранд олон жил амьдрах уу, үгүй юү гэдгээ сайн мэдэхгүй байна.

Батхүү энэ байранд олон жил амьдрах уу?
А. Батхүүг энэ байранд олон жил амьдрах, үгүйг би мэдэхгүй байна.
Б. Батхүүг энэ байранд олон жил амьдрах уу, үгүй юү гэдгийг би мэдэхгүй байна.

1. Ирэх сард бороо орох уу?
2. Та 10 жилийн дараа энд байх уу?
3. Та маргааш таван цагт гэртээ байх уу?
4. Найз чинь таван жилийн дараа энд байх уу?
5. Та урт наслах уу?
6. Хамгийн сайн найз тань хөгжим тоглох дуртай юу?
7. Хамгийн сайн найз тань энэ долоо хоногт тан руу утастах уу?
8. Та энэ цүнхэн дотор байгаа хоолыг идэж чадах уу?
9. Танай хүү сургуулиа сайн дүнтэй төгсч чадах уу?

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I don't know if I can do this or not.
2. My friend can tell you if I can do this or not.
3. I can't tell you now if I will stay here long or not.
4. No one knows if they can come or not.
5. I don't want to tell you if I smoke or not.
6. Ask my parents if I smoke or not.
7. I can't tell you if it will rain tomorrow or not.
8. Find out if she can go with us or not and let me know.
9. Think well if you can do this job or not and then contact me.

10. Think well if he can be your best friend or not and then make a decision.
11. Find out if he is a good person or not
12. Ask him if he can work with you or not.

Дасгал 8

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Тэнд сэрүүн/бүгчим/чийглэг/манантай гэдгийг найз маань и-мэйлдээ бичсэн байсан.
2. Түүнийг өгөөмөр/харамч/бардам/даруу/шуналтай хүн гэдгийг би найзаасаа сонссон.
3. Таныг монгол хүн гэдгийг би мартчихжээ.
4. Долгормааг ганц бие/бэлэвсэн гэдгийг би мэдээгүй юм байна.
5. Энд гутал ийм үнэтэй/чанартай гэдгийг би танд хэлсэн шүү дээ.
6. Тэр ихэр/өргөмөл хүүхэд гэдгээ надад хэлээгүй.
7. Тэр зургийн авъяастай гэдгээ мэддэггүй.
8. Сүхүү хатуу/зөрүүд/зальтай/зожиг хүн гэдгээ хүлээн зөвшөөрдөггүй.

Дасгал 9

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
She laughed but I didn't know why. → Тэр инээсэн. Харин яагаад гэдгийг нь би мэдээгүй.
She was in a hurry but she didn't tell me why. → Тэр яарч байсан. Харин яагаад гэдгээ тэр надад хэлээгүй.

1. She was angry. Did you know why?
2. She was disappointed. Did she tell you why?
3. She was very strange. I didn't understand why.
4. They were very happy. Please guess why.
5. They were very sad. Later I will tell you why.
6. They were very nervous. Do you want to know why?
7. He didn't come to the lesson yesterday. Did you hear why?
8. He didn't talk to anyone. He explained to me why.
9. He didn't want to get advice from us. Don't ask me why.
10. You were very emotional yesterday. Tell me why.
11. You were very impatient yesterday. I know why.
12. You talked to me in a ioud voice this morninig. I want to hear from you why.
13. He learned Mongolian very well. Do you know how?
14. He learned Mongolian very well. He told me how.
15. He learned Mongolian very well. Ask him how.
16. She asked me for forgiveness. I didn't understand why.
17. She asked me for forgiveness. She didn't tell me why.

Давтлага хичээл (21–25)

Дасгал 1

Эгөгдсөн нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences that suit each situation.)
Жишээ нь:
Гадаа их халуун байна. → Бороо ороосой.

1. Гадаа их хүйтэн байна.
2. Их бороо орж байна.
3. Гадаа их салхитай байна.
4. Зам түгжрээтэй байна.
5. Юмны үнэ их өсөж байна.
6. Хүү чинь тан руу утсаар ярихгүй байна.
7. Та автобус удаан хүлээж байна.
8. Найз чинь өвчтэй байна.

Дасгал 2

Ямар нөхцөл байдалд доорх өгүүлбэрүүдийг хэлж болохыг бич.
(Write down what situations you can use the following sentences for.)

1. Мужааны ажил хийж сурах юмсан.
2. Оюутны байранд амьдрах юмсан.
3. Монгол хэл хурдан сурах юмсан.
4. Хүүдээ илгээмж явуулах юмсан.
5. Цэцэг тарих юмсан.
6. Гэртээ харих юмсан.
7. Тэр багийг хожих юмсан.
8. Машин худалдаж авах юмсан.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. ой модон дээгүүр
2. гүүрэн доогуур
3. дээшээ
4. доошоо
5. талбайн хажуугаар
6. захын урдуур
7. баруун тийшээ
8. зүүн тийшээ
9. байрны хойгуур
10. голын наагуур
11. наашаа
12. цаашаа

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I will stop teasing my friends.
2. You should stop saying swear words.
3. Stop laughing.
4. Please stop playing computer games too much.
5. When will you stop drinking coffee too much?
6. I was going to put wall paper on my walls, but I decided not to and painted them instead.
7. We were going to sell our apartment, but we decided not to and rented it instead.
8. They were going to buy mutton, but they decided not to and they bought beef instead.

Дасгал 5

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд нөхөж бич. (Write the appropriate words in the spaces.)

айлгүй	индүүдэлгүй	түгжилгүй
асуулгүй	бодолгүй	танилгүй
хүлээлгүй	асгалгүй	яаралгүй

1. Би хоцорч ирнэ шүү. Намайг ... ажлаа эхлээрэй.
2. Хүүхдүүд ээ, хоолоо ... идээрэй.
3. Бидэнд цаг хангалттай байгаа учраас энэ ажлаа ... дуусгаарай.
4. Би машинаа... орхичихжээ.
5. ... өнгөрсөнд уучлаарай.
6. Миний хүү, хүний юмыг ... авч болохгүй шүү.
7. Чи алдаа гаргахаас ... монголоор яриарай.
8. Угаасан хувцсаа ... битгий өмсөөрэй.
9. Би ... үг хэлээд дараа нь харамсдаг.

Дасгал 6

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. "Барс" зах, хаана, байх; та мэдэх?
2. Тэр, ямар ажил, хийх; та, тэр, асуух
3. Баярхүү, хаана, амьдрах; Баярхүү, та, хэлэх
4. Та, би, пицца, яаж хийх; заах
5. Би, пицца, яаж хийх; сурах хэрэгтэй
6. Би, найз, юу, хэлэх; би, мартах
7. Би, өмнө нь, ямар үстэй байх; та, анзаарах?
8. Найз, дуугаа хураах; яагаад; би мэдэх(гүй)
9. Би, их ядрах; яагаад; би мэдэх(гүй)
10. Тэд, ажил, хурдан дуусгах; яаж; дарга, тэд, асуух
11. Тэд, ажил, хурдан дуусгах; яаж; тэд, хэлэх
12. Тэр, сугалаанд мөнгө хожих; үгүй; би мэдэх(гүй)
13. Би, сугалаанд мөнгө хожих; үгүй; би мэдэх(гүй)

Тест (21–25)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. I wish it snows.
А. Бороо орог.
Б. Бороо орох юмсан.
В. Бороо ороосой.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Аав маань ажлаасаа хурдан ир.
Б. Аав маань ажлаасаа хурдан ирээсэй.
В. Аав маань ажлаасаа хурдан ирээрэй.

3. I want to buy a dog, but it's not possible now.
А. Нохой худалдаж авмаар байна.
Б. Нохой худалдаж авах юмсан.
В. Нохой худалдаж авъя.

4. The dog is laying down on the floor.
А. Нохой шалан дээгүүр хэвтэж байна.
Б. Нохой шалан дээр хэвтэж байна.
В. Нохой шалан дээшээ хэвтэж байна.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Машинууд гүүрэн доогуур өнгөрч байна.
Б. Машинууд гүүрэн доор өнгөрч байна.
В. Машинууд гүүрэн доошоо өнгөрч байна.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Битгий доор хараад бай.
Б. Битгий доошоо хараад бай.
В. Битгий доогуур хараад бай.

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Урагшаа хараад суу.
Б. Урдуур хараад суу.
В. Урд хараад суу.

8. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Найз маань тамхи татаж больсон.
Б. Найз маань тамхи татахаа больсон.
В. Найз маань тамхи татах больсон.

9. I was watching TV, but decided not to.
А. Би зурагт үзэх гэж байгаад больчихлоо.
Б. Би зурагт үзэж байгаад больчихлоо.
В. Би зурагт үзэхээ больчихлоо.

10. Use this without breaking it.
А. Энийг битгий эвдэж хэрэглэ.
Б. Энийг эвдэлгүй хэрэглэ.
В. Энийг эвдэхээргүй хэрэглэ.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би энийг өмсөж үзэлгүй авсан.
Б. Би энийг өмсөж үзэхлгүй авсан.
В. Би энийг өмсөж үзээлгүй авсан.

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Таныг хаана амьдардгийг би мэднэ.
Б. Таныг хаана амьдардаг вэ би мэднэ.
В. Таныг хаана амьдардаг би мэднэ.

13. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Энхмаа хэзээ ирэхийг надад хэлсэн.
Б. Энхмаа хэзээ ирэхээ надад хэлсэн.
В. Энхмаа хэзээ ирэх надад хэлсэн.

14. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Цас орох, үгүй би мэдэхгүй.
Б. Цас орох, үгүй гэдгийг би мэдэхгүй.
В. Цас орох, үгүйг би мэдэхгүй.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Энэ зөв үү, буруу юу гэдгийг хэл.
Б. Энэ зөв үү, буруу юуг хэл.
В. Энэ зөв үү, буруу юу хэл.

16. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр инээсэн. Яагаад нь би мэдэхгүй.
Б. Тэр инээсэн. Яагаад вэ би мэдэхгүй.
В. Тэр инээсэн. Яагаад гэдгийг нь би мэдэхгүй.

Оноо (point): 16/ .....

Хорин зургадугаар хичээл

Тусагдахуун гишүүн өгүүлбэр (Objective Clause)

гэдэгт(ээ)

Тэдний бодлыг өөрчилж чадна **гэдэгтээ** би **эргэлзэж байна.**	I **doubt that** I can change their minds.
Таныг энэ багийг удирдаж чадна гэдэгт би эргэлзэхгүй байна.	I don't doubt that you can lead this team.
Чамайг амжилт гаргаж чадна **гэдэгт** би **итгэж байна**.	I **believe that** you can be successful.
Чамайг энийг хийж чадна гэдэгт би итгэлтэй байна.	I'm confident that you can do this.

гэдгээс

Энэ ажил хурдан дуусах уу?	Will this work finish quickly?
—Бидний хурдан хийх үү, үгүй юу **гэдгээс шалтгаална**.	—**It will depend on** if we will do it fast or not.
—Бидний хурдан хийх, үгүйгээс шалтгаална.	—It will depend on if we will do it fast or not.
—Бидний хир хурдан хийхээс шалтгаална.	—It will depend on how fast we do it.
Ногоо ургах, үгүй нь бороо орох уу, үгүй юу гэдгээс их шалтгаална.	Vegetables being able to grow or not will depend a lot on if it will rain or not.

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Та, энэ, ажил, хийх, чадах; би, эргэлзэх (итгэх)
А. Таныг энэ ажлыг хийж чадна гэдэгт би эргэлзэж байна (итгэхгүй байна).
Б. Таныг энэ ажлыг хийж чадна гэдэгт би эргэлзэхгүй байна (итгэж байна).

1. Тэр, хэлсэндээ хүрэх; би, эргэлзэх (итгэх)
2. Би, хайж байгаа юм, олох, чадах; би, эргэлзэх (итгэх)
3. Тэр, үнэн, хэлэх; би, эргэлзэх (итгэх)
4. Тэр, сайн, хүн; би, эргэлзэх (итгэх)
5. Энхмаа, энэ байгууллага, удирдах, чадах; би, эргэлзэх (итгэх)
6. Би, жин хасах, чадах; би, эргэлзэх (итгэх)
7. Тэр, жин нэмэх, чадах; би, эргэлзэх (итгэх)
8. Тэдний бизнес, өргөжих; би, эргэлзэх (итгэх)
9. Долларын ханш, буух; би эргэлзэх (итгэх)
10. Тэр, чиний үгэнд орох; би эргэлзэх (итгэх)
11. Тэр үйлдвэр, чанартай бүтээгдэхүүн гаргах; би эргэлзэх (итгэх)

Дасгал 2

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ нь:
Хүмүүс өдөр бүр гадаа алхдаг уу?
А. Цаг агаараас шалтгаалдаг. (It depends on the weather.)
Б. Цаг агаар ямар байхаас шалтгаална. (It will depend how the weather is.)
В. Гадаа дулаахан байна уу, үгүй юү гэдгээс шалтгаалдаг. (It depends on if it's warm outside or not.)

1. Бүх хүн гадаад хэлийг хурдан сурч чаддаг уу?
2. Та шөнө болгон сайн унтаж чаддаг уу?
3. Та өдөр болгон завгүй байдаг уу?
4. Юмны үнэ яагаад газар газар өөр өөр байдаг вэ?
5. Цаг яагаад заримдаа удаан, заримдаа хурдан өнгөрдөг вэ?
6. Бизнес амжилттай байх, үгүй нь юунаас шалтгаалдаг вэ?
7. Байгууллагын/гэр бүлийн уур амьсгал сайхан байх, үгүй нь юунаас шалтгаалдаг вэ?
8. Хүмүүсийн эрүүл мэнд сайн байх, үгүй нь юунаас шалтгаалдаг вэ?

Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр (Subjective Clause)

Миний ирэх, ирэхгүй хамаагүй. = Ирэх, ирэхгүй минь хамаагүй.	It doesn't matter if I will come or not.
Чиний ирэх, ирэхгүй хамаагүй. = Ирэх, ирэхгүй чинь хамаагүй.	It doesn't matter if you will come or not.
Түүний ирэх, ирэхгүй хамаагүй. = Ирэх, ирэхгүй нь хамаагүй.	It doesn't matter if he/she will come or not.
Түүний ирэх үү, үгүй юү гэдэг нь хамаагүй.	It doesn't matter if he/she will come or not.

Verbs in passive form can be used after subjective clauses. For example:

Хүн амын тоо өсөж байгаа нь харагдаж байна.	It's been seen that the number of the population is increasing.
Түүний үсээ засуулсан нь анзаарагдаж байна.	It's noticable that he had hair cut.

Дасгал 3

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

... гэдэг нь чухал (чухал биш, хамаатай, хамаагүй, сонин биш)

1. Орон сууц том байх нь чухал уу?
2. Эрэгтэй хүмүүс мөнгөтэй байх нь чухал уу?
3. Өөрийнхөө санаа бодлыг хүмүүст үргэлж илэрхийлж хэлэх нь чухал уу?
4. Хүүхэд хувцас хунар, эд мөнгө, хоол хүнсээр дутахгүй бол сайн хүн болж хүмүүждэг үү?
5. Хүмүүс чамин, үнэтэй хувцас өмсвөл сайхан харагддаг уу?
6. Их мөнгө, эд хөрөнгөтэй хүн аз жаргалтай амьдардаг уу?

Хорин долдугаар хичээл

Нийлмэл өгүүлбэр (Combined Sentences (When))

1. If two actions happen at the same time, we use suffix "-хад⁴ (-хдаа⁴)."

Би энд ирэхдээ Монголын тухай сайн мэддэггүй байсан.	When I came here, I didn't know much about Mongolia.
Намайг Монголд ирэхэд дулаахан байсан.	When I came to Mongolia, it was warm.
Би Америкт байхдаа Монголын талаар нэг их сонсож байгаагүй.	When I was in America, I didn't hear much about Mongolia.
Намайг Америкт байхад манай найз надад Монголын талаар ярьж өгсөн.	When I was in America, my friend told me about Mongolia.

2. If two actions happened one after another, we use suffix "-аад⁴." (The words that express emotions, are used this way.)

Би Монголд ирээд гайхсан.	When I came to Mongolia, I was surprised.
Тэд гэртээ ирээд хоол хийсэн.	When they came home, they cooked.
Би түүнийг хараад их баярласан.	When I saw her, I was very happy.
Охин ээжийгээ хараад уйлсан.	When the girl saw her mother, she cried.
Тэр, найзынхаа захиаг уншаад уурласан.	When he read his friend's letter, he got angry.

3. If first action causes the second action, we use suffix "-х(л)аар⁴ (-х(л)аараа⁴)" after verb stems.

Хүүхдүүд ядрахлаараа уйлдаг.	When children are tired, they cry.
Нар гарахлаар гадаа дулаан болдог.	When the sun rises, it gets warmer outside.
Зарим хүн уурлахлаараа дуугай болдог.	When some people are angry, they become quiet.
Удаан алхахлаар миний хөл өвддөг.	When I walk a long time, my feet hurt.

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-(а⁴)х(л)аар(аа)⁴ (When (Whenever))

Sentences with same subject:

Нялх хүүхдүүд өлсөхлөөрөө уйлдаг.	When babies are hungry, they cry.
Тэр нэг юманд анхаарахлаараа хажууд нь юу болж байгааг анзаардаггүй.	When he pays attention to something, he doesn't notice what is going on next to him.
Найз маань уурлахаараа чанга ярьдаг.	When my friend is angry, he talks loud.

Sentences with different subjects:

Намайг оройтохлоор аав ээжийн маань санаа их зовдог.	When I'm late, my parents worry a lot.
Хүмүүсийг ирэхлээр энд суулгаарай.	When people come, have them sit here.

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (-**аа**⁴).

Ахыг**аа** ирэхлээр дүү нар нь баярладаг.	When their brother comes, siblings are happy.

When a complex sentence has different subjects and if the subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль and the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Намар болохоор модны навч шарлаж, унадаг.	When autumn comes, leaves become yellow and fall down.
Хонх дуугарахлаар хүүхдүүд ангидаа ордог.	When the bell rings, children go in to their classroom.

If the main clause's subject is a part of the body, we don't have to mention the subordinate clause's subject because it's logical that if someone does something, it effects that person's body not some one else's.

Хүнд юм өргөхлөөр түүний нуруу өвддөг.	When he lifts up heavy things, his back hurts.
Шорвог хоол идэхлээр ам минь их цангадаг.	When I eat food that is too salty, my mouth is thirsty.
Тамхи татахлаар хүмүүсийн уушиг хорддог.	When people smoke, their lungs are poisoned.

Үгүйсгэх (negative) + болох(л)оор(оо)

Шингэн юм уухгүй болохоор толгой өвддөг.	When (people) don't drink liquid things, (they) get a headache.

Spelling rule:

Verb stems with а, у and я +(а)хлаар(аа) →	уухлаар(аа), явахлаар(аа)
Verb stems with э, ү and и +(э)хлээр(ээ) →	үзэхлээр(ээ), хийхлээр(ээ)
Verb stems with о +(о)хлоор(оо) →	орохлоор(оо), тоглохлоор(оо)
Verb stems with ө +(ө)хлөөр(өө) →	өгөхлөөр(өө), өвдөхлөөр(өө)

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.

1. Хүмүүс ядрахлаараа яадаг вэ? (When people are tired, what do they do?)
2. Хүмүүс уурлахлаараа яадаг вэ?
3. Хүмүүс баярлахлаараа яадаг вэ?
4. Хүмүүс санаа зовохлоороо яадаг вэ?
5. Хүмүүс даарахлаараа яадаг вэ?
6. Хүмүүс халууцахлаараа яадаг вэ?
7. Хүмүүс сандрахлаараа яадаг вэ?
8. Найзыгаа өвдөхлөөр та яадаг вэ?
9. Найзыгаа уурлахлаар та яадаг вэ?
10. Найзыгаа ядрахлаар та яадаг вэ?
11. Найзыгаа баярлахлаар та яадаг вэ?
12. Найзыгаа инээхлээр та яадаг вэ?
13. Найзыгаа даарахлаар та яадаг вэ?
14. Найзыгаа халууцахлаар та яадаг вэ?
15. Найзыгаа сандрахлаар та яадаг вэ?
16. Найзын чинь санаа зовохлоор та яадаг вэ?

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
... хүмүүс айдаг. → Харанхуйд ганцаараа явах(л)ааараа хүмүүс айдаг.

1. ... хүмүүс баярладаг.
2. ... хүмүүсийн сэтгэл хөөрдөг.
3. ... хүмүүс эвшээдэг.
4. ... хүмүүс сандардаг.
5. ... хүмүүс гайхдаг.
6. ... хүмүүс сэтгэлээр унадаг.
7. ... хүмүүсийн сэтгэл сэргэдэг.
8. ... хүмүүс санаа алддаг.
9. ... хүмүүс ганцаарддаг.
10. ... хүмүүс унтаж чаддаггүй.

Дасгал 3

Сурсан хэлзүйгээ ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио.
(Make sentences with the given words using the grammar you have learned.)

1. Гэрэл, унтраах; хүүхдүүд, айх
2. Зурагт, хүүхэлдэйн кино гарах; хүүхдүүд баярлах
3. Нялх хүүхэд, өлсөх; уйлах
4. Хүмүүс, сэтгэл санаа тавгүйтэх; уур уцаартай болох
5. Тэр, юм, бодох; юу ч, анзаарах(гүй)

6. Тэр хүүхэд, уурлах; тоглоом, шидэх
7. Гэрт исгэрэх; настай хүмүүс дургүйцэх
8. Хүмүүс, орой, их хоол, идэх; сайн, унтах, чадах(гүй)
9. Тэр, ямар нэг юм тохиолдох; найз, ярих
10. Өтгөн кофе, уух; тэр, зүрх дэлсэх
11. Багш, дохио өгөх; оюутнууд, гүйх
12. Хүйтэн жин, тавих; хавдар, буух
13. Нар хиртэх; хэсэг хугацаа, харанхуй болох

Удаан суухлаар миний өвдөг өвддөг. (When I sit a long time, my knees hurt.)

14. Их өөх, тостой хоол, идэх; би, ходоод, өвдөх
15. Хурдан, босох; тэр, толгой эргэх
16. Машин, хойшоо харах, суух; настай хүмүүс, толгой эргэх
17. Нар, олон цаг, суух; би, арьс, түлэгдэх
18. Халуун ногоо, хоол идэх; зарим хүн, нус гоожих
19. Олон цаг, ном, унших; би, нүд, чилэх
20. Халууцах; тэр, нүүр, улайх

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. When it rains a lot, grass grow very much.
2. When ever (I) smell that paint, I get a headache.
3. When he becomes drunk, he becomes crazy.
4. When they go fishing, they are exited.
5. When her sister visits, my mom is always happy.
6. When people get tired, they can't work actively.
7. When we see street children, we feel sorry for them.
8. When people do wrong things, they regret it.
9. When my neighbors make noises, I can't sleep.
10. When people walk regularly, they loose weight.
11. When she sings a lullaby, that baby goes to sleep quickly.
12. When fruit are ripe, people pick them.
13. When he makes a language mistake, he is embarrassed.
14. When it rains, children like to go outside.

Дасгал 5

Эгүүлбэрүүдийг орчуулахдаа 3 нөхцөлийн (-аад^4, -хад^4 (-хдаа^4), -хлаар^4(аа^4)) аль нь тохиромжтой болохыг сайтар бод. Утгаасаа шалтгаалаад зарим өгүүлбэрт нь хоёр хувилбар байж болно.
(When you translate the sentences, think carefully which one of the three suffixes (-аад^4, -хад^4 (-хдаа^4), -хлаар^4(аа^4)) is suitable. Because of the meaning, some sentences can have two versions.)

1. When she saw her sister there, she was very happy.
2. When he is angry, he talks very loud.
3. When I came home, I cooked.
4. When I came home, I took a taxi.
5. When I sit long, my knees hurt.
6. When I came to Mongolia, I didn't know Mongolian.
7. When people sit long, they yawn.
8. When I came to Mongolia, I was suprised.
9. When they were walking, they were singing.
10. When we were in the countryside, we rode horses.
11. When he threw me a ball, I threw the ball back.
12. When Gerelmaa went to the countryside, she met many people.
13. When I heard that news, I felt angry.
14. When it gets warm, I will travel in the countryside.
15. When they hear about it, they will be happy.
16. When I am home, I like to make souvenirs.
17. When little children are hungry, they cry.
18. When my child grows up, he wants to become a doctor.
19. When my son graduates from his university, I will buy a car for him.
20. When he graduates from his school, he will go to Japan.
21. When he read that letter, he read it very loud.
22. When he reads a letter from his mother, he cries.
23. When he cries, his friend cries too.
24. When we read that letter, we laughed.
25. When he read that letter, he was standing.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Түүнийг ирэхээр энийг өгөөрэй. (= Ирэхээр нь энийг өгөөрэй.)
2. Түүнийг ирэхээр би (түүнд) хэлье. (= Ирэхээр нь би түүнд хэлье.)
3. Ядрахаар нь би түүнд тусална. (Ядрахаар нь би түүнд тусалсан.)
4. Намайг шоолохоор нь би бас түүнийг шоолсон.
5. Хичээлээ хийж дуусахаар чинь би чамд нэг юм үзүүлнэ ээ.
6. Хичээлээ хийж дуусахаараа надад хэлээрэй.
7. Би Америкт очихоороо найзтайгаа уулзана аа.
8. Барилгын материалын үнэ өсөхөөр орон сууцны үнэ бас өснө.
9. Машины үнэ буухаар та нар худалдаж аваарай.
10. Цас хайлахаар би хөдөө явна.
11. Дулаарахлаар бид зуслан руугаа нүүнэ.

(Таван мэдрэмж)	Мэдрэх
(Сэтгэлийн хөдөлгөөн+ бие мах бод)	Хүрэх
(Сэтгэлийн хөдөлгөөн)	Санагдах
Халуун, хүйтэн, үнэр, амт, хэлбэр дүрс	мэдрэх
нойр, уур, инээд, залхуу, дургүй	хүрэх
сайхан, муухай, хачин, тэнэг, гайхамшигтай	санагдах
Тэр хуруугаараа сайн мэдэрдэг.	He feels things well with his fingers.
Түүний уур их хүрсэн.	He felt angry.
Түүнд сайхан санагдсан.	He felt nice.

Дасгал 7

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Хүмүүс юугаараа халуун, хүйтнийг мэдэрдэг вэ?
2. Хүмүүс юугаараа үнэрийг (амтыг, дууны долгионыг, юмны шинж чанарыг) мэдэрдэг вэ?
3. Ямар үед (яахлаар) танд сайхан (муухай, хэцүү, аймаар, хачин) санагддаг вэ?
4. Ямар үед (яахлаар) таны уур (залхуу, инээд, дургүй, нойр) хүрдэг вэ?

Дасгал 8

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. How do you feel when someone helps you?
2. What makes you feel nice?
3. What makes you feel bad?
4. He gave me a candy by throwing. I felt bad.
5. Please go into this room. … How do you feel?
6. I heard there was an earthquake here last night. But I didn't feel anything.
7. I don't like to watch horror movies because I feel terrible when I watch them.
8. When I went into that building, I felt strange.
9. Children feel their parents' love in their hearts.
10. If you take this medicine, you won't feel pain.
11. Sometimes I feel that living in a foreign country is difficult.
12. Sometimes I feel that doing things is easy.
13. When he was walking in the dark, he felt someone was behind him and he felt terrible.
14. In the summer time I feel annoyed because there are many flies.
15. They do very hard work. One time I did their work and felt it myself (with my body). To me it felt very difficult.

Хорин наймдугаар хичээл

Хүрэх гэдэг үйл үгийн утгууд (Meanings of the Verb "хүрэх")

-д/-т хүрэх	to touch, to reach, to arrive (to get to)

Нойр хүрэх	to feel sleepy	Гар хүрэх	to spank
Залхуу хүрэх	to feel lazy	Ханиад хүрэх	to catch cold
Гижиг хүрэх	to feel ticklish	... (нас) хүрэх	to get to ... (age)
Уур хүрэх	to feel angry	(мөнгө г.м.) хүрэх	to be enough (money etc.,)
Инээд хүрэх	to feel like laughing		
Дургүй хүрэх	to feel dislike	Зорилгодоо хүрэх	to achieve one's goal
Сэтгэлд хүрэх	to touch one's heart	Амжилтанд хүрэх	to gain success
Сананд хүрэх	to meet one's expectation	Хэлсэндээ хүрэх	to keep one's word
		Насанд хүрэх	to become an adult
Аминд хүрэх	to kill		

Note: The words that are in the first column are used with nouns with genitive cases. For example: Миний нойр хүрч байна. (I'm feeling sleepy.)

Шилэнд бүү хүр.	Don't touch the glass.
Миний гар өлгүүрт хүрэхгүй байна.	My hand can't reach the hanger.
Бид 5 цаг гэхэд тэнд хүрнэ.	We will get there by 5 o'clock.
Миний залхуу хүрч байна.	I'm feeling lazy.
Чиний гижиг хүрч байна уу?	Are you feeling ticklish?
Хүмүүсийг муухай үг хэлэхээр түүний уур хүрдэг.	When people say bad words, she feels angry.
Түүнийг унахад миний инээд хүрсэн.	When he fell down, I felt like laughing.
Нэг юмаа олон дахин хийвэл миний дургүй хүрдэг.	If I do one thing many times, I feel I dislike it.
Энэ дуу миний сэтгэлд хүрсэн.	This song touched my heart.
Миний хийсэн юм түүний санаанд хүрдэггүй.	Things I do don't meet her expectation.
Тэр алуурчин олон хүний аминд хүрсэн.	That killer killed many people.
Зарим эцэг эх хүүхдүүддээ гар хүрдэггүй.	Some parents don't spank their children.
Өвлийн улиралд хүмүүс ханиад их хүрдэг.	In the season of winter, people catch colds a lot.
Манай охин ирэх сард 16 (нас) хүрнэ.	My daughter will turn 16 next month.
Машин авахад энэ мөнгө хүрэх үү?	Will this money be enough to buy a car?
Бүх хүн зорилгодоо хүрэхийг хүсдэг.	All people want to achieve their goals.
Ажилсаг хүн амжилтанд хүрнэ.	A hard working person can gain success.
Тэр хэлсэндээ үргэлж хүрдэг.	She keeps her promises all the time.
Насанд хүрээгүй хүүхдүүдэд архи, тамхиар үйлчлэхийг хориглоно.	It's prohibited to serve children who are under 18 vodka or cigarettes.

Дасгал 1

Нөхцөл байдал бүрт тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

Жишээ нь:
Миний нойр хүрч байна. → Нойр чинь хүрч байвал дуг хий.

1. Миний залхуу хүрч байна.
2. Миний уур хүрч байна.
3. Миний инээд хүрч байна.
4. Миний дургүй хүрч байна.
5. Би ханиад хүрчихсэн байна.
6. Би зорилгодоо хүрмээр байна.
7. Би амжилтанд хүрмээр байна.
8. Би хэлсэндээ хүрмээр байна.

Дасгал 2

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ нь:
Чи яагаад эвшээгээд байна аа? → Миний нойр хүрч байна.

1. Чи яагаад ийш тийшээ холхиод байна аа?
2. Чи яагаад ангиас гүйгээд гараад явчихсан юм бэ?
3. Чи яагаад улайчихсан байсан юм бэ?
4. Чи яагаад ажлаа хийхгүй суугаад байгаа юм бэ?
5. Чи яагаад эм уугаад байгаа юм бэ?
6. Чи яагаад инээгээд байгаа юм бэ?
7. Чи яагаад их ажилладаг юм бэ?
8. Чи яагаад хоолоо идэхээ больчхов оо?

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. Don't touch this glass. It will be broken easily.
2. If you touch this, you will burn your finger.
3. The girl's hand doesn't reach the door bell.
4. If your hands don't reach the shelf, use this ladder.
5. We will arrive there by five o'clock.
6. Do things that people do meet your expectation?
7. The picture I drew doesn't meet my expectation.
8. Do you spank your children sometimes?
9. Is it good or bad to spank kids?
10. I will turn 30 this year.
11. What do I need to do if I catch a cold?
12. This silk will be enough to make a dress for you.
13. Will this money be enough to buy warm winter boots?

Хорин есдүгээр хичээл

Төлөөний үг (яах) (Proword (to do what))

Яасан бэ?	What happened?
Чи яасан бэ?	What happened to you?/What did you do?
Яах вэ?	What shall we do?/What should I do?
Ингэвэл яадаг вэ?	What happens if I do this?
Чи яадаг вэ?	What do you do?
Чи яаж байгаа юм бэ?	What are you doing? (Scolding)
Чи яах гэж байгаа юм бэ?	What are you going to/about to do?
Чи яамаар байна вэ?	What do you want to do?
Чи яах хэрэгтэй вэ?	What do you need to do?
Чи яах дуртай вэ?	What do you like to do?

яагаад	Why
яаж	How
яавал	What makes ... (If what happens ...)
яахлаар	What makes ... (When what happens ...)

Нохой тан руу дайрахад та яасан бэ?	What did you do when the dog attacked you?
Энэ төлөвлөгөө бүтэхгүй бол чи яах вэ?	What will you do if this plan doesn't succeed?
Хүмүүстэй санал нийлэхгүй бол чи яадаг вэ?	What do you do if you don't agree with people?
Чи шугамаар яах гэж байгаа юм бэ?	What are you going to do with the ruler?
Чи төрсөн өдрөөрөө яамаар байна (вэ)?	What do you want to do on your birthday?
Чи яах дургүй юм бэ?	What don't you like to do?
Чи амралтаараа яах хэрэгтэй юм бэ?	What do you need to do during your vacation?
Чи яагаад найздаа туслаагүй юм бэ?	Why didn't you help your friend?
Та энийг яаж хийсэн юм бэ?	How did you do this?
Намайг яавал ээж чинь баярлах вэ?	Am I doing what will make your mother happy?
Яавал таны инээд хүрдэг вэ?	What makes you feel like laughing?
Таны инээд хүрвэл та яадаг вэ?	If you feel like laughing, what do you do?
Яахлаар таны уур хүрдэг вэ?	What makes you feel angry?
Уур чинь хүрэхлээр та яадаг вэ?	When you feel angry, what do you do?

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Хүмүүсийг яах(л)аар таны уур хүрдэг вэ?
   Уур чинь хүрэхээр та яадаг вэ?
2. Яахаар таны залхуу хүрдэг вэ?
   Залхуу чинь хүрэхээр та яадаг вэ?
3. Яахаар нойр чинь хүрдэг вэ?
   Нойр чинь хүрэхээр та яадаг вэ?

4. Хүмүүсийг яахаар дургүй чинь хүрдэг вэ?
   Дургүй чинь хүрэхээр та яадаг вэ?
5. Би яавал хурдан амжилтанд хүрэх вэ?
6. Яавал хүмүүс урт наслах вэ?
7. Яавал хүмүүс залуу харагдах вэ?
8. Амжилтанд хүрэхийн тулд би яах ёстой вэ?
9. Зорилгодоо хүрэхийн тулд би яах хэрэгтэй вэ?
10. Таны бүх ажил бүтэхгүй байвал та яах вэ?

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдал бүрт яах гэдэг үгийг ашиглан гурван асуулт бич.
(Write three questions for each situation using the word яах.)

Жишээ нь:
Найз чинь хоолоо идэхгүй байна. Түүнээс юу гэж асуух вэ?
А. Чи яагаад хоолоо идэхгүй байгаа юм бэ?
Б. Намайг яавал чи хоолоо идэх юм бэ?
В. Чамайг хоолоо идэхгүй болохоор надад хэцүү байна. Би яах ёстой юм бэ?

1. Найз чинь их баяр баясгалантай байна. Түүнээс юу гэж асуух вэ?
2. Хөдөө машин чинь эвдрээд зогсчихсон байна. Хамт явж байгаа хүнээсээ юу гэж асуух вэ?
3. Дүү чинь хичээлдээ явахгүй гэж танд хэлсэн. Түүнээс юу гэж асуух вэ?
4. Та монгол хэлийг маш хурдан сурмаар байна. Багшаасаа юу гэж асуух вэ?
5. Нэг найз чинь дандаа бухимдаж байдаг. Та тэр найздаа зөвлөгөө өгөхийг хүсч байна. Тэгээд найзаасаа юу гэж асуух вэ?
6. Хоорондоо маш эвсгээр хамтарч ажилладаг нэгэн компанийн ажилтнуудтай та уулзаж байна. Тэднээс юу гэж асуух вэ?

Дасгал 3

Зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the pictures.)



Гучдугаар хичээл

Үйлдүүлэх хэв (Causative Voice)

In the sentence has a transitive verb (verb that requires an object), the name of the person who does the action takes instrumental case (**-аар**[4]).

Би **Батхүүгээр** энэ хоолыг хийлгэсэн.	I had Bathuu cook this food.
Тэр, хүүхдүүдээр энэ номыг уншуулдаг.	He has children read this book.
Багш сурагчдаар тэр ширээг хийлгэсэн.	The teacher had pupils make that table.

In the sentence that has an intransitive verb (verb that doesn't require an object), the name of the person who is the object takes accusative case (**-ийг/-ыг/-г**).

Би **Батхүүг** инээлгэсэн.	I made Bathuu laugh.
Би найзыгаа баярлуулмаар байна.	I want to make my friend happy.
Тэд намайг айлгасан.	They scared me.

In the sentence that has a transitive verb, if the subject does action for someone, the name of that person who receives the action takes **dative and locative case**.

Би **Батхүүд** энэ хөгжмийг сонсгосон.	I made Bathuu listen to this music.
Би хүүхдэд тэр хоолыг идүүлсэн.	I made the child eat that food.
Ээж надад дулаан малгай өмсгөсөн.	Mom made me wear a warm hat.

After verb stems ending with consonants, short vowels or soft sign	After verb stems ending with long vowels or diphthongs	After verb stems ending with consonants **р** or **с**	After some verb stems
-уул[2]	**-лга**[4]	**-га**[4]	**-аа**[4]
явуулах	хийлгэх	гаргах	унтраах
торгуулах	инээлгэх	хөргөх	амраах
ажиллуулах	суулгах	хүргэх	асаах
хэлүүлэх	буулгах	норгох	хатаах
бичүүлэх	угаалгах	өсгөх	сэрээх
олуулах	хаалгах	өлсгөх	ядраах
уншуулах	түүлгэх	босгох	гомдоох
бариулах	нээлгэх	эсгэх	цочоох
өгүүлэх	заалгах	нисгэх	шатаах

Exceptions: авах → авахуулах, болох → болгох, унах → унагах (to make someone fall down or drop)/унуулах (to have someone ride), харах → харуулах, өвдөх → өвтгөх, цадах → цатгах, өргөдөх → өргөтгөх, сулдах → султгах

Note: When the causative suffixes "-уул" and "-үүл" are added to verb stems, the suffixes that are added after them will depend on them, not the stems. For example: оруулсан (not оруулсон), өгүүлсэн (not өгүүлсөн)

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, ах, дугуй, засах
Би ахаараа дугуйгаа засуулсан. (I had my brother fix my bicycle.)

1. Жаргалмаа, найз, хоол, хийх
2. Би, дүү, дэлгүүр, мах, авах
3. Багш, тэд, хичээл, бичих
4. Би, тэр багш, монгол хэл, заах
5. Хүү, аав, байшин, барих
6. Би, Болд, зураг, авах
7. Охин, эмээ, үлгэр, унших
8. Би, эгч, хувцас, угаах
9. Тэр, найз, цонх, арчих
10. Баярхүү, найз, цэцэг, түүх
11. Би, ах, цаасан шувуу, хийх
12. Тэр, найз, захиа, бичих
13. Тэр, дүү, гэр, цэвэрлэх
14. Би, охин, цэцэг, услах
15. Би, оёдолчин, даашинз, оёх
16. Би, тэр хүн, бүжиг, заах
17. Тэр, Ууганхүү, дуу, орчуулах
18. Би, гуталчин, гутал, засах
19. Тэд, багш, хэлзүй, тайлбарлах
20. Жаргалмаа, би, ажил, хийх
21. Би, мужаан, сандал, хийх
22. Бид, цахилгаанчин, тоолуур, засах
23. Би, тэр хүн, зураг, авах
24. Цэцэгмаа, эмээ, хүү, харах
25. Охин, өвөө, үлгэр, унших
26. Тэр, нөхөр, дэлгүүр, цамц, авах

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, ах, уурлах → Би ахыгаа уурлуулсан. (I made my brother angry.)

1. Би, Батхүү, айх
2. Жаргалмаа, дүү, инээх
3. Багш, би, дэлгүүр, явах
4. Ээж, хүү, эрт, босох
5. Багш, хүүхдүүд, анги, байх
6. Та, тэр хүмүүс, энд, суух
7. Би, та нар, гэр, байх
8. Чи, хүүхэд, ширээ, дээр, буух
9. Би, ээж, хөдөө, амрах
10. Би, найз, баярлах
11. Тэр, би, их, хүлээх
12. Найз, битгий, уурлах
13. Жолооч, битгий, их, ажиллах
14. Морь, битгий, ядрах
15. Гөлөг, битгий, цочих
16. Нохой, битгий, сэрэх
17. Үхэр, битгий, босох
18. Хүүхдүүд, битгий, гүйх
19. Туулай, битгий, унах
20. Найз, битгий, гомдох

Дасгал 3

Үйл үгсийг үйлдүүлэх хэвийн нөхцөлөөр хувирга. (Add causative suffixes to the verbs.)

Жич: Доогуур нь зурсан үгс үйлдүүлэх хэвийн –аа[4] нөхцөлөөр хувирна. (The verbs that are underlined will use the suffix –аа[4].)

1. яв
2. хий
3. гар
4. ас
5. заа
6. торго
7. унт
8. инээ
9. ажилла
10. ядар
11. түү
12. бос
13. буу
14. хэл
15. хүр
16. барь
17. бич
18. угаа
19. нис
20. нээ
21. сэр
22. хат
23. суу
24. унш
25. ол
26. хаа
27. амар
28. гомд

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Тэр надад сонирхолтой ном үзүүлнэ гэсэн.
2. Батхүү бээрсэн хүүд халуун цай уулгав.
3. Би дүүдээ сүүтэй будаа идүүлсэн.
4. Тэр шүлэг хүмүүст их юм бодуулсан байх.
5. Багш надад тэр хичээлийг ойлгуулсан.
6. Баярхүү хүүдээ намуухан хөгжим сонсгодог.
7. Та надад хичээлийн талаар сануулаарай.
8. Та хүүдээ дулаан хувцас өмсүүлэх (өмсгөх) хэрэгтэй.
9. Түүний үг надад олон юмыг мэдрүүлсэн.

Дасгал 5

Доорх үйл үгс ямар тийн ялгалд (-ыг[2]/-г, -аар[4], -д/-т) байгаа тусагдахууныг захирахыг сайтар бодож, өгүүлбэр зохиож бич. (Think about objects which with what cases (-ыг[2]/-г, -аар[4], -д/-т) can be used with the following verbs and make sentences with them.)

1. явуулах
2. хийлгэх
3. гаргах
4. сануулах
5. угаалгах
6. инээлгэх
7. хөргөх
8. амраах
9. ажиллуулах
10. суулгах
11. хүргэх
12. асаах
13. хэлүүлэх
14. ойлгуулах
15. бариулах
16. нээлгэх
17. идүүлэх
18. буулгах
19. босгох
20. хатаах
21. бичүүлэх
22. унтраах
23. авахуулах
24. өмсгөх
25. мэдрүүлэх
26. нисгэх
27. сэрээх
28. заалгах
29. олуулах
30. хаалгах
31. болгох
32. уулгах
33. уншуулах
34. түүлгэх
35. унагах
36. гомдоох
37. цочоох
38. сонсгох
39. ядраах
40. үзүүлэх

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I had that teacher teach me Mongolian.
2. They don't like having their mother clean the house.
3. We had Gerelmaa take our photo.
4. We had Bathuu talk about Mongolian history at the meeting.
5. The teacher had the students write an essay.
6. Loud noise makes me tired.
7. I will have my brother paint the walls.
8. Please have the kids stand here.
9. Please don't make them wait for a long time.
10. He always makes me laugh.
11. Don't have the baby stay outside a long time.
12. The boy had the repair man fix his bicycle.
13. The grandmother had her grandson look for her glasses.
14. Ganhuu had his granddauther tell the truth.
15. That story made me think a lot.
16. Bad people always want to have their friends do bad things.
17. Don't say scary things and scare children.

Дасгал 7

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Нийлмэл хэв (Double Causative Voice)

Intransitive verbs (that don't require objects) can be used with double causative suffixes.

For example: **суух → суулгах → суулгуулах**

Хүмүүс ширээнд суусан.	People sat at the table.
Захирал хүмүүсийг ширээнд суулгасан.	The director made people sit at the table.
Захирал зөөгчөөр хүмүүсийг ширээнд суулгуулсан.	The director had the waiter have people sit at the table.

шатах → шатаах → шатаалгах

Тэр хог шатсан.	That garbage was burned.
Хүрэлхүү тэр хогийг шатаасан.	Hurelhuu burned that garbage.
Хүрэлхүү хүүхдүүдээр тэр хогийг шатаалгасан.	Hurelhuu had the children burn that garbage.

сэрэх → сэрээх → сэрээлгэх

Би сэрсэн.	I woke up.
Аав маань намайг сэрээсэн.	My father woke me up.
Аав маань Ганхүүгээр намайг сэрээлгэсэн.	My father had Ganhuu wake me up.

Дасгал 8

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Босох → босгох → босгуулах

Манай дүү боссон.	My brother got up.
Ээж дүүг босгосон.	Mom made my brother get up.
Ээж надаар дүүг босгуулсан.	Mom had me get my brother up.

1. Унтрах, унтраах, унтраалгах
2. Асах, асаах, асаалгах
3. Хатах, хатаах, хатаалгах
4. Зогсох, зогсоох, зогсоолгох
5. Гарах, гаргах, гаргуулах
6. Буух, буулгах, буулгуулах
7. Норох, норгох, норгуулах
8. Хүлээх, хүлээлгэх, хүлээлгүүлэх
9. Халах, халаах, халаалгах
10. Хөрөх, хөргөх, хөргүүлэх
11. Нисэх, нисгэх, нисгүүлэх
12. Хүрэх, хүргэх, хүргүүлэх
13. Суух, суулгах, суулгуулах
14. Гүйх, гүйлгэх, гүйлгүүлэх
15. Амрах, амраах, амраалгах
16. Буцах, буцаах, буцаалгах
17. Болох, болгох, болгуулах
18. Гүйцэх, гүйцээх, гүйцээлгэх

Давтлага хичээл (26–30)

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I don't doubt that you will work successfully.
2. I doubt that I will be able to come on time.
3. I don't doubt that he can help me.
4. I don't doubt that you can give up smoking.
5. I believe that he will become a good person.
6. I'm confident that you will learn Mongolian well.
7. I'm confident that I will learn Mongolian well.
8. Smoking is bad for your health.
9. I don't care if he is tall or not.
10. If you want to work or not is important.
11. This will depend on if you can finish soon or not.
12. It will depend on if it will be warm or not.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүмүүс баярлахлаараа ...
2. Намайг сэтгэлээр унахлаар ...
3. Миний уур хүрэхлээр ...
4. Таны залхуу хүрэхлээр ...
5. Хүүхдүүд айхлаараа ...
6. Намайг ханиад хүрэхлээр ...
7. Хүүхдүүд ядрахлаараа ...
8. Хүмүүсийг эвшээхлээр ...
9. Цаг агаар дулаарахлаар ...
10. Тэр зургаа авахуулахлаараа ...

Дасгал 3

Доорх үйл үгсээс тохирохыг нь бичиж өгүүлбэрүүдийг гүйцээ.
(Choose the appropriate verb from the following list and complete the sentences.)

мэдэрдэг, хүрдэг, санагддаг

1. Хүмүүс арьсаараа халуун, хүйтнийг ...
2. Нэг газраа удаан суухлаар миний нойр ...
3. Нохой үнэрийг маш сайн ...
4. Хүмүүсээс баярлалаа гэдэг үгийг сонсохлоор надад сайхан ...
5. Хэрэлдэж байгаа хүмүүсийг харахлаар надад аймаар ...
6. Халуун газар байхлаар миний залхуу ...
7. Хүмүүс хэлээрээ амтыг ...

Дасгал 4

Асуултуудыг орчуулж хариулт бич. (Translate the sentences and answer them.)

1. What did you do with your old car?
2. What are you going to do with that money?
3. What happened to you yesterday?
4. What do you do with this stick?
5. If your car breaks down, what will you do?
6. What makes people angry?
7. When people are angry, what do they do?
8. What makes people happy?
9. When people are happy, what do they do?

Дасгал 5

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. шүүрдүүлэх
2. гаргах
3. баярлуулах
4. самнуулах
5. инээлгэх
6. амраах
7. бариулах
8. нээлгэх
9. бичүүлэх
10. суулгах
11. өмсгөх
12. сэрээх
13. яриулах
14. олуулах
15. болгох
16. уулгах
17. шалгуулах
18. түүлгэх
19. унагах
20. авахуулах
21. ядраах

Дасгал 6

Доорх үйл үгсийг нийлмэл хэвийн нөхцөлөөр хувиргаж өгүүлбэр зохио.
(Use double causative suffix on the following verbs and make sentences with them.)

1. Суух
2. Болох
3. Зогсох
4. Хатах
5. Хөрөх
6. Халах

Тест (26–30)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би энийг хийж чадна гэдэгтээ итгэж байна.
Б. Би энийг хийж чадна гэдгээсээ итгэж байна.
В. Би энийг хийж чадна гэдэгтэй итгэж байна.

2. This will depend on if it will snow or not.
А. Энэ нь цас орох уу, үгүй юу гэдэгт шалтгаална.
Б. Энэ нь цас орох уу, үгүй юу гэдгээс шалтгаална.
В. Энэ нь цас орох уу, үгүй юу гэдгээсээ шалтгаална.

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүмүүс айхлаар яадаг вэ?
Б. Хүмүүс айхлаараа яадаг вэ?
В. Хүмүүсийг айхлаараа яадаг вэ?

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Багш дохио өгөхөөрөө бид гүйнэ.
Б. Багшийг дохио өгөхөөрөө бид гүйнэ.
В. Багшийг дохио өгөхөөр бид гүйнэ.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хавар болохлоор цэцэг ногоо ургадаг.
Б. Хавар болохлоороо цэцэг ногоо ургадаг.
В. Хаврыг болохлоор цэцэг ногоо ургадаг.

6. People feel taste with their tongue.
А. Хүмүүс хэлтэйгээ амтыг мэдэрдэг.
Б. Хүмүүс хэлээрээ амтыг мэдэрдэг.
В. Хүмүүс хэлээр амтыг мэдэрдэг.

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр жүжиг надыг сайхан санагдсан.
Б. Тэр жүжгийг надад сайхан санагдсан.
В. Тэр жүжиг надад сайхан санагдсан.

8. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Миний нойр хүрч байна.
Б. Би нойр хүрч байна.
В. Надад нойр хүрч байна.

9. Don't touch the glass.
А. Шил битгий хүр.
Б. Шилэнд битгий хүр.
В. Шилийг битгий хүр.

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чи хэлсэндээ хүрэх хэрэгтэй.
Б. Чи хэлсэнд хүрэх **хэрэгтэй**.
В. Чиний хэлсэндээ **хүрэх хэрэгтэй**.

11. What makes you feel angry?
А. Ямар үед таны уур хүрдэг вэ?
Б. Яагаад таны уур хүрдэг вэ?
В. Яахлаар таны уур хүрдэг вэ?

12. What should I do?
А. Би яах вэ?
Б. Би яадаг вэ?
В. Би яасан бэ?

13. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Багш хүүхдүүдэд анги цэвэрлүүлнэ.
Б. Багш хүүхдүүдийг анги цэвэрлүүлнэ.
В. Багш хүүхдүүдээр анги цэвэрлүүлнэ.

14. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр надаар инээлгэсэн.
Б. Тэр намайг инээлгэсэн.
В. Тэр надад инээлгэсэн.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би найзаараа зураг зургасан.
Б. Би найзаараа зураг зуруулсан.
В. Би найзаараа зураг зуралгасан.

16. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Ахаараа цонх нээлгэ.
Б. Ахаараа цонх нээгүүл.
В. Ахаараа цонх нээгэ.

Оноо (point): 16/ .....

Гучин нэгдүгээр хичээл

Үйлдэгдэх хэв (Passive Voice)

Transitive verbs (that require objects) can be used as a passive. The suffixes are **-гд**, **-т**, **-д** and **-р**.

харах	→	харагдах	to been seen (to look)
бичих	→	бичигдэх	to be written
өөрчлөх	→	**өөрчлөгдөх**	to be changed
солих	→	**солигдох**	to be exchanged
барих	→	**баригдах**	to be built, to be held, to be caught
нэмэх	→	нэмэгдэх	to be added, to be increased
хасах	→	хасагдах	to be subtracted/to be taken
сонсох	→	сонсогдох	to be heard
авах	→	автах/авагдах	to be addicted, to be taken
үнэрлэх	→	үнэртэх	to be smelled
олох	→	олдох	to be found

Миний нүдний шил **олдоогүй**.	My glasses were not found.
Энд олон юм **өөрчлөгджээ**.	Many things **have changed** here.
Махны үнэ **нэмэгдлээ**.	Meat price **has increased**.
Гэмт хэрэгтэн цагдаад **баригджээ**.	The criminal **was caught** by police.

Some verbs use **р**. For example: эвдэх → эвдрэх (to be broken (doesn't work))
хагалах → хагарах (to be broken (glass, ball, tire etc.,))
хугалах → хугарах (to be broken (long things like pencil, tree and stick into two pieces))
цоолох → цоорох (to have a hole)

Few verbs use passive voice suffix and change their meaning. For example: хожих (to win) → хожигдох (to loose), ялах (to win) → ялагдах (to loose)

Usages:

1. When it's not important to mention a person who did (will do) it then passive form is used.

Энэ байшин 1980 онд баригдсан.	This building was built in 1980.

If it's important to mention a person who did (will do) it, then active form is used.

Орос хүмүүс энэ байшинг 1980 онд барьсан.	Russians built this building in 1980.

2. Some verbs that express feelings or senses (like харагдах, сонсогдох, баригдах, үнэртэх, амтагдах, мэдрэгдэх, анзаарагдах, бодогдох etc.,) are used with words that have suffixes **-д** or **-т**. For example:

Надад мод харагдаж байна.	I see a tree.
Танд хоол үнэртэж байна уу?	Do you smell any food?

3. Some verbs use both passive and causative suffixes (for passive form) and mean different things.

Би нохойд хазуулсан.	I was bitten by the dog.
Хоол идэж байхад чулуу хазагдсан.	When I was eating food, I bit a stone.
Нэг хонь чононд идүүлжээ.	One sheep was eaten by a wolf.
Төмөр зэвэнд идэгддэг.	Iron is eroded by rust.

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.

1. Танай ногооны талбай их гоё харагдаж байна.
2. Тэр уулын бэлд байдаг байшин эндээс сайн харагдахгүй байна.
3. Та залуу/сайхан/өөр харагдаж байна.
4. Би энд, хотод удаан ирээгүй. Олон юм өөрчлөгдсөн байна.
5. Миний утасны дугаар өөрчлөгдсөн шүү.
6. Яана аа, миний нэг товч гээгдчихжээ.
7. Энэ сүм 100 жилийн өмнө баригдсан гэж би сонссон.
8. Надад нэг ч загас баригдсангүй.
9. Энэ номыг уншаарай. Энэ номонд Монголын тухай бичигдсэн байгаа.
10. Улаан, шар будаг сайн холигдоогүй байна. Дахиад хутга.
11. Ханиад хүрээд хамар маань битүүрчихсэн учраас надад юу ч үнэртэхгүй байна.
12. Энд их чимээтэй байгаа учраас надад юу ч сонсогдохгүй байна.
13. Гадаа шороон шуурга шуурч байгаа болохоор надад зам сайн харагдахгүй байна.
14. Таны хагархай шил анзаарагдахгүй байна.
15. Би их сандарсан. Тэгээд надад юу ч санагдаагүй.
16. Өнгөрсөн шөнө би нэг зүүд зүүдэллээ. Би нэг том хаалганы урд зогсож байсан ба хаалга өөрөө удаан нээгдээд намайг дотогшоо орсны дараа удаан хаагдав. Би тэнд олон гайхамшигтай юм үзлээ.
17. Хүүхэд насны дурсамжууд ерөөсөө мартагддаггүй.
18. Та шинэ үгээ олон удаа давтвал мартагдахгүй.
19. Хүний хэлсэн муухай/сайхан үг ерөөсөө мартагддаггүй.
20. Үер бууж хот усанд автжээ.
21. Олон хонь чононд идүүлсэн.
22. Хүүхэд байхдаа тэр нэг удаа нохойд хазуулсан.
23. Тэр ерөнхийлөгчөөр/захирлаар/даргаар сонгогдсон.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуулаад өмнөх дасгалаас харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the previous exercise and correct any mistakes.)

1. Your vegetable field looks very beautiful.
2. I can't see the house that is at the foot of that mountain.
3. You look young/nice/different.
4. I didn't come here to the city for a long time and many things have changed.
5. My phone number has changed.
6. Oh, no. One of my buttons is lost.
7. I heard that this church was built 100 years ago.

8. I didn't catch fish, not even one. (Fish were not caught by me, not even one.)
9. Please read this book. It has been written about Mongolia.
10. The red and yellow paints haven't mixed well. Stir them again.
11. I don't smell anything because I have a cold and my nose is stuffed-up.
12. I don't hear anything because it's very noisy here.
13. I don't see the road well because there is a dust storm outside.
14. Your broken glass is not noticeable.
15. I was very nervous and I couldn't remember anything.
16. I had one dream last night. I was in front of one big door and it opened slowly by itself. After I went in, the door was closed slowly. I saw many wonderful things there.
17. Memories from childhood time are never forgotten.
18. If you repeat a new word many times it won't be forgotten.
19. A bad/good word that someone said is never forgotten.
20. There was a flood and the city was taken by water.
21. Many sheep are eaten by wolves.
22. When he was a child, he was bitten by a dog once.
23. He was elected as the president/director/boss.

Дасгал 3

Доорх өгүүлбэрүүдийг үйлдэгдэх хэвтэй болгон өөрчилж бич.
(Change the following sentences into sentences with passive voice.)

Жишээ нь:

Би таны нэрийг энд бичсэн байгаа.	I have written your name here.
Таны нэр энд бичигдсэн байгаа.	Your name has been written here.

1. Би Ганхүүг хараагүй.
2. Та тэр модыг харж байна уу?
3. Багш энэ хичээлийг заагаагүй.
4. Хүүхдүүд олон эрвээхий барьсан.
5. Би түүний үсийг өөрчилнө.
6. Би энэ зургийг солино.
7. Багш номоо олоогүй.
8. Би хөлийн чимээ сонсоогүй.
9. Тэр нутгаа их санадаг
10. Ээж олон хувцас угаасан.
11. Бороо орж олон юмыг угаасан.
12. Бид нэг өдөр олон ажил хийдэг.
13. Би ээжийгээ бодож байна.
14. Түүний үгийг би ойлгохгүй байна.
15. Тэр сарын өмнө энэ дэлгүүрийг нээсэн.
16. Энэ номыг олон хувь хэвлэсэн.
17. Засварчин таны машиныг засаагүй байна.
18. Тэд энэ айлын малыг тоолоогүй.
19. Тэд энэ байрыг жилийн өмнө барьсан.

Гучин хоёрдугаар хичээл

Хамтран үйлдэлцэх хэв (Communal Voice)

Verb stem + лц

This suffix expresses the meaning that someone helps someone to do something.

Би ээжтэйгээ хоол хийсэн.	I cooked with my mother.
Би ээжтэйгээ хоол хийлцсэн.	I helped my mother to cook.
Тэр эгчтэйгээ гэр цэвэрлэлцдэг.	She helps her sister to clean the house.
Чи ээжтэй хоол хийлц(ээрэй).	(Please) help mom to cook.
Тэр ээжтэй хоол хийлцэг.	Let her help mom to cook.

Spelling rule:
Suffix **–лц** is added directly to verb stems ending with vowels and when it's added to verb stems ending with consonants, vowels are inserted. For example: хий + лц = хийлц, гарга + лц = гаргалц, хай + лц = хайлц, бич + лц = бичилц, зас + лц = засалц
If it's added to verb stems ending with a soft sign, the soft sign becomes **и**. For example: барь + лц = барилц, ярь + лц = ярилц

Note: In some cases the suffix -лц means two people do something to each other equally. For example: танилцах, ярилцах, хэлэлцэх, буудалцах, оролцох, шидэлцэх

Тэд тун удахгүй энэ асуудлыг хэлэлцэнэ.	They will discuss this issue very soon.
Хоёр тал буудалцсан.	Two sides shoot each other.
Бид бие биентэйгээ танилцлаа.	We got to know each other.

Дасгал 1

Үйл үгийн үндсэнд –лц нөхцөлийг залгаж өгүүлбэр зохио.
(Add the suffix –лц to the verb stems and make sentences with them.)

1. тат	5. зас	9. тоол	13. орчуул
2. хий	6. өргө	10. шалга	14. буд
3. цэвэрлэ	7. тавь	11. хэмж	15. арч
4. барь	8. хая	12. тарь	16. хар

Дасгал 2

Доорх нөхцөл байдалд тохируулан (–лц нөхцөлийг ашиглан) өгүүлбэр зохио.
(Make sentences that suit the following situations using the suffix –лц.)

Жишээлбэл:
Найз чинь ажил хийгээд ядарч байх шиг байна. → Би найздаа тусалж хамт хийлцэнэ.

1. Хүүхдүүд ангийнхаа сандал, ширээнүүдийг өөр анги руу зөөж байна.
2. Охин чинь өндөг шарж байна.
3. Найз чинь олон хуудас юм гараараа хуулж бичих ёстой болсон.
4. Найз чинь дугуйгаа засах хэрэгтэй байна.
5. Номын санч номуудаа цэгцэлж байна.
6. Ах чинь ганцаараа байшин барьж байна.
7. Хүү чинь гал түлэхээр мод хагалж байна.
8. Хүүхэд хаалгаа хааж чадахгүй байна.
9. Найз чинь олон хувцас зарах хэрэгтэй байна.
10. Найзын чинь машин эвдрээд явахгүй байна. Нэг хүн машиныг нь түлхэж байна.
11. Найз чинь нүхнээс унадаг дугуйгаа татаж гаргахаар оролдож байна.
12. Эгч чинь ханын цаас нааж байна.
13. Найз чинь юм орчуулахаар сууж байна. Орчуулга хийх түүнд хэцүү байна.
14. Найз чинь дэлгүүрээс олон юм авах хэрэгтэйгээ чамд хэлсэн.

Харилцан үйлдэлдэх хэв (Reciprocal Voice)

Verb stem + лд

This suffix shows there are two or more people/things/animals in the action.

Хүүхдүүд сургуулийн үүдээр гүйлддэг. (Children run in the school entrance area.)
1024 бөх наадмаар барилдсан. (1024 wrestlers wrestled during Naadam Festival.)
Олон улс орон өөр хоорондоо байлдсан. (Many countries have waged a war between themselves.)

Spelling rule is same as the suffix –лц (in the page 123).

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Зам дээр хэд хэдэн машин мөргөлджээ.
2. Хүү маань сэлмээр сайн тулалддаг.
3. Хүүхдүүд тоглоомоо булаалдаад уйлалдаад байна.
4. Онгоц эсэн мэнд газардахад онгоцонд байсан хүмүүс хоорондоо тэврэлдэн баярлалдав.
5. Сандарсан хүмүүс дэмий л нааш цааш гүйлдэнэ.
6. Гадаа хүүхдүүд шуугилдаад би унтаж чадсангүй.
7. Миний чанасан гоймон хоорондоо наалдчихжээ.
8. Эрэгтэй хүүхдүүд маргалдаж байгаад зодолдоод эхэллээ.
9. Хүүхдүүдийн хувцас холилдчихсон байна.
10. Битгий тэр муу хүүхэдтэй зууралдаад бай.

Гучин гуравдугаар хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-саар[4] (л) байна/байгаа (keep ...-ing)/байсан (kept ...-ing)

Юмны үнэ **нэмэгдсээр байна**.
Бороо орсоор байна.
Ус бохирдсоор л байна.
Голууд ширгэсээр л байна.
Хүмүүс түүнд захиа бичсээр байгаа.
Машин хурдалсаар л байсан.

The price of things **keeps increasing**.
It keeps raining.
Waters keep being polluted.
The rivers keep drying up.
People keep writing letters to her.
The car kept going fast.

Note: The suffix **л** gives emphasis to it.
Spelling rules: The suffixes -саар (verb stems with а, у and я), -сээр (verb stems with э, ү and и), -соор (verb stems with о), -сөөр (verb stems with ө) are used directly after all verb stems. For example: орсоор, хийсээр, итгэсээр, авсаар, өгсөөр, үзсээр

Дасгал 1

Үйл үгийн үргэлжлэх хэлбэрийн нөхцөлийг ашиглан өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences using the continuous form.)

1. Хүмүүс байгалийг судал ...
2. Хүмүүс муу зүйл хий ...
3. Хүмүүс авлигатай тэмц ...
4. Хүмүүс охинд тусал ...
5. Сурагч хичээлээ хий ...
6. Тэр хүний бие мууд ...
7. Таны бие сайжир ...
8. Долларын ханш өс ...
9. Мод хорогд ...
10. Барилгачид байр барь ...
11. Дэлхийн цаг агаар дулаар ...
12. Шувууд олноороо үх ...
13. Нислэг хойшил ...
14. Цас ор ...
15. Гэмт хэргийн тоо өс ...
16. Хүмүүс хоолонд хорд ...

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
Малын тоо толгой ...
Малын тоо толгой өссөөр л байна. (The number of the livestock still keeps increasing.)

1. Том хүмүүс ...
2. Хүүхдүүд ...
3. Ан амьтад ...
4. Юмны үнэ ...
5. Улс төрчид ...
6. Байгаль судлаачид ...
7. Багш нар ...
8. Байгаль ...
9. Хүмүүсийн зан ааш ...
10. Техник технологи ...
11. Хотууд ...
12. Цаг агаар ...
13. Гэр бүл ...
14. Гэмт хэрэг ...
15. Ажилгүйдэл ...

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Тэд нар алхах, харанхуй болохоос өмнө хотод очих
Тэд нар (зогсолгүй) алхсаар байгаад харанхуй болохоос өмнө хотод очсон.
They kept walking (without stopping) and arrived at the city before it got dark.

1. Хүүхдүүд гадаа тоглох, ядрах
2. Бид тэр жимсийг идэх, бүгдийг нь дуусгах
3. Барилгачид өдөржин, шөнөжин барих, байшингаа хурдан дуусгах
4. Хүү ааваасаа гуйх, мөнгө авах
5. Тэр аав хүүдээ мөнгө өгөх, хүүгээ залхуу болгох
6. Тэр казинод тоглох, бүх мөнгөө дуусгах
7. Махны үнэ өсөх, 5000-д хүрэх
8. Гутлын үнэ хямдрах, 10 000-д хүрэх
9. Хүү гэртээ үзгээ хайх, олох
10. Хүү тоглоомоо цохих, эвдэх
11. Хүүхдүүд жимс түүх, оройтох
12. Хүүхэд зураг зурах, алдартай зураач болох
13. Хүмүүс нэг юмыг дахин дахин хийх, туршлагатай болох
14. Машин хурдлах, осол гаргах
15. Хүмүүс шаардах, цалингаа нэмүүлэх

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
Би ... хүчтэй болсон. → Би биеийн тамирын дасгал хийсээр байгаад хүчтэй болсон.

1. Би ... монгол хэл сайн сурна.
2. Хүмүүс ... өвчин тусдаг.
3. Тэд ... сургуулиа төгсч чадаагүй.
4. Тэр ... баян болсон.
5. Хүүхдүүд ... олон юмыг сурч авдаг.
6. Хүүхдүүд ... хичээлээсээ хоцордог.
7. Тэр ... дүүгээ инээлгэсэн.
8. Би ... балаа хугалчихлаа.
9. Тэр ... найзыгаа уйлуулчихжээ.
10. Тэд ... мөнгөө дуусгачихсан.
11. Хүүхдүүд ... сайн найзууд боллоо.
12. Би ... залхаад больсон.

Гучин дөрөвдүгээр хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-нгуут²(аа⁴)/-магц⁴(аа⁴) (As soon as/Immediately after)

Sentences with same subject:

Хүмүүс гэрт орж ирмэгцээ их гайхсан.	As soon as people came in the ger, they were very suprised.
Би гэртээ очингуутаа и-мэйлээ шалгана аа.	As soon as I get home, I will check my emails.

Sentences with different subjects:

Түүнийг өрөөнд оронгуут хүмүүс баяр хүргэж алга ташив.	As soon as he entered the room, people congratulated him and clapped their hands.
Багшийг дохио өгмөгц хүүхдүүд гүйсэн.	As soon as the teacher gave a signal, children ran.

When subordinate clause's subject belongs to main clause's subject, subordinate clause's subject takes reflexive suffix (-аа⁴).

Захирлыгаа ирмэгц оюутнууд түүнтэй уулзсан.	As soon as their director came, the students met him.

When a complex sentence has different subjects and if subordinate clause's subject is a thing without энэ, тэр, аль or the word with genitive case in front of it, it is not used with accusative case.

Цасан шуурга намдангуут бид гарч малаа хайв.	As soon as the snow storm stopped, we went out and looked for our animals.
Хичээл дуусмагц ангиа цэвэрлээрэй.	As soon as the lesson is over, please clean your classroom.

Spelling rules:

The suffixes **-магц** (for verb stems with а, у and я), **-мэгц** (for verb stems with э, ү and и), **-могц** (for verb stems with о), **-мөгц** (for verb stems with ө) are added directly to all verb stems.
For example:
яв + магц = явмагц, хар + магц = хармагц, эхэл + мэгц = эхэлмэгц, ор + могц = ормогц, хөр + мөгц = хөрмөгц.

The suffixes **-нгуут**(аа) (for verb stems with а, у, о and я), **-нгүүт**(ээ) (for verb stems with э, ү, ө and и) are added directly to the verb stems that end with vowels and when it's added to stems that end with consonants, vowels are added.
For example: хаа + нгуутаа = хаангуутаа, хий + нгүүтээ = хийнгүүтээ, өлгө + нгүүтээ = өлгөнгүүтээ, самна + нгуутаа = самнангуутаа, ид + нгүүтээ = идэнгүүтээ, өг + нгүүтээ = өгөнгүүтээ, бод + нгуутаа = бодонгуутаа, хар + нгуутаа = харангуутаа

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Автобус, зогсох; хүүхдүүд, үсэрч буух
2. Тэр, дуулах; хүмүүс, чимээгүй болох
3. Хүүхдүүд, орц, гарах; тоглоомын талбай, гүйх
4. Хичээл, дуусах; сурагчид, гэр гэр, явах
5. Бөхийн өргөө, урд, очих; би, утастах
6. Шүүгч, дохио өгөх; та нар, уралдах
7. Тэр, ном, унших, дуусах; унтах
8. Тог тасрах; хүүхэд, уйлах
9. Хүү, гэр, орох; зурагт, асаах
10. Дэлгүүр, онгойх; хүмүүс, дотогшоо орох
11. Тэр, дүү, таних; тэвэрч авах
12. Багш, анги, орох; хүүхдүүд, мэндлэх
13. Дээрэмчин, цагдаа, харах; нуугдах
14. Хулгайч, цагдаа, харах; зугтах
15. Ганхүү, эм уух; бөөлжих
16. Тэр, сэрэх; босох
17. Тэр, хараалын үг, хэлэх; ичих

Дасгал 2

Сурсан хэлзүйгээ ашиглан асуултад хариул.
(Answer the questions using the grammar you have just learned.)

Жишээ нь:
Та найздаа их инээдтэй юм ярьж өгчээ. Найз чинь яасан бэ? → Манай найз сонсогуутаа их инээсэн./ Намайг ярьж дуусангуут тэр инээсэн.

1. Та хоол хийж идэхийг хүссэн боловч танай цахилгаан тасраад чадахгүй байжээ. Харин цахилгаан их орой иржээ. Та яасан бэ?
2. Манай найз малдаа яваад их орой гэртээ ирдэг. Тэгээд хоолоо идэж дуусаад удалгүй унтдаг. Манай найз яадаг вэ?
3. Та найзтайгаа уулзахаар гэрт нь очжээ. Найз чинь гэртээ байхгүй байсан. Та найздаа нэг чухал бичиг өгөх хэрэгтэй байсан. Тэгээд та хүүд нь тэр бичгээ өгчээ. Та хүүд нь юу гэж хэлэх вэ?
4. Та 3 цагт хуралтай учраас ажил руугаа явах ёстой байжээ. Тэгээд та найзаасаа 2:30-д өөрт чинь хэлэхийг гуйсан гэж бодъё. Та найздаа юу гэж хэлэх вэ?
5. Хүүхэд чинь гадаа тоглоод гар нь их муухай болчихжээ. Одоо гэртээ орох гэж байна. Та хүүхдээ юу гэж хэлэх вэ?
6. Та даргатайгаа уулзах хэрэгтэй байгаа ч дарга чинь гадагшаа явчихсан байна. Нарийн бичигт нь юу гэж хэлэх вэ?
7. Та найзаараа текст бичүүлжээ. Хурдан бичиж дуусгах хэрэгтэй байсан бол та найздаа юу гэж хэлэх вэ?
8. Найз чинь нэг шүдний эмнэлгийн утасны дугаарыг мэддэг байжээ. Тэгээд танд хэлж өгөх гэсэн боловч санахгүй байна. Бас хаана тэмдэглэж бичсэнээ санахыг хичээж байна. Найздаа юу гэж хэлэх вэ?
9. Та монголоор өгүүлбэр хэлээд, буруу хэлснээ мэддэг үү?
10. Заримдаа хүмүүс хэлэх ёсгүй юм хэлээд дараа нь яадаг вэ?
11. Олон цаг ээжийгээ хараагүй нялх хүүхэд ээжийгээ [illegible] вэ?

12. Нохойноос айдаг хүүхэд нохой хараад яах вэ?
13. Сургуулийн хонх дуугарахад хүүхдүүд яадаг вэ?

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. As soon as the movie started, the children sat at their seats.
2. As soon as your lesson is over, come and meet me.
3. As soon as you finish eating, wash the dishes.
4. As soon as I brought my sister to her kindergarten, I ran to my school.
5. As soon as my parents come from their work, I will tell them about what happened to me.
6. As soon as that child cries, give this milk to him.
7. As soon as they understood what I said, they laughed.
8. As soon as Bathuu got the cake from the table, he started eating fast.
9. As soon as Ganhuu got off the train, he remembered he forgot his mobile phone on the table.
10. As soon as he comes home, he plays computer games.
11. As soon as he gets up in the morning, he drinks coffee.
12. As soon as spring time comes, they will move to another place.
13. As soon as Gerelmaa saw her mother, she ran to her.
14. As soon as the electricity comes on, tell me.
15. As soon as you hear from him, please tell me.

Дасгал 4

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Гучин тавдугаар хичээл

Үйл үгийн холбох нөхцөл (Verb Determining Suffix)

-нгаа⁴ (While)

Тэр хөгжим **сонсонгоо** хоолоо идсэн. (Тэр хөгжим сонсож байхдаа хоолоо идсэн.)
Тэр хоолоо **хийнгээ** зурагт үзэж байсан.
Хүүхдүүд тоглонгоо бие биентэйгээ танилцлаа.
Би автобус хүлээнгээ байн байн цагаа харж байлаа.

While he was **listening** to the music, he ate his food.
While she was **cooking**, she was watching TV.
While the children were playing, they got to know each other.
While I was waiting for a bus, I kept on looking at my watch.

Spelling rule: The suffixes **-нгаа** (for verb stems with а, у and я), **-нгээ** (for verb stems with э, ү and и), **-нгоо** (for verb stems with о), **-нгөө** (for verb stems with ө) are added directly to the verb stems that end with vowels and when it's added to stems that end with consonants, vowels are added. For example: хаа + нгаа = хаангаа, хий + нгээ = хийнгээ, өлгө + нгөө = өлгөнгөө, самна + нгаа = самнангаа, ид + нгээ = идэнгээ, өг + нгөө = өгөнгөө, бод + нгоо = бодонгоо, хар + нгаа = харангаа

Note: This suffix "-нгаа⁴" is used for complex sentences with only same subjects and if a complex sentence has two different subjects, -хад(аа)⁴ (form of "when") is used. For example:

Багш **яринга**а самбар дээр бичиж байлаа.
= Багш **ярьж байхдаа** самбар дээр бичиж байлаа.
Багшийг **ярьж байхад** сурагчид дэвтэр дээрээ бичиж байлаа.

While the teacher was **talking**, she was writing on the blackboard.

While (when) the teacher was **talking**, students were writing in their notebook

Дасгал 1

Доогуур нь зурсан үгсийг "–нгаа⁴" нөхцөлтэй болгон бич.
(Use the suffix "–нгаа⁴" with the verbs that are underlined.")

Жишээлбэл:
Сурагч багшийнхаа ярианг сонсож байхдаа дэвтэр дээрээ бичиж байлаа. → Сурагч багшийнхаа ярианг сонсонгоо дэвтэр дээрээ бичиж байлаа.

1. Энхмаа ном уншиж байхдаа алим идэж байв.
2. Тэр Монголд ажиллаж байхдаа монгол хэл сурчээ.
3. Өнөрмаа дүүгээ харж байхдаа хувцсаа угаасан.
4. Зарим хүн утсаар ярьж байхдаа цаасан дээр юм зурдаг.
5. Багш хичээл зааж байхдаа хүүхдүүдийг ажиглаж байлаа.
6. Би найзыгаа хүлээж байхдаа цаг агаарын мэдээ үзэж байсан.
7. Хүүхдүүд тоглож байхдаа их юм мэдэж авдаг.

Дасгал 2

Сурсан хэлзүйгээ ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио.
(Make sentences out of the given words using the grammar you have just learned.)

1. Би, найз, ярих; ногоо хэрчих
2. Бид, хоол, идэх; аялал, тухай, ярих
3. Сувилагчид, сүүтэй цай, уух; өвчтөнүүд, талаар, ярих
4. Тэд, эмч, хүлээх; сэтгүүл унших
5. Настай хүмүүс, гадаа, суух; шатар, тоглох дуртай
6. Би, их сургууль, сурах; ажил, хийх
7. Би, хувцас, индүүдэх; байн байн, цаг харах
8. Хүүхдүүд, алхах; дуу, дуулах
9. Би, найз, ажил, туслах; шинэ юм сурч авах
10. Тэр, дуулах; гитар, тоглох
11. Тэд, хөдөө, амрах; мал саах, сурах
12. Эмэгтэй, хүмүүс, ярих; бохь зажлах
13. Тэр, тэмцээнд оролцох; олон, хүүхэд, танилцах

Дасгал 3

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Давтлага хичээл (31–35)

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Багш, ирэх; хүүхдүүд, олон асуулт, асуух → Багшийг ирэнгүүт хүүхдүүд олон асуулт асуусан.

1. Ус буцлах; данх, хийх
2. Ногоон гэрэл, асах; машин, хөдлөх
3. Хулгайч, баригдах; бууруугаа хүлээх
4. Тэр, түрийвч, хулгайд алдах; цагдаагийн газар, утастах
5. Тэр, лонх, бөглөх; сэгсрэх
6. Багш, асуулт, асуух; оюутан, хариулах
7. Цайны цаг, болох; ажилчид, хоолонд орох
8. Хүүхэд, буруу юм, хийх; аав, шийтгэх

Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудыг хүлээн зөвшөөрч байгаа, үгүйгээ бичин, яагаад гэдгээ тайлбарла. (Write if you agree with the following situations and then explain why.)

1. Хүүхдийг уйлангуут авах хэрэгтэй. Тэгээд унттал нь тэврэх хэрэгтэй.
2. Хүүхдийг гэртээ ирэнгүүт ээж аав нь хувцсыг нь авч өлгөн, хоол өгдөг.
3. Хүүхдийг үнэнээ хэлтэл нь загнаад үнэнээ хэлэнгүүт нь шийтгэх хэрэгтэй.
4. Хүүхдээ сургуулиа төгстөл аав ээж нь анхаарал тавьдаг. Харин хүүхдээ сургууль төгсөнгүүт нь анхаарал тавихаа больдог.
5. Хүүхдүүд тоглонгоо олон юмыг сурч авдаг.
6. Монголд их сургуульд сурангаа ажил хийх боломжтой.

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. If Ganhuu gave flowers to her as soon as he met her, she would have been happy.
2. If he started working as soon as he graduated from his university, it would have been good for him.
3. If he washed his hands as soon as he came home, he wouldn't have gotten sick.
4. If Gerelmaa told the truth to her friend as soon as she came to his house, her friend wouldn't have gotten angry at her.
5. If I came home as soon as I finished my work, I would have been able to meet my brother.

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Сануулах, санагдах
2. Бариулах, баригдах
3. Засуулах, засагдах
4. Мартуулах, мартагдах
5. Нэмүүлэх, нэмэгдэх
6. Хасуулах, хасагдах
7. Өөрчлүүлэх, өөрчлөгдөх
8. Хийлгэх, хийгдэх
9. Будах, будагдах
10. Хэмжүүлэх, хэмжигдэх
11. Хугалуулах, хугарах
12. Цээжлүүлэх, цээжлэгдэх

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. People keep doing bad things.
2. His health keeps getting better.
3. Crime keeps increasing in the world.
4. Unemployment keeps increasing.
5. Water is still running in the bathroom.
6. He kept running and he got tired.
7. She kept watching the TV and couldn't do her house work.
8. The boy kept teasing his friend and made him cry.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүүхдүүд кино үзэнгээ ...
2. Би самбар арчингаа ...
3. Багш төгөлдөр хуур тоглонгоо ...
4. Би хувцсаа өлгөнгөө ...
5. Тэр надтай шал угаалцангаа ...
6. Чи гэртээ харингаа ...
7. Чи үйлдвэрт ажилланган ...
8. Бид төлөвлөгөө гаргангаа ...

Дасгал 7

Өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Хаялцах
2. Услалцах
3. Сонголцох
4. Түүлцэх
5. Хаалцах
6. Барилцах
7. Арчилцах
8. Засалцах
9. Өргөлцөх
10. Цэвэрлэлцэх
11. Чаналцах
12. Хайлцах

Тест (31–35)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Улаанбаатар хот их өөрчлөхгджээ.
Б. Улаанбаатар хот их өөрчлөгджээ.
В. Улаанбаатар хот их өөрчлөджээ.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Надад загас баригдахгүй байна.
Б. Надаар загас баригдахгүй байна.
В. Би загас баригдахгүй байна.

3. My house window has broken.
А. Манай гэрийн цонх эвдэрчихсэн байна.
Б. Манай гэрийн цонх хугарчихсан байна.
В. Манай гэрийн цонх хагарчихсан байна.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би ээждээ тусалж хоол хийлцсэн.
Б. Би ээждээ тусалж хоол хийлэцсэн.
В. Би ээждээ тусалж хоол хийхэлцсэн.

5. Which one is right in meaning?
А. Би дүүдээ тусалж шүдээ угаалцсан.
Б. Би дүүдээ тусалж гэр цэвэрлэлцсэн.
В. Би дүүдээ тусалж цай уулцсан.

6. The number of the city population keeps increasing.
А. Хотын хүн амын тоо өссөөр байна.
Б. Хотын хүн амын тоо өсөж байна.
В. Хотын хүн амын тоо өссөн байна.

7. Price of fuel still keeps increasing.
А. Шатахууны үнэ нэмэгдэж л байна.
Б. Шатахууны үнэ нэмэгдсээр л байна.
В. Шатахууны үнэ нэмэгдсээр байна.

8. We kept doing our work and finished it.
А. Бид ажлаа хийж байгаад дуусгалаа.
Б. Бид ажлаа хийсээр байгаад дуусгалаа.
В. Бид ажлаа хийсээр л байгаад дуусгалаа.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Охин нь тэр нохойг харангүүтээ уйлсан.
Б. Охин нь тэр нохойг харангуутаа уйлсан.
В. Охин нь тэр нохойг харангүүтаа уйлсан.

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүүг сэрэнгүүтээ энэ сүүг өгөөрэй.
Б. Хүү сэрэнгүүтээ энэ сүүг өгөөрэй.
В. Хүүг сэрэнгүүт энэ сүүг өгөөрэй.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүүхдүүд зайрмаг авмагцаа идлээ.
Б. Хүүхдүүд зайрмаг авахмагцаа идлээ.
В. Хүүхдүүд зайрмаг авсанмагцаа идлээ.

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр ярьж дуусмагц гарч явав.
Б. Тэр ярьж дуусмагцаа гарч явав.
В. Түүнийг ярьж дуусмагцаа гарч явав.

13. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр юм угаахангаа надтай ярьсан.
Б. Тэр юм угаангаа надтай ярьсан.
В. Тэр юм угаасангаа надтай ярьсан.

14. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би дэлгүүр оронгоо танайхаар дайрна.
Б. Би дэлгүүр оронгаа танайхаар дайрна.
В. Би дэлгүүр оронгөө танайхаар дайрна.

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чамайг зурагт үзэнгээ хоолоо ид.
Б. Чи зурагт үзэнгээ хоолоо ид.
В. Чиний зурагт үзэнгээ хоолоо ид.

16. While you were playing, I was watching you.
А. Чамайг тоглож байнгаа би харж байсан.
Б. Чамайг тоглож байхад би харж байсан.
В. Чамайг тоглож байхдаа би харж байсан.

Оноо (point): 16/ .....

Гучин зургадугаар хичээл

"Гэ" язгууртай үйл үг (The Verb "гэ")

гэсэн/гэлээ (said)

Тэр гадаа манантай байна гэсэн. — He said it's foggy outside.
Би түүнд хамт явж чадахгүй нь гэлээ. — I said to him that I can't go with him.

гэнэ (will say/I was told, I heard)

Тэр энэ ажлыг хийж чадахгүй гэнэ. — He will say that he can't do this work.
Маргааш халуун, бүгчим болно гэнэ ээ. — I heard that it will be hot and stuffy tomorrow.

гэж байна (is (are) saying)

Ээж "Олон нийтийн газраар битгий яв!" гэж байна. — Mom is saying "Don't go to public places!"

гэдэг (says (say)/ is (are) called)

Ээж дандаа "Хоол сайн идээрэй" гэдэг. — Mom always says "Please eat well."
Энийг англиар "chair" гэдэг. — This is called "chair" in English.

-х гэсэн (I wanted to)

Миний авах гэсэн ном дуусчихсан байсан. — The book I wanted to buy had sold out.

гээд (said and)

Тэр удахгүй ирнэ гээд явсан. — He said he would come soon and then left.

гэхэд (гэхдээ) (When ... say (said))

Намайг үгүй гэхэд тэр их гайхсан. — When I said no, he was very surprised.

Note: Би энийг маргааш гэхэд (гээд) дуусгана. — I will finish this by tomorrow.

гэвэл (If ... say)

Чамайг хий гэвэл тэр хийнэ. — If you say do it, he will do it.

гэтэл (Until ... say/but)

Түүнээс за гэтэл нь гуйгаарай. — Ask him until he says okay.

гэхлээр(ээ) (When(ever) ... say)

Багшийг "Сайн байна" гэхлээр сурагчид баярладаг. — When a teacher says "Good," pupils are happy.

Гэвч/Гэхдээ (but)

Их хүйтэн байсан. Гэвч (гэхдээ) тэд гадаа тоглосон. — It was very cold, but they played outside.

гэнгүүт(ээ) (As soon as ... say)

Тэр за гэнгүүтээ шал угааж гарсан. — As soon as she said yes, she started washing the floor.

гэсээр (байгаад) (Keep saying)

Тэр хөдөө явна гэсээр байгаад явсан. — He kept saying he would go to the countryside and then went.

гэсэн ч гэсэн (Even though … say)

Аавыг битгий ав гэсэн ч гэсэн би аавдаа бэлэг авна.	I will buy a gift for my father even though he says don't buy a gift.

The verb "гэх" is used as conjunction too. (For more detail see Lessons 25 and 26.)

гэдгийн(хээ)

Миний "Галаар битгий тогло" гэдгийн учрыг одоо л ойлгов уу?	Did you understand just now the reason why I say "Don't play with fire"?

гэдгийг(ээ)

Таныг зураач гэдгийг би мэдээгүй.	I didn't know that you are an artist.
Та зураач гэдгээ надад хэлээгүй.	You didn't tell me that you are an artist.

гэдэгт(ээ)

Таныг энийг хийж чадна гэдэгт би итгэж байна.	I believe that you can do this.
Би энийг хийж чадна гэдэгтээ эргэлзэж байна.	I doubt that I can do this.

гэдгээс(ээ)

Найз маань надад итгэхгүй байх вий гэдгээс би айж байна.	I'm afraid that my friend wouldn't believe me.

гэдэгтэй(гээ)

Тэр сайн хүн гэдэгтэй би санал нийлж байна.	I agree that he is a good person.

гэдгээр(ээ)

Тэр дуучин гэдгээрээ бахархдаг.	She is proud that she is a singer.

Дасгал 1

Гэх гэдэг үйл үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдалд тохируулан асуулт, хариулт бич.
(Write questions and answers that suit the given situations using the verb гэх.)

Жишээ нь:
Хаалган дээр бичиг байна.
А: —Энэ юу гэж байна? (What does this say?)
Б: —"Гадны хүн орохыг хориглоно" гэж байна. (It says "Outside person can't come in.")

1. Байшингийн ханан дээр бичиг байна.
2. Хашаан дээр нэг бичиг байна.
3. Эмний шилэн дээр бичиг байна.
4. Тамхины хайрцган дээр бичиг байна.
5. Танай гэрийн хаалган дээр бичиг байна.
6. Ширээн дээр ил захидал байна.
7. Ресторан цонхон дээр бичиг байна.
8. Эмчийн хаалган дээр бичиг байна.
9. Банкны ханан дээр бичиг байна.

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Америк, их цас, орох → Америкт их цас орсон гэнэ ээ. (I heard that it snowed much in America.)

1. Ирэх долоо хоног, хүйтрэх, гэнэ ээ
2. Онгоц, осол, болох; олон хүн, нас барах, гэнэ ээ
3. Энэ зун, сайхан зун, болох, гэнэ ээ
4. Настай хүмүүс, тэр сүм, явах, гэнэ ээ
5. Ногоо идэх, биенд сайн, гэнэ ээ
6. Ажилчид, ажил хаях, гэнэ ээ
7. Хүний мах иддэг хүн, байх, гэнэ ээ
8. Тэд нар, ирэх, чадахгүй, гэнэ ээ
9. Сөүл, их халуун, байх, гэнэ ээ
10. Тэд, хүүхэдтэй болох, гэнэ ээ
11. Энэ зун, их үер болох, гэнэ ээ
12. Галт уул, дэлбэрэх, гэнэ ээ
13. Газар хөдлөх, гэнэ ээ
14. Энэ жил, нар хиртэх, гэнэ ээ

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
He said he would come tomorrow and then left. → Тэр маргааш ирнэ гээд явсан.

1. He said he would meet you tomorrow and then left.
2. She said she would come back soon and then left.
3. He said he would give my book back next week and then took it.
4. He said he is interested in art and then showed me some pictures.
5. I said I was not hungry and then I did not eat.
6. He said he was not cold and then he did not wear his warm clothes.
7. They said it's prohibited to park a car here and then made us leave.
8. He said he was in a hurry and then he ran.
9. He said please keep this for me and then gave me his camera.
10. The boy said catch me and then he ran.
11. She said thank you and then she gave me flowers.
12. I said to him "You need to do it yourself" and then I did not help him.
13. He said he didn't know about that and then he didn't tell me anything.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Батхүүтэй ярих гэсэн юм. (I would like to talk Bathuu. (On the phone))
2. Танаас нэг юм асуух гэсэн юм. (I would like to ask you one thing.)
3. Тосон/усан будгаар яаж зурдгийг танаар заалгах гэсэн юм.
4. Дарга аа, өнөөдрийн хурлыг нэг цагаар хойшлуулах гэсэн юм. Болох болов уу?
5. Эндээс нэг сандал авах гэсэн юм.
6. Та нарт хичээлийн шинэ хуваарийн талаар сануулах гэсэн юм.
7. Тантай нэг юмны талаар зөвлөлдөх гэсэн юм.
8. Худалдагч аа! Талх авах гэсэн юм.

Дасгал 5

Доорх нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences that suit the given situations.)

Жишээ нь:
Та найзаасаа хөдөөний амьдралын талаар асуух хэрэгтэй байна. → Чамаас хөдөөний амьдралын талаар асуух гэсэн юм.

1. Та нэг хүнээс найзынхаа утасны дугаарыг авах хэрэгтэй байна.
2. Та банкны теллерээс хадгаламжийн данс хэрхэн нээлгэх талаар асуух хэрэгтэй болжээ.
3. Та даргатайгаа ээлжийн амралтынхаа талаар ярих хэрэгтэй байна.
4. Та нэгэн байгууллага руу утсаар ярьж, хаягийг нь авах хэрэгтэй болжээ.
5. Та гудамжинд хүнээс үсчин хаана байдгийг асуух хэрэгтэй байна.
6. Та хуульчаас зөвлөгөө авах хэрэгтэй байна.
7. Та сургуулийн захиралтай уулзах хэрэгтэй байна. Та жижүүртэй нь ярьж байна.

Дасгал 6

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
[хэлэх гэсэн] үг
А. Миний хэлэх гэсэн үгийг тэр хэлсэн. (She said the word I wanted to say.)
Б. Би хэлэх гэсэн үгээ хэлсэн. (I said the word I wanted to say.)

1. [авах гэсэн] газрын зураг
2. [асуух гэсэн] асуулт
3. [хэрэглэх гэсэн] гар чийдэн
4. [заах гэсэн] сэдэв
5. [мэдэх гэсэн] юм
6. [шилжүүлэх гэсэн] мөнгө
7. [уулзах гэсэн] хүн
8. [хаях гэсэн] хог
9. [суух гэсэн] автобус
10. [тоглох гэсэн] тоглоом
11. [сурах гэсэн] дуу
12. [явах гэсэн] зам
13. [заах гэсэн] мэдээлэл
14. [унах гэсэн] мөсөн

Дасгал 7

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ:
Та ... -х гэсэн (юм)аа ...
Take the book you want to read and read it. (Та унших гэсэн номоо аваад унш.)

Таны ... -х гэсэн (юм)ыг би ...
I just brought the book you want to read. (Таны унших гэсэн номыг би аваад ирлээ.)

1. Please say directly what you want to say.
2. Please ask directly what you want to ask.
3. Please buy what you want to buy.
4. Please do what you want to do.
5. I ordered the food you want to eat.
6. You can find out from this book the things that you want to know.
7. I brought the information about the university that you want to enter.
8. I couldn't find the bag you wanted to buy.
9. I didn't understand the idea you wanted to say.
10. I translated the text you wanted to translate.
11. I will teach you what you want to learn.

Дасгал 8

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Чамайг битгий нисгэгч бол гэвэл дүү чинь ...
2. Чамайг шалгалтаа сайн өгч чадна гэвэл аав ээж чинь ...
3. Намайг гэрт нь очиж чадахгүй нь ээ гэвэл тэр ...
4. Намайг боль гэсэн ч гэсэн тэр ...
5. Хүүгээ спортоор хичээллэмээргүй байна гэсэн ч гэсэн ...
6. Багшийг битгий хичээлээс хоцроорой гэхэд би ...
7. Даргыг сайн ажилласан байна гэхэд бид ...
8. Баярхүүг нааш ир гэнгүүт нохой нь ...
9. Галхүү та нар яаж байна аа гэнгүүтээ ...
10. Намайг "За" гэхлээр та нар ...
11. Захирлыг эхэл гэхлээр бид ...
12. Манай хүү хуульч болно гэсээр байгаад ...
13. Охин маань өндөр өсгийтэй гутал өмсмөөр байна гэсээр байгаад ...

Гучин долдугаар хичээл

"Болох" гэдэг үйл үгийн утгууд (Meanings of the Verb "болох")

1. Time expressions:

—Цаг хэд болж байна (вэ)?	What time is it?
—Нэг цаг болж байна.	It's one o'clock.
Энийг хийхэд хоёр цаг л болно.	It will take only two hours to make this.
Тэр цагийг засахад 30 минут болсон.	It took 30 minutes to fix that watch.
—Хичээл эхлэх болсон уу?	Is it time to start a lesson?
—Болсон./Арай болоогүй байна.	Yes, it is./Not yet.
—Та энд хэдэн жил болох юм бэ?	How many years will you stay here?
—Би энд таван жил болно.	I will stay here for five years.

2. To become, to get

Түүний бие зүгээр болсон.	His health has become okay.
Гадаа их хүйтэн болж байна.	It is getting (becoming) cold outside.

3. To have (new things), to acquire

Тэд удахгүй хүүтэй болно.	They will have a (new) son soon.
Би шинэ машинтай болмоор байна.	I want to have a new car.

4. To be enough

—Шөл хийхэд энэ ус болох уу?	Is this water enough to make soup?
—Болно.	It's enough.

5. To be done, to finish

—Хоол болсон уу?	Is the food done?
—Арай болоогүй байна.	It's not done yet.
(Та) болсон уу?	Are you done?/Are you ready?

6. May ...

—(Би) орж болох уу?	May I come in?
—Болно.	Yes, you may.

7. To happen

Энэ явдал нэг жилийн өмнө болсон.	This thing (event) happened one year ago.
Тэнд их сайхан юм болсон.	A very good thing happened there.

8. To take place

—Хурал хэзээ, хаана болох вэ?	When and where will the meeting take place?
—Маргааш таван цагт, энд болно.	It will take place here tomorrow at five o'clock.

9. To decide

Бид ирэх сард хөдөө явах(аар) болсон.	We decided to go to the countryside next week.
Би их сургуульд сурах болсон.	I decided to study in a university.

10. Because of ...

Архинаас болж жил болгон олон хүн нас бардаг.	Because of vodka, many people die each year.
Замын түгжрэлээс болж би ажлаасаа хоцорсон.	I was late for my work because of the traffic.

11. Started ...-ing

Манай хүүхэд нэг хоёр үг хэлдэг болсон.	Our child started saying one or two words.
Тэр хүмүүсийн үгийг авдаг болсон.	He started obeying people.

12. Because ...

Би өвчтэй байсан болохоор хичээлдээ яваагүй.	Because I was sick, I didn't go to my lesson.
Хүйтэн байсан болохоор би гадаа тоглоогүй.	Because it was cold, I didn't play outside.

13. and

Олон нийтийн газар болон ажлын байранд тамхи татахыг хориглоно.	Smoking in public places and work places is not permitted.
Эцэг эхчүүд болон багш нар хамтарч ажиллах ёстой.	Parents and teachers have to work together.

14. In official documents it expresses emphasis.

Тус байгууллага төлөвлөгөөгөө 100% биелүүлсэн болно.	This organization has fulfilled one hundred percent of it's plan.
Танай байгууллагатай хамтран ажиллахдаа бид баяртай байх болно.	We will be happy to work together with your organization.

15. Even though

Тэр намхан боловч сагсан бөмбөг сайн тоглодог.	Even though he is short, he plays basketball well.
Гадаа нартай байсан боловч хүйтэн байлаа.	It was cold outside even though it was sunny.

16. It seems/looks/feels/sounds like ...

Маргааш цаг агаар хүйтрэх бололтой.	It looks like the weather will become cold tomorrow.
Тэд ямар нэг юм хайж байгаа бололтой.	It seems like they are looking for something.

17. To work (to be okay)

Хүүхдүүд цаасаар цэцэг хийж байна.	Children are making flowers out of paper.
—Багш аа, энэ болж байна уу?	—Teacher, is it okay?
—Болж байна, болж байна.	—Yes, it is okay.
Энэ CD тоглуулагч асахгүй байна. (Хэдэн минутын дараа) Аа, одоо болж байна.	This CD player is not on. (After some minutes) Okay, it's working now.

18. To be able to

Энэ хаалгыг онгойлгож болохгүй байна. Цоож нь эвдэрсэн юм шиг байна.	I can't open this door. It seems like its lock has broken.
Энэ хадаасыг сугалж авч болохгүй байна.	I can not pull this nail out.

19. I wonder ...?

Тэр яагаад хичээлдээ ирээгүй юм бол? Өвдсөн юм бол уу?	I wonder why he didn't come to his lesson? I wonder if he got sick?
Тэд юу хийж байгаа юм бол? Хоол хийж байгаа юм бол уу?	I wonder what they are doing? I wonder if they are cooking?

20. What (how ...) do you think? Do you think ...?

Маргааш гадаа ямар байх бол?	How do you think it will be tomorrow outside?
Маргааш гадаа дулаахан байх бол уу?	Do you think it will be warm tomorrow?

21. As ... as possible

Аль болох хурдан ирээрэй.	Please come as soon as possible.
Аль болох их ажил хийгээрэй.	Please do as much work as possible.

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Юунаас/хэнээс болж хүмүүс эрт нас бардаг вэ?
2. Юунаас/хэнээс болж хүмүүс хорт хавдартай болдог вэ?
3. Юунаас/хэнээс болж гэр бүл салдаг вэ?
4. Юунаас/хэнээс болж хүүхдүүд сургууль завсарддаг вэ?
5. Юунаас/хэнээс болж хүмүүс ажлаасаа гардаг вэ?
6. Юунаас/хэнээс болж хүүхдүүд муу юм хийдэг вэ?
7. Юунаас/хэнээс болж хүмүүс уурлаж бухимддаг вэ?
8. Юунаас/хэнээс болж хүмүүс сэтгэл санааны хямралд ордог вэ?

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits the given situations.)

Жишээ нь:
Миний зүрх их өвдөж байна. → Аль болох хурдан эмчид үзүүл.

1. Би цэрэгт явмааргүй байна.
2. Сүүлийн хэдэн сард миний жин их нэмэгдлээ.
3. Би сүүлийн хэдэн сарл их турсан.
4. Би дандаа хямд юм худалдаж авдаг. Хямд юм чанаргүй юм аа.
5. Хөл, гараа түлбэл яах вэ?
6. Манай хүү ер нь их завтай байдаг болохоор найзуудтайгаа гадуур яваад хэрэг төвөгт орооцолдоод байх юм аа.
7. Шөнө миний нойр хүрдэггүй учраас би дандаа нойрны эм [illegible] даг.
8. Би гурилан бүтээгдэхүүн их иддэг.
9. Би ер нь шингэн юм их бага уудаг.

Дасгал 3

Өгүүлбэр бүрт хоёр асуулт бич. (Write two questions for each sentence.)

Жишээ нь:
Хүүхэд уйлж байна. → Хүүхэд яагаад уйлж байгаа юм бол? Айсан юм бол уу?

1. Багш чинь танай гэрт ээжтэй чинь яриад сууж байна.
2. Хичнээн залгаад ч найз чинь утсаа авахгүй байна.
3. Ширээн дээр чинь жижиг хайрцагтай юм байна.
4. Хэдэн эрэгтэй хүн тойрч суугаад ямар нэгэн юм шивнэлдэн ярьж байна.
5. Ер нь энэ дэлгүүр өдөр бүр онгорхой байдаг. Харин өнөөдөр хаалттай байна.
6. Зарим хүн маш аюултай спортын төрлөөр хичээллэх дуртай байдаг.
7. Сургууль дээрээ ирсэн чинь хэн ч байхгүй байна.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I wonder what time he will come? I wonder if he will come at five or six?
2. I wonder where I put my book? I wonder if I put my book here or there?
3. I wonder how she can finish this much work?
4. I wonder how old he is? I wonder if he is 30 years old?
5. I wonder where he is coming from? I wonder if he is coming from his house?
6. I wonder what they are going to do? I wonder if they are going to do something bad?
7. I wonder why they laughed? I wonder if I said something wrong?
8. I wonder why he doesn't like to do work? I wonder if his parents give him money?
9. I wonder why she always sits here? I wonder if she waits for someone?
10. I wonder how people play this game? I wonder if I can play it?

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
It seems like this person is a good person. → Энэ хүн сайн хүн бололтой.

1. It seems like it will rain tomorrow.
2. It seems like the children were here.
3. It seems like she got sick.
4. It seems like he didn't understand my question.
5. It looks like she didn't recognize me.
6. It seems like they are close friends.
7. It seems like he is a difficult person.
8. It looks like this building is very old.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

Жишээ нь:
Тэр өмнө нь тамхи татдаггүй байсан. **Харин одоо** ...
Тэр өмнө нь тамхи татдаггүй байсан. **Харин одоо тамхи татдаг** болсон.

1. Найз маань хараалын үг хэлдэггүй **байсан. Харин одоо** ...
2. Хүү маань нохойноос айдаггүй байсан. **Харин одоо** ...
3. Би хүмүүстэй хэрэлддэггүй. Харин одоо ...
4. Энхмаа хүмүүстэй сэтгэлийнхээ үгийг **хуваалцдаггүй байсан.** Харин одоо ...
5. Охин маань хүүхдүүдтэй муудалцдаггүй байсан. **Харин одоо** ...
6. Хүүхдүүд тоглоомоо эвддэггүй байсан. Харин одоо ...
7. Тэр залуу ажлаа тасалдаггүй байсан. Харин одоо ...
8. Дүү маань хүний үг авдаггүй байсан. Харин одоо ...
9. Би бууз чимхэж чаддаггүй байсан. Харин одоо ...
10. Би монголоор сайн ярьж чаддаггүй байсан. Харин одоо ...
11. Их дэлгүүр хаана байдгийг би мэддэггүй байсан. Харин одоо ...
12. Манай пар сайн халдаггүй байсан. Харин одоо ...

Дасгал 7

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Та өмнө нь юу хийдэггүй байгаад одоо хийдэг болсон бэ?
2. Та өмнө нь яадаггүй байгаад одоо яадаг болсон бэ?
3. Та юу хийдэг байгаад одоо хийхээ больсон бэ?
4. Та яадаг байгаад одоо больсон бэ?

Дасгал 8

Асуултад хриулж бич. (Answer the questions.)

1. 2001 оны 9-р сарын 11-нд Америкт юу болсон бэ?
2. Америкт болсон алан хядах үйл ажиллагааны дараа юу болсон бэ?
3. 2011 оны 2 сарын эхээр Египетэд юу болсон бэ?
4. Тэр улс төрийн бослогын дараа юу болсон бэ?
5. Таны өмнө нь хийж байсан ажил юу болсон бэ?
6. Таныг бага байхад сургууль дээр чинь ямар нэгэн хөгжилтэй зүйл болдог байсан уу?
7. Та хүүхэд байхдаа сургууль дээрээ болж өнгөрсөн зүйлсийг **аав ээждээ** хэлдэг байсан уу?
8. Өнгөрсөн жил танай хотод ямар нэгэн аймшигтай (гайхамшигтай, сонирхолтой) зүйл болсон уу?
9. Танай оронд байгалийн ямар нэгэн гамшиг болж байсан **уу?**

Дасгал 9

Нөхцөл байдалд тохирох хариултыг бич. (Write sentences that suit the given situations.)

1. Та нар хаана амьдрахаар болсон бэ? Хөдөө амьдрахаар болсон уу, хотод амьдрахаар болсон уу?
2. Хүүгээ анагаахын сургуульд орно гэхэд нь та нар дургүйцэж байсан. Тэгээд хүү чинь ямар сургуульд орохоор болсон бэ?
3. Чи найзтайгаа хэзээ шинэ бизнес явуулж эхлэх тухайгаа ярьж байсан гэсэн. Хэзээ эхлэхээр болсон бэ?
4. Хүмүүсийн зарим нь маргааш ажиллана, зарим нь ажиллахгүй гэж байсан. Тэгээд яахаар болсон бэ?
5. Та нар хөдөө явах үгүйгээ шийдэж чадахгүй байсан. Тэгээд яахаар болсон бэ?
6. Хүүхдүүдийн зарим нь кино үзнэ, зарим нь концерт үзнэ гэж байсан. Тэгээд тэд яахаар болсон бэ?
7. Та нар оройн хоолонд бууз хийх үү, хуушуур хийх үү гэж ярьж байсан. Тэгээд яахаар болсон бэ?
8. Цонх хагалсан хүүхдүүдийн эцэг эх нь сургуульд шилний мөнгө өгнө, эсвэл шил авчирч, хагарсан цонхыг шиллэнэ гэж байсан. Яахаар болсон бэ?

Дасгал 10

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Гучин наймдугаар хичээл

Төлөөний үг (тэгэх) (Proword (to do so))

This word is used as a response **when someone** has said something or has shown how to do things.

Тэгнэ.	(I) will.
Тэгсэн.	(I) did.
Тэгдэг.	(I) do.
Тэгж байна.	(I) am.
Тэгдэг байсан.	(I) used to.
Тэгэх хэрэгтэй.	(I) need to.
Тэгэх дуртай.	(I) like to.
Тэгж чадна.	(I) can.
Тэгж болно.	(I) may.
Тэгье.	Okay. (Let me do (what you said.))
Тэгээрэй.	Please (do what you said).
Тэг тэг.	Please (do what you said).
Тэгээч.	You should.
Тэгэг.	Let him do (do what you said).

Тэгээд ...	So ...
Тэгэхэд(ээ) ...	When so .../but
Тэгвэл ...	If so ...
Тэгсэн ч гэсэн ...	Even so ...
Тэгэнгүүт(ээ) ...	As soon as so ...
Тэгэхлээр(ээ) ...	When(ever) so .../So
Тэгтэл	Until so ... /but
Тэгж (хийх) ...	(to do) that way ...

—Төлбөрийн баримтаа надад авчирч өг.	Bring your payment receipt and give it to me.
—Тэгнэ ээ.	Yes, I will.
—Чи миний хувцаснуудыг индүүдсэн үү?	Did you iron my clothes?
—Тэгсэн. Юу гэж?	Yes, I did. Why?
—Чи тийм гэж хэлэхдээ толгойгоо дохидог уу?	When you say yes, do you nod your head?
—Бүх хүн тэгдэг шүү дээ.	All people do that.
—Чи гудамжинд хог хаядаг байсан уу?	Did you used to throw garbage in the street?
—Тэгдэг байсан. Одоо тэгэхээ больсон.	I used to do that, but now I have stopped doing it.
—Тэд нар хөзөр тоглож байна уу?	Are they playing cards?
—Тэгж байна.	Yes, they are.
—Тамхи татахлаар нь би хүүгээ загнасан.	When my son smoked, I scolded him.
—Тэгэх хэрэгтэй.	You need to do that.

—Чи гараараа ингэж чадах уу?	Can you do this with your hand?
—Би гараараа тэгж чадахгүй.	I can't do that with my hand.
—Энийг цэвэрлэчхээрэй.	Please clean this.
—Тэгье, тэгье.	Okay.
—Чи завтай болохоороо манайд очоорой.	Please visit my home when you have time.
—Тэгнэ ээ.	I will.
—Би тэгж байгаад нэг танайд очно оо.	I will visit your home sometime.
—Тэг тэг./Тэгээрэй.	Okay./Please do.
—Би дэлгүүр явж өөртөө шинэ хувцас авна аа.	I will go to the store and buy new clothes for myself.
—Тэгээч.	You should.
—Тэр ирэх долоо хоногоос ажил хайна гэнэ ээ.	He said he will look for a job from next week.
—Тэгэг. Тэгэх цаг нь болсон.	Let him do that. It's time for him to do that.
—Би маргааш их завгүй байх юм шиг байна.	It seems like I will be very busy tomorrow.
—Тэгээд?	So?
—Тэгээд би чамтай гадагшаа гарч чадахгүй нь.	So I can't go out with you.
—Хотод маш их үер болж билээ. Тэгэхэд би 12 настай байсан.	There was a big flood in the city. At that time (when that happened) I was 12 years old.
—Би солонгос хоол идэх дуртай.	I like to eat Korean food.
—Тэгвэл хоёулаа солонгос хоол хийж идье.	If so, let's make Korean food and eat.
—Чи энийг ингэж хийгээд үз.	Do this this way and see.
—Тэгсэн ч гэсэн болохгүй байсан.	I did it that way, but it didn't work.
—Ээж ээ, тэр хүүхэд намайг аймаар чанга цохисон. Тэгэнгүүт нь би бас буцаагаад цохичихсон.	Mom, that child hit me very hard. As soon as he hit me, I also hit him back.
—Миний хүү, тэгж болдоггүй юм аа.	My son, you can't do that.
—Би өглөө болгон ингэж нурууны дасгал хийдэг.	Every morning I do back exercises like this.
—Тэгэхлээр миний нуруу их өвддөг.	When I do that, my back hurts.
—Аав аа, би багшдаа гэрийн даалгавар авмааргүй байна гэж хэлнэ ээ.	Daddy, I will tell my teacher that I don't want to have homework.
—Тэгж хэлж болохгүй шүү, миний хүү.	My son, you can't say that.
—Би хичээлээ хийхдээ сандал дээрээ ингэж суудаг.	When I do my lesson, I sit like this on my chair.
—Битгий тэгж суугаарай. Тэгж суугаад байвал нуруу чинь бөгтөр болно шүү.	Please don't sit like that. If you keep sitting like that, your back will become bent.
—Би хоолоо ингэж хурдан иддэг.	I eat my food fast like this way.
—Битгий тэгж идээрэй.	Please don't eat like that.
—Эмэгтэй хүүхдүүд дандаа уйлдаг, их сул дорой гэж би боддог.	I think girls always cry and they are weak.
—Би тэгж боддоггүй.	I don't think so.

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Чи энийг эвдсэн үү?
2. Чи зээлээ хугацаанд нь төлнө биз дээ?
3. Чи аав ээжийгээ хүндэлдэг үү?
4. Чи наранд биеэ шармаар байна уу?
5. Чи ингэж чадах уу?
6. Чи шүлэг бичдэг байсан уу?
7. Тэд шатахуун авч байна уу?
8. Та нар түр амсхийх гэж байна уу?
9. Чи өмнө нь гэрт амьдарч байсан уу?
10. Чи хичээлээ таслах гэж байсан уу?

Дасгал 2

Доорх өгүүлбэрүүдэд тохирох хариултыг бич. (Write the replies that suit the given sentences.)

Тэгье, тэг тэг (more now)
Тэгнэ ээ, тэгээрэй (more later)

1. Чи энийг хатаачхаарай.
2. Би энийг хатаачихъя.
3. Би маргааш чам руу ярина аа.
4. Чи маргааш над руу яриарай.
5. Асуулт гарвал би чамаас асууна аа.
6. Асуулт гарвал надаас асуугаарай.
7. Би энд суучих уу?
8. Та энд суучих.
9. Та цай уух уу?
10. Би энэ цайг уучих уу?
11. Чи ирэх сард хөдөө ажиллаарай.
12. Би ирэх сард хөдөө ажиллана аа.
13. Би энийг одоо хайчилчих уу?
14. Чи энийг одоо хайчилчих.
15. Харанхуйд болгоомжтой яваарай.
16. Би харанхуйд болгоомжтой явна аа.

Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suit the given situations.)

Жишээ нь:
Миний толгой өвдөж байна. → Тэгвэл ажлаа түр орхиод амар.

1. Миний гэдэс гүйлгээд байна.
2. Хүүхэд уйлаад байна.
3. Миний шүд өвдөөд байна.
4. Миний хараа муудаад байна.
5. Хүүхэд халуурч байна.
6. Би цангаад байна.
7. Би утсаа хайгаад олохгүй байна.
8. Миний гутал хөл бариад байна.
9. Миний бал гарахгүй байна.
10. Би хөнгөн хоол идмээр байна.
11. Маргааш цасан шуурга шуурна гэнэ.
12. Би англи хэл мэдэхгүй шүү дээ.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Манайх хотод 1995 онд орж ирсэн. Тэгэхэд би 15 настай байсан.
2. Та энэ ажлыг өөрийнхөөрөө хийгээрэй. Тэгэхдээ миний хэлснийг бас битгий мартаарай.

3. Тэр намайг цохисон. Тэгэхэд нь миний уур их хүрсэн ч гэсэн би уураа бариад өнгөрсөн.
4. Тэр унтаж байхдаа намайг цохисон. Тэгэхдээ юу ч мэдээгүй гэсэн.
5. Тэд хүмүүстэй чөлөөтэй ярихгүй байна. Тэгэхлээр тэдний монгол хэл яаж сайжрах юм бэ?
6. Манай хажуу өрөөнд байсан айл нүүсэн. Тэгэхлээр та манай тэр өрөөнд байж болно.
7. Манай үйлдвэр долоо хоногт хийж дуусгадаг байсан ажлаа 4 хоногт хийж дуусгадаг болсон. Тэгээд манай үйлдвэрийн ашиг 30 хувиар нэмэгдсэн.
8. Хүүхдэд хичээлийг тоглоомын аргаар заах хэрэгтэй. Тэгвэл хүүхэд хичээлдээ дуртай болж, илүү сайн сурах болно.
9. Сургуулийн ойр зам дээр бага насны хүүхдүүдэд зориулсан тусгай гарц гаргах хэрэгтэй. Тэгвэл хүүхдийн төлөө хийж байгаа чухал алхам болно.
10. Хүн болгон өөрийн хийж байгаа ажилдаа эзэн болж, үнэн сэтгэлээсээ хандах нь чухал юм. Тэгвэл улс орны хөгжил эрс дээшилнэ.
11. Хүүхдэдээ заавар зөвлөгөө өгч ярилцах нь чухал. Тэгэхэд зарим эцэг эхчүүд хүүхдээ загнаж, зодохоо урдаа барьдаг.
12. Хүү ойд явж байлаа. Тэгтэл гэнэт хаанаас ч юм нэг аймаар чимээ гарлаа.
13. Тэр хүү модноос яг унах гэж байлаа. Тэгтэл нэг том биетэй хүн гарч ирээд түүнийг аварлаа.
14. —Чи найздаа үнэнээ хэлээд уучлал гуйх хэрэгтэй.
    —Тэгсэн ч гэсэн тэр намайг уучлахгүй ээ.
15. Чи бөмбөгөө шидээрэй. Тэгэнгүүт манай нохой бөмбөгний чинь араас хөөнө.

Дасгал 5

Тохирох холбох үгийг нөхөж бич. (Write the right conjunctions in the space.)

Тэгээд, Тэгвэл, Тэгэхэд, (Тэгэхдээ)Тэгэхлээр(ээ), Тэгтэл

1. Найз маань намайг гэнэт баярлуулсан. ... би өмнө нь баярлаж байгаагүйгээрээ их баярласан. ... би баярлаж байгаагаа түүнд үзүүлээгүй.
2. Эмээгийн бие нь өвдөөд гудамжинд босч чадахгүй сууж байлаа. ... нэг сайн санаатай хүн эмээд тусалж гэрт нь хүргэж өгөв.
3. Хүүхдийг тоглоомоо хайрлахад сургах хэрэгтэй. ... хүүхэд аав ээж, найз нөхдөө хайрлаж сурна.
4. Батхүүд чухал хэрэг гараад өнөөдөр ажилдаа ирж чадсангүй. ... та нар ажлыг нь хувааж хийх хэрэгтэй боллоо шүү.
5. —Миний хөл өвдөөд байна. — ... сууж амар.
6. Чи орчинд нь очиж хэл сурах хэрэгтэй. ... хэл хурдан сурахад дөхөм болно.
7. Би автобус их хүлээлээ. ... хичээлээсээ хоцорчихлоо, уучлаарай.
8. Хөдөлгөөн дутсанаас зарим хүн хэт таргалж байна. ... тэд өвчлөх нь эрс нэмэгдэж байна.
9. Та амжилтанд хүрч болно. ... нэг л өдөр биш, олон өдөр хичээж хөдөлмөрлөсний үр дүнд амжилтанд хүрдэг юм шүү.
10. Тэр хүүхэд найздаа үргэлж тусалдаг. ... манай хүүхэд найздаа тусална гэж байхгүй.

Гучин есдүгээр хичээл

Төлөөний үг (ингэх) (Proword (to do this way))

You can use this verb before (or while) you do and show something physically.

For example: Би үзгээ ингэж барьдаг. (I hold my pen like this.)
(After you say this sentence you show to your listener how you hold your pen.)

Би монгол хүмүүсийн тухай ингэж боддог. (I think about Mongolians this way.)
(After you say this sentence, you can tell what you think about Mongolians.)

(Би) ингэсэн/ингэнэ.	(I) did/will do it this way.
(Би) ингэдэг.	(I) do it this way.
(Би) ингэх дуртай.	(I) like to do it this way.
(Би) ингэх хэрэгтэй.	(I) need to do it this way.
(Би) ингэж болно.	(I) may do it this way.
(Би) ингэж чадна.	(I) can do it this way.
Ингэе.	Let me do it this way.
Ингэ./Ингээрэй.	Do it this way./Please do it this way.
Ингэг.	Let him do it this way.
Ингээд ...	(I) do it this way and ...
Ингэвэл ...	If (I) do it this way ...
Ингэхэд(ээ) ...	When (I) do it this way ...
Ингэсэн ч гэсэн ...	Even though (I) do it this way ...
Ингэхлээр(ээ) ...	When(ever) (I) do it this way ...
Ингэнгүүт(ээ)...	As soon as (I) do it this way ...
Ингэж (хийх)	(to do) this way ...
За, хүүхдүүд ээ! Намайг дуурайгаад цаасан шувуу хийгээрэй. Ингээд, ингээд, ингээд ...	Okay, kids! Please copy me and make paper birds. Like this, like this, like this ...
Ингэвэл (багш эрхий хуруугаа гозойлгож байна) сайн гэсэн үг.	If we do this (the teacher is having her thumb up), it means good.
Ингэвэл (багш чигчий хуруугаа гозойлгож байна) муу гэсэн үг.	If we do this (the teacher is having her little finger up), it means bad.
Та нар хөлөө ингэхдээ болгоомжтой байгаарай.	When you do this with your foot, please be careful.
Намайг ингэхэд (гараараа доошоо дохиж байна) суугаарай.	When I do this (she is nodding her hand down), please sit down.
Намайг ингэнгүүт (гараараа доошоо дохиж байна) суугаарай.	As soon as I do this (she is nodding her hand down), please sit down.
Ингэсэн ч гэсэн болохгүй байна.	Even though I do this, it doesn't work.
Ингэхлээр миний гар өвдөж байна.	When I do this, my hand hurts.
Би халбагаа ингэж бариад, хоолоо ингэж иддэг.	I hold my spoon like this and eat my food like this.

Дасгал 1

Багш оюутан хоёр доорх асуултуудыг бие биенээсээ асууж ярилц. Асуултад хариулахдаа үйлдлийг биеэрээ үзүүлж яагаад гэдгийг тайлбарла. (Teacher and student should ask the following questions of each other and talk. When you answer the questions, show the actions physically and explain why.)

Жишээ нь:
Та үзгээ яаж барьдаг юм бэ? → Би үзгээ ингэж барьдаг. (Үзгээ барьж үзүүлнэ.) Ингэж барихлаар гарт эвтэйхэн байдаг.

1. Та шөлтэй хоол идэхдээ халбагаа яаж барьдаг вэ?
2. Та хоол идэхдээ хутга, сэрээгээ яаж барьдаг вэ?
3. Орон орны хүмүүс бие биентэйгээ яаж мэндэлдэг вэ?
4. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс яаж алхдаг вэ?
5. Та хоолны ширээний ард яаж сууж, гараа яаж ширээн дээр тавьдаг вэ?
6. Хүмүүс хол байгаа нэгнийгээ дуудахдаа яаж дууддаг вэ?
7. Монгол хүмүүс бие биендээ юм өгөхдөө яаж өгдөг вэ?
8. Хамгаалалтын харуулууд яаж зогсдог вэ?
9. Цэргүүд жагсаалд яаж алхдаг вэ?
10. Цэргийн хүмүүс яаж ёсолдог вэ?
11. Сэтгэл санаа нь тавгүй байвал хүмүүс яадаг вэ?
12. Хүмүүс уурлахлаараа яадаг вэ?

Дасгал 2

Доорх зүйлсийг яаж хийдгийг бие биендээ зааж өг. (Teach each other how to make the following things.)

Жишээ нь:
Цаасан цэцэг хийх → Эхлээд ингээд, дараа нь ингээд, ингээд, ингэнэ. Одоо ингээрэй. Ингэж нугалж болохгүй. Ингэж нугал.

1. Цаасан онгоц хийх
2. Бууз чимхэх
3. Бичмэлээр бичих
4. Цамц эвхэх
5. Зангиа зангидах
6. Хүзүүний алчуур ороох
7. Монгол ардын бүжиг бүжиглэх
8. Нүдний дасгал хийх

Дасгал 3

Ингэх гэдэг үгийг ашиглан доорх нөхцөл байдалд тохирох үйлдлийг хийж үзүүл.
(Show the actions that suit the following situations using the word ингэх.)

Жишээ нь:
Муухай үнэр үнэртвэл та яадаг вэ? → Би ингэдэг. (Гараараа хамраа таглаж үзүүлнэ.)

1. Гоё хоол үнэртвэл та яадаг вэ?
2. Таны уур хүрвэл та яадаг вэ?
3. Та найзыгаа ярьж байхад ярьж байгаа зүйлийг нь зөвшөөрч байгаагаа үг хэлэлгүй яаж илэрхийлдэг вэ?

4. Найз чинь сайн юм хийвэл та яадаг вэ?
5. Санамсаргүй халуун юм баривал та яадаг вэ?
6. Хүмүүс гайхахлаараа яадаг вэ?
7. Хүмүүс айхлаараа яадаг вэ?
8. Хүмүүс уйлахлаараа яадаг вэ?
9. Хүмүүс хэлсэн үгэндээ харамсахлаараа яадаг вэ?

Төлөөний үгс (ингэж/тэгж, ийм/тийм) (Prowords (like this/that))

"Ингэж/тэгж" go with verbs.

ингэж/тэгж тавих	to put it like this/that way
ингэж/тэгж бичих	to write like this/that way
ингэж/тэгж тоглох	to play like this/that way
Чи бууз ингэж/тэгж хийх хэрэгтэй.	You need to make buuz like this/that way.

"Ийм/тийм" go with nouns.

ийм/тийм цавуу	a glue like this/that
ийм/тийм хувцас	an article of clothing like this/that
ийм/тийм шохой	a chalk like this/that
Би ийм/тийм балруул авсан.	I bought an eraser like this/that.

"Ийм/тийм" also go with adjectives.

ийм/тийм том	this/that big
ийм/тийм жижиг	this/that small
ийм/тийм их	this/that much
Би ийм/тийм том алим идсэн.	I ate an apple this/that big.

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I hold my pen like this/that way.
2. I bought a pen like this/that.
3. I bought this/that long pen.
4. You need to sit like this/that way.
5. You need to sit on a chair like this/that.
6. You sat on this/that small chair.
7. She makes a pizza this/that way.
8. She makes a pizza like this/that one.
9. She makes a pizza this/that big.
10. He wears his boots this/that way.
11. He wears boots like this/that.
12. He wears boots this/that big.
13. We will build our house this/that way.
14. We will build a house like this/that.
15. We will build a building this/that tall.
16. She wears her hair like this/that way.
17. She has hair like this/that.
18. She has hair this/that long.
19. He ate candies this/that way.
20. He ate candies like this/that.
21. He ate this/that many candies.
22. She brushes her teeth this/that way.
23. She has a brush like this/that.
24. She has teeth this/that white.

Дөчдүгээр хичээл

Цагтай холбоотой үгс (Words That are Related to Time)

цаг авах	to take time	бугуйн цаг	wrist watch
цаг идэх	to eat time	цагны нүүр	watch-face
цаг гаргах	to make time	цагны оосор	watch-chain
цаг барих	to be on time	цагны зүү	hand of watch/clock
цаг алдах	to lose time	ширээний цаг	table clock
цаг үрэх	to waste time	сэрүүлэгтэй цаг	alarm clock
цаг зарах	to spend time	ханын цаг	wall clock
цаг хэмнэх	to save time	бөгжин цаг	ring watch
цаг нөхөх	to make up for lost time	халаасны цаг	pocket watch
цаг нөхцөөх	to kill time	элсэн цаг	hourglass
цаг сунгах	to extend time	электрон цаг	electronic clock
цаг өнгөрөх	to be passing time	механик цаг	mechanic clock
цаг болох	to be time to ...	өнгөрсөн цаг	past tense
цаг хожих	to gain time	одоо цаг	present tense
цаг товлох	to set a time	ирээдүй цаг	future tense
цаг тохирох	to set a time	цаг хугацаа	time
цаг давчдах	to have very short time	цаг тооны бичиг	calendar
цагтай уралдах	to work against time	цаг агаар	weather
цаг ашиглах	to use time effectively	цагийн хуваарь	time table

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуулж, Дасгал 2-оос харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at Exercise 2 and correct any mistakes.)

1. Хүмүүсийг цаг барихгүй бол түүний уур хүрдэг.
2. Цагийг чинь үрэх ажил битгий хий. Цагаа зөв ашиглаж сур.
3. Чи ингэж хийсэн бол цагаа хэмнэх байсан.
4. Цаг нь болохоор амьдрал бүх юмыг харуулдаг.
5. Цаг нь болохоор би чамд хэлнэ. Цаг хугацаа бүх үнэнийг харуулдаг.
6. Хүмүүс уулзахдаа уулзах цаг, газраа товлох хэрэгтэй.
7. Цагтай уралдаж ажилладаг хүн их юм хийж чадна.
8. Өнгөрсөн цаг хугацаа эргэж олдохгүй.
9. Цаг хугацаа заримдаа удаан, заримдаа хурдан өнгөрдөг.
10. Та ямар нэг юм хийвэл хангалттай цаг зарах хэрэгтэй.
11. Та сайн найз байхыг хүсвэл найздаа цаг гаргах хэрэгтэй.
12. Бидний хэнийх нь зөв болохыг цаг хугацаа харуулна.
13. Бүх юм цаг хугацаатай байдаг. Явах цаг боллоо.
14. Машин маань эвдрээд бид маш их цаг алдсан.
15. Зарим хүүхэд гудамжаар тэнэж, цаг нөхцөөдөг.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуулаад өмнөх дасгалаас харж алдаагаа зас.
(Translate the sentences. Look at the previous exercise and correct any mistakes.)

1. If people aren't on time, he feels angry.
2. Don't do work that wastes your time. Learn to use your time effectively.
3. If you did it this way, you would saved your time.
4. Life reveals things when the time comes.
5. I will tell you when the right time comes. Time reveals all the truth.
6. When people meet they need to set a time and place to meet.
7. The person who works against time can do a lot of things.
8. The time passed will never be found again.
9. Sometimes the time passes slowly and sometimes fast.
10. If you do something, you need to spend enough time for it.
11. If you want to be a good friend, you need to make time for your friend.
12. Time will reveal which of us is right.
13. All things are in their own time. Now it's time to go.
14. Our car broke down and we lost so much time.
15. Some children just wander around in the street and kill time.

Дасгал 3

Асуултуудыг орчуулж, хариулт бич. (Translate the questions and answer them.)

1. How much time do you make for your family?
2. How much time do you spend for house work?
3. Are people always on time in your country?
4. What do you think when you see people who have nothing to do and are killing time outside?
5. Why does time sometimes go slowly and sometimes go fast?
6. How well do you use your time?
7. In what professions do people have to work against time?
8. What wastes people's time?
9. How much time do you spend on doing your homework?
10. How do you save time (money)?
11. When do athletes extend alloted time?
12. What are the things that save people's time?

Дасгал 4

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд зөв хэлбэрт оруулан нөхөж бич.
(Choose the right words from the following list and write them in the spaces with the correct form.)

болох, сунгах, үрэх, алдах, нөхөх, гаргах, идэх, ашиглах, тулах, өнгөрөх, хэмнэх, товлох

1. Тэмцээний цаг дуусахад хоёр багийн оноо тэнцүү байсан учраас цаг ..... хэрэгтэй болсон.
2. Тэр өвөө залуу байхдаа цаг ..... мэддэггүй, дандаа хөзөр тоглож цаг ..... байсан гэсэн.
3. Дарга аа, би өнөөдөр чөлөө авах гэсэн юм. Би маргааш илүү цаг ажиллаж алдсан цагаа ..... болох уу?
4. Тэр энэ ажлыг 7 цагт дуусгах ёстой. Харин тэр одоо зурагт үзэж байна. Тэр цаг ..... байна.
5. Чи гэрээ цэвэрлэж байхдаа шинэ үгээ цээжлээрэй. Чи ..... хэрэгтэй. Чамд цаг бага байгаа шүү.
6. Тэр хичээл их сонирхолтой байсан учраас цаг хурдан .....
7. Бид нар 10 цагт эндээс хөдлөх ёстой. Одоо 9 цаг 55 минут болж байна. Явах цаг ..... учраас одоо явцгаая.
8. Чи тэдэнтэй уулзах цагаа ..... ?
9. Шалгалт өгөх цаг ..... учраас ах маань хүнтэй ч мэндлэх завгүй байна.
10. Та их завгүй ч гэсэн гэр бүлийнхэндээ цаг ..... хэрэгтэй.
11. Гол юмаа шууд ярь. Битгий миний цагийг ..... Надад цаг бага байна.

Дасгал 5

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Давтлага хичээл (36–40)

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I heard that it will snow tomorrow.
2. Sorry, what does this say?
3. What did he say?
4. What do you call this in Mongolian?
5. This is called "аяга" in Mongolian.
6. I would like to meet your manager.
7. I would like to ask you something.
8. He said he would come soon and left.
9. If he says he can't do this work, I will do it.
10. When you said sorry, she was surprised.
11. I was able to do things that I wanted to do.
12. Have you finished what you wanted to talk about?

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг уншаад "болох" гэдэг үйл үг ямар утгаар хэрэглэгдсэнийг багштайгаа ярилц. (Read the sentences and discuss with your teacher the meanings of the verb "болох.")

1. Их цас орсноос болж олон мал үхсэн.
2. Жолооч хурд хэтрүүлснээс болж осол их гардаг.
3. Энэ ажлыг аль болох хурдан дуусгах хэрэгтэй байна.
4. Та нар аль болох их оноо авах хэрэгтэй шүү.
5. Тэд юу хийж байгаа юм бол?
6. Хүүхдүүд гэр лүүгээ явсан юм бол уу?
7. Энэ их чанартай эд бололтой.
8. Энэ хүн сайхан сэтгэлтэй хүн бололтой.
9. Хүү маань уснаас их айдаг болсон.
10. Хүүхдүүд гэрийн ажил хийхэд минь тусалдаг болсон.
11. Юу болсон бэ? Хүүхдүүд яагаад баярлаад байгаа юм бэ?
12. Өчигдөр сургууль дээр сонин юм болсон.
13. Та нар хаашаа явахаар болсон бэ?
14. Өнөөдрөөс эхлээд Галхүү танай даргаар ажиллахаар болсон.

Дасгал 3

Багш оюутан хоёр бие биенээсээ доорх асуултуудыг асууж, үйлдлийг биеэрээ үзүүлэн ярилц. (Teacher and student ask each other the following questions, show actions and discuss.)

Жишээ нь:
Багш: —Та ингэж алхдаг уу?
Оюутан: —Би тэгж алхдаггүй, ингэж алхдаг.

1. Та үзгээ ингэж бариад ингэж бичдэг үү?
2. Та ороолтоо ингэж зүүдэг үү?
3. Та хичээлээ бичихдээ ингэж суудаг уу?
4. Та аягаа ингэж барьж цай уудаг уу?
5. Та хүмүүст ингэж юм өгдөг үү?
6. Та хоолоо ингэж хөргөдөг үү?

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
цэцэг → А. Би ийм цэцэг таримаар байна. Б. Би ийм гоё цэцэг таримаар байна.

1. Машин
2. Даашинз
3. Чимэглэл
4. Ор
5. Гар утас
6. Ханын цаас
7. Будаг
8. Чийдэн
9. Ажлын ширээ

Дасгал 5

Цагтай холбоотой үгсийг ашиглан, өгөгдсөн нөхцөл байдалд тохирох хариултыг бич. (Write down the appropriate answers for the given situations using the words that are related to time.)

Жишээ нь:
Би найзтайгаа биш, ганцаараа энэ ажлыг хийж дуусгана. → Тэгвэл чи цаг их алдана.

1. Би зурагт үзэх их дуртай. Ихэнх цагаа зурагтын өмнө өнгөрөөдөг.
2. Намайг хичээлээсээ дандаа хоцордог болохоор багш маань дургүй байдаг.
3. Би ер нь их ажилтай байдаг болохоор эхнэртэйгээ ч тухтай ярих зав байдаггүй.
4. Би одоо хорин таван настай. Би ер нь найзуудтайгаа цагийг зугаатай өнгөрөөдөг. Ажил хийх уйтгартай санагддаг.
5. Би юмыг их хурдан хийх дуртай.
6. Би уйдаад найзууд руугаа дандаа утсаар ярьдаг. Заримдаа тэд дургүй юм шиг байдаг.
7. Би Увс аймаг руу онгоцоор биш, машинаар явмаар байна.
8. Ээж ээ, би хичээлээ 30 минут хийгээд, 30 минут амраад, хийж болох уу?
9. Би одоогийн энэ ажилдаа жаахан дургүй учраас ажлын цаг их удаан өнгөрдөг. Аав ээж маань хий гэсэн болохоор хийж байгаа юм.

Тест (36–40)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та хийх гэсэн юмаа хийж чадав уу?
Б. Та хийх гэсэн юм хийж чадав уу?
В. Та хийх гэсэн юмыг хийж чадав уу?

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Намайг үгүй гэвэл тэр их гайхсан.
Б. Намайг үгүй гээд тэр их гайхсан.
В. Намайг үгүй гэхэд тэр их гайхсан.

3. What does this say?
А. Энэ юу гэж байна вэ?
Б. Энэ юу гэдэг вэ?
В. Энэ юу гэсэн бэ?

4. Because of the snow, there was a traffic jam.
А. Цас ороод зам түгжирсэн.
Б. Цас орсон учраас зам түгжирсэн.
В. Цас орсноос болж зам түгжирсэн.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр хүн юу хийж байгаа юм бол уу?
Б. Тэр хүн юу хийж байгаа юм бол?
В. Тэр хүн юу хийж байгаа юм бол вэ?

6. What happened there?
А. Тэнд юу болсон бэ?
Б. Тэнд юу болдог вэ?
В. Тэнд юу болсон уу?

7. He started smoking.
А. Тэр тамхи татахаар болсон.
Б. Тэр тамхи татахаас болсон.
В. Тэр тамхи татдаг болсон.

8. Та ирэх 7 хоногт манайд очоорой.
А. Тэгнэ ээ.
Б. Тэгээрэй.
В. Тэг.

9. Та цай уух уу?
А. Тэгнэ ээ.
Б. Тэгье.
В. Тэгээрэй.

10. If so, eat food.
А. Тэгээд хоол ид.
Б. Тэгвэл хоол ид.
В. Тэгж хоол ид.

11. I hold my pen like this.
А. Би үзгээ ингэж барьдаг.
Б. Би үзгээ ийм барьдаг.
В. Би үзгээ тэгж барьдаг.

12. I bought a pen like this.
А. Би ийм үзэг авсан.
Б. Би ингэж үзэг авсан.
В. Би тийм үзэг авсан.

13. I ate an apple this big .
А. Би тийм том алим идсэн.
Б. Би ийм том алим идсэн.
В. Би том алим ингэж идсэн.

14. We lost so much time.
А. Бид их цаг алдсан.
Б. Бид их цаг зарсан.
В. Бид их цаг үрсэн.

15. Make time for your health.
А. Эрүүл мэнддээ цаг гарга.
Б. Эрүүл мэнддээ цаг зарцуул.
В. Эрүүл мэнддээ цаг ашигла.

16. Which one is right in meaning?
А. Алдсан цагаа нөх.
Б. Алдсан цагаа хэмнэ.
В. Алдсан цагаа ашигла.

Оноо (point): 16/ .....

Дөчин нэгдүгээр хичээл

Өөрийн төлөөний үг (Reflexive Proword)

өөрөө	myself/yourself/himself (subject)
өөрийнхөө	my own/your own/his own
өөрийгөө	myself/yourself/himself (direct object)
өөртөө	to/for myself/...
өөрөөсөө	from myself/...
өөртэйгөө	with myself/...
өөрөөрөө	(of) myself/...
өөр лүүгээ	to/towards myself/...
өөрсдөө	ourselves/yourselves/themselves (subject)
өөрсдийнхөө	our own/your own/their own
өөрсдийгөө	ourselves/yourselves/themselves (direct object)
өөрсдөдөө	to/for ourselves/...
өөрсдөөсөө	from ourselves/...
өөрсөдтэйгөө	with ourselves/...
өөрсдөөрөө	(of) ourselves/...
өөрсөд рүүгээ	to/towards ourselves/...

Та энийг өөрөө хийж чадна.	You can do this yourself.
Долгормаа өөрийнхөө аягыг угаагаагүй.	Dolgormaa didn't wash her own cup.
Тэр өөрийгөө заримдаа ойлгодоггүй.	He doesn't understand himself sometimes.
Би өөртөө гутал авна.	I will buy boots for myself.
Би өөрөөсөө дүү хүмүүстэй ажилладаг.	I work with people who are younger than myself.
Би өөртэйгөө адилхан хүнийг хараагүй.	I didn't see someone who is like myself.
Чи өөрөөрөө бахархах хэрэгтэй.	You should be proud of yourself.
Тэр өөр лүүгээ кофе асгачихлаа.	He spilled coffee on himself.

Дасгал 1

Асуултад хариулж бич. Ойлгохгүй асуулт байвал Дасгал 2-оос орчуулгыг хар.
(Answer the questions. If you are unsure of any of the sentences, look at the translations in Exercise 2.)

1. Та өөрөө бүх юмаа хийдэг үү?
2. Та өөртөө итгэлтэй байдаг уу?
3. Танд өөрийгөө ойлгохгүй үе гардаг уу?
4. Та хамгийн сүүлд өөртөө юу авсан бэ?
5. Та ер нь өөртөө юу гэж хэлдэг вэ?
6. Та өөрөөсөө юу гэж асуудаг вэ?
7. Та хүмүүсийг өөртэйгөө харьцуулдаг уу?
8. Та өөрөөрөө бахархдаг уу?
9. Та өөрийнхөө муу зуршлуудыг мэддэг үү?

10. Та өөрийгөө сайн мэдэх үү?
11. Та өөртөө анхаарал тавьдаг уу?
12. Та өөртөө сэтгэл хангалуун байдаг уу?
13. Та өөртөө амрах цаг зав гаргадаг уу?
14. Та өөрийнхөө эрүүл мэндэд хир их цаг гаргадаг вэ?
15. Та бусдын өмнө өөрийгөө магтдаг уу?
16. Та өөрийгөө ямар нэг юманд буруутгадаг уу?
17. Та өөрийгөө бусдад зөвөөр ойлгуулж чаддаг уу?
18. Та өөрийнхөө санааг бусдад тодорхой илэрхийлж чаддаг уу?
19. Та ямар ч үед өөрийнхөөрөө байж чаддаг уу?
20. Та өөрийгөө өөрчлөхийг хүсдэг үү?

Дасгал 2

Асуултуудыг орчуулаад Дасгал 1-ээс харж алдаагаа зас.
(Translate the questions. Look at Exercise 1 and correct any mistakes.)

1. Do you do all of your things yourself?
2. Are you confident of yourself?
3. Do you have times that you don't understand yourself?
4. What did you buy for yourself last time?
5. What do you tell yourself in general?
6. What do you ask yourself?
7. Do you compare people to yourself?
8. Are you proud of yourself?
9. Do you know your bad habits?
10. Do you know yourself well?
11. Do you care about yourself?
12. Are you satisfied with yourself?
13. Do you make time to rest for yourself?
14. How much time do you make for your own health?
15. Do you praise yourself in front of others?
16. Do you accuse yourself for something?
17. Are you able to make others understand you right?
18. Are you able to express your ideas to others clearly?
19. Are you able to be yourself (by your own way) anytime?
20. Do you want to change yourself?

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Би өөрөө ...
2. Би өөрийнхөө ...
3. Би өөрийгөө ...
4. Би өөртөө ...
5. Би өөрөөсөө ...
6. Би өөртэйгөө ...
7. Би өөрөөрөө ...
8. Би өөр лүүгээ ...

Ялгах төлөөний үг (Demonstrative Proword)

Бие биенийхээ	each other's
Бие биендээ	to/for each other
Бие биенийгээ	each other
Бие биенээсээ	from each other
Бие биентэйгээ	with each other
Бие биенээрээ	to have each other
Бие биен рүүгээ	to/towards each other

Бид бие биенийхээ алдааг уучилдаг.	We forgive each other's mistakes.
Бид бие биендээ бэлэг өгнө.	We will give gifts to each other.
Та нар бие биенийгээ уучлах хэрэгтэй.	You need to forgive each other.
Тэд бие биенээсээ юу ч нуудаггүй.	They don't hide anything from each other.
Бид бие биентэйгээ санаа бодлоо хуваалцдаг.	We share our thoughts with each other.
Тэд бие биенээрээ бахархдаг.	They are proud of each other.
Бид бие биен рүүгээ бөмбөг шидсэн.	We threw the ball to each other.

Дасгал 4

Асуултад хариулж бич. Ойлгогдохгүй асуулт гарвал Дасгал 5-аас орчуулгыг хар.
(Answer the questions. If there are questions you don't understand, look at Exercise 5 for translations.)

1. Хүмүүс бие биенийхээ сул талыг анзаардаг уу?
2. Хүмүүс бие биендээ туслах хэрэгтэй юү?
3. Хүмүүс бие биендээ итгэдэг үү?
4. Хүмүүс бие биендээ ямар үг хэлэх хэрэгтэй вэ?
5. Хүмүүс бие биенийгээ уучилдаг уу?
6. Хүмүүс бие биенийгээ хүндлэх хэрэгтэй юү? Яагаад?
7. Хүмүүс бие биенийгээ хайрлах хэрэгтэй юү?
8. Хүмүүс бие биенээсээ өө эрдэг үү?
9. Хүмүүс бие биенээсээ айдаг уу?
10. Хүмүүс бие биентэйгээ эвтэй байдаг уу?
11. Хүмүүс яагаад бие биентэйгээ маргалддаг вэ?
12. Хүмүүс ярьж байхдаа бие биен рүүгээ харах хэрэгтэй юү? Яагаад?
13. Хүмүүс бие биен рүүгээ буруугаа чихдэг үү?

Дасгал 5

Асуултуудыг орчуулаад Дасгал 4-өөс харж алдаагаа зас.
(Translate the questions. Look at Exercise 4 and correct any mistakes.)

1. Do people notice each other's weak side?
2. Do people need to help each other?
3. Do people trust each other?
4. What words do people need to tell each other?
5. Do people forgive each other?
6. Do people need to respect each other? Why?
7. Do people need to love each other?
8. Do people pick on each other?
9. Are people afraid of each other?
10. Are people friendly to each other?
11. Why do people argue with each other?
12. When people are talking, do they need to look at each other? Why?
13. Do people blame their wrongs on each other?

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Та нар бие биенийхээ ...
2. Та нар бие биендээ ...
3. Та нар бие биенийгээ ...
4. Та нар бие биенээсээ ...
5. Та нар бие биентэйгээ ...
6. Та нар бие биенээрээ ...
7. Та нар бие биен рүүгээ ...

Дасгал 7

Доорх асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич.
(Write down at least three answers for each question.)

1. Эхнэр нөхөр хоёр ямар байх ёстой вэ?
2. Нэг ангийн хүүхдүүд ямар байх ёстой вэ?
3. Ах дүүс ямар байх ёстой вэ?

Дөчин хоёрдугаар хичээл

Ялгах төлөөний үгс (Demonstrative Prowords)

зарим нь	some of them/us/you (subject)
заримынх нь	some of their
заримд нь	to/for some of them
заримыг нь	some of them (direct object)

заримаас нь	from some of them
заримтай нь	with some of them
заримаар нь	by/with/out of some of them
зарим руу нь	to/towards some of them

Олон хайрцаг байна. Зарим нь шинэ, зарим нь хуучин байна.
Заримынх нь өнгө цагаан байна.
Би хайрцагнуудын заримд нь ном, заримд нь хоол хүнсээ хийнэ.
Би заримыг нь дэлгүүрээс, заримыг нь найзаасаа авсан.

There are many boxes. Some of them are new and some of them are old.
The color of some of them is white.
I will put books in some of the boxes and food in some of them.
I bought some of them from the store and got some of them from my friend.

Би хүүхдүүдийн заримаас нь өндөр.
Би хүүхдүүдийн заримтай нь тоглосон.
Багш хүүхдүүдийн заримаар нь зураг зуруулсан.
Багш хүүхдүүдийн зарим руу нь и-мэйл явуулсан.

I'm taller than some of the children.
I played with some of the children.
The teacher had some of the children draw pictures.
The teacher sent e-mails to some of the children.

бүгд(ээрээ)	all of them/us/you (subject)
бүгдийнх нь	all of their
бүгдэд нь	to/for all of them
бүгдийг нь	all of them (object)

бүгдээс нь	from all of them
бүгдтэй нь	with all of them
бүгдээр нь	by/with/out of all of them
бүгд рүү нь	to/towards all of them

Өрөөнд байгаа хүмүүс бүгдээрээ эмч үү?

Are all of the people who are in the room doctors?

Өрөөнд байгаа хүмүүсийн бүгдийнх нь нэрийг та мэдэх үү?
Өрөөнд байгаа хүмүүст бүгдэд нь та цай өгсөн үү?
Өрөөнд байгаа хүмүүсийг бүгдийг нь та таньдаг уу?
Өрөөнд байгаа хүмүүсээс бүгдээс нь та киноны тасалбарын мөнгө авсан уу?
Өрөөнд байгаа хүмүүстэй бүгдтэй нь та мэндэлсэн үү?
Өрөөнд байгаа хүмүүсээр бүгдээр нь та дуу дуулуулах уу?
Өрөөнд байгаа хүмүүс руу бүгдэн рүү нь та утсаар ярьсан уу?

Do you know the names of all of the people who are in the room?
Did you give tea to all of the people who are in the room?
Do you know all of the people who are in the room?
Did you get money for the movie thickets from all of the people who are in the room?
Did you greet all of the people who are in the room?
Will you have all of the people who are in the room sing songs?
Did you call (on the phone) all of the people who are in the room?

Дасгал 1

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд бич.
(Choose the right words from the following list and write them in the spaces.)

зарим нь	заримд нь	заримаас нь	заримаар нь
заримынх нь	заримыг нь	заримтай нь	зарим руу нь

1. Жуулчдын ..... сууж, ... зогсож байна.
2. Жүжигчдийн ..... нэрийг би мэднэ.
3. Дасгалжуулагчийн хэлсэн үгийн ..... би ойлгоогүй.
4. Би энэ харандаануудын ..... бичих дуртай, ... бичих дургүй.
5. Багш сурагчдын ..... асуусан.
6. Би хүүхдүүдийн ..... хөөсөн чихэр, ... иштэй чихэр өгсөн.
7. Сурагчдын ..... эцэг эх хуралд ирсэн.
8. Эмэгтэйчүүдийн ..... дуулж, ... бүжиглэнэ.
9. Эцэг эхчүүдийн ..... би өмнө нь хараагүй юм байна.
10. Хүүхдүүдийн ..... би шалгалт аваагүй байгаа.
11. Би тамирчдын ..... утсаар ярьж амжаагүй л байна.
12. Дарга ажилчдынхаа ..... ярих хэрэгтэй.
13. Ширээн дээр байгаа жимснүүдийн ..... би идэж үзээгүй.
14. Энэ савнуудын ..... сүү, ... тараг хий.
15. Би эмч нарын ..... хөдөө явж ажиллана.
16. Уутанд байгаа ногоонуудын ..... хоол хийгээрэй.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээ. (Complete the sentences.)

1. Хотуудын зарим нь ...
2. Сургуулиудын заримынх нь ...
3. Амьтдын заримд нь ...
4. Хадааснуудын заримыг нь ...
5. Багш нарын заримаас нь ...
6. Жуулчдын заримтай нь ...
7. Савхнуудын заримаар нь ...
8. Сурагчдын зарим руу нь ...

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь:
Та энэ хүмүүсийг таних уу? → Би (энэ хүмүүсийг) бүгдийг нь танина.

1. Та энэ хөргөгчинд байгаа хоолнуудад дуртай юу?
2. Танай байгууллагын ажилчид монгол уу?
3. Чи энэ номнуудаас алинаас нь авмаар байгаа юм бэ?
4. Чи энэ гурван утасны дугаарын алин руу нь залгаж үзмээр бэ?

5. Чи гэр бүлийнхэндээ хайртай юу?
6. Та хамт ажилладаг хүмүүстээ итгэдэг үү?
7. Та дунд сургуулийн англи хэлнээ хүүхдүүдийн нэрийг санаж байна уу?
8. Та найзуудынхаа утасны дугаарыг цээжээрээ мэдэх үү?
9. Танай оронд хүмүүс тавагтай хоолоо үлдээлгүй иддэг үү?
10. Та найз нөхөд, хамт ажилладаг хүмүүс, гэр бүлийнхэнтэйгээ эвтэй байдаг уу?

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I know all of these grammars.
2. I have tried all of these fruits.
3. Tell all of them to bring their warm clothes.
4. My son, drink all of your milk.
5. Try all of these meats.
6. Please say hi to all of them.
7. All of them are good students.
8. Did you fix all of these toys?
9. All of these boots are new.
10. These will be enough for all of them.
11. I love all of them.
12. I shook hands with all of them.
13. All of you can do it.
14. Memorise all of these words.
15. Wash all of those dishes.

Дасгал 5

Доорх зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the following pictures.)



Ялгах төлөөний үгс (Demonstrative Prowords)

бусад	other (subject)
бусдын	others'
бусдад	to others
бусдыг	others (direct object)

бусдаас	from others
бусадтай	with others
бусдаар	to have others
бусад руу	to/towards others

Чи бусад хүний юу хийж байгааг хар.	See what other people are doing.
Чи бусдын алдааг битгий давтаарай.	Please don't repeat others' mistakes.
Чи бусдад урмын үг хэлж сурах хэрэгтэй.	You need to learn to say encouraging words to others.
Чи бусдыг ойлгохыг хичээх хэрэгтэй.	You should try to understand others.
Чи бусдаас асуух хэрэгтэй.	You should ask of others.
Чи бусадтай ярилцах хэрэгтэй.	You need to talk (discuss) with others.
Чи бусдаар буруу юм хийлгэж болохгүй.	You may not make others do wrong things.
Чи бусад руу битгий буруугаа чихээрэй.	Please don't blame your mistakes on others.

бусад нь	the rest of them
бусдынх нь	the rest of their
бусдад нь	to/for the rest of them
бусдыг нь	the rest of them

бусдаас нь	from the rest of them
бусадтай нь	with the rest of them
бусдаар нь	to have the rest of them
бусад руу нь	to/towards the rest of them

Энэ хоёр хүүхдээс бусад нь өчигдөр ирсэн.	Besides those two children, others came yesterday.
Энэ хоёр хүүхэд өчигдөр ирээгүй. Бусад нь ирсэн.	Those two children didn't come yesterday. The rest came.
Би тэр улаан цамцтай хүүхдийн нэрийг мэдэхгүй. Бусдынх нь нэрийг мэднэ.	I don't know the name of the child who has a red shirt. I know the names of the rest.
Би энэ хоёр нохойнд хоол өгсөн. Бусдад нь хоол өгөөгүй.	I gave food to these two dogs. I did not give food to the rest.
Би энэ гурвыг одоо авна. Бусдыг нь дараа авна.	I will buy these three now. I will buy the rest later.
Би тэр оюутнаас л асуулт асуусан. Бусдаас нь асуугаагүй.	I asked questions of only that student. I did not ask questions of the rest.
Би энэ хүүхэдтэй тогломоор байна. Бусадтай нь тогломооргүй байна.	I want to play with this child. I don't want to play with the rest.
Би энэ балаар бичих дуртай. Бусдаар нь бичих дургүй.	I like to write with this ball point pen. I do not like to write with the rest.
Би гурван оюутан руу утсаар ярьсан. Бусад руу нь яриагүй.	I called up three students on the phone. I did not call the rest.

бусдынхаа	the rest of you
бусдыгаа	the rest of you
бусдадаа	to the rest of you
бусдаасаа	from the rest of you

бусадтайгаа	with the rest of you
бусдаараа	to have the rest of you
бусад руугаа	to/towards the rest of you

Та нар бусдынхаа үгийг сонс.	You listen to the others.
Та нар бусдыгаа хүлээ.	You wait for the others.
Та нар бусдадаа туслах хэрэгтэй.	You need to help the others.
Та нар бусдаасаа үлгэр дуурайл ав.	You get good examples from the others.
Та нар бусадтайгаа тоглоорой.	You play with the others.
Та нар бусдаараа муу юм битгий хийлгэ.	Don't have the others do bad things.
Та нар бусад руугаа битгий дайр.	Don't attack the others.

цагаан нь	the white one
цагааных нь	the white one's
цагаанд нь	to/in the white one
цагааныг нь	the white one
цагаанаас нь	from the white one
цагаантай нь	with the white one
цагаанаар нь	by/with/out of the white one
цагаан руу нь	to/towards the white one

Олон машин байна.	There are many cars.
Цагаан нь их үнэтэй юм аа.	The white one is very expensive.
Цагааных нь дугуйнууд нь их сайн юм.	The tires of the white one are good.
Цагаанд нь би дургүй.	I don't like the white one.
Цагааныг нь үзэж болох уу?	May I see the white one?
Цагаанаас нь нэгийг авъя.	I want to buy one from the white ones.
Цагаантай нь адилхан машин надад байгаа.	I have a car the same as the white one.
Цагаанаар нь би хөдөө явна.	I will go to the countryside by the white one.
Цагаан руу нь бүх хүн харж байна.	All people are looking at the white one.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Чи бусдын ...
2. Чи бусдад ...
3. Чи бусдыг ...
4. Чи бусдаас ...
5. Чи бусадтай ...
6. Чи бусдаар ...
7. Чи бусад руу ...
8. Чи бусдынхаа ...
9. Чи бусдыгаа ...
10. Чи бусдадаа ...
11. Чи бусдаасаа ...
12. Чи бусадтайгаа ...
13. Чи бусдаараа ...
14. Чи бусад руугаа ...
15. Том нь ...
16. Би томынх нь ...
17. Би томд нь ...
18. Би томыг нь ...
19. Би томоос нь ...
20. Би томтой нь ...
21. Би томоор нь ...
22. Би том руу нь ...

Дасгал 7

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Багш нэг ангид хамт сурдаг хүүхдүүдэд юу гэж хэлдэг вэ?
2. Ганцаараа тоглох, юм хийх дуртай хүүхдэд багш нь юу гэж хэлдэг вэ?
3. Багаар ажиллаж байгаа хүмүүс ямар байх шаардлагатай вэ?
4. Сайн хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

Дөчин гуравдугаар хичээл

Нийлмэл үгс (Compound Words)

Everywhere = гадаа гэртгүй, гадна дотногүй
Everything = шинэ хуучингүй, том жижиггүй, хиртэй хиргүй
All the time = өдөр шөнөгүй, өглөө оройгүй, өвөл зунгүй
All people = хөгшин залуугүй, эр эмгүй, том жижиггүй, гадаад дотоодгүй, баян ядуугүй, дарга цэрэггүй, эрүүл согтуугүй, багш оюутангүй

Дасгал 1

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ нь:

Эр хүмүүс л тамхи татдаг уу? → Эр эмгүй тамхи татдаг.

1. Эрэгтэй хүмүүс л гэмт хэрэг үйлддэг үү?
2. Согтуу хүмүүс л гэмт хэрэг үйлддэг үү?
3. Хүмүүс гадаа л тамхи татдаг уу?
4. Хүмүүс өглөө л цай уудаг уу?
5. Хүүхдүүд л шинэ юм сурах хэрэгтэй юү?
6. Улаанбаатарт монгол хүмүүс л машин барьдаг уу?
7. Ядуу хүмүүс л нас бардаг уу?
8. Эмч нар өдөр л ажилладаг уу?
9. Дэлгүүрт зөвхөн шинэ хувцас зарагддаг уу?
10. Ажилчид л ажлаас хоцордог уу?
11. Том хүмүүс л өвддөг үү?
12. Та өглөө л хичээл хийдэг үү?
13. Та гэртээ л монголоор ярьдаг уу?

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүмүүс гадна дотногүй ...
2. Цагдаа нар өглөө оройгүй ...
3. Сургуульд багш сурагчгүй ...
4. Малчид өвөл зунгүй ...
5. Хөдөө хөгшин залуугүй ...
6. Зарим газар эр эмгүй ...

Нийлмэл үгс (Compound Words)

...-сан⁴ ...-аа⁴гүй (whether ..... or not)

(Та/Таныг) байсан **байгаагүй** (хамаагүй)	Whether (you) are or not
(Та/Таныг) хэлсэн **хэлээгүй** (хамаагүй)	Whether (you) tell or not
Ээж аавыгаа **хэлсэн хэлээгүй** хүүхдүүд гадаа тоглодог.	Children play outside whether their parents tell them so or not.
Даргыгаа **байсан байгаагүй** ажилчид нь ажлаа сайн хийдэг.	His workers do their work well whether their boss is there or not.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, гэр, ирэх; чи, хоол хийх, идэх → Намайг гэрт ирсэн ирээгүй (хамаагүй) чи хоолоо хийж идээрэй.

1. Гадаа, гэгээтэй байх; тэр ганцаараа явах, айх
2. Би, тэр, туслах; тэр, бүх юм, хийх, чадах
3. Чи, бүртгэх; тэд хоцрох, ирэх
4. Чи, тэр, хэлэх; тэр, энд, ирэх(гүй)
5. Чи, яруулах; тэд, цагтаа, ажил, дуусгах
6. Чи, тэр, асуух; тэр, үнэнийг хэлэх
7. Хүмүүс, энэ, заалгах; хийх, чадах
8. Тэр, энэ, унших; мэдэх
9. Би, энэ, бичих; мартах(гүй)

Дасгал 4

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

Жишээ нь:
Та (өмнө нь) бууз идэж байсан уу? → Би (өмнө нь) бууз идэж байсан. (I have eaten buuz (before).)
Би (өмнө нь) ерөөсөө бууз идэж байгаагүй. (I have never eaten buuz (before).)

1. Та өмнө нь Монголд ирж байсан уу?
2. Та өмнө нь ийм хоол идэж байсан уу?
3. Та хэцүү асуудалтай их тулгарч байсан уу?
4. Та монгол гэрт амьдарч байсан уу?
5. Та хойд мөсөн далайд очиж байсан уу?
6. Та нутагтаа машин барьж байсан уу?
7. Та авлига авч байсан уу?
8. Та хүнд гар хүрч байсан уу?

Дөчин дөрөвдүгээр хичээл

Чимэх үг (Modal Construction)

... юм бол? (I wonder ...?)/... юм бол уу? (I wonder if ...?)

Хүүхдүүд хэдэн цагт хоол идсэн юм бол?	I wonder what time the children ate food?
Хүүхдүүд нэг цагт хоол идсэн юм бол уу?	I wonder if the children ate food at one o'clock?
Энэ юу юм бол?	I wonder what it is?
Энэ тоглоом юм бол уу?	I wonder if it's a toy?
Тэд яагаад маргалдаад байгаа юм бол?	I wonder why they are arguing?
Ямар нэгэн асуудал гарсан юм бол уу?	I wonder if some problem came out?

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Тэр хаашаа яваад ирсэн юм бол? Төв шуудан руу яваад ирсэн юм бол уу?
2. Тэр хэзээ шинжилгээ өгөх юм бол? Өнөөдөр өгөх юм бол уу, маргааш өгөх юм бол уу?
3. Тэр ямар ажил эрхэлдэг юм бол? Хувиараа бизнес эрхэлдэг юм бол уу?
4. Тэр хаашаа ингэтлээ яараад байгаа юм бол? Гэр лүүгээ яараад байгаа юм бол уу?
5. Тэр өмнө нь хаана амьдарч байсан юм бол? Оюутны байранд юм бол уу?
6. Тэр хэн рүү илгээмж явуулах гэж байсан юм бол? Ач охин руугаа юм бол уу?
7. Тэр чөлөөт цагаараа юу хийх дуртай юм бол? Аялах дуртай юм бол уу?
8. Тэд хаанаас ийм их мэдээллийг олж авдаг юм бол? Интернэтээс юм бол уу?
9. Тэр өмнө нь аль гоо сайхны газраар үйлчлүүлдэг байсан юм бол? Энэ газраар юм бол уу?
10. Тэр яагаад надад хариу и-мэйл бичихгүй байгаа юм бол? Миний бичсэн и-мэйлийг аваагүй юм бол уу?

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. I wonder where my book is? I wonder if it's in my house?
2. I wonder where he came from? I wonder if he came from Canada?
3. I wonder what my friend likes to eat? I wonder if she likes to eat fruit?
4. I wonder why she didn't call me? I wonder if she forgot my phone number?
5. I wonder how he achieved this much success?
6. I wonder if she understood me or not? I wonder why she didn't say anything?
7. I wonder how she is going to come? I wonder if she is going to come by bus?
8. I wonder when we will start our project? I wonder if we will start it soon?
9. I wonder who he is? I wonder if he is a new student?

Чимэх үг (Modal Construction)

... бол? (What/when/who ... do you think ...?)
... бол уу? (Do you think ...?)

Гадаа ямар байгаа бол? Дулаахан байгаа бол уу, хүйтэн байгаа бол уу?
Хамгийн сүүлийн үеийн компьютер ямар үнэтэй байгаа бол? Үнэтэй байгаа бол уу, гайгүй байгаа бол уу?
Эндээс Ховд аймгийн төв хүртэл машинаар хэдэн өдөр явах бол? Хоёр өдөр явах бол уу, гурван өдөр явах бол уу?

How do you think it is outside? Do you think it's warm outside or cold?
How much do you think the newest computer is? Do you think it's expensive or not so expensive?

How many days do you think it will take from here to the center of Hovd aimag? Do you think it will take two days or three days?

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Хэн, энэ, угсрах, чадах?
2. Би, энэ, эвлүүлэх, чадах?
3. Тэр, би, гаргаж өгөх?
4. Тэр, би, тосч авах?
5. Цаг агаар, хэзээ, дулаарах?
6. Цас, хэзээ, хайлах?
7. Маргааш, ямар, байх?
8. Дарга, тэр, шагнах?
9. Тэр, тэмцээн, ялах?
10. Байр, үнэ, буух?
11. Тэд, хаагуур явах?
12. Ачаа, хурдан, ирэх?
13. Онгоц, цагтаа, хөөрөх?
14. Тэр, үнэн хэлэх?
15. Тэр, би, ойлгох?
16. Тэд, би, хүсэлт, хүлээн авах?

Дасгал 4

Зургуудыг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the pictures.)



Дөчин тавдугаар хичээл

Чимэх үг (Modal Construction)

... гэж? **When/where/who ... do you mean ...? / ... did you say ... ?**
... гэж үү? **Do you mean ...?**

Эмээ чинь хэдэн настай гэж?	How old did you say your grandmother is?
Тэр 96 настай гэж үү?	Do you mean she is 96 years old?
Кофе биенд муу гэж үү?	Do you mean coffee is bad for the body?
Юу тэр сайн хүн гэж?!	What do you mean he is a good person?!
Юу гэж?	Why (did you ask that)?

Дасгал 1

Багш оюутан хоёр доорх өгүүлбэрүүдийг харилцан хэлж бие биенээсээ асуулт асуу. (Teacher and students say the sentences to each other and ask questions.)

Жишээлбэл:
Багш: —Баярхүү муу хүн.
Оюутан: —Хэн муу хүн гэж? Баярхүү муу хүн гэж үү? Тэр сайн хүн шүү дээ.

Оюутан: —Баярхүү муу хүн.
Багш: —Баярхүү ямар хүн гэж? Муу хүн гэж үү? Тэр муу хүн биш шүү дээ.

1. Би гэртээ сармагчин тэжээдэг.
2. Сүххүү хууль бус наймаа хийдэг.
3. Намайг хиймэл үстэй гэдгийг чи мэдэхгүй байх аа.
4. Би таныг танихгүй юм байна. Та хэн билээ?
5. Хэл сурах маш амархан.
6. Гэмт хэргийн гаралт буурч байгаа байх аа.
7. Тэр гутранги биш, өөдрөг хүн.
8. Улаанбаатар хотын зам дандаа түгжрээгүй байдаг.
9. Хүмүүс байгаль орчинд их болгоомжтой ханддаг.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. When do you mean he will come? Do you mean he will come today?
2. Why did you say you don't want to eat food? Do you mean you want to eat later?
3. Where do you mean you put my cup? Do you mean you put my cup on the floor?
4. Who do you mean can clean this? Do you mean I can clean this?
5. What do you mean is good for eyes? Do you mean carrot is good for eyes?

Чимэх үг (Modal Construction)

... гэлээ? When/where/who did you say ...?
... гэлүү? Did you say ...?

Та хаана төрсөн гэлээ? Улаанбаатарт төрсөн гэлүү?	Where did you say you were born? Did you say you were born in Ulaanbaatar?
Та Америкийн аль мужаас ирсэн гэлээ?	Which state of America did you say you came from?
Калифорни мужаас ирсэн гэлүү?	Did you say you came from the state of California?
Америк хэдэн жилийн түүхтэй гэлээ? 200 жилийн түүхтэй гэлүү?	How many years of history did you say America has? Did you say it has 200 years of history?

Дасгал 3

Доорх нөхцөл байдлуудад тохируулан бие биенээсээ асуулт асуу.
(Ask each other questions that suit the following situations.)

1. Та өмнө нь уулзсан хүнтэйгээ дахин уулзаад тэр хүний ажил, гэр бүлийн тухай дахин асуухыг хүсч байна.
2. Найзаасаа юу идэх дуртайг нь дахин асуу.
3. Найзынхаа амьдарч байсан улсын талаар та дахин сонсохыг хүсч байна.
4. Найзаасаа ямар ямар хоол биенд сайн болохыг дахин асуу.
5. Та найзаасаа нэг хоолны жорын талаар дахин лавлаж асуухыг хүсч байна.
6. Та найзаасаа Энэтхэг ресторан хаана байдгийг дахин лавлаж асуухыг хүсч байна.

Дасгал 4

Өгүүлбэрүүдэд асуулт зохиож бич. (Make questions for the sentences.)

1. Монгол улсын хүн ам 1918 онд 647500, 1969 онд 1197600 байсан бол 2011 онд 2800000 болсон байна.
2. Монгол улс 21 аймаг, 340 сум, 1664 багтай.
3. Монгол улсад буддын шашин зонхилдог.

Дасгал 5

Оюутан багш хоёр бие биендээ ямар нэгэн мэдээлэл хэлээд эргээд тэр мэдээллийнхээ талаар бие биенээсээ асуу. (Student and teacher tell each other some information and then ask each other questions about them.)

Жишээ нь:
Багш: —Монголын хүн амын гуравны нэг хувь нь Улаанбаатар хотод амьдардаг.
Оюутан: —Монголын хүн амын хэдэн хувь нь Улаанбаатар хотод амьдардаг гэлээ? Гуравны нэг хувь нь гэлүү?

Давтлага хичээл (41–45)

Дасгал 1

Доорх үгсээс тохирохыг нь цэгийн оронд нөхөж бич.
(Write the appropriate words from the following list in the spaces.)

өөрөө	өөрийгөө	өөрөөсөө	өөрөөрөө
өөрийнхөө	өөртөө	өөртэйгөө	өөр лүүгээ

1. Чи … цаг гаргах хэрэгтэй.
2. Чи … алдааг хүлээн зөвшөөр.
3. Тэр … цай асгачихлаа.
4. Чи … хүмүүст сайн ойлгуулаагүй байна.
5. Миний хүү, … олон ах хүүхдүүдтэй битгий тогло.
6. Тэр … маш их бахархдаг.
7. Чи … хувцсыг угаах хэрэгтэй.
8. Чи хүмүүсийг … битгий харьцуулаарай.

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. You should listen to each other.
2. They love each other.
3. We asked each other for forgiveness.
4. We know each other's character well.
5. They respect each other.
6. You need to share your opinion with each other.
7. We didn't look at each other.

Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирсон өгүүлбэр бич. (Write sentences that suit the given situations.)

Жишээ нь:
Ширээн дээр бохир аяга байна. → Бүгдийг нь угаагаарай. Нэгийг нь миний ширээн дээр тавиад бусдыг нь шүүгээнд хийгээрэй.

1. Торон дотор төрөл бүрийн жимс байна.
2. Номын тавиур дээр маш олон ном байна.
3. Уутан дотор янз бүрийн өнгөтэй оймс байна.
4. Ширээний шургуулган дотор олон мужааны багаж байна.
5. Цонхны тавцан дээр цэцгүүд байна.

Дасгал 4

Өгөгдсөн нөхцөл байдалд тохирох зөвлөгөөг өг. (Give advice that is appropriate to the given situations.)

1. Нэг ангид сурдаг хүүхдүүд хамт юм хийх, тоглох дургүй. Та тэдэнд юу гэж хэлэх вэ? (Та нар бие биен ...)
2. Нэг эрэгтэй хүүхэд ангийнхаа хүүхдүүдэд дургүйгээ танд хэлсэн. Та түүнд юу гэж хэлэх вэ? (Чи бусад...)

Дасгал 5

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

1. гадаа гэртгүй
2. шинэ хуучингүй
3. том жижиггүй
4. өдөр шөнөгүй
5. өглөө оройгүй
6. хөгшин залуугүй
7. гадаад дотоодгүй
8. баян ядуугүй
9. багш оюутангүй
10. эр эмгүй

Дасгал 6

Доорх өгүүлбэрүүдэд тохирох асуултуудыг зохиож бич.
(Make questions that are appropriate to the following sentences.)

Жишээ нь:
Энхмаа хөдөө амьдардаг.
А. Энхмаа яагаад хөдөө амьдардаг юм бол? Хөдөө амьдрах дуртай юм бол уу?
Б. Энхмаа хаана амьдардаг гэж? Хөдөө амьдардаг гэж үү?
В. Энхмаа хаана амьдардаг гэлээ? Хөдөө амьдардаг гэлүү?

1. Би жолооны үнэмлэх аваагүй мөртлөө машин худалдаж авсан.
2. Би халуун ногоотой хоол идэх ёстой дургүй шүү.
3. Олон том дэлгүүр цахилгаан болон урсдаг шаттай.
4. Тэд гитар маш сайхан тоглодог.
5. Одмаа усанд сэлэхээс айдаг.
6. Монголд олон газар халуун рашаан байдаг.

Тест (41–45)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би энийг өөрөө хийлээ.
Б. Би энийг өөрийгөө хийлээ.
В. Би энийг өөр лүүгээ хийлээ.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Чи өөрөөсөө юм авсан уу?
Б. Чи өөрийнхөө юм авсан уу?
В. Чи өөртөө юм авсан уу?

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та нар өөрсдөө тэр ажлыг хийж чадна.
Б. Та нар өөрөө тэр ажлыг хийж чадна.
В. Та нар өөрөөсөө тэр ажлыг хийж чадна.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Бид бие биенийгээ хүндэлдэг.
Б. Бид бие биендээ хүндэлдэг.
В. Бид бие биенийхээ хүндэлдэг.

5. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та нар бусад ярилцаарай.
Б. Та нар бусдаасаа ярилцаарай.
В. Та нар бусадтайгаа ярилцаарай.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэдний заримыг нь ирчихсэн байна.
Б. Тэдний зарим нь ирчихсэн байна.
В. Тэдний зарим ирчихсэн байна.

7. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би сурагчидтай бүгдэнтэй нь ярьсан.
Б. Би сурагчидтай бүгдээрээ ярьсан.
В. Би сурагчидтай бүгдээр нь ярьсан.

8. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Харыг нь авч болох уу?
Б. Хар нь авч болох уу?
В. Хартай нь авч болох уу?

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хөгшин залуугүй тоглоом тоглодог.
Б. Хөгшин залуу тоглоом тоглодог.
В. Хөгшингүй залуугүй тоглоом тоглодог.

10. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Гэртгүй гадаа халуун байна.
Б. Гадаа гэрт халуун байна.
В. Гадаа гэртгүй халуун байна.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Маргааш цаг агаар ямар байх бол?
Б. Маргааш цаг агаар ямар байх бол уу?
В. Маргааш цаг агаар ямар байна бол?

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хурал 11 цагт дуусах бол?
Б. Хурал 11 цагт дуусах бол уу?
В. Хурал 11 цагт дуусах юм бол?

13. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Энэ юу юм бол уу?
Б. Энэ юу юм бол вэ?
В. Энэ юу юм бол?

14. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хэзээ хүйтэрнэ гэж?
Б. Хэзээ хүйтэрнэ гэж үү?
В. Хэзээ хүйтэрч гэж?

15. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Манай оюутнууд хожигдчихсон гэж?
Б. Манай оюутнууд хожигдчихсон гэж үү?
В. Манай оюутнууд хожигдчихсон гэж вэ?

16. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Та тамирчин гэлээ?
Б. Та тамирчин гэлүү?
В. Та тамирчин гэл?

Оноо (point): 16/ .....

Дөчин зургадугаар хичээл

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-х замд(аа) (On the way to ...)

Sentences with same subject:

Би энд ирэх замдаа найзтайгаа тааралдсан.	I ran into my friend on the way here.
Бид найзынхаа гэрт очих замдаа төөрсөн.	We got lost on the way to our friend's house.

Sentences with different subjects:

Намайг энд ирэх замд найз маань над руу утсаар ярьсан.	My friend called me when I was on the way here.
Их дэлгүүрээс Сүхбаатарын талбай хүрэх замд нэг том хөшөө байдаг.	There is one big statue on the way to Sukhbaatar Square from the Department Store.

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Би, энд, ирэх зам, (би), тэр, утсаар ярих → Би энд ирэх замдаа түүн рүү утсаар ярьсан.

1. Би, энд, ирэх зам, (би), тэр, дуу, заах, өгөх
2. Би, энд, ирэх зам, (би), тэр, олон юм, тухай, ярилцах
3. Би, энд, ирэх зам, (би), тэр, гуанз, хоол идэх
4. Бид, хөдөө, наашаа, ирэх зам, бороо, их орох
5. Бид, хөдөө, наашаа, ирэх зам, машин, эвдрэх
6. Тэд, манайд, очих зам, (тэд), осол, харах
7. Тэд, манайд, очих зам, (тэд), төөрөх
8. Хүүхдүүд, уралдах зам, (хүүхдүүд), нэг ч удаа, амрах(гүй)
9. Тэр, сургууль, гүйх зам, (тэр), халтирч унах
10. Манай гэр, зах, явах зам, нэг сайн үсчний газар, байх
11. Их дэлгүүр, уруудах зам, солонгос ресторан, байх

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Ирэх, тоглох
2. Ирэх, дэлгүүр орох
3. Ирэх, ядрах
4. Явах, тааралдах
5. Явах, үзэх
6. Явах, дуулах
7. Явах, утастах
8. Очих, алдах
9. Очих, даарах

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-х болгонд(оо) (Every time ...)

Sentences with same subject:

Аав нь ажлаасаа гэртээ ирэх болгондоо хүүхдүүдээ үнсдэг.	Every time the father comes home from his work, he gives a kiss to his children.
Найз маань манайд ирэх болгондоо эхлээд утсаар ярьдаг.	Every time my friend comes to my house, she calls first.

Sentences with different subjects:

Ээжийгээ гэртээ ирэх болгонд хүүхдүүд нь баярладаг.	Every time the mother comes home, her children are happy.
Цас орох болгонд байгууллагууд гаднах цасаа цэвэрлэдэг.	Every time it snows, organizations clean the snow outside (of their organizations).

Дасгал 3

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Намайг хичээлдээ явах болгонд ...
2. Би хичээлдээ явах болгондоо ...
3. Түүнийг хочоор нь дуудах болгонд ...
4. Ач хүүгээ өвдөх болгонд ...
5. Тэд хурал хийх болгондоо ...
6. Хүүхдүүд муу дүн авах болгондоо ...
7. Хүүхдүүдийг муу дүн авах болгонд ...
8. Намайг кассанд мөнгө төлөх болгонд ...

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Тэр амжилт гаргах, баяр хөөр болох
2. Тэр амжилт гаргах, гэр бүлийнхэн нь баяр хүргэх
3. Энхмаагийн шүлгийн ном хэвлэгдэж гарах, би авч унших
4. Би түүхийн музейд очих, шинэ үзмэр тавигдах
5. Би монголоор ярих, сандрах
6. Нүүдлийн шувуу ирэх. хүүхдүүд баярлах
7. Солонго татах, хүүхдүүд сонирхох
8. Болдхүү дуурь үзэх, сандал дээрээ унтах
9. Би балет үзэх, тэр надтай хамт явах
10. Баярхүү буруу юм хийх, ээж нь загнах
11. Баярхүү буруу юм хийх, ээжээсээ уучлал гуйх
12. Эмэгтэйчүүдийн баяр болох, хүү ээждээ бэлэг өгөх

Дөчин долдугаар хичээл

Чимэх үг (Modal Construction)

(Би) ...-даг[4] байж (I should have ...-ed)

It is always used only for first person and it is not nessesary to say "Би."

(Би) гэрийн даалгавраа **хийдэг байж**.	I **should have done** my homework.
Найздаа **тусалдаг байж**.	I **should have helped** my friend.
Тэдэнтэй **явдаг байж**.	I **should have gone** with them.
Машин **барьдаггүй байж**.	I **shouldn't have driven** the car.
Тэгдэг байж.	I **should have done that** (what you said).

(чи, тэр) verb stem + **хгүй** (You/he/she should have ...-ed)

Чи гэрийн даалгавраа **хийхгүй** (яасан юм бэ?).	You **should have done** your homework.
Тэр гэрийн даалгавраа хийхгүй.	He/she should have done his/her homework.
Чи уурлахгүй байхгүй (яасан юм бэ?).	You should not have been angry.
Тэгэхгүй.	You/he **should have done that** (what you said).

Note: The verb "хийхгүй" (which is in the examples above) looks like future tense. However the difference is how you say the "-гүй" part. You have to say it with a rising tone.

Дасгал 1

Ямар нөхцөл байдалд доорх өгүүлбэрүүдийг хэлж болохыг бич.
(Write situations for which the following sentences can be used.)

1. Өчигдөр шалгалтандаа бэлддэг байж.
2. Чи өчигдөр шалгалтандаа бэлдэхгүй.
3. Хагархай цонхоо шиллэдэг байж.
4. Чи хагархай цонхоо шиллэхгүй.
5. Чимээгүй суудаг байж.
6. Чи чимээгүй суухгүй.
7. Дулаан хувцсаа өмсдөг байж.
8. Чи дулаан хувцсаа өмсөхгүй.
9. Хөгжмийн сургуульд ордог байж.
10. Чи хөгжмийн сургуульд орохгүй.
11. Ногоон гэрлээр зам гардаг байж.
12. Чи ногоон гэрлээр зам гарахгүй.

Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудад тохирох өгүүлбэрүүдийг бич.
(Write sentences that suit the following situations.)

1. Чи яагаад бидэнтэй хөдөө яваагүй юм бэ? Бид их хөгжилтэй явсан.
2. Би сая номын дэлгүүр ороод чиний ав гэсэн номыг авах гэтэл дуусчихсан байна. Чи өчигдөр яагаад надад авчхаагүй юм бэ?
3. Чи яагаад гэр лүүгээ утастаагүй юм бэ? Аав ээжийн чинь санаа их зовсон.
4. Ээ, чих чинь хөлдчихсөн байна. Малгайгаа өмс гэж би чамд хэлсэн шүү дээ.
5. Цамц чинь чамд багадаж байна шүү дээ. Чи дэлгүүрт өмсөж үзээгүй юм уу?
6. Хүү чинь таны гар утсыг усанд хийчихжээ. Яагаад хүүдээ утсаа өгсөн юм бэ?

Чимэх үг (Modal Construction)

-хаас^4 (даа^4)

This suffix expresses the meaning that the speaker doesn't want to do that action, but he/she has to do it because of some reason.

Дэлгүүр явахаас (даа).	I don't want to, but I have to go to the store.
Энэ ажлыг хийхээс (дээ).	I don't want to, but I have to do this work.
Номоо уншихаас даа.	I don't want to, but I have to read my book.
Найзтайгаа ярихаас.	I don't want to, but I have to talk to my friend.
Тэдэнтэй явахаас гэж би бодсон.	I thought "I don't want to, but I have to go with them."

It is always used only for first person. It is not nessesary to say "Би" and it expresses only present tense. If you want to use this form for other tenses, look at the note below.

Note: It's the short version of "–аас^4 өөр аргагүй (арга байхгүй) байх/болох."

Дэлгүүр явахаас өөр аргагүй.	There is no other way than to go to the store.
Дэлгүүр явахаас өөр аргагүй байсан.	There was no other way than to go to the store.
Дэлгүүр явахаас өөр аргагүй болно.	There will be no other way than to go to the store.
Та/тэр, дэлгүүр явахаас өөр аргагүй.	There is no other way for you/him than to go the store.

Дасгал 3

Доорх нөхцөл байдалд юу гэж хэлэхээ бич. (Write down what you can say in the following situations.)

1. Чи хоол идмээргүй байна. Харин ээж чинь чамайг хараад сууж байна.
2. Та кино үзмээргүй байна. Харин найз чинь кино үзье гээд гуйгаад байна.
3. Та хоол хийхийг хүсэхгүй байгаа ч гэдэс чинь өлсөж байна.
4. Таны угаагаад хатаасан оймс чинь газар унаад шороо болчихсон байна.
5. Шүүгээнд байсан талх чинь хатчихсан байна.
6. Таныг автобусаар гэр лүүгээ явах гэсэн чинь зам түгжрээд машинууд зам дээр гацчихсан байна.
7. Концерт сонирхолтой байгаа боловч хөгжим нь хэтэрхий чанга байгаа болохоор чих чинь өвдөж байна.

Дасгал 4

Ямар нөхцөл байдалд доорх өгүүлбэрүүдийг хэлж болохыг бич.
(Write situations where the following sentences can be used.)

1. Гэр лүүгээ алхахаас.
2. Тамхи татахаа болихоос доо.
3. Шинэ машин авахаас.
4. Найздаа үнэнийг хэлэхээс дээ.
5. Үндсэн хууль сайн судлахаас.
6. Шалан дээр суухаас даа.
7. Найз руугаа дахиад и-мэйл явуулахаас.
8. Ажил хийхээс дээ.

Дөчин наймдугаар хичээл

Захируулан холбох үгс (Subordinating Conjunctions)

-хаар[4] барахгүй (Not only ..., ...)
-х нь байтугай (... didn't/don't ... not even ...)

Би англиар **ярихаар барахгүй** орчуулга хийдэг.
Би англиар **ярих нь байтугай** нэг ч үг **мэдэхгүй**.
Би монгол гэрт орж үзэхээр барахгүй амьдарч байсан.
Би монгол гэрт амьдрах нь байтугай орж ч үзээгүй.

Not only do I **speak** English, I do translation.

I **don't speak** English, I **don't even know** one word.
Not only did I go in a Mongolian ger, I was living in a Mongolian ger.
I didn't live in a Mongolian ger. I didn't even enter a Mongolian ger.

Дасгал 1

Загварын дагуу асуулт зохиож, хариултыг нь бич.
(Make questions as in the example and answer them.)

Жишээ:
Ном уншиж эхлэх, ном уншиж дуусах

Та нөгөө номоо уншиж эхэлсэн үү? (Have you started reading that book?)
Эхлэхээр барахгүй уншаад дуусчихсан. (Not only have I started, I have finished reading it.)

Та нөгөө номоо уншиж дууссан уу? (Have you finished reading that book?)
Дуусах нь байтугай эхлээгүй (эхлээ ч үгүй). (I didn't finish it. I didn't even start it.)

1. Хүүхдүүдээ загнах — Хүүхдүүдээ зодох
2. Хөзөр тоглох — Мөрийтэй тоглоом тоглох
3. Аав ээжийнхээ үгэнд орох — Багшийнхаа үгэнд орох
4. Гэрлэх — Хүүхэдтэй болох
5. Дунд сургуулиа төгсөх — Их сургууль төгсөх
6. Англи цагаан толгой мэдэх — Англиар сайн ярих
7. Өндөг шарж сурах — Хоол хийж сурах
8. Түүнийг таних — Түүнтэй нэг орцонд амьдрах
9. Пиво уух — Архи уух
10. Найздаа туслах — Танихгүй хүнд туслах
11. Англи хэл мэдэх — Англи хэл заах
12. Шинэ номын тухай сонсох — Шинэ ном авах
13. Биеийн тамирын дасгал хийх — Гимнастикийн төрлөөр алтан медаль авах

Дөчин есдүгээр хичээл

Захируулан холбох үгс (Subordinating Conjunctions)

Хэдий чинээ ..., төдий чинээ ... (How much ..., that much .../amount of ...)

Чи хэдий чинээ ажилсаг байна, төдий чинээ сайхан амьдарна.
Хэдий чинээ ном их уншина, төдий чинээ их юм мэдэж авна.
Хэдий чинээ их мэднэ, төдий чинээ даруу байна.

The amount of hard worker you are, the same amount of good life you will have.
The amount of books you read, will equal the amount you learn.
The amount of knowledge (a person has) will equal the same amount of humility.

Note: For general ideas, we don't have to mention any subject.

Дасгал 1

Үзсэн хэлзүйгээ ашиглан өгүүлбэрүүдийг гүйцээж бич.
(Complete the sentences using the grammar you have just learned.)

1. Ямар нэг юмыг ... их давтах, ... сайн сурах
2. Та ... олон үг мэдэх, хүмүүсийг ... сайн ойлгох
3. Та хүмүүстэй монголоор ... их ярих, монгол хэлийг ... хурдан сурах
4. Хүмүүс ... залхуу байх, ... ядуу байх
5. Та бусад хүмүүсийг ... хүндлэх, бусад хүмүүс таныг ... хүндлэх
6. Хүнд ... муу юм хийх, ... олон дайсантай болох
7. ... олон асуулт асуух, ... их юм мэдэж авах
8. ... дасгал хийх, ... эрүүл байх
9. ... чанартай хоол идэх, ... эрүүл байх
10. ... цаг сайн ашиглах, ... их юм хийх
11. ... хурдан явах, ... хурдан очих
12. ... олон бөмбөг хаалганд оруулах, ... олон оноо авах
13. ... өндөрт гарах, ... хүйтэн болох
14. ... тамхи их татах, ... бие хордох

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Хурдан хийх, хурдан дуусах
2. Эрт босох, олон юм хийх
3. Их хоол идэх, таргалах
4. Туслах, найзтай болох
5. Бага хоол идэх, туранхай байх
6. Олон газар явах, олон юм үзэх
7. Унших, мэдэх
8. Босох, сайн болох

Захируулан холбох үг (Subordinating Conjunction)

-х тусам(аа) (More ... more ...)

Sentences with same subject:

Тэр том болох тусмаа ээжтэйгээ адилхан болж байна.	The older she gets, the more like her mother she becomes.

Sentences with different subjects:

Өдөр өнгөрөх тусам түүний бие дээрдэж байна.	The more days go by, the better he is feeling.
Хүмүүстэй ярих тусам түүний хэл сайжирна.	The more he talks with people, the better his language will become.

Дасгал 3

Сурсан шинэ үгээ ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио.
(Make sentences with the given words using the new grammar you have learned.)

1. Өдөр өнгөрөх, би гэрээ илүү санах
2. Өдөр өнгөрөх, түүний монгол хэл сайжрах
3. Өдөр өнгөрөх, тэдний харьцаа муудах
4. Өдөр өнгөрөх, тэд бие биенийгээ сайн ойлгох
5. Өдөр өнгөрөх, тэр буруугаа ухаарах
6. Өдөр өнгөрөх, гадаа хүйтрэх
7. Тэр, их мөнгө олох, хэрэггүй юманд үрэх
8. Тэд хол явах, ус ховордох
9. Чи олон юм орчуулах, олон шинэ үг тогтоох
10. Эцэг эх хүүхдүүдээ эрхлүүлэх, хүүхдийн зан ааш эвдрэх
11. Эцэг эх хүүхдүүдээ хориглох, хүүхдүүд тэр юмыг хийх
12. Тэр номыг дахин дахин унших, утгыг нь илүү сайн ойлгох

Дасгал 4

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. The more you do one thing again and again, the more experience you will get.
2. The more you are afraid of dogs, the more they will attack you.
3. The more the days go by, the more it is getting hotter outside
4. The more children stay alone, the more unsociable they get.
5. The more we went, the worse the road got.

Тавьдугаар хичээл

Холбох үг (... юм чинь) (Conjunction (Because ...))

Тэр надад тусалсан **юм чинь** би түүнд тусална. (**Because** he helped me, I will help him.)

Дасгал 1

Англи, монгол өгүүлбэрүүдийг харьцуулж унш. (Read and compare the English and Mongolian sentences.)

His fever will go down soon because he took medicine.	Эм уусан юм чинь удахгүй халуун нь бууна аа.
He can come to our house without getting lost because it's light outside.	Гадаа гэгээтэй байгаа юм чинь тэр манайд төөрөлгүй ирж чадна.
Our car will be okay when we go there because we fixed it very well.	Бид машинаа их сайн зассан юм чинь тийшээ явахад машин зүгээр байна.
I think she is doing okay because she is not writing any emails to us.	Тэр бидэнд и-мэйл бичихгүй байгаа юм чинь зүгээр байгаа байх аа.
He can reach that hanger because he is tall.	Тэр өндөр юм чинь өлгүүрт хүрч чадна.
Your friend didn't learn English, so how will he understand that American?	Найз чинь англи хэл сураагүй юм чинь яаж тэр америк хүнийг ойлгох юм бэ?
They probably know country life very well because they have been living in the countryside for a long time.	Тэд хөдөө удаан амьдарч байгаа юм чинь хөдөөний амьдралыг сайн мэдэх байх аа.
We won't recognise each other by sight because we never met before.	Бид өмнө нь уулзаж байгаагүй юм чинь бие биенийгээ хараад танихгүй.
That little boy won't cry again now because he took the toy he wanted to take.	Тэр жаахан хүү авах гэсэн тоглоомоо авсан юм чинь одоо дахиад уйлахгүй.
Jargalmaa can cook food like that herself because she saw how I was cooking that food.	Жаргалмаа намайг тэр хоолыг яаж хийж байсныг харсан юм чинь өөрөө тийм хоол хийж чадна.
He is probably tired now because he worked many hours.	Тэр олон цаг ажилласан юм чинь одоо ядарч байгаа байх аа.
He probably can't come to his lesson because he is sick.	Тэр өвчтэй байгаа юм чинь хичээлдээ ирж чадахгүй байх аа.
Water in the container is probably frozen because it was outside.	Савтай ус гадаа байсан юм чинь хөлдсөн байх аа.

Холбох үг (чинь) (Conjunction (When))

"Би аягыг чинь хагалчихсан" гэж хэлсэн **чинь** тэр их уурласан.
(**When** I said "I broke your cup" he got very angry.)

Дасгал 2

Англи, монгол өгүүлбэрүүдийг харьцуулж унш. (Read and compare the English and Mongolian sentences.)

When I got up in the morning, the electricity had been cut off.
(Намайг) өглөө боссон чинь цахилгаан тасарчихсан байсан.

When I was about to cook, the electricity went off.
(Намайг) хоол хийх гэж байсан чинь цахилгаан тасарчихсан.

I was told that when he was walking in the street, someone hit him with a stone.
Түүнийг гудамжинд явж байсан чинь нэг хүн чулуугаар цохичихсон гэсэн.

When he went to the school to meet Bathuu, the doorman didn't let him in.
Түүнийг Батхүүтэй уулзахаар сургууль дээр очсон чинь жижүүр оруулаагүй.

When I tried to call my friend all day yesterday, her phone wasn't working.
Өчигдөр өдөржингөө найз руугаа залгасан чинь утас нь болохгүй байсан.

When I was wiping the dust off the statue, it fell down and broke.
Өчигдөр хөшөөний тоосыг арчиж байсан чинь унаад хагарчихсан.

When I was absent from my lesson, my teacher was very angry.
Хичээлээ тасалчихсан чинь манай багш их уурласан.

When I looked in the mirror, my face had paint on it.
Толинд харсан чинь миний нүүр будаг болчихсон байсан.

When I came home, no one was there.
Гэртээ ирсэн чинь хэн ч байхгүй байсан.

When I told him to rest, he didn't.
Түүнд амар гэж хэлсэн чинь тэр амраагүй.

When I drank two cups of coffee, I stopped feeling sleepy.
Хоёр аяга кофе уусан чинь миний нойр хүрэхээ байчихсан.

When I took a deep breath, my anger went away.
Гүнзгий амьсгаа авсан чинь миний уур гарчихсан.

When I took a deep breath, I stopped being nervous.
Гүнзгий амьсгаа авсан чинь би сандрахаа больчихсон.

When I got up in the morning and looked through the window, it had snowed much.
Өглөө босоод цонхоор харсан чинь их цас орчихсон байсан.

When I said sorry to my friend, she was so surprised.
Найздаа уучлаарай гэж хэлсэн чинь найз маань их гайхсан.

When I cooked Mongolian food for the first time yesterday, it had become very salty.
Өчигдөр анх удаа монгол хоол хийсэн чинь шорвог болчихсон байсан.

Давтлага хичээл (46–50)

Дасгал 1

Өгүүлбэрүүдийг орчуул. (Translate the sentences.)

1. On the way here, I ran into my friend.
2. On the way home, don't play outside with other kids.
3. On the way to my school, I stopped by the store.
4. On the way to Ulaanbaatar, their car got stuck in the mud.
5. On the way to the store, I lost my key.
6. On the way from here to the bank, there is one restaurant that has good food.
7. On the way to Terelj, there are many families that have animals.
8. On the way to your house, I called her.
9. Did you see that new building when you were on the way to my house?

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
явах, уйлах → Ээжийгээ ажилдаа явах болгонд бага хүү нь уйлдаг.

1. Уурлах, чанга ярих
2. Ирэх, баярлах
3. Ярих, инээмсэглэх
4. Уралдах, түрүүлэх
5. Өвдөх, санаа зовох
6. Машин барих, сандрах
7. Утас дуугарах, цочих
8. Уулзах, хэлэх

Дасгал 3

Жишээ өгүүлбэрт бичсэнчлэн нөхцөл байдалд тохирох өгүүлбэрийг бич.
(Write sentences that suit each situation as in the example.)

Жишээ:
Чи надаас тэр талаар асуухгүй. → Харин тийм ээ, танаас асуудаг байж.

1. Чи найзтайгаа уулзахгүй.
2. Чи ээжийнхээ үгэнд орохгүй.
3. Хичээлдээ цагтаа ирэхгүй.
4. Чи гэрээсээ гарахгүй байхгүй.
5. Та нар хоолоо сайн идэхгүй.
6. Та нар надад хэлэхгүй.
7. Чи өчигдөр тэр номоо авчихгүй.
8. Чи надтай хамт явахгүй.

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь: амьдрах → Энэ жижиг өрөөнд амьдрахаас даа.

1. Явах
2. Тайлбарлах
3. Хадгалах
4. Хожигдох
5. Сурах
6. Болих
7. Цэвэрлэх
8. Хуваах
9. Барих

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг уншаад асуулт зохиож бич. (Read the sentences and make questions out of them.)

Жишээ нь:
Би тэр хүнийг танихаар барахгүй хамт ажилладаг. → Та тэр хүнийг таних уу?
Би тэр хүнтэй хамт ажиллах нь байтугай нэрийг нь ч мэдэхгүй. → Та тэр хүнтэй хамт ажилладаг уу?

1. Би Дархан хотод очихоор барахгүй тэнд амьдарч байсан.
2. Би Дархан хотод амьдрах нь байтугай очиж ч үзээгүй.
3. Би гэртээ нохой тэжээх нь байтугай хашаандаа нохой байлгадаггүй.
4. Би хашаандаа нохойтой байхаар барахгүй гэртээ бас нохой тэжээдэг.
5. Би аяга таваг угаахаар барахгүй хоол хийдэг.
6. Би хоол хийх нь байтугай аяга таваг ч угаадаггүй.
7. Би машин барихаар барахгүй онгоц жолооддог.
8. Би онгоц жолоодох нь байтугай машин ч барьж чадахгүй.

Дасгал 6

Өгүүлбэрүүдийг гүйцээж бич. (Complete the sentences.)

1. Хүмүүс хэдий чинээ их ажиллана, төдий чинээ ...
2. Хүмүүс нэг юмыг хэдий чинээ их давтаж хийнэ, төдий чинээ ...
3. Хүмүүс хэдий чинээ их ном уншина, төдий чинээ ...
4. Хүмүүс хэдий чинээ их мөнгө үрнэ, төдий чинээ ...
5. Хүмүүс хэдий чинээ их асуулт асууна, төдий чинээ ...
6. Хүмүүс хэдий чинээ их залхуурна, төдий чинээ ...
7. Хүмүүс бие биентэйгээ хэдий чинээ их ярина, төдий чинээ ...
8. Хүмүүс хол газар явах тусам ...
9. Хүмүүс их дасгал хийх тусмаа ...
10. Хүүхдээ том болох тусам ...
11. Хүүхэд том болох тусмаа ...
12. Өдөр өнгөрөх тусам ...
13. Хүмүүс их юм мэдэж авах тусмаа ...
14. Гадаа хүйтрэх тусам ...

Тест (46–50)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүүхдүүд ирж замдаа их даарчээ.
Б. Хүүхдүүд ирэх замдаа их даарчээ.
В. Хүүхдүүд ирсэн замдаа их даарчээ.

2. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Эндээс зах орох замд үсчин байдаг.
Б. Эндээс зах орох замдаа үсчин байдаг.
В. Эндээс зах орж замд үсчин байдаг.

3. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүү тэмцээнд түрүүлэх болгонд аав нь баярладаг.
Б. Хүүгээ тэмцээнд түрүүлэх болгондоо аав нь баярладаг.
В. Хүүгээ тэмцээнд түрүүлэх болгонд аав нь баярладаг.

4. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр ямар нэг юман дээр шийдвэр гаргах болгондоо ээжээсээ асуудаг.
Б. Тэр ямар нэг юман дээр шийдвэр гаргах болгонд ээжээсээ асуудаг.
В. Түүнийг ямар нэг юман дээр шийдвэр гаргах болгондоо ээжээсээ асуудаг.

5. I should have worn warm boots.
А. Дулаан гутал өмсдөг байж.
Б. Дулаан гутал өмсөхөөс дөө.
В. Дулаан гутал өмсөх хэрэгтэй байсан.

6. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Гэрээсээ арай эрт гарсан байж.
Б. Гэрээсээ арай эрт гарч байж.
В. Гэрээсээ арай эрт гардаг байж.

7. I have to take my medicine (eventhough I don't want to).
А. Эмээ уухаас даа.
Б. Эмээ уудаг байж.
В. Эмээ уух ёстой.

8. Which one is right in meaning?
А. Тэр англи цагаан толгойн үсэг мэдэхээр барахгүй англиар сайн ярьдаг.
Б. Тэр англиар сайн ярихаар барахгүй англи цагаан толгойн үсэг мэднэ.
В. Тэр англиар сайн ярихаар барахгүй англиар тоолж чадна.

9. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Тэр манайд ирэхээс барахгүй гэрийн ажил хийхэд надад тусалдаг.
Б. Тэр манайд ирэхээр барахгүй гэрийн ажил хийхэд надад тусалдаг.
В. Тэр манайд ирэх барахгүй гэрийн ажил хийхэд надад тусалдаг.

10. Which one is right in meaning?
А. Тэр, хүн зодох нь байтугай хараалын үг ч хэлдэггүй.
Б. Тэр, хараалын үг хэлэх нь байтугай хүн ч зоддоггүй.
В. Тэр, хүн зодох нь байтугай хараалын үг ч хэлдэг.

11. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Би пицца хийхээр байтугай идэж ч үзээгүй.
Б. Би пицца хийгээд байтугай идэж ч үзээгүй.
В. Би пицца хийх нь байтугай идэж ч үзээгүй.

12. Аль нь зөв бэ? (Which one is right?)
А. Хүн хэдий чинээ их ном уншсан, төдий чинээ юм мэдэж авна.
Б. Хүн хэдий чинээ их ном уншина, төдий чинээ юм мэдэж авна.
В. Хүн хэдий чинээ их ном уншдаг, төдий чинээ юм мэдэж авна.

Оноо (point): 12/ .....

Дасгалуудын хариу
(Key to Exercises)

Нэгдүгээр хичээл

Дасгал 3

1. Би гэртээ байхдаа гэрийн ажил хийсэн.
2. Би гэр лүүгээ явахдаа таксигаар явна.
3. *Ганхүү сургуульд байхдаа англи хэл сурсан.*
4. Багшийг ангид ороход сурагчид ширээндээ сууж байсан.
5. Би арван найман настай байхдаа сургуулиа төгссөн.
6. Би гучин настай байхдаа гэрлэсэн.
7. Хоол идэж байхдаа битгий хэтэрхий их ярь.
8. Тэр, ном уншиж байхдаа алим идэж байсан.
9. Намайг гэртээ ирэхэд ээж маань цай чанаж байсан.
10. Багшийг явахад оюутнууд нь түүнд цэцэг өгсөн.
11. Өчигдөр бороо орж эхлэхэд би дэлгүүрт байсан.
12. Батхүүг дуулахад бид гайхсан.
13. Чамайг/таныг и-мэйл бичиж байхад би хөгжим сонсож байсан.
14. Бороо орж байхад бид гадаа тоглож байсан.

Хоёрдугаар хичээл

Дасгал 2

1. Чи олон цаг ажиллавал ядарна.
2. Чамайг олон цаг ажиллавал би чамд тусална.
3. Хоол сайн идэхгүй бол чи өвдөнө.
4. Гадаа хүйтэн байвал дулаан хувцсаа өмс.
5. Түүнийг ирэхгүй бол би гэрт нь очно.
6. Чи манайд очиж чадахгүй бол над руу утсаар яриарай.
7. Чи түүнтэй уулзвал 5 цагт ир гэж хэлээрэй.
8. Тэднийг монгол хэл сурах хэрэгтэй бол зааж өгөөрэй.
9. Түүнийг гуйвал аав нь түүнд тусална.
10. Чи хувцсаа гадаа өлгөвөл хурдан хатна.
11. Чи хичээлдээ анхаарвал, (хичээлээ) сайн ойлгоно.
12. Салхитай байвал би гадаа тоглохгүй.
13. Түүнийг манай багт тогловол бид хожно.

Дасгал 5

1. Тэр их сургуулиа төгссөн бол сайн ажилд орчихсон байх байсан.
2. Чи тэр шилийг хагалсан бол их мөнгө төлөх байсан.
3. Чи өчигдөр ирсэн бол харамсахгүй (байх) байсан.
4. Тэр хөдөө яваагүй бол өвдөхгүй (байх) байсан.
5. Ээжийгээ яваагүй бол тэр уйлахгүй байсан.
6. Бороо ороогүй бол би гэртээ байхгүй байх байсан.
7. Найзыгаа туслаагүй бол би энийг хийж дуусгаж чадахгүй байх байсан.
8. Тэд хөл бөмбөг тоглосон бол хожих байсан.
9. Би эмч байсан бол энийг чамд тайлбарлаж өгч чадах байсан.
10. Чи бөх байсан бол дэлхийн аварга байх байсан.
11. Чи тэрбумтан байсан бол яах байсан бэ?

Дасгал 6

1. Болдхүү өвдсөн бол эм уух байсан.
2. Болдхүү өвдөөгүй бол эм уухгүй байх байсан.
3. Хүүхэд бүдэрч унасан бол уйлах байсан.
4. Хүүхэд бүдэрч унаагүй бол уйлахгүй байх байсан.
5. Би өчигдөр театр луу явсан бол жүжиг үзэж чадах байсан.
6. Би өчигдөр театр луу яваагүй бол жүжиг үзэж чадахгүй байх байсан.
7. Тэр миний хэлсэн өгүүлбэрийг ойлгосон бол инээх байсан.
8. Тэр миний хэлсэн өгүүлбэрийг ойлгоогүй бол инээхгүй байсан.
9. Тэр монгол хэл сайн сураагүй бол монгол хүмүүстэй ярьж чадахгүй байх байсан.
10. Тэр монгол хэл мэддэг байсан бол монгол хүмүүстэй ярих байсан.

Дөрөвдүгээр хичээл

Дасгал 2

1. Тэр хичээл хийхээсээ өмнө жаахан амарна.
2. Би ирэх долоо хоногт хөдөө явахаасаа өмнө тантай уулзана.
3. Та манайд ирэхээсээ өмнө утастаарай.
4. Би мартахаасаа өмнө таны номыг өгнө.
5. Би хувцасны шүүгээгээ цэвэрлэхээсээ өмнө номын тавиураа янзална.
6. Чи шалаа угаахаасаа өмнө шүүрдэх хэрэгтэй.
7. Та ямар нэг юм хийхээсээ өмнө сайн бодох хэрэгтэй.
8. Та баярын ширээ засахаасаа өмнө бүтээлгийг нь солих хэрэгтэй.
9. Чи ногоогоо хэрчихээсээ өмнө сайн угаах хэрэгтэй.
10. Та шинэ бизнес эхлэхээсээ өмнө сайн төлөвлөх хэрэгтэй.
11. Түүнийг манай гэрт ирэхээс өмнө би хичээлээ хийж байсан.
12. Хичээл өглөө 9 цагт эхлэхээс өмнө би сургууль дээр ирэх ёстой.
13. Багшийг хичээлээ 9 цагт эхлэхээс өмнө бүх оюутан ширээндээ суудаг.
14. Ээжийг ирэхээс өмнө би эвдэрхий сандлаа засах хэрэгтэй.
15. Удахгүй бороо орохоос өмнө чи гэр лүүгээ явах хэрэгтэй.
16. Цас орохоос өмнө бид хотод очсон.
17. Нар мандахаас өмнө би боссон.

Дасгал 3

1. Намайг ирэхээс өмнө ах маань гэртээ ирсэн.
2. Түүнийг явахаас өмнө төлөвлөгөөнийхөө талаар түүнтэй ярь.
3. Ямар нэг юм худалдаж авахаасаа өмнө хугацааг нь хар.
4. Тэр шалаа будахаасаа өмнө ханаа будсан.
5. Хайчлахаасаа өмнө цаасаа сайн хэмж.
6. Өвөл болохоос өмнө малчид малдаа тэжээл бэлтгэдэг.
7. Харанхуй болохоос өмнө бид тэнд хүрэх хэрэгтэй байна.
8. Арван цаг болохоос өмнө тэр машинаа засах ёстой байсан.
9. Ханын цаасаа наахаасаа өмнө ханаа цэвэрлэ.
10. Чи ямар нэг юм хэлэхээсээ өмнө бодох хэрэгтэй.
11. Чи ямар нэг юм хийхээсээ өмнө бодох хэрэгтэй.
12. Чи хэн нэг хүнд уурлахаасаа өмнө бодох хэрэгтэй.
13. Чи хоол идэхээсээ өмнө гараа угаах хэрэгтэй.
14. Ирэхээсээ өмнө над руу утсаар ярь.
15. Явахаасаа өмнө цонхнуудаа хаагаарай.
16. Тэр Монголд ирэхээсээ өмнө монгол хэл сурч байсан.

17. Чи хоол идэхээсээ өмнө юу хийдэг (яадаг) вэ?
18. Хүмүүс шинэ байранд нүүж орохоосоо өмнө яадаг вэ?
19. Чи аялалд явахаасаа өмнө юу бэлддэг вэ?

Дасгал 5

1. Түүнд миний өмнөөс мэнд хүргээрэй.
2. Миний өмнөөс түүнээс уучлалт гуйгаарай.
3. Миний өмнөөс түүнд баярлалаа гэж хэлээрэй.
4. Миний өмнөөс ахад маань сайхан үг (урмын үг) хэлээрэй.
5. Миний өмнөөс энэ бэлгийг эгчид минь өгөөрэй.
6. Миний өмнөөс түүнтэй гар бариарай.
7. Миний өмнөөс хүүг минь үнсээрэй.
8. Миний өмнөөс найзыг минь тэврээрэй.
9. Миний өмнөөс найзыг маань зоригжуулаарай.
10. Миний өмнөөс хурал дээр үг хэлээрэй.
11. Би тэдний өмнөөс ичсэн.
12. Тэр чиний өмнөөс санаа зовно.
13. Тэр миний өмнөөс захиралтай уулзана.
14. Би оюутнуудын чинь өмнөөс энэ цэцгийг танд өгч байна.
15. Ах маань өвчтэй байсан болохоор би түүний өмнөөс бүх ажлыг хийдэг байсан.

Тавдугаар хичээл

Дасгал 1

1. Тэр сургуулиа төгссөнийхөө дараа ажил хийсэн.
2. Би баншаа жигнэснийхээ дараа бага зэрэг шарна.
3. Махаа чанасныхаа дараа утаарай.
4. Би заримдаа монголоор буруу ярьсныхаа дараа шууд мэддэг.
5. Хоолоо идсэнийхээ дараа энэ эмийг уугаарай.
6. Хоолоо идсэнийхээ дараа амттан идээрэй.
7. Кофегоо сайн хутгасныхаа дараа уу.
8. Модоо сайн хэмжсэнийхээ дараа хөрөөдөөрэй.
9. Өгүүлбэр бичсэнийхээ дараа шалгаарай.
10. Намайг ярьсны дараа найз маань их баярласан.
11. Хүүхдүүдийг явсны дараа би тэднийг их үгүйлсэн.
12. Багшийг самбар дээр үг бичсэний дараа хүүхдүүд уншдаг.
13. Бороо орсны дараа шалбааг тогтдог.
14. Цас орсны дараа хүүхдүүд цасан дээр тоглодог.
15. Бороо зогссоны дараа бид гадаа гарсан.

Дасгал 2

1. Чи энэ номыг уншсаныхаа дараа надад өгөөрэй.
2. Чи сайн бодсоныхоо дараа шийдвэр гаргах хэрэгтэй.
3. Хүмүүс заримдаа ямар нэг юм хэлснийхээ дараа харамсдаг.
4. Тэр их сургуулиа төгссөнийхөө дараа ямар ч ажил хийгээгүй.
5. Тэр хотод ирснийхээ дараа хотын амьдралыг ойлгоно.
6. Тэр Монголд нэг жил болсныхоо дараа монгол хэл сурч эхэлсэн.
7. Текстээ бичиж дууссаныхаа дараа багшид өгөөрэй.
8. Монголчууд гэрт орсныхоо дараа хүмүүстэй мэндэлдэг.

9. Чи өгүүлбэрүүдээ орчуулсныхаа дараа шалгаарай.
10. Тэр хоол идсэнийхээ дараа дандаа тамхи татдаг.
11. Асуусныхаа (зөвшөөрөл авсныхаа) дараа хүний юмыг хэрэглэ.
12. Монголчууд нялх хүүхдийг төрсний дараа хувцас авдаг байсан.
13. Бүх хүнийг танхимд орсны дараа хаалга хаа.
14. Бүх оюутныг бэлэн болсны дараа хичээлээ эхэл.
15. Махаа хэрчсэнийхээ дараа ногоогоо хэрч.
16. Чамайг хоолоо идсэний дараа би чамд сонирхолтой юм ярьж өгнө.
17. Бороо зогссоны дараа гадаа гар.
18. Тоосыг нь арчсаныхаа дараа номнуудаа тавиур дээр тавь.
19. Түүнийг ярьж дууссаны дараа би ярина.

Давтлага хичээл (1–5)

Дасгал 7

1. Та болон таны гэр бүлийн төлөө би санаа зовж байна.
2. Би таны эрүүл мэнд, ажлын төлөө залбирна аа.
3. Манай аав ээж миний төлөө бүхнийг хийдэг.
4. Тэр хүүхдүүдийнхээ төлөө илүү ихийг хийх хэрэгтэй.
5. Таны амжилтын төлөө!

Тест (1–5)

1. В 2. А 3. В 4. Б 5. А 6. Б 7. А 8. Б 9. А 10. Б 11. В 12. А 13. А 14. Б 15. Б 16. А

Зургадугаар хичээл

Дасгал 1

1. Гар нь хар болчихжээ.
2. Би нэрийг нь мартчихжээ.
3. Би машинаар нь явсан.
4. Яриа нь сонирхолтой байдаг.
5. Удаан алхсан учраас хөл нь өвдөж байлаа.
6. Хүүхдүүд нь их хүмүүжилтэй.
7. Би байранд нь нэг хэсэг амьдарсан.
8. Ирэхэд нь би гэр бүлийнхнийх нь талаар асуусан.
9. Манайд байх үед нь би монгол хоолоор дайлсан.
10. Явахад нь ээж нь дандаа "Болгоомжтой яваарай" гэж хэлдэг.
11. Гэртээ байхад нь тог тасрав.
12. Ажил дээрээ байхад нь дарга нь дуудлаа.
13. Өглөө босоход нь ээж нь цай чанаж байсан.
14. Очиход нь хичээл нь эхэлчихсэн байсан.

Дасгал 5

1. Сургуулийн гадаа олон хүн байна. Зарим нь оюутан, зарим нь багш. Зарим нь сууж, зарим нь зогсож байна. Би заримыг нь танина. Би өмнө нь заримтай нь уулзаж байсан.
2. Ширээн дээр номнууд байна. Гурав нь хөх, дөрөв нь цагаан, нэг нь улаан байна. Хамгийн том нь минийх, хамгийн жижиг нь манай найзынх. Улаан нь монгол хэлний ном. Би улааныг нь дэлгүүрээс авсан. Чи хөхийг нь уншиж болно. Би цагааныг нь ширээн дээр тавьсан.
3. Дөрвөн цаасан шувуу байна. Би нэгийг нь, тэр гурвыг нь хийсэн. Хоёр нь хайрцагны хажууд, нөгөө хоёр нь хайрцган дээр байна.
4. Тавган дээр гурван алим байсан. Нэг нь улаан, бусад нь ногоон байсан. Би нэгийг нь, эгч маань хоёрыг нь идсэн.
5. Хэдэн цамц байна. Шар нь гоё учраас би шарыг нь авмаар байна. Тэр хоёрыг нь авмаар байна. Тэр эмэгтэй томыг нь авмаар байна. Том нь ширээн дээр байна.
6. Урт нь минийх. Би уртыг нь өчигдөр авсан.

7. Бүгдээрээ гоё харагдаж байна. Би бүгдийг нь авмаар байна.

Наймдугаар хичээл

Дасгал 1

1. Халуун (халуундуу, халуувтар, хав халуун)
2. Хөгшин (хөгшиндүү, хөгшивтөр, хөв хөгшин)
3. Шингэн (шингэндүү, шингэвтэр, шив шингэн)
4. Хүйтэн (хүйтэндүү, хүйтэвтэр, хүв хүйтэн)
5. Хатуу (халуундуу, халуувтар, хав халуун)
6. Гашуун (гашуундуу, гашуувтар, гав гашуун)
7. Зузаан (зузаандуу, зузаавтар, зув зузаан)
8. Тарган (таргандуу, таргавтар, тав тарган)
9. Хурдан (хурдандуу, хурдавтар, хув хурдан)
10. Зөөлөн (зөөлөндүү, зөөлөвтөр, зөв зөөлөн)
11. Бүлээн (бүлээндүү, бүлээвтэр, бүв бүлээн)
12. Богино (богинодуу, богиновтор, бов богино)
13. Туранхай (туранхайдуу, туранхайвтар, тув туранхай)
14. Шар (шардуу, шаравтар, шав шар)
15. Улаан (улаандуу, улаавтар, ув улаан)
16. Хар (хардуу, харавтар, хав хар)
17. Ногоон (ногоондуу, ногоовтор, нов ногоон)
18. Бор (бордуу, боровтор, бов бор)

Есдүгээр хичээл

Дасгал 3

1. Би мах авахаар дэлгүүр лүү явсан.
2. Тэд нэг цагт тэр түргэн хоолны газарт өдрийн хоол идэхээр очдог.
3. Би англи хэл заахаар энд ирсэн.
4. Тэд ярилцлага өгөхөөр энд ирсэн.
5. Хүүхдүүд хөл бөмбөг тоглохоор гадаа гарсан.
6. Багш нар болон эцэг эхчүүд ярилцахаар өрөөнд суув.
7. Тэр найздаа захиа бичихээр ширээнд сууж байна.
8. Манай аав загас барихаар найзуудтайгаа хөдөө явна.
9. Тэр хичээлээ бичихээр миний балыг авсан.
10. Нохой саваа модыг зууж авахаар үсэрсэн.
11. Болормаа сургууль руугаа явахаар автобусанд суув.
12. Тэр маргааш бороо орно гэж бидэнд хэлэхээр иржээ.
13. Бид найздаа шинэ дэлгүүрийг үзүүлэхээр алхаж байна.
14. Хүүхдүүд сайхан дуу сонсохоор тийшээ явах дуртай.
15. Би музей үзэхээр найзтайгаа явна.
16. Тэр цүнхээ авахаар гэр лүүгээ гүйлээ.
17. Оюутнууд дуулахаар боссон.
18. Охин цэцэг түүхээр машинаас буув.
19. Тэр алхахаар гадаа гарлаа.
20. Хүүхдүүд унтахаар хэвтэж байна.
21. Манай найз маргааш хичээлдээ очиж чадахгүй гэж хэлэхээр над руу утастав.

Дасгал 5

1. Чи хөдөө юу авч явах вэ?
2. Тэр сургууль руугаа юу авч явсан бэ?
3. Чи гадагшаа гарахдаа их мөнгө авч явах хэрэггүй.
4. Тэр кино театр луу явахдаа чихэр авч явах дуртай.
5. Тэд хоол авч явахгүй бол өлсөнө.
6. Чи хуриманд юу авч очих вэ?
7. Би найзынхаа гэрт тоглоом авч очно.
8. Тэр эмэгтэй, хүүхдээ эмнэлэг рүү авч яваад эмчид үзүүлсэн.
9. Тэд хөдөөнөөс энд олон юм авчирсан.
10. Тэр сургуулиас номоо авахаар явсан.
11. Бид талх авахаар дэлгүүр лүү явах гэж байна.
12. Би дүүгээ авахаар сургууль руу удахгүй явна.
13. Тэд цусны шинжилгээнийхээ хариуг авахаар ирнэ.
14. Тэр, захирлаас зөвшөөрөл авахаар явж байна.
15. Тэр юмаа авахаар ирсэн байж магадгүй.
16. Би чамтай уулзахаар ирлээ.
17. Оюутнууд багшаасаа шалгалтынхаа талаар асуухаар явсан.
18. Би найзынхаа гэр лүү номоо авахаар явсан.
19. Тэр, оюутнуудад маргааш сургууль дээр ирэх ёстой шүү гэж хэлэхээр тэнд очно.

Давтлага (6–10)

Дасгал 4

1. Амьдралд хамгийн чухал юм юу вэ?
2. Амьдралд хамгийн муухай юм юу вэ?
3. Таны хамгийн дуртай юм юу вэ?
4. Та хэзээ хав халуун цай уудаг вэ?
5. Та хэзээ хүв хүйтэн ус уудаг вэ?
6. Та жаахан хүүхдүүдэд хир халуун хоол өгдөг вэ?
7. Монголчууд, Америкчууд адилхан гэж та бодож байна уу?
8. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс адилхан бодолтой гэж та бодож байна уу?
9. Том хүмүүс, хүүхдүүд их өөр гэж та бодож байна уу?

Дасгал 7

1. Бүжиглэж байгаа охиныг би танина.
2. Бүжиглэж байгаа охин англи хэл мэднэ.
3. Ширээн дээр байгаа хоол халуун байна.
4. Ширээн дээр байгаа хоолыг хэн хийсэн юм бэ?
5. Энийг хичээл заасан багшид өг.
6. Чиний сурсан дууг би сурмаар байна.
7. Чи сурсан дуугаа надад зааж өгөөрэй.
8. Угаасан аяга тавгаа энд тавь.
9. Чиний авсан гутлыг би үзэж болох уу?

Тест (6–10)

1. А 2. Б 3. В 4. А 5. Б 6. В 7. А 8. Б 9. А 10. В 11. А 12. Б 13. В 14. Б 15. А 16. Б

Арван нэгдүгээр хичээл

Дасгал 1

1. гаднах 2. урдах 3. хойдох 4. наадах 5. цаадах 6. доторх 7. доторх 8. өмнөх 9. доорх 10. дээрх 11. доторх

Арван хоёрдугаар хичээл

Дасгал 1

1. эгчийндээ 2. хамаатныдаа 3. эмээ өвөөгийндөө 4. эмээ өвөөгийнхөөсөө 5. багшийнхыгаа 6. хүүгийндээ 7. шоколадтайг 8. манайд 9. танайд 10. тэднийд 11. шоколадтайгаас 12. махтайг нь 13. махгүйг нь 14. махтайгаас нь 15. хадмынхаараа

Арван гуравдугаар хичээл

Дасгал 4

1. Хоол болтол хөзөр тоглоцгооё.
2. Хичээл дуустал энд суугаад хүлээ.
3. Оюутнууд зун болтол хичээлтэй байдаг.
4. Үзгээ олтлоо хайгаарай.
5. Намайг иртэл тэд хүлээсэн.
6. Тэд унтталаа зурагт үзсэн.
7. Бороо зогстол гадаа битгий гар.
8. Чи хурдан хийвэл ирэх нэгдэх өдөр хүртэл 10 сандал хийж чадна.
9. Тэр гэрлэтлээ эцэг эхтэйгээ хамт амьдарсан.
10. Тэр, теннис тоглох үнэхээр дуртай. Тэр ядартлаа тоглодог.
11. Тэр ямар нэгэн юмыг сайн хийж чаддаг болтлоо дахин дахин хийдэг.
12. Эмч "Эрүүл болтлоо энэ эмийг уу" гэж хэлсэн.
13. Зарим хүүхэд хүссэн юмаа автлаа уйлдаг.
14. Тэд есөн цагаас арван долоон цаг хүртэл найман цаг ажилладаг.
15. Улаанбаатараас Дархан хүртэл машинаар гурван цаг явдаг.
16. Сурагчдыг текстээ бичиж дуустал хүлээгээрэй.
17. Хүүхдүүд ээ, будаг нь хаттал сандлууд дээр сууж болохгүй шүү.
18. Бид даартлаа гадаа тоглосон.

Арван тавдугаар хичээл

Дасгал 2

1. дуусчихсан байна 2. явчихсан байна 3. ирчихсэн байсан 4. эхэлчихсэн байсан/эхэлчихсэн байна 5. хийчихсэн байдаг 6. А. хийчихсэн байсан Б. хийчихсэн байдаг В. хийчихсэн байна 7. явчихсан байсан 8. чаначихсан байдаг 9. унтчихсан байна 10. буцалчихсан байна. 11. мартчихсан байна, мартчихсан байсан

Дасгал 3

1. Хөөх, цас орчихсон байна. Намайг өглөө босоход цас орчихсон байсан.
2. Хүүхдүүд ирчихсэн байна. Намайг ирэхэд хүүхдүүд ирчихсэн байсан.
3. Харанхуй болчихсон байна. Намайг гадаа гарахад харанхуй болчихсон байсан.
4. Хувцас чинь бохир болчихсон байна. Намайг уулзахад түүний хувцас бохир болчихсон байсан.
5. Хичээл эхэлчихсэн байна. Намайг ирэхэд хичээл эхэлчихсэн байсан.
6. Оюутнууд их сургуулийнхаа төлбөрийг төлчихсөн байна. Намайг оюутнуудтай уулзахад тэд төлөөрөө төлчихсөн байсан.
7. Цахилгаан тасарчихсан байна. Намайг явахад цахилгаан тасарчихсан байсан.
8. Хүү маань унтчихсан байна. Намайг өрөөнд ороход хүү маань унтчихсан байсан.
9. Тасалбар зарагдчихсан байна. Биднийг тэнд очиход тасалбар зарагдчихсан байсан.

Дасгал 5

1. Тамхи биенд хичнээн муу болохыг тэр мэдсэн бол тамхи татахаа болих байсан.
   Тэр надтай уулзахдаа тамхи татахаа больчихсон байсан байж магадгүй.
   Намайг хэлэхэд тэр, муу найзаасаа салсан бол өдөөд аль хэдийн тамхи татахаа больчихсон байх байсан.
2. Би сургуульд орохдоо аль хэдийн морь унаад сурчихсан байсан.
   Хэрэв би хөдөө өссөн бол морь унаж сурах байсан.
   Хэрэв би хөдөө өссөн бол өдийд аль хэдийн морь унаад сурчихсан байх байсан.
3. Түүнд дахиад цаг байсан бол тэр ажлыг дуусгачихсан байх байсан.
   Найз нь туслаагүй бол тэр, тэр ажлыг дуусгаж чадахгүй байсан.
   Биднийг ирэхэд тэр, тэр ажлыг дуусгачихсан байсан.
4. Батхүүг уурлаагүй бол тэд амралтаараа хаашаа явахаа аль хэдийн шийдчихсэн байх байсан.
   Батхүүг уурлахаас өмнө тэд амралтаараа хаашаа явахаа аль хэдийн шийдчихсэн байсан.
   Батхүүг уурлаагүй бол хаашаа явахаа хурдан шийдэх байсан.
5. Сэрүүлэг нь дуугарсан бол ээжийгээ ирэхэд тэр аль хэдийн босчихсон байх байсан.
   Сэрүүлэг нь дуугарсан бол тэр сэрэх байсан.
   Сэрүүлэг нь дуугарахад тэр аль хэдийн сэрчихсэн байсан.

Давтлага (11–15)

Дасгал 2

1. Тэр ахындаа очсон.
2. Тэр эгчийнхээсээ ирсэн.
3. Би найзынх руугаа явна.
4. Тэд эмээ өвөөгийндөө амьдардаг.
5. Би шоколадтайгаас нь авмаар байна.
6. Чи үзэмтэйг нь идмээр байна уу?
7. Би самартайд нь дуртай.
8. Чи цэцэгтэйгээр нь хувцас хийж болно.
9. Устайг нь ав.
10. Усгүйг нь ав.

Дасгал 3

1. Намайг ирэхэд нохой бүх махыг идчихсэн байсан.
2. Нохой бүх махыг идчихсэн байхад би ирсэн.
3. Намайг багш нарын өрөөнд ороход зарим багш аль хэдийн явчихсан байсан.
4. Онгоц хөөрөхөд зорчигчид аль хэдийн суудалдаа суугаад хамгаалалтын бүсээ бүсэлчихсэн байдаг.
5. Сурагчдыг ангиа цэвэрлэчихсэн байхад багш ирдэг.
6. Харанхуй болохоос өмнө тэд гэрээ барьчихсан байсан.
7. Намайг кино театрт очиход кино аль хэдийн эхэлчихсэн байсан.
8. Намайг гэрээг үзэхэд тэд аль хэдийн гарын үсгээ зурчихсан байсан.
9. Намайг 7 сарын сүүлээр ойд очиход гүзээлзгэнэ болчихсон байдаг.
10. Намайг гэртээ ирэхэд манай ээж хоол хийчихсэн байна.
11. Тэр энд ирэхээсээ өмнө монгол хэл сурчихсан байсан.
12. Чамайг над руу ярихаас өмнө би аль хэдийн босчихсон байсан.
13. Намайг хэлэхээс өмнө тэд цэцгүүдийг усалчихсан байсан.
14. Намайг гуйхаас өмнө тэд хог гаргаад хаячихсан байсан.
15. Тэр гэрийн даалгавраа хийчихсэн байсан бол бидэнтэй явах байсан.
16. Намайг түүнд сануулчихсан байсан бол тэр тийм алдаа гаргахгүй байсан.
17. Түүнийг ажлаа дуусгаагүй байсан бол найзууд нь түүнд туслах байсан.
18. Тэр хөдөө яваагүй байсан бол бидэнтэй энэ сонирхолтой концертийг үзэх байсан.
19. Их цас орчихсон байсан бол бид тэнд очиж чадахгүй байсан.
20. Би энэ киног үзчихсэн байсан ч гэсэн түүнтэй дахиад үзсэн.

Тест (11–15)

1. Б 2. А 3. А 4. Б 5. А 6. В 7. А 8. А 9. Б 10. А 11. Б 12. В 13. Б 14. Б 15. Б 16. В

Арван зургадугаар хичээл

Дасгал 1

1. Хэн ч ирээгүй.
2. Хэн ч хог тариагүй.
3. Хэн ч надад туслахгүй.
4. Би хэнд ч энэ номыг өгөхгүй.
5. Би хэнд ч итгэдэггүй.
6. Би хэнд ч хичээл заагаагүй байгаа.
7. Би хэнд ч энэ тухай хэлээгүй.
8. Би хэнээс ч айдаггүй.
9. Би хэнд ч энийг аваагүй.
10. Энэ хэний ч буруугаас болоогүй.
11. Энэ хэний ч шугам биш.
12. Би хэн рүү ч цаас шидээгүй.
13. Багш хэн рүү ч хараагүй байна.
14. Би хэнтэй ч уулзаагүй.
15. Би гудамжинд хэнтэй ч тааралдаагүй.
16. Би энд хэнтэй ч амьдрахгүй.
17. Би хэнийг ч загнадаггүй.
18. Би хэнийг ч дуурайдаггүй.
19. Би дэлгүүрээс юу ч аваагүй.
20. Би оройн хоолонд юу ч идээгүй.
21. Би юу ч уумааргүй байна.
22. Би уржигдар өглөө юу ч хийгээгүй.
23. Би юугаар ч гэр лүүгээ явахгүй.
24. Би юугаар ч бичих дургүй.
25. Би энийг юугаар ч хийгээгүй.
26. Би хаана ч суумааргүй байна.
27. Манай гэр хаана ч байдаггүй.
28. Би машинаа хаана ч тавиагүй.
29. Би маргааш хаашаа ч аялахгүй.
30. Би хаашаа ч онгоцоор нисэхгүй.
31. Би дахиад хэзээ ч энд ирэхгүй.
32. Би хэзээ ч мөрийтэй тоглохоо болихгүй.
33. Би хэзээ ч машин жолоодож сурахгүй.
34. Би хэзээ ч найзыгаа зодоогүй.

Дасгал 2

1. Та юу идмээр байна вэ? Би юу ч идмээргүй байна.
2. Та юунд дуртай вэ? Би юунд ч дуртай биш.
3. Та юу хийх дуртай вэ? Би юу ч хийх дургүй.
4. Тэнд юу идэж болох вэ? Тэнд юу ч идэж болохгүй.
5. Тэндээс юу авч болох вэ? Тэндээс юу ч авч болохгүй.
6. Та юу авсан бэ? Би юу ч аваагүй.
7. Энд юу тавьж болох вэ? Энд юу ч тавьж болохгүй.
8. Та юунаас айдаг вэ? Би юунаас ч айдаггүй.
9. Би хичээлээ юугаар бичиж болох вэ? Та хичээлээ юугаар ч бичиж болохгүй.
10. Би хоолоо юугаар идэж болох вэ? Та хоолоо юугаар ч идэж болохгүй.
11. Би юугаар цэцэг хийж болох вэ? Та юугаар ч цэцэг хийж болохгүй.
12. Би юугаар тийшээ явж болох вэ? Юугаар ч явж болохгүй.
13. Та энд юугаар ирсэн бэ? Юугаар ч ирээгүй.
14. Би хэзээ машин барьж болох вэ? Хэзээ ч машин барьж болохгүй.
15. Би хэзээ үдэшлэгт явж болох вэ? Хэзээ ч явж болохгүй.
16. Би хэзээ энэ файлыг устгаж болох вэ? Хэзээ ч устгаж болохгүй.
17. Тэр хэзээ энд ирэх вэ? Тэр хэзээ ч энд ирэхгүй.
18. Чи хэзээ усанд сэлж сурах вэ? Би хэзээ ч усанд сэлж сурахгүй.
19. Чи хэзээ надад туслах юм бэ? Би чамд хэзээ ч туслахгүй.
20. Би хэзээ ээмэг зүүж болох вэ? Хэзээ ч зүүж болохгүй.
21. Би хаанаас гар утас худалдаж авч болох вэ? Хаанаас ч худалдаж авч болохгүй.
22. Би хэзээ ажил хийж эхэлж болох вэ? Хэзээ ч болохгүй.
23. Би хаана тамхи татаж болох вэ? Хаана ч тамхи татаж болохгүй.
24. Би хаана тоглож болох вэ? Хаана ч тоглож болохгүй.
25. Чи өчигдөр хаашаа явсан бэ? Хаашаа ч яваагүй.
26. Чи хогоо хаашаа шидсэн бэ? Хаашаа ч шидээгүй.

Дасгал 4

1. Би өмнө нь ийм хоол хийж байгаагүй.

2. Энэ хүнтэй өмнө нь ерөөсөө уулзаж байгаагүй гэж тэр хэлсэн.
3. Тэд өмнө нь ерөөсөө Дархан руу явж байгаагүй.
4. Би ийм том морь өмнө нь амьдралдаа харж байгаагүй.
5. Би өмнө нь ийм аймшигтай гэмт хэргийн талаар сонсож байгаагүй.
6. Намайг тэдэнд өгөхөөс өмнө тэд хэзээ ч пицца идэж байгаагүй.
7. Тэр өмнө нь ажлынхаа талаар гомдоллож байгаагүй.
8. Би өмнө нь энэ талаар бодож байгаагүй.
9. Бид тэнд өмнө нь очиж байгаагүй.
10. Би өмнө нь хэзээ ч энэ тоглоомыг тоглож байгаагүй.
11. Тэр өмнө нь ямар ч сургуульд сурч байгаагүй.
12. Тэд аав ээжийнхээ үгэнд ерөөсөө орж байгаагүй гэж би сонссон.
13. Түүний зүрх өмнө нь ерөөсөө өвдөж байгаагүй.
14. Тэр өмнө нь ингэж баярлаж байгаагүй.
15. Тэр өмнө нь ингэж уурлаж байгаагүй.
16. Тэр өмнө нь ингэж сэтгэлээр унаж байгаагүй.
17. Тэр өмнө нь ингэж ядарч байгаагүй.
18. Тэр өмнө нь ингэж гуниглаж байгаагүй.

Арван долдугаар хичээл

Дасгал 1

1. Шөнө хэн нэгэн хүн хаалга цохивол битгий онгойлго.
2. Хэн нэгэн хүн миний өрөөнд байсан байх аа.
3. Хэн нэгэн хүн миний түрийвчийг авчихжээ.
4. Хэн нэгэн хүн чамайг гомдоовол надад хэлээрай.
5. Чиний үзэг энэ өрөөнд хаа нэг газар байгаа. Дахиад хай.
6. Энийг энэ хашаан дотор хаа нэг газар нуу. Би олно.
7. Чамайг найзтайгаа хэзээ нэгэн цагт, хаа нэгэн газар уулзана гэж би найдаж байна.
8. Тэр хэзээ нэгэн цагт аав ээжийгээ ойлгоно.
9. Тэр хэзээ нэгэн цагт ирж чамаас уучлалт гуйна.
10. Би найздаа нэг юм хэлэх хэрэгтэй байна.
11. Чи тэндээс ямар нэгэн юм олов уу?
12. Чи найздаа ямар нэгэн юм авах уу?
13. Тэр бидэнд ямар нэгэн юм хэлэхийг хүсэж байгаа байх аа.
14. Тэд биднээс ямар нэгэн юм нуугаад байгаа юм шиг байна.
15. Ямар нэгэн юм болбол над руу утсаар яриарай.

Арван есдүгээр хичээл

Дасгал 3

1. Энийг засаад өгөөч.
2. Тэрийг засаад өгөөч.
3. Машины хаалгыг хаагаад өгөөч.
4. Шал цэвэрлээд өгөөч.
5. Энэ модыг хугалаад өгөөч.
6. Чимээгүй байгаад өгөөч.
7. Энийг бичээд өгөөч.
8. Давс аваад өгөөч.
9. Энийг зүсээд өгөөч.
10. Тэр бөмбөгийг над руу шидээд өгөөч.
11. Энийг бариад өгөөч.
12. Энийг тайлбарлаад өгөөч.
13. Энийг орчуулаад өгөөч.
14. Энэ ажлыг хийгээд өгөөч.
15. Надад дуу заагаад өгөөч.
16. Цэцэг зураад өгөөч.

Дасгал 4

1. Би тэдэнд монгол хоол хийж өгч чадна.

2. Бид хүүхдүүдэд олон дуу зааж өгсөн.
3. Миний төрсөн өдрөөр надад үнэртэй ус авч өгөөрэй.
4. Оройн хоолон дээр надад дуулж өгөөрэй.
5. Би чамд жинхэнэ түүх ярьж өгмөөр байна.
6. Намайг сургуульд явахад эмээ маань надад өдрийн хоол бэлдэж өгдөг байсан.
7. Тэр найздаа гоё бэлэг авч өгсөн.
8. Аав маань миний унадаг дугуйг засч өгдөг.
9. Маргааш миний үсийг самнаж өгөөрэй.
10. Тэр надад гитар тоглож өгсөн.
11. Би түүнд цэцэрлэгт хүрээлэн хүрэх замыг зааж өгсөн.
12. Завтай болохоороо энэ зааврыг надад орчуулж өгөөрэй.
13. Манай эмээ надад үлгэр уншиж өгдөг байсан.
14. Гэрлэхэд нөхөр маань надад сайхан хүзүүний зүүлт авч өгсөн.
15. Чамайг манайд очвол би чамд итали хоол яаж хийдгийг зааж өгнө.
16. Манай багш бидэнд олон юм тайлбарлаж өгсөн.
17. Тэр, охиндоо дандаа үнэтэй хувцас авч өгдөг.
18. Ах маань бидэнд сайхан байшин барьж өгсөн.
19. Чи найздаа ямар нэгэн сайн юм хийж өгөх хэрэгтэй.
20. Тэд баяраар ээждээ ил захидал хийж өгөх дуртай.
21. Би хувцсыг чинь угааж өгнө өө.
22. Би чамд өөр сонирхолтой номнууд авчирч өгнө өө.

Хорьдугаар хичээл

Дасгал 1

1. унтаг 2. бодог 3. зүүг 4. мэдэг 5. асууг 6. яриг 7. үзэг 8. зааг 9. сонгог 10. цэвэрлэг 11. үлдэг 12. үзүүлэг 13. шийдэг 14. оролцог

Дасгал 3

1. Хүүхэд эхлээд хоол идэг.
2. Тэр их сайхан дуулдаг. Тэр дуулаг.
3. Тэр өрөөгөө өөрөө цэвэрлэг.
4. Тэр эвдсэн сандлаа засаг.
5. Тэр энэ тухай бодог.
6. Бороо орог. Би бороонд дуртай.
7. Чи олон удаа тоглолоо. Найз чинь тоглог.
8. Тэр хэтэрхий их ажиллалаа. Тэр амраг.
9. Тэр найзыгаа дотор хүлээг. Гадаа хүйтэн байна.
10. Тэр Хөвсгөл нуур хүрэх замыг сайн мэднэ. Тэр жолоодог.
11. Ширээн дээр байгаа цэцгийг битгий тасал. Ургаг.
12. Тэр бугыг битгий ал. Амьдраг.
13. Тэр уйлаг. Дараа нь тэр тайвширна.
14. Тэр яриг. Тэр сонирхолтой юм ярьдаг.
15. Тэд алхаг. Алхах биенд сайн.
16. Тэд өөрсдөө хоол хийж сураг.
17. Тэд манай гэрт нэг долоо хоног байг.
18. Тэд онгоцоор яваг.
19. Тэр, галын хажууд сууг.

Давтлага (16–20)

Дасгал 2

1. Чи энд хэзээ ч ирж болно.
2. Би чамд хэзээ ч тусалж чадна.
3. Чи надаас юу ч асууж болно.
4. Чи энд юу ч тавьж болно.
5. Чи хаана ч сууж болно.
6. Хүмүүс хаашаа ч явж болно.
7. Хэн ч энэ ажлыг хийж чадна.
8. Чи энэ тоглоомыг хэнтэй ч тоглож болно.
9. Би энэ дууг хэнд ч зааж өгч болно.
10. Тэр хаана ч амьдарч чадна.

Дасгал 3

1. хэн нэгэн хүнээс 2. хэн нэгэн хүн рүү 3. хэн нэгэн хүнд/нэгэн юманд 4. хэзээ нэгэн цагт 5. хэн нэгэн хүнд 6. хэн нэгэн хүнийг 7. ямар нэгэн юмнаас/хэн нэгэн хүнээс 8. хэн нэгэн хүн 9. ямар нэгэн юмаар 10. хэн нэгэн хүнтэй 11. ямар нэгэн юм 12. хаа нэгэн газар

Дасгал 4

1. Чи баншнаас гадна өөр юу хийж чадах вэ?
2. Та монгол хэлээс гадна өөр ямар хэл сурч байгаа вэ?
3. Танаас гадна өөр хэн хэн ирсэн бэ?
4. Охид хоол хийж сурахаас гадна өөр юу юу хийж сурах хэрэгтэй вэ?

Дасгал 7

1. Мориноос унуузай/унав аа.
2. Алдаа гаргуузай/гаргав аа.
3. Хуруугаа түлэв ээ.
4. Хуруугаа эсгүүзэй.
5. Ядруузай.
6. Хичээлээсээ хоцров оо.
7. Номоо авчрахаа мартуузай.
8. Гэрлээ унтраахаа мартав аа.
9. Хоол идэхээ мартуузай.
10. Найз руугаа утсаар ярихаа мартав аа.

Тест (16–20)

1. Б 2. В 3. Б 4. А 5. В 6. Б 7. Б 8. А 9. Б 10. В 11. А 12. В 13. В 14. А 15. В 16. А

Хорин хоёрдугаар хичээл

Дасгал 2

1. Биднийг гадаа сууж байхад олон шувуу бидний дээгүүр нисэж өнгөрсөн.
2. Цэргүүд офицерүүдийн хажуугаар өнгөрвөл ёсолдог.
3. Хуучин гүүрэн дээгүүр гарах аюултай.
4. Монгол хүмүүс хэцэн доогуур гардаггүй.
5. Хэн нэг хүн сууж байвал бид урдуур нь өнгөрдөггүй.
6. Зочдын урдуур битгий гар.
7. Сүхбаатарын талбайн урд нэг сайхан зураг байдаг. Чи Сүхбаатарын талбайн урдуур өнгөрвөл тэр зургийг хараарай.
8. Намайг гадаа алхаж байхад нэг машин миний хажуугаар их ойрхон өнгөрсөн.
9. Хөл бөмбөг тоглож байхад бөмбөг Батхүү бид хоёрын дундуур өнгөрсөн.
10. Тэр над руу бөмбөг шидсэн. Үсэрсэн учраас бөмбөг миний хөлөн доогуур өнгөрсөн.
11. Түүний над руу шидсэн чулуу миний толгой дээгүүр өнгөрсөн.
12. Банкны хажуугаар гарвал надад хэлээрэй. Би мөнгө солиулах хэрэгтэй.
13. Тэр дэлгүүрийн урдуур алхаж байгаа хүн миний найз.
14. Аав ээжийнхээ урдуур, хойгуур битгий гүй.
15. Хашаан дээгүүр битгий яв, аюултай.
16. Бид энд театрын баруун талаар ирсэн.

17. Тэр байшингийн зүүн талаар явбал ойрхон.
18. Тэд бөмбөгөө торон дээгүүр цохиж гаргаж чадсангүй.
19. Тэр миний хажуугаар ойрхон өнгөрсөн ч гэсэн намайг таниагүй.

Дасгал 3

1. Дээшээ (доошоо, зүүн тийшээ, баруун тийшээ) хар.
2. Шатаар дээшээ (доошоо) яв.
3. Шатаар дээшээ гарах амархан уу, доошоо буух амархан уу?
4. Багш нар хичээл зааж байхдаа урагшаа хойшоо холхидог.
5. Ийшээ явцгаах уу, тийшээ явцгаах уу?
6. Бөмбөгөө наашаа (цаашаа) шид.
7. Эхлээд зүүн тийшээ гурав алхаад, дараа нь баруун тийшээ гурав алх.
8. Урагшаа гүй. Арагшаа битгий хар.
9. Урагшаа хараад хичээлээ хий.
10. Бид дотогшоо ороод их сайхан зүйлс харсан.
11. Би цонхоор гадагшаа харах дуртай.
12. Баруун гар тийшээ эргээд, дараа нь зүүн гар тийшээ эргэ. Дараа нь чигээрээ яв.
13. Наашаа хар. Битгий хажуу тийшээ хар.
14. Гадаа хүйтэн байна. Дотогшоо орцгооё.

Хорин тавдугаар хичээл

Дасгал 3

1. Монгол хоол яаж хийдгийг та мэдэх үү?
2. Хэл яаж хурдан сурдгийг та мэдэх үү?
3. Төв шуудан руу яаж явдгийг та мэдэх үү?
4. Цаасан шувуу яаж хийдгийг та хэзээ сурсан бэ?
5. Монгол хоол яаж хийдгийг та хэзээ сурсан бэ?
6. Монгол улс хэрхэн хөгжиж байгааг та харж байна уу?
7. Монголчуудыг мах идэх дуртайг та анзаарсан уу?
8. Энд хүйтэрч байгааг та анзаарч байна уу?

Дасгал 4

1. Торт яаж хийдгийг надад зааж өгөөрэй.
2. Энэ тоглоомыг яаж тоглодгийг надад зааж өгөөрэй.
3. Яагаад ирээгүйг нь түүнээс асуу.
4. Монгол хэл яаж сурч байгааг нь түүнээс асуу.
5. Өнөө өглөө хэн энд ирснийг таа.
6. Миний гарт хэдэн чулуу байгааг таа.
7. Намайг дэлгүүрээс юу авсныг таа.
8. Уржигдар тэнд юу болсныг таа.
9. Тэрийг яаж хийснээ надад хэл.
10. Хэдэн цагт ирснээ надад хэл.
11. Яагаад тэнд суумааргүй байснаа надад хэл.
12. Энд яаж ирснээ надад хэл.
13. Юу гэж хэлснээ бичээрэй.
14. Юу хийснээ бичээрэй.
15. Юу сурснаа бичээрэй.
16. Тэр юу хийснээ санахгүй байсан.
17. Тэр юу гэж хэлснээ санахгүй байсан.

Дасгал 6

1. Ирэх сард бороо орох, үгүйг би мэдэхгүй байна.
   Ирэх сард бороо орох уу, үгүй юү гэдгийг би мэдэхгүй байна.

2. Би 10 жилийн дараа энд байх үгүйгээ мэдэхгүй байна.
   Би 10 жилийн дараа энд байх уу үгүй юу гэдгээ мэдэхгүй байна.
3. Би маргааш 5 цагт гэртээ байх үгүйгээ мэдэхгүй байна.
   Би маргааш 5 цагт гэртээ байх уу үгүй юу гэдгээ мэдэхгүй байна.
4. Найзыгаа 5 жилийн дараа энд байх, үгүйг би мэдэхгүй байна.
   Найзыгаа 5 жилийн дараа энд байх уу, үгүй юу гэдгийг би мэдэхгүй байна.
5. Би урт наслах, үгүйгээ одоо хэлж мэдэхгүй нь.
   Би урт наслах уу, үгүй юу гэдгээ одоо хэлж мэдэхгүй нь.

Дасгал 7

1. Би энийг хийж чадах уу, үгүй юу гэдгээ мэдэхгүй байна.
2. Намайг энийг хийж чадах уу, үгүй юу гэдгийг манай найз танд хэлж өгч чадна.
3. Би энд удах уу, үгүй юу гэдгээ одоо танд хэлж өгч чадахгүй нь ээ.
4. Тэднийг ирж чадах уу, үгүй юу гэдгийг хэн ч мэдэхгүй.
5. Би тамхи татдаг уу, үгүй юу гэдгээ танд хэлмээргүй байна.
6. Намайг тамхи татдаг уу, үгүй юу гэдгийг аав ээжээс минь асуу.
7. Маргааш бороо орох уу, үгүй юу гэдгийг би танд хэлж чадахгүй нь.
8. Түүнийг бидэнтэй явж чадах уу, үгүй юу гэдгийг олж мэдээд надад хэл.
9. Энэ ажлыг хийж чадах уу, үгүй юу гэдгээ сайн бодоод надтай холбоо барь.
10. Түүнийг чиний хамгийн сайн найз байж чадах уу, үгүй юу гэдгийг сайн бодоод шийдвэр гарга.
11. Түүнийг сайн хүн үү, үгүй юу гэдгийг олж мэд.
12. Тантай ажиллаж чадах уу, үгүй юу гэдгийг нь түүнээс асуу.

Дасгал 9

1. Тэр ууртай байсан. Яагаад гэдгийг нь чи мэдсэн үү?
2. Тэр сэтгэлээр унасан байсан. Яагаад гэдгээ тэр чамд хэлсэн үү?
3. Тэр их сонин байсан. Яагаад гэдгийг нь би ойлгоогүй.
4. Тэд их баярласан. Яагаад гэдгийг таагаарай.
5. Тэд их гунигтай байсан. Яагаад гэдгийг би дараа чамд хэлнэ ээ.
6. Тэд их сандарсан. Яагаад гэдгийг нь мэдмээр байна уу?
7. Тэр өчигдөр хичээлд ирээгүй. Яагаад гэдгийг нь чи сонссон уу?
8. Тэр хэнтэй ч яриагүй. Яагаад гэдгээ тэр надад тайлбарласан.
9. Тэр биднээс зөвлөгөө авахыг хүсээгүй. Яагаад гэдгийг нь надаас битгий асуу.
10. Өчигдөр чиний сэтгэл их хөдөлсөн байсан. Яагаад гэдгийг хэл.
11. Чи өчигдөр их тэвчээргүй байсан. Яагаад гэдгийг чинь би мэднэ.
12. Чи өнөө өглөө надтай хашгирч яриад байсан. Яагаад гэдгийг чинь би чамаас сонсмоор байна.
13. Тэр, монгол хэл их сайн сурсан. Яаж гэдгийг нь мэдэх үү?
14. Тэр, монгол хэл их сайн сурсан. Яаж гэдгээ тэр надад хэлсэн.
15. Тэр, монгол хэл их сайн сурсан. Яаж гэдгийг нь түүнээс асуу.
16. Тэр надаас уучлалт гуйсан. Яагаад гэдгийг нь би ойлгоогүй.
17. Тэр надаас уучлалт гуйсан. Яагаад гэдгээ надад хэлээгүй.

Давтлага (21–25)

Дасгал 4

1. Би найзуудаа шоолохоо болино.
2. Чи хараалын үг хэлэхээ болих хэрэгтэй.
3. Инээхээ боль.
4. Компьютер тоглоом хэтэрхий их тоглохоо болиорой.
5. Чи хэзээ хэтэрхий их кофе уухаа болих юм бэ?
6. Би ханандаа ханын цаас наах гэж байгаад болиод будсан.

7. Бид байраа зарах гэж байгаад болиод түрээсэлсэн.
8. Тэд хонины мах авах гэж байгаад болиод үхрийн мах авав.

Дасгал 5

1. хүлээлгүй 2. асгалгүй 3. яаралгүй 4. түгжилгүй 5. Танилгүй 6. асуулгүй 7. айлгүй 8. индүүдэлгүй 9. бодолгүй

Тест (21–25)

1. В 2. Б 3. Б 4. Б 5. А 6. Б 7. А 8. Б 9. Б 10. Б 11. А 12. А 13. Б 14. В 15. А 16. В

Хорин долдугаар хичээл

Дасгал 4

1. Бороо их орохлоор өвс их ургадаг.
2. Тэр будгийг үнэрлэхлээр миний толгой өвддөг.
3. Тэр согтохлоороо галзуу болдог.
4. Загасанд явахлаар тэдний сэтгэл хөөрдөг.
5. Эгчийгээ зочилж ирэхлээр манай ээж дандаа баярладаг.
6. Хүмүүс ядрахлаараа идэвхтэй ажиллаж чаддаггүй.
7. Гудамжны хүүхдүүдийг харахлаараа бид өрөвддөг.
8. Хүмүүс буруу юм хийхлээрээ харамсдаг.
9. Хөршүүдийгээ чимээ гаргахлаар би унтаж чаддаггүй.
10. Тогтмол алхахлаар хүмүүсийн жин хасагддаг.
11. Түүнийг бүүвэйн дуу дуулахлаар тэр хүүхэд хурдан унтдаг.
12. Жимс боловсрохлоор хүмүүс түүдэг.
13. Тэр, хэлний алдаа гаргахлаараа ичдэг.
14. Бороо орохлоор хүүхдүүд гадаа гарах дуртай.

Дасгал 5

1. Тэр тэнд эгчийгээ хараад их баярласан.
2. Тэр уурлахлаараа их чанга ярьдаг.
3. Би гэртээ ирээд хоол хийсэн.
4. Би гэртээ ирэхдээ таксигаар ирсэн.
5. Удаан суухлаар миний өвдөг өвддөг.
6. Би Монголд ирэхдээ монгол хэл мэддэггүй байсан.
7. Хүмүүс удаан суухлаараа эвшээдэг.
8. Би Монголд ирээд гайхсан.
9. Тэд алхаж байхдаа дуулж байсан.
10. Бид хөдөө байхдаа морь унасан.
11. Түүнийг над руу бөмбөг шидэхлээр нь би буцаагаад түүн рүү шидсэн.
12. Гэрэлмаа хөдөө очоод олон хүнтэй уулзсан.
13. Тэр мэдээг сонсоод миний уур хүрсэн.
14. Дулаан болохлоор би хөдөөгүүр аялна.
15. Тэд энийг сонсоод баярлана.
16. Би гэртээ байхдаа бэлэг дурсгалын зүйл хийх дуртай.
17. Жаахан хүүхдүүд өлсөхлөөрөө уйлдаг.
18. Манай хүүхэд том болоод эмч болохыг хүсдэг.
19. Хүүгээ сургуулиа төгсөхлөөр би машин авч өгнө.
20. Тэр сургуулиа төгсөөд Япон руу явна.

21. Тэр, тэр захиаг уншихдаа ю [illegible]
22. Тэр ээжийнхээ захиаг у[illegible]
23. Түүнийг уйлахлаар найз нь [illegible]
24. Бид тэр захиаг уншаад [illegible].
25. Тэр, тэр захиаг уншихдаа [illegible].

Дасгал 8

1. Хүн туслахлаар танд ямар санагддаг вэ?
2. Яахлаар танд сайхан санагддаг вэ?
3. Яахлаар танд муухай санагддаг вэ?
4. Тэр надад чихэр шидэж өгсөн. Надад муухай санагдсан.
5. Энэ өрөөнд ороорой. … Танд ямар санагдаж байна?
6. Өчигдөр орой энд газар хөдөлсөн гэж би сонссон. Харин би юу ч мэдрээгүй.
7. Аймшгийн кино үзэхлээр надад аймаар санагддаг учраас би үзэх дургүй.
8. Тэр байшинд орсон чинь надад сонин санагдсан.
9. Хүүхдүүд аав ээжийнхээ хайрыг зүрх сэтгэлээрээ мэдэрдэг.
10. Чи энэ эмийг уувал өвдөлтийг мэдрэхгүй.
11. Заримдаа гадаад улсад амьдрах надад хэцүү санагддаг.
12. Заримдаа юм хийх надад амархан санагддаг.
13. Тэр харанхуйд явж байгаад хэн нэгэн хүн ард нь байгааг мэдрээд, түүнд аймаар санагдсан.
14. Зун их ялаа байдаг болохоор надад ядаргаатай санагддаг.
15. Тэд маш хүнд ажил хийдэг. Нэг удаа би тэдний ажлыг хийгээд биеэрээ мэдэрсэн. Надад их хэцүү санагдсан.

Хорин наймдугаар хичээл

Дасгал 3

1. Энэ шилэнд битгий хүр. Амархан хагарна.
2. Энэнд хүрвэл хуруугаа түлнэ шүү.
3. Охины гар хаалганы хонхонд хүрдэггүй.
4. Гар чинь тавиурт хүрэхгүй бол энэ шатыг хэрэглэ.
5. Бид тэнд таван цаг гэхэд хүрчихнэ.
6. Хүмүүсийн хийсэн юм таны санаанд хүрдэг үү?
7. Миний зурсан зураг санаанд хүрэхгүй байна.
8. Та хүүхдүүддээ заримдаа гар хүрдэг үү?
9. Хүүхдүүдэд гар хүрэх сайн уу, муу юу?
10. Би энэ жил 30 хүрнэ.
11. Би ханиад хүрвэл яах хэрэгтэй вэ?
12. Чамд даашинз хийхэд энэ торго хүрнэ.
13. Өвлийн дулаан гутал авахад энэ мөнгө хүрэх үү?

Гучдугаар хичээл

Дасгал 3

1. явуул 2. хийлгэ 3. гарга 4. асаа 5. заалга 6. торгуул 7. унтуул 8. инээлгэ 9. ажиллуул 10. ядраа 11. түүлгэ 12. босго 13. буулга 14. хэлүүл 15. хүргэ 16. бариул 17. бичүүл 18. угаалга 19. нисгэ 20. нээлгэ 21. сэрээ 22. хатаа 23. суулга 24. уншуул 25. олуул 26. хаалга 27. амраа 28. гомдоо

Дасгал 6

1. Би тэр багшаар монгол хэл заалгасан.
2. Тэд ээжээрээ гэр цэвэрлүүлэх дургүй.
3. Бид Гэрэлмаагаар зургаа авахуулсан.
4. Бид Батхүүгээр хурал дээр Монголын түүхийг яриулсан.
5. Багш сурагчдаар зохион бичлэг бичүүлсэн.
6. Чанга чимээ намайг ядраадаг.
7. Би ахаараа хананууды будуулна.
8. Хүүхдүүдийг энд зогсоогоорой.
9. Тэднийг битгий удаан хүлээлгээрэй.
10. Тэр намайг дандаа инээлгэдэг.
11. Хүүхдийг битгий гадаа удаан байлгаарай.
12. Хүү засварчнаар унадаг дугуйгаа засуулсан.
13. Эмээ ач хүүгээрээ нүдний шилээ хайлгасан.
14. Ганхүү ач охиноороо үнэнийг хэлүүлэв.
15. Тэр түүх надад олон юм бодууллаа.
16. Муу хүмүүс найзуудаараа муу юм хийлгэхийг хүсдэг.
17. Битгий аймаар юм хэлж хүүхдүүдийг айлга.

Давтлага хичээл (26–30)

Дасгал 1

1. Чамайг амжилттай ажиллана гэдэгт би эргэлзэхгүй байна.
2. Цагтаа ирж чадна гэдэгтээ би эргэлзэж байна.
3. Түүнийг надад тусалж чадна гэдэгт би эргэлзэхгүй байна.
4. Чамайг тамхинаас гарч чадна гэдэгт би эргэлзэхгүй байна.
5. Түүнийг сайн хүн болно гэдэгт би итгэж байна.
6. Таныг монгол хэл сайн сурна гэдэгт би итгэлтэй байна.
7. Би монгол хэл сайн сурч чадна гэдэгтээ итгэлтэй байна.
8. Тамхи татах нь биенд муу.
9. Түүний өндөр үү, үгүй юү гэдэг нь надад хамаагүй.
10. Ажил хийхийг хүсч байна уу, үгүй юү гэдэг чинь чухал.
11. Энийг хурдан хийж дуусгаж чадах уу, үгүй юү гэдгээс чинь энэ шалтгаална.
12. Дулаан байх уу, үгүй юү гэдгээс энэ шалтгаална.

Дасгал 3

1. мэдэрдэг 2. хүрдэг 3. мэдэрдэг 4. санагддаг 5. санагддаг 6. хүрдэг 7. мэдэрдэг

Дасгал 4

1. Чи хуучин машинаа яасан бэ?
2. Чи тэр мөнгөөр яах гэж байгаа юм бэ?
3. Өчигдөр чи яасан бэ?
4. Чи энэ саваагаар яадаг юм бэ?
5. Машин чинь эвдэрвэл чи яах вэ?
6. Яахлаар хүмүүс уурладаг вэ?
7. Хүмүүс уурлахлаараа яадаг вэ?
8. Яахлаар хүмүүс баярладаг вэ?
9. Хүмүүс баярлахлаараа яадаг вэ?

Тест (26–30)

1. А 2. Б 3. Б 4. В 5. А 6. Б 7. В 8. А 9. Б 10. А 11. В 12. А 13. В 14. Б 15. Б 16. А

Гучин нэгдүгээр хичээл

Дасгал 3

1. Ганхүү харагдаагүй.
2. Тэр мод танд **харагдаж** байна уу?
3. Энэ хичээл **заагдаагүй**.
4. Хүүхдүүдэд **олон зүйлийг** заасангүй.
5. Түүний **үс өөрчлөгдөнө**.
6. Энэ **зураг солигдоно**.
7. Багшийн **ном олдоогүй**.
8. Надад **хөлийн чимээ** сонсогдоогүй.
9. **Түүнд нутаг нь их** санагддаг.
10. Олон **хувцас** угаагдсан.
11. **Энэ ном** бороонд угаагдсан.
12. Нэг өдөр олон ажил хийгддэг.
13. Ээж маань (надад) бодогдож байна.
14. Түүний үг ойлгогдохгүй байна.
15. Энэ дэлгүүр сарын өмнө нээгдсэн.
16. Энэ ном олон хувь хэвлэгдсэн.
17. Таны машин засагдаагүй байна.
18. Энэ айлын мал тоологдоогүй.
19. Энэ байр жилийн өмнө баригдсан.

Гучин дөрөвдүгээр хичээл

Дасгал 3

1. Кино эхлэнгүүт хүүхдүүд суудалдаа суулаа.
2. Хичээлээ дуусангуут ирж надтай уулзаарай.
3. Хоолоо идэж дуусангуутаа аяга таваг угаагаарай.
4. Би эмэгтэй дүүгээ цэцэрлэгт нь хүргэж өгөнгүүтээ сургууль руугаа гүйлээ.
5. Аав ээжийгээ ажлаасаа ирэнгүүт би өөртөө юу тохиолдсоныг ярьж өгнө.
6. Тэр хүүхдийг уйлангуут энэ сүүг өгөөрэй.
7. Миний хэлснийг ойлгонгуутаа тэд инээсэн.
8. Батхүү ширээн дээрээс бялууг авангуутаа хурдан идэж гарлаа (=эхэллээ).
9. Ганхүү галт тэрэгнээс буунгуутаа гар утсаа ширээн дээр мартсанаа саналаа.
10. Тэр гэртээ ирэнгүүтээ компьютер тоглоом тоглодог.
11. Тэр өглөө босонгуутаа кофе уудаг.
12. Хавар болонгуут тэд өөр газар луу нүүнэ.
13. Гэрэлмаа ээжийгээ харангуутаа ээж рүүгээ гүйлээ.
14. Цахилгаан ирэнгүүт надад хэл.
15. Түүнээс сураг дуулангуутаа надад хэлээрэй.

Гучин тавдугаар хичээл

Дасгал 1

1. уншингаа 2. ажилламгаа 3. харангаа 4. яринга 5. заангаа 6. хүлээнгээ 7. тоглонгоо

Дасгал хичээл (31–35)

Дасгал 3

1. Ганхүүг түүнтэй уулзангуутаа цэцэг өгсөн бол тэр баярлах байсан.
2. Тэр их сургуулиа төгсөнгүүтээ ажил хийж эхэлсэн бол түүнд сайн байх байсан.
3. Тэр гэртээ ирэнгүүтээ гараа угаасан бол өвчин тусахгүй байсан.
4. Гэрэлмааг гэрт нь ирэнгүүтээ үнэнийг хэлсэн бол найз нь түүнд уурлахгүй байсан.
5. Би ажлаа дуусгангуутаа гэртээ ирсэн бол ахтайгаа уулзаж чадах байсан.

Дасгал 5

1. Хүмүүс муу зүйл хийсээр байна.
2. Түүний бие сайжирсаар байна.
3. Дэлхий дээр гэмт хэрэг өссөөр байна.
4. Ажилгүйдэл нэмэгдсээр байна.
5. Банны өрөөнд ус гоожсоор л байна.
6. Тэр гүйсээр байгаад ядарсан.
7. Тэр зурагт үзсээр байгаад гэрийн ажлаа хийж чадсангүй.
8. Хүү найзыгаа шоолсоор байгаад уйлуулчихлаа.

Тест (31–35)

1. Б 2. А 3. В 4. А 5. Б 6. А 7. Б 8. Б 9. Б 10. В 11. А 12. Б 13. Б 14. А 15. Б 16. Б

Гучин зургадугаар хичээл

Дасгал 3

1. Тэр чамтай маргааш уулзана гээд явсан.
2. Тэр удахгүй ирнэ гээд явсан.
3. Тэр дараагийн долоо хоногт миний номыг буцааж өгнө гээд авав.
4. Тэр уран зураг сонирхдог гээд надад хэдэн зураг үзүүлсэн.
5. Би өлсөөгүй байна гээд хоол идээгүй.
6. Тэр даараагүй гээд дулаан хувцсаа өмсөөгүй.
7. Тэд энд машин тавих хориотой гээд биднийг (тэндээс) явуулсан.
8. Тэр яарч байна гээд гүйчихсэн.
9. Тэр, энийг хадгалж байгаарай гээд надад зургийн аппаратаа өгсөн.
10. Хүү намайг бариарай гээд гүйв.
11. Тэр баярлалаа гээд надад цэцэг өгсөн.
12. Би түүнд "Чи энийг өөрөө хийх ёстой" гээд түүнд туслаагүй.
13. Тэр, тэр тухай мэдээгүй гээд надад юу ч хэлээгүй.

Дасгал 7

1. Хэлэх гэсэн юмаа шууд хэлээрэй.
2. Асуух гэсэн юмаа шууд асуугаарай.
3. Авах гэсэн юмаа аваарай.
4. Хийх гэсэн юмаа хийгээрэй.
5. Чиний идэх гэсэн хоолыг би захиалчихсан.
6. Мэдэх гэсэн юмаа энэ номноос мэдэж авч чадна.
7. Чиний орох гэсэн сургуулийн талаарх мэдээллийг би аваад ирлээ.
8. Таны авах гэсэн цүнхийг би олж чадсангүй.
9. Таны хэлэх гэсэн санааг би ойлгосонгүй.
10. Таны орчуулах гэсэн текстийг би орчуулсан.
11. Таны сурах гэсэн юмыг би зааж өгнө.

Гучин долдугаар хичээл

Дасгал 4

1. Тэр хэдэн цагт ирэх юм бол? Тэр 5 цагт ирэх юм бол уу, 6 цагт ирэх юм бол уу?
2. Би номоо хаана тавьсан юм бол? Энд тавьсан юм бол уу, тэнд тавьсан юм бол уу?
3. Тэр ийм их ажлыг яаж дуусгах юм бол?
4. Тэр хэдэн настай юм бол? Тэр 30 настай юм бол уу?
5. Тэр хаанаас ирж байгаа юм бол? Тэр гэрээсээ ирж байгаа юм бол уу?
6. Тэд юу хийх гэж байгаа юм бол? Тэд ямар нэгэн муу юм хийх гэж байгаа юм бол уу?
7. Тэд яагаад инээсэн юм бол? Би буруу юм хэлсэн юм бол уу?
8. Тэр яагаад ажил хийх дургүй юм бол? Аав ээж нь түүнд мөнгө өгдөг юм бол уу?
9. Тэр яагаад дандаа энд суудаг юм бол? Тэр хэн нэгэн хүнийг хүлээдэг юм бол уу?
10. Хүмүүс энэ тоглоомыг яаж тоглодог юм бол? Би энийг тоглож чадах юм бол уу?

Дасгал 5

1. Маргааш борОо орох бололтой.
2. Хүүхдүүд энд байсан бололтой.
3. Тэр өвдсөн бололтой.
4. Тэр миний асуултыг ойлгоогүй бололтой.
5. Тэр намайг таниагүй бололтой.
6. Тэд дотно найзууд бололтой.
7. Тэр хэцүү хүн бололтой.
8. Энэ байшин их хуучин байшин бололтой.

Гучин наймдугаар хичээл

Дасгал 1

1. Тэгсэн. 2. Тэгнэ. 3. Тэгдэг. 4. Тэгмээр байна. 5. Тэгж чадна. 6. Тэгдэг байсан. 7. Тэгж байна. 8. Тэгэх гэж байна. 9. Тэгж байсан. 10. Тэгэх гэж байсан.

Дасгал 2

1. Тэгье. 2. Тэг тэг. 3. Тэгээрэй. 4. Тэгнэ ээ. 5. Тэгээрэй. 6. Тэгнэ ээ. 7. Тэг тэг. 8. Тэгье. 9. Тэгье. 10. Тэг тэг. 11. Тэгнэ ээ. 12. Тэгээрэй. 13. Тэг тэг. 14. Тэгье. 15. Тэгнэ ээ. 16. Тэгээрэй.

Дасгал 5

1. Тэгэхэд, Тэгэхдээ 2. Тэгэхэд/Тэгтэл 3. Тэгвэл 4. Тэгэхлээр 5. Тэгвэл 6. Тэгвэл 7. Тэгээд 8. Тэгээд 9. Тэгэхдээ 10. Тэгтэл/Тэгэхэд

Гучин есдүгээр хичээл

Дасгал 4

1. Би үзгээ ингэж/тэгж барьдаг.
2. Би ийм/тийм үзэг авсан.
3. Би ийм/тийм урт үзэг авсан.
4. Чи ингэж/тэгж суух хэрэгтэй.
5. Чи ийм/тийм сандал дээр суух хэрэгтэй.
6. Чи ийм/тийм жижиг сандал дээр суусан.
7. Тэр, пицца ингэж/тэгж хийдэг.
8. Тэр ийм/тийм пицца хийдэг.
9. Тэр ийм/тийм том пицца хийдэг.
10. Тэр гутлаа ингэж/тэгж өмсдөг.
11. Тэр ийм/тийм гутал өмсдөг.
12. Тэр ийм/тийм том гутал өмсдөг.
13. Бид байшингаа ингэж/тэгж барина.
14. Бид ийм/тийм байшин барина.
15. Бид ийм/тийм өндөр байшин барина.
16. Тэр үсээ ингэж/тэгж самнадаг.
17. Тэр ийм/тийм үстэй.
18. Тэр ийм/тийм урт үстэй.
19. Тэр, чихэр ингэж/тэгж идсэн.
20. Тэр ийм/тийм чихэр идсэн.
21. Тэр ийм/тийм их чихэр идсэн.
22. Тэр шүдээ ингэж/тэгж угаадаг.
23. Тэр ийм/тийм шүдний сойзтой.
24. Тэр ийм/тийм цагаан шүдтэй.

Дөчдүгээр хичээл

Дасгал 3

1. Та гэр бүлдээ хир их цаг гаргадаг вэ?
2. Та гэрийн ажилд хир их цаг зарцуулдаг вэ?
3. Танай улсад хүмүүс дандаа цаг барьдаг уу?
4. Гадаа хийх юмгүй цаг нөхцөөж байгаа хүмүүсийг хараад та юу гэж боддог вэ?
5. Яагаад цаг заримдаа удаан заримдаа хурдан өнгөрдөг вэ?
6. Та цагаа хир сайн ашигладаг вэ?
7. Ямар мэргэжилтэй хүмүүс цагтай уралдаж ажиллах ёстой байдаг вэ?
8. Хүмүүсийн цагийг юу үрдэг вэ?
9. Та гэрийн даалгавраа хийхдээ хир их цаг зардаг вэ?
10. Та яаж цаг (мөнгө) хэмнэдэг вэ?
11. Тамирчид хэзээ цаг сунгадаг вэ?
12. Юу юу хүмүүсийн цагийг хэмнэдэг вэ?

Дасгал 4

1. сунгах 2. ашиглаж, үрдэг 3. нөхөж 4. алдаж 5. хэмнэх 6. өнгөрсөн 7. болж байгаа 8. товлосон уу 9. тулсан 10. гаргах 11. ид

Давтлага хичээл (36–40)

Дасгал 1

1. Маргааш цас орно гэнэ ээ.
2. Уучлаарай, энэ юу гэж байна?
3. Тэр юу гэнэ вэ/гэсэн бэ?
4. Энийг монголоор юу гэдэг юм бэ?
5. Энийг монголоор аяга гэдэг.
6. Танай зохион байгуулагчтай уулзах гэсэн юм.
7. Танаас юм асуух гэсэн юм.
8. Тэр удахгүй ирнэ гээд явсан.
9. Түүнийг энэ ажлыг хийж чадахгүй гэвэл би хийнэ.
10. Таныг уучлаарай гэхэд тэр гайхсан.
11. Би хийх гэсэн юмаа хийж чадсан.
12. Та хэлэх гэсэн юмаа хэлж дуусав уу?

Тест (36–40)

1. А 2. В 3. А 4. В 5. Б 6. А 7. В 8. А 9. Б 10. Б 11. А 12. А 13. Б 14. А 15. А 16. А

Дөчин хоёрдугаар хичээл

Дасгал 1

1. зарим нь, зарим нь 2. заримынх нь 3. заримыг нь 4. заримаар нь, заримаар нь 5. заримаас нь 6. заримд нь, заримд нь 7. заримынх нь 8. зарим нь, зарим нь 9. заримыг нь 10. заримаас нь 11. зарим руу нь 12. заримтай нь 13. заримыг нь 14. заримд нь, заримд нь 15. заримтай нь 16. заримаар нь

Дасгал 4

1. Би энэ дүрмүүдийг бүгдийг нь мэднэ.
2. Би энэ жимснүүдийг бүгдийг нь идэж үзсэн.
3. Бүгдэд нь дулаан хувцсаа авчир гэж хэл.
4. Миний хүү, сүүгээ бүгдийг нь уу.
5. Энэ махнуудыг бүгдийг нь идэж үз.
6. Бүгдэд нь мэнд хүргээрэй.
7. Тэд бүгдээрээ сайн оюутнууд.
8. Чи энэ тоглоомуудыг бүгдийг нь зассан уу?
9. Энэ гуталнууд бүгдээрээ шинэ.
10. Энэ тэдэнд бүгдэд нь хүрнэ.
11. Би тэдэнд бүгдэд нь хайртай.
12. Би тэдэнтэй бүгдтэй нь гар барьсан.
13. Та нар бүгдээрээ энийг хийж чадна.
14. Энэ үгнүүдийг бүгдийг нь цээжлээрэй.
15. Энэ аяга тавагнуудыг бүгдийг нь угаа.

Дөчин дөрөвдүгээр хичээл

Дасгал 2

1. Миний ном хаана байгаа юм бол? Манай гэрт байгаа юм бол уу?
2. Тэр хаанаас ирсэн юм бол? Канадаас ирсэн юм бол уу?
3. Манай найз юу идэх дуртай юм бол? Тэр жимс идэх дуртай юм бол уу?
4. Тэр яагаад над руу утсаар яриагүй юм бол? Тэр миний утасны дугаарыг мартчихсан юм бол уу?
5. Тэр яаж ийм их амжилтанд хүрсэн юм бол?
6. Тэр намайг ойлгосон юм бол уу, үгүй юм бол уу? Тэр яагаад юу ч хэлээгүй юм бол?
7. Тэр яаж ирэх гэж байгаа юм бол? Тэр автобусаар ирэх гэж байгаа юм бол уу?
8. Бид нар хэзээ төслөө эхлэх юм бол? Удахгүй эхлэх юм бол уу?
9. Тэр хэн юм бол? Тэр шинэ оюутан юм бол уу?

Дөчин тавдугаар хичээл

Дасгал 2

1. Тэр хэзээ ирнэ гэж? Тэр өнөөдөр ирнэ гэж үү?
2. Чи яагаад хоол идмээргүй байна гэж? Дараа идмээр байна гэж үү?
3. Чи миний аягыг хаана тавьсан гэж? Миний аягыг шалан дээр тавьсан гэж үү?
4. Хэн энийг цэвэрлэж чадна гэж? Би энийг цэвэрлэж чадна гэж үү?
5. Нүдэнд юу сайн гэж? Лууван нүдэнд сайн гэж үү?

Давтлага хичээл (41–45)

Дасгал 1

1. өөртөө 2. өөрийнхөө 3. өөр лүүгээ 4. өөрийгөө 5. өөрөөсөө 6. өөрөөрөө 7. өөрийнхөө 8. өөртэйгөө

Дасгал 2

1. Та нар бие биенийгээ сонсох хэрэгтэй.
2. Тэд бие биендээ хайртай.
3. Бид бие биенээсээ уучлалт гуйсан.
4. Бид бие биенийхээ зан аашийг сайн мэднэ.
5. Тэд бие биенийгээ хүндэлдэг.
6. Та нар санаа бодлоо бие биентэйгээ хуваалцах хэрэгтэй.
7. Бид бие биен рүүгээ хараагүй.

Тест (41–45)

1. А 2. В 3. А 4. А 5. В 6. Б 7. А 8. А 9. А 10. В 11. А 12. Б 13. В 14. А 15. Б 16. Б

Дөчин есдүгээр хичээл

Дасгал 4

1. Нэг юмыг дахин дахин хийх тусам чи туршлагатай болно.
2. Нохойноос айх тусам нохой чам руу дайрна.
3. Өдөр өнгөрөх тусам гадаа халуун болж байна.
4. Хүүхдүүд ганцаараа байх тусам зожиг болдог.
5. Биднийг явах тусам зам муу болсон.

Давтлага хичээл (46–50)

Дасгал 1

1. Би энд ирэх замдаа найзтайгаа тааралдсан.
2. Гэртээ ирэх замдаа өөр хүүхдүүдтэй битгий гадаа тогло.
3. Би сургууль руугаа (сургуульдаа) ирэх замдаа дэлгүүрээр орсон.
4. Улаанбаатар луу (Улаанбаатарт) ирэх замд тэдний машин шаварт суусан.
5. Дэлгүүр лүү явах замдаа би түлхүүрээ гээчихжээ.
6. Эндээс банк руу явах замд нэг сайхан хоолтой ресторан байдаг.
7. Тэрэлж рүү явах замд малтай олон айл байдаг.
8. Би танай гэр лүү ирэх замдаа түүн рүү утсаар ярьсан.
9. Чи манайд очих замдаа тэр шинэ байшинг харав уу?

Дасгал 5

1. Та Дархан хотод очиж үзсэн үү?
2. Та Дархан хотод амьдардаг уу?
3. Та гэртээ нохой тэжээдэг үү?
4. Та хашаандаа нохойтой юу?
5. Та аяга таваг угаадаг уу?
6. Та хоол хийдэг үү?
7. Та машин барьдаг уу?
8. Та онгоц жолоодож чадах уу?

Тест (46–50)

1. Б 2. А 3. В 4. А 5. А 6. В 7. А 8. А 9. Б 10. А 11. В 12. Б

Хавсралт (Appendix)

Үгүйсгэх болон хориглон чимэх үгс (Negative Particles)

бус

Ашгийн бус байгууллага	Non profit organization
Төрийн бус байгууллага	Non government organization
Хууль бус үйл ажиллагаа	Illegal activity
Цаг бусын үхэл	Sudden death
Ээлжит бус	Irregular
Тогтмол бус	Irregular
Нэг бус удаа	More than once
Зориулалтын бус	Not intended for

эс

Чи үүнийг эс хийвэл хожим харамсана.	If you don't do this, you will regret it later.
Ажлаас жаахан хоцордгийг нь эс тооцвол тэр сайн ажилтан.	He is a good staff member if we don't count him being a little bit late for work.

үл

Үл тоох (not to pay attention to)	Үл хамаарах (not to depend on)
Үл ойшоох (not to pay attention to)	Үл мэдэх (not to know)
Үл таних (not to know)	Үл болох (not to be allowed to)
Үл ойлголцох (not to understand)	

бүү

Тамхи бүү тат.	Don't smoke.
Хог бүү хая.	Don't throw garbage.
Хүүхдийг муу юманд бүү уруу тат.	Don't tempt children to do bad things.
Бие биендээ бүү атаарх.	Don't be jealous of each other.
Хүнд бэрх ажлаас бүү шантар.	Don't be discouraged by hard work.

битгий

Дахиад битгий ийм юм хийгээрэй.	Don't do this kind of thing again.
Хараалын үг битгий хэлээрэй.	Don't say swear words.
Энийг битгий ав.	Don't take this.

-гүй

Өчигдөр бороо ороогүй.	It didn't rain yesterday.
Тэд энд амьдардаггүй.	They do not live here.
Би улаан балгүй.	I don't have a red pen.

биш

Энэ миний ном биш.	This is not my book.
Маргааш биш, өнөөдөр ажлаа эхэлцгээе.	Let us start our work today, not tomorrow.
Би эмч биш.	I am not a doctor.

Онцлон чимэх үг "л" (Particle "л")

1. **... л ... (only)**

Батхүүгийн л ах англи хэл мэдэхгүй.	Only *Bathuu's* brother doesn't know English.
Батхүүгийн ах л англи хэл мэдэхгүй.	Only *Bathuu's brother* doesn't know English.
Батхүүгийн ах англи хэл л мэдэхгүй.	Bathuu's brother only doesn't know English.

2. **... л даа[4] (meaning of begging)**

Ханан дээр битгий бич л дээ.	I'm begging you not to write on the wall.
Гэрийн даалгавраа хий л дээ.	I'm begging you to do your homework.
Хараалын үг битгий хэл л дээ.	I'm begging you not to curse.
Ээж ээ, намайг аваад яв л даа.	Mom, I'm begging you to take me with you.

3. **... л ... (It gives emphasis.)**

Хүн бүрт л өөр өөрийн асуудал байдаг.	EVERY ONE has their own problems.
Тэр өглөө болгон л гүйдэг.	He runs EVERY morning.
Тэр дандаа л сонгодог хөгжим сонсдог.	He ALWAYS listens to classical music.
Жаргалмаа үргэлж л ном уншдаг.	Jargalmaa OFTEN reads books.
Баярхүү гэртээ орж ирэнгүүтээ шууд л хоол идсэн.	As soon as Bayarhuu came into his house, he ate food DIRECTLY.

4. **... л ... (still)**

Хүүхдүүд ангидаа сууж л байна.	The children are still sitting in their classroom.
Багш хичээлээ эхлээгүй л байна.	The teacher still has not started her lesson.
Гадаа бороо орж л байна.	It's still raining.
Тэр номоо хаана тавьснаа санахгүй л байна.	He still does not remember where he put his book.

5. **... л бол ... (any ...)**

Энийг яаж л бол яаж (= яаж ч) хийж болно.	You may do this anyhow.
Би танд хэзээ л бол хэзээ тусалж чадна.	I can help you anytime.
Тэр танд хэдийг л бол хэдийг өгнө.	He will give you any number of it.
Энэ машинаар хаашаа л бол хаашаа явж болно.	You can go anywhere by this car.
Тэр хэнтэй л бол хэнтэй ярих дуртай.	She likes to talk to anyone.

6. **... л биз (It expresses anger.)**

—Дүү чинь кино үзнэ гэнэ ээ.	Your brother said he would watch a movie.
—Үзнэ л биз.	Whatever.
—Тэр чамайг шоолох байх аа.	Probably he will mock you.
—Аа, шоолно л биз. Би уйлахгүй.	Whatever. I won't cry.
—Жаргалмаа явах гэж байна.	Jargalmaa is going to leave.
—Аа, явна л биз. Би битгий яв гэж зөндөө гуйсан шүү дээ.	Oh, whatever. I asked her many times not to leave.

7. **... л даа[4] (It expresses that the story will go on.)**

Би гудамжинд явж байлаа л даа.	I was going in the street. (Then ...)

8. **... л даа[4] (meaning of actually)**

Би гэрийн даалгавраа хийсэн л дээ. Гэхдээ дэвтрээ гэртээ мартчихжээ.	Actually I did my homework, but I forgot my notebook at my house.

Онцлон чимэх үг "ч" (Particle "ч")

1. ч (also, too, either)

Би ч (гэсэн) ирээгүй.	I did not come either.
Батхүү ч тэр тухай надад хэлсэн.	Also Bathuu told me about that.
Тэнд гар бөмбөг ч тоглож болно.	You may also play volleyball there.
Буузны маханд перц хийж ч болно, хийхгүй ч байж болно.	You may either put pepper in the meat for buuz or not.

2. ч/ч гэсэн (even though)

Тэр намхан ч сагс сайн тоглодог.	Even though he is short, he plays basketball well.
Түүний хэлсэн үг хатуу ч үнэн үг шүү.	Even though the word he said is hard, it's true.
Тэр, нохойноос айсан ч айгаагүй юм шиг байлаа.	Even though he was afraid of the dog, he acted as though he was not afraid of it.

3. ч (any)

Хэн ч ийм хоол хийж чадна.	Anyone can cook this kind of food.
Та манайд хэзээ ч ирж болно.	You may come to my house anytime.
Цаасаар юу ч хийж болно.	You can make anything out of paper.

4. ч ...-гүй (no ...)

Хэн ч ирээгүй байна.	No one has come.
Би дэлгүүрээс юу ч аваагүй.	I bought nothing from the store.
Би хэзээ ч тамхи татахгүй.	I will never smoke.

5. ч (even)

Би түүний хэлснээс нэг ч үг ойлгосонгүй.	I did not understand even one word of what he said.
Одоо ч хүмүүс тэр тухай ярьдаг.	Even now, people talk about that.

6. ч дээ (It expresses someone is not happy about something/someone.)

Батхүү ч дээ. Дандаа юм эвдэж байдаг шүү дээ.	I don't know about Bathuu. He always breaks things.
Тэр анги ч дээ. Удаан суухлаар их хүйтэн шүү дээ.	Well that classroom, it's cold when we sit for a long time.
Би ч дээ. Одоо хөгшрөөд хурдан явж чадахгүй болж дээ.	Well me, I have become old and can't go fast.

7. ч юмуу (or)

Монгол хүмүүс айлд очихдоо чихэр ч юмуу, жимс ч юмуу, цагаан идээ ч юмуу аль байгаа юмаа авч очдог.	When Mongolians visit a family, they bring something they have such as candies, or fruits, or milk products.
Би маргааш ч юмуу, нөгөөдөр ч юмуу нэг завтай үедээ танайд очно оо.	I will visit your house tomorrow or the day after tomorrow when I have free time.

Батлан чимэх үг "даа[4]" (Particle "даа[4]")

1. ... даа, юм даа (I'm telling you.)

Ирэх сард хөдөө явна даа.	I will go to the countryside next month.
Энэ хүн сайн хүн байна даа.	I'm telling you. This person is a good person.
Тэр хүн авъяастай хүн юм даа.	I'm telling you. That person is a talented person.

2. Verb stem даа[4] (meaning of checking)

Та дахиад хэл дээ.	Say it again. (Let me see if you are saying right.)
Энэ аргаар хийгээд үз дээ.	Do it this way and see (if it works).
Ногоон өнгөөр будаад үз дээ.	Paint it green and see (if you will like it).

3. ...–на[4] даа (It expresses worry.)

Энэ ажлыг яаж дуусгана даа?!	How will I finish this work?!
Энэ хүүхэд хэзээ ухаан сууна даа?!	When will this child be mature?!
Шаварт суусан машинаа яаж гаргана даа?!	How will we take out our car that is stuck in the mud?!

4. ... шүү дээ (It gives emphasis.)

—Чи миний номыг авсан шүү дээ.	YOU TOOK MY BOOK.
—Үгүй шүү дээ.	NO.
—Тийм шүү дээ.	YES.

5. ... биз дээ? (..., isn't it? etc.,)

Та багш биз дээ?	You are a teacher, aren't you?
Тэр өчигдөр ирээгүй биз дээ?	He didn't come yesterday, did he?
Та маргааш ирнэ биз дээ?	You will come tomorrow, won't you?

6. л даа[4] (meaning of begging)

Ханан дээр битгий бич л дээ.	I'm begging you not to write on the wall.
Гэрийн даалгавраа хий л дээ.	I'm begging you to do your homework.
Хараалын үг битгий хэл л дээ.	I'm begging you not to curse.
Ээж ээ, намайг аваад яв л даа.	Mom, I'm begging you to take me with you.

7. ... ч дээ (It expresses that a speaker is not happy about something or someone.)

—Батхүү энийг хийж чадах байх аа.	I think Bathuu can do this.
—Батхүү ч дээ.	I don't know about Bathuu.
—Тэр анги дулаахан.	That classroom is warm.
—Тэр анги ч дээ.	I don't know about that classroom.
—Та сайн дуулдаг шүү дээ.	You sing well.
—Би ч дээ.	I don't know about myself.

8. ... л даа[4] (It espresses the story will go on.)

Би гудамжинд явж байлаа л даа. Тэгсэн чинь ...	I was going in the street. Then ...

9. ... л даа[4] (meaning of actually)

Би гэрийн даалгавраа хийсэн л дээ. Гэхдээ дэвтрээ гэртээ мартчихжээ.	Actually I did my homework, but I forgot my note book at my house.

10. **–аас[4] даа (I don't want to, but I have to ...)**

Дэлгүүр явахаас даа.	I don't want to, but I have to go to the store.
Тэдэнтэй хамт явахаас даа.	I don't want to, but I have to go with them.

11. **вий дээ (make sure he/she/it ...)**

Тэр хүүхэд уначих вий дээ.	Make sure that child doesn't fall down.
Хүүхдүүд айчих вий дээ.	Make sure the children are not scared.

Өгүүлбэрийн зэрэгцүүлэн холбох үгс (Sentence Coordinating Conjunctions)

Гэтэл/Гэвч/Тэгтэл/Харин	But
Тэгвэл	If so
Тэглээ ч гэсэн	Even so
Тэгэхлээр	So, accordingly
Ингэхлээр	By doing this, so
Тэгээд/Ингээд	So
Тэрчлэн/Мөн түүнчлэн	Similarly, like-wise
Үүнчлэн	Similarly, like-wise
Иймээс/Иймд	This being so
Тиймээс	That being so
Ийм учраас	Therefore
Тийм учраас	Therefore/That's why
Тиймийн тулд	Therefore/That's why
Түүгээр ч барахгүй	Not only that
Түүгээр ч зогсохгүй	Not only that
Өөрөөр хэлбэл	In other words
Цаашилбал	Furthermore
Цаашлаад	Furthermore
Нэг бол	On the one hand
Нэг бол ... үгүй бол ...	Either ... or ...
Эсвэл	or
Аль эсвэл	or
Ийнхүү/тийнхүү	By doing this/that
ба	and
буюу	or
бөгөөд	and
болон	and
агаад	and
мөн	also
бас	also
төдийгүй	not only
байтугай	not even
үл барам	not only
барахгүй	not only

Өгүүлбэрийн захируулан холбох үгс (Sentence Subordinating Conjunctions)

тулд (in order to)

Ажилдаа амжилт гаргахын тулд хүмүүс бэрхшээлээс шантралгүй ажиллах хэрэгтэй.	People need to work without discouraging difficulties in order to achieve success at their work.

төлөө (for)

Эмч өвчтөнийхөө амь насыг аврахын төлөө бүхнийг хийнэ.	The doctor will do everything for the sake of saving his patient's life.

улмаас (because of)

Осол болсны улмаас олон хүн бэртэж гэмтжээ.	Because of the accident, many people were injured.

дагуу/ёсоор (according to)

Бид энэ ажлыг таны хэлсний дагуу хийлээ.	We did this work according to what you said.

зэрэгцээ (along with)

Тэр сурахын зэрэгцээ ажил хийж байв.	He was doing work along with studying.

далимд/ялдамд (on the occasion of)

Би тэднийд очих далимдаа таны ажлын талаар ярина.	I will talk about your work on the occasion of visiting their house.

хэрд (by the time)

Намайг ажлаа дуусгахын хэрд тэр ирсэн.	He came by the time I finished my work.

хирнээ (but/even though)

Тэр сургуульд ороогүй хирнээ уншиж, бичиж чаддаг.	She can write and read even though she has not entered school yet.

мөртлөө (but/even though)

Тэр намхан мөртлөө сагс сайн тоглодог.	Even though he is short, he plays basketball well.

1. Үг бүтээх дагаврууд (Word Forming Suffixes)

Нэр үг бүтээх дагавар (The suffixes that make nouns)

Нэр үгээс нэр үг бүтээх дагавар: (Suffixes make new nouns out of existing nouns)

-чин	малчин, ажилчин, дуучин, бүжигчин, жүжигчин, адуучин, хоньчин, үхэрчин, ямаачин, тэмээчин, нэхмэлчин, анчин, модчин
-ч	эмч, жолооч, домч
-вч	хуруувч, хүзүүвч, бугуйвч, салхивч
-тан[4]	араатан, үнэртэн, хөрөнгөтөн (саятан, тэрбумтан), өвчтөн
-гтай[2]	эмэгтэй, эрэгтэй, хатагтай

Үйл үгээс нэр үг бүтээх дагавар: (Suffixes make nouns out of verbs)

-л(а)га[4]	гарлага, зорилго, орлого, барилга
-аа[4](н)	идээ, ачаа, барилдаан, мөргөлдөөн
-аас[4]	зураас, бөглөөс, үдээс, оёос
-гч	сурагч, уншигч, амрагч, зорчигч, хядагч, шүүмжлэгч, мөрдөгч, байцаагч
-л	санал, бодол, нэгдэл
-лт	ялалт, ололт, уулзалт
-дал[4]	явдал, асуудал, боодол, өргөдөл
-г	бичиг, зураг, будаг, зориг
-аач	зураач, харваач, бичээч, манаач
-бар[4]/-вар[4]	салбар, төлбөр, чадвар, үйлдвэр
-ц	орц, гарц, сууц
-мшиг	аймшиг, гутамшиг
-м	хэрчим, зүсэм
-с	дарс, баас, шүүс

Тэмдэг нэр бүтээх дагавар (The suffixes that make adjectives)

Нэр үгээс тэмдэг нэр бүтээх дагавар: (Suffixes make adjectives out of nouns)

-тай[3]	зоригтой, амттай, үнэтэй, ааштай, алдартай, азтай, аюултай, гэмтэй, зугаатай, зальтай, гунигтай, аймшигтай, амжилттай, халтиргаатай, итгэлтэй, тухтай
-гүй	зориггүй, гэрэлгүй, амтгүй, азгүй, аюулгүй, гэмгүй, зүггүй, тухгүй, зохисгүй, хязгааргүй
-н	хурдан, тарган, цэцэн
-т	мөст, цаст, гэрэлт, модот, гэмт, түүхт, галт

Үйл үгээс тэмдэг нэр бүтээх дагавар: (Suffixes make adjectives out of verbs)

-шгүй	дуусашгүй, шантаршгүй, тоолшгүй, хэмжишгүй, хувиршгүй, хөдөлшгүй
-мал[4]	хиймэл, хадмал, өргөмөл, зурмал, будмал, суумал, түгээмэл
-аа[4]	үглээ, босоо, хэвтээ

Үйл үг бүтээх дагавар (The suffixes that make verbs)

-л (ла[4])	дуул, цоожил, аягал, эмчил, хариул, малла, бүжиглэ, номло, жүжиглэ, борло, шарла, тагла, савла, харла
-д	багад, томд, уртад, богинод
-р	ногоор, томор, жижгэр, халуур
-шир	тайвшир, бодлогошир, удаашир
-т	мөст, цант, гэмт

2. Үг нийлэх аргаар нэр үг бүтэх (Word—Building by Word Combinations)

Зэрэгцээ нэр үг (Coordinate Word Combinations)

А. Ойролцоо утгатай нэр үгс (Words that are similar in meaning)
Эрх чөлөө, үр дүн, аз жаргал, бичиг баримт, онгорхой цоорхой, орой үдэш, энх тайван

Б. Эсрэг утгатай үг (Words that are opposite in meaning)
Эцэг эх, орлого зарлага, ах дүү, зовлон жаргал, хол ойр, сайн муу, эрт орой

В. Сүүлийн үгийн эхний авиаг М, З, С-ээр сэлгэж (Changing the first letters of the last word to М, З and С)
Сандал мандал, хоол моол, дэвтэр мэвтэр, мах зах, мал зал, өвс мөвс, бага сага

Угсраа нэр үг (Subordinate Word Combinations)

Хамжсан угсраа нэр үг (Subordinate Word Combinations without Suffixes)

А. Өнгө зүс заасан тэмдэг нэр жинхэнэ нэрд үндсээрээ захирагдан (Colors + noun)
Шар шувуу, шар айраг, бор шувуу, улаан булан

Б. Таван хошуу малын нэр + амьтан, ургамал, зэвсэг хэрэгсэл, бодис (Livestock names + animal names, weapons, substances)
Морин шоргоолж, морин хуур, тэмээн хяруул, үхэр буу, хонин гүрвэл, ямаан харгана

В. Байгалийн бодис + бодис (Substances + substances)
Усан үзэм, мөнгөн ус, элсэн чихэр, усан болор, утаат болор, мөсөн чихэр

Г. Учир шалтгаан + нэр үг (Words that explain reasons + nouns)
Гар бөмбөг, гар чийдэн, хөл машин, гэрэл зураг, дээд сургууль, дунд сургууль

Д. Өнгө + өнгө (Colors + colors)
Хар хөх, улаан шар, цагаан цэнхэр

Е. Тухайн өнгөний дээд чанарыг агуулсан юм + өнгө (Things that have best quality of that color + color)
Хун цагаан, гал улаан, үнсэн саарал, хөө хар, цусан улаан

Найрсан угсраа нэр үг (Subordinate Word Combinations with Suffixes)

А. Нэр үг+хтя + нэр үг (Noun with genetive case + noun)
Үхрийн нүд, нохойн хошуу, эдийн засаг

Б. -х, -даг[4] (Verb stem+х or -даг[4] + noun)
Шийлэх ухаан, унадаг дугуй, нисдэг тэрэг, зөвлөх эмч, дүрслэх урлаг

Ном зүй (Bibliography)

1. Ц. Өнөрбаян "Орчин цагийн монгол хэлний үг зүй" 2004 он
2. Монгол Судлалын Сургууль (Монгол Улсын Боловсролын Их Сургууль) "Орчин цагийн монгол хэл" 2010 он
3. D. Tserenpil, R. Kullman "Mongolian Grammar" 2008
4. Б. Пүрэв-Очир "Монгол хэлний энгийн ба нийлмэл өгүүлбэрийн хувиргал" 2006 он
5. Ц. Оюун "Зөв бичих дүрмийн тогтолцоот хураамж" 2000 он
6. Ж. Надмид "Монгол бичгийн хэл ба авиазүйн онолын асуудлууд" 2005 он
7. Я. Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" 1966 он
8. Bawden, C.R. "Mongolian–English Dictionary" 1997
9. Oxford Monsudar "English–Mongolian Dictionary"
10. Paymond Murphy "English Grammar in Use" 1985

15273
28000

LINGO LAB

Following on from Mongolian Language for Beginners, this book takes the advancing student of Mongolian deeper into the grammatical structure and practical use of the language.

Detailed English explanations are provided for the new grammar introduced. There are copious examples of the Mongolian usage, presented together with English translations, that help the student to clearly understand the nuances of the language.

The examples and exercises have been written to reflect the real situations of everyday life in Mongolia that the student is likely to encounter.

ISBN 978-99962-0-483-8

9 789996 204838